

СТИВЕН
КИНГ

МАНАН

Стивен Кинг

МАНАН

www.ibooks.mn

1. Шуурга

19... оны долдугаар сард Шинэ Английн хойд хэсэгт түүний түүхэнд урьд өмнө байгаагүй аймшигт халуун өдрүүд өнгөрч, харин араас нь урьд өмнө үзэгдээгүй ширүүн догшин шуурга орж ирсэн юм.

Бид Лонг-Лэйк нуурын эрэгт амьдардаг, тиймээс ч нар жаргахын яг өмнө салхи нуурын усыг бужигнуулж эхлэхийг хамгийн түрүүнд харцгааж билээ. Үүнээс цагийн өмнө ямар ч салхигүй нам болов. Аав маань бүр 1936 онд завиныхаа саравчны дээр зоосон Америкийн далбаа доош ямар ч хөдөлгөөнгүй унжин, бүр зах нь ч дэрвэхгүй байлаа. Маш халуун, бараг л гараар бариад авмаар бүгчим, нуурын тохойн усан дотор ч ийм л халуун байгаа гэж бодогдоно. Үдийн хоолны дараа бид гурав усанд орохоор явсан ч бүр гүнд л шумбахгүй бол сэргүүцэх ч аргагүй байлаа. Харин би ч, Стефф ч үүнийг хүссэнгүй. Хэргийн учир Биллид байгаа юм. Тэр дөнгөж таван настай. Тав хагаст бид нуур сайхан харагддаг сүүдрэвчиндээ сууцгаан оройн хоолоо идэж эхэллээ. Оройн хүйтэн хоол төмсний салат, гахайн махтай талхаа бид ямар ч сонирхолгүй зажилцгааж суулаа. Мөстэй хувинд хийсэн хэдэн лааз пепси-коланаас өөр юм хэн ч хүссэнгүй.

Хоолны дараа Билли тоглохоор гарч, харин Стефф бид хоёр тамхи татан, Харрисоны зүг, нуурын баргар усны цаана харагдах эргийг дуугүй харж суулаа. Эргийн модод навч нь хатаж, тоосонд дарагджээ. Баруун зүгт эгээ л тулалдаанд бэлтгэж буй арми адил аварга том хөхавтөр улаан өнгийн үүлс цуглаж, цахилгаан цахиж харагдана. Тэр бүрт манай хөрш Нортоны, Вашингтоны уулнаас байнга сонгомол хөгжим дамжуулдаг хүлээн авагч тачигнан дуугарч байлаа. Нортон Нью-Жерсид өмгөөлөгчөөр ажилладаг, тиймээс ч Лонг-Лэйкт пийшин, халаалт дулаалгагүй зуны байшинтай. Хоёр жилийн өмнө би түүнтэй эзэмшил газрынхаа хэмжээ хязгаараас болж маргалдаж, шүүхээр шийдүүлэх болоод, би хожсон юм. Нортон өөрөө эндхийн хүн биш болохоор л хожигдсон гээд, түүнээс хойш бидний харьцаа нилээд хүйтэн болж билээ.

Стефф санаа алдаж, усны хувцасныхаа дээд талаар цээжээ сэвж гарлаа. Түүнд нэг их сэргүүн сайхан болсон нь юу л бол, харин надад хамаагүй их зүйл харагдаж эхэллээ.

-Чамайг би айлгах гээгүй гэж би хэллээ.

-Гэхдээ удахгүй хүчтэй шуурга эхлэх бололтой.

Тэр намайг эргэлзсэн шинжтэй харав.

-Өчигдөр ч бас үүл хураад л байсан шүү дээ, Дэвид. Гэхдээ шуурга болоогүй.

-Өнөөдөр бол өөр байна.

-Чи итгэлтэй байна уу?

-Хэрэв их шуурга болвол бид доош буух хэрэгтэй.

-Чи тэгээд хэр хүчтэй болно гэж тооцоолж байгаа юм бэ?

Эцэг маань нуурын энэ эрэг дээр жил тойрон амьдарч болох сайхан байшин анх барьсан юм. Бүр хүүхэд байхдаа ах нартайгаа тэр энд зуслангийн байшин барьсан, харин түүнийг нь 1938 онд шуурга юу ч үгүй сүйдэлчихсэн, бүр чулуун хана нь ч тэсээгүй. Тэгээд зөвхөн завины саравч л үлдсэн гэдэг. Жилийн дараа тэр энэ байшиг барьж эхэлжээ. Ер нь үхэж хатсан модод шуурганаар байшинд хамгийн их хохирол учруулдаг. Түүнийг салхи үндсээр нь суга татаж, хийсгээд ирдэг юм. Байgal эх байсхийгээд ингэж "цэвэрлэгээ" хийдэг бололтой.

-Мэдэхгүй юм гэж би хэллээ. Энэ ч үнэн, би гучин найман оны шуурганы тухай бараг юу ч мэдэхгүй. -Гэхдээ нуурын зүгээс ирэх салхи хурдан галт тэрэг шиг хүчээ авч магад.

Тоглох сонирхолгүй болчихлоо, бүр нэвт хөлрөөд гэж гомдоллосоор Билли эргэж ирэв. Би түүний үсийг илээд бас нэг пепси задалж өглөө. Шүдний эмчийн ажлыг л нэмж байгаа хэрэг юмдаа.

Шуурганы хар үүлс хөх тэнгэрийг шахан зайлцуулах мэт ойртоор байлаа. Шуурга болно гэдэгт би одоо эргэлзэхээ болилоо. Билли тэнгэрийг аиж гайхан ширтэж бидний дунд сууна. Нууран дээгүүр аянгын дуун нүргэллээ. Хар, хөх, судалтай, захаараа бас хар үүлс тэнгэрт хөвнө. Аажмаар үүлс нуурыг бүрхэж, би орж буй борооны цагаан хөшгийг харлаа. Гэхдээ л бороо хол байна. Болтер-миллс, эсвэл Норвэй хавиар орж байгаа бололтой.

Агаар хөдөлгөөнд орж, тут багахан дэrvэлзэн хөдлөв. Сэруусч, удалгүй салхи улам ширүүсэн, эхлээд бидний хөлөрсөн биесийг хатааж, дараа нь бүр даарч ирэх шиг боллоо.

Яг знэ үед би нуурын дээгүүр гулсаж буй мөнгөлөг хуйг олж харсан юм. Хэдхэн хормын дотор бороон хөшиг Харрисоныг халхалж, шууд биднийг чиглэлээ. Моторт завинууд аль хэдийнэ арилаад өгцгөөж.

Билли нэрийг нь бичиж хадсан жижигхэн сандлаасаа босон харайлаа.

-Аав, хараач!

-Явъя, байшиндаа орьё гээд би босч, хүүгийнхээ мөрөн дээр гараа тавив.

-Аав, энэ юу вэ?

-Усан хуй гэдэг юм. Явъя.

Стефф миний зүг гайхсан шинжтэй харлаа.

-Явъя хүү минь, аавынхаа үгэнд орох хэрэгтэй.

Бид зочдын өрөөндөө гулсаж нээгддэг шилэн хаалгаар орж, би хаалгыг хааж, түгжээд гадагш харан түр зогслоо. Мөнгөлөг хуй замынхaa дөрөвний гурвыг туулж, одоо доош сорогдох мэт болсон хар тэнгэр, усны цайвар, цагаан судалт гадаргуу хоёрын дунд галзуу мэт эргэлдэх усан манан болон хувирчээ. Нуур тэнгис мэт болж, аварга том долгионууд эргийн зүг довтлон,

давалгаа хагалагч, зогсоолыг мөргөж эхэллээ. Харин нуурын голд цагаан толгойт давалгаанууд ар араасаа хөвнө.

Усан хуй харцыг өөртөө татаж байлаа. Тэр манай эрэгт бараг тулж ирэхэд гэнэт цахилгаан аймшигтай хурцаар гялсхийж, би нэг хэсэгтээ зургийн аппаратын хальсыг харах мэт сохрох шахлаа. Утас айх мэт жинхийв. Би эргэж хүү, эхнэр хоёр нуурын баруун хойд зүг харсан том шилэн цонхны наана зогсоод гадагш харцгааж байхыгхарлаа.

Гэнэт надад шил дотогш цөм үсрэн хагарч, шилний сум шиг хурц хэлтэрхийнүүд эхнэрийн нүцгэн гэдэс, хүүгийн нүүр рүү цацагдаж байгаа аймшигт дүр зураг харагдах шиг болов.

Би тэдний гараас шүүрэн авч цонхноос чирэх шахам холдууллаа.

-Ямар чөтгөрөө хийгээд энд зогсоод байгаа юм. Холдоцгоо!

Стефф намайг гайхсан нүдээр харж, харин Билли гүн нойрноос сэрэх мэт болчихов. Би тэднийг гал тогоонд аваачиж, гэрэл асаалаа. Утас бас л жинхийн дуугарлаа.

Яг энэ үед салхи дайран орж ирлээ. Байшин маань эгээ л "Боинг-747" онгоц мэт хөөрч байх шиг надад санагдав. Хaa ч юм салхи жингэнэтэл исгэрэн шуугиснаа нарийхнаар чарлах дуун болж хувирлаа.

-Доошоо бууцгаа гэж би Стеффид хашгиран хэллээ. Яг байшингийн дээр аварга том моддыгхооронд нь балбах мэт тэнгэр дуугарлаа. Билли миний хөлөөс тэврэв.

-Чи ч бас доошил гэж Стефф надад хэллээ.

Би толгой дохиод тэднийг доош хөөн гараа савчив. Биллиг арайхийж өөрөөсөө салгалаа.

-Ээжтэйгээ яв. Аав нь лаа хайж олоод очно.

Хүү ээжийнхээ араас явж, харин би лаа хайн хайрцагнуудаа үзэж эхэллээ. Laa гэж сонин эд шүү. Хавар болгон зуны шуурганаар тог тасарч магад хэмээн лаа авч хадгалдаг, тэгээд яг хэрэг болохоор тэд "нуугдчихдаг".

Дөрөвдэх хайрцаг. Дөрвөн жилийн өмнө Стефф бид хоёр худалдаж аваад дахиж бараг гар хүрээгүй арван таван грамм "өвс", Биллид авч өгсөн тоглоомон аварга загас, гэр бүлийн альбомд наана гэж Стефф аль эртнээс яриад байгаа баахан фото зураг. Би барааны сурталчилгааны зузаан номыг өргөж, Тайландад хийсэн хүүхэлдэйн араар шагайв. Хүүхэлдэйг би спортын тоглоомд хожиж шагнуулсан юм.

Гялгар уутанд боодлтой лаанууд яг энэ амьгүй шилэн нүдэт хүүхэлдэйн доор байжээ. Энэ үед гэрэл тасарч, тэнгэрийн цахилгаанаас өөр гэрэлтэх зүйлгүй болов. Зочдын өрөөнд байсхийгээд л гэрэл гялалзана. Дор Билли уйлж, Стефф тайвшруулж байгааг би сонслоо.

Би тэнгэрийн байдлыг дахин нэг хархаар дээшлэв.

Хүй салхи хаашаа ч юм алга болсон ч хорин метрээс цааш юу ч үл харагдана. Ус бараг л буцалж байх шиг. Жессерийнхний бололтой завины зогсоолыг хуу татчихсан, тэр нь нэг далд орж, нэг ил гаран урсан өнгөрлөө.

Намайг доош буумагц Билли дахин өвдгөөр тэвэрч авлаа. Би түүнийг өргөн өөртөө наалдуулаад, дараа нь лаануудыг асаав. Бид миний ажлын өрөөний дэргэдэх зочдын өрөөнд сууцгаав. Суугаад лааны анивалзах гэрэлд бие биесээ ширтэн, гадаа хуугинан дуугарах шуургыг чагнацгаалаа. Хорин минутын дараа унаж байгаа модны чимээ сонсогдоход бид хажууханд ургадаг хэдэн том нарсны нэг унасныг ойлголоо. Тэгээд чимээ намдав.

-Намдаж байна уу? -гэж Стефф асуулаа.

-Магадгүй, үгүй ч байж магад.

Бид гурвуул харанхуйд яваа лам нар мэт лаа барьцгаан цувран дээшлэв. Билли лаагаа болгоомжтой, гэхдээ сүрхий итгэлтэй барьж явна, гал түүнийг айдсаас ангижуулж байгаа бололтой.

Гэрэл байхгүй шахам болохоор байшин хэр зэрэг эвдэрч хэмхэрснийг тогтоох арга алга. Билли хэдийнэ унтах болсон ч Стефф бид хоёр түүнийг орондоо орохыг шаардсангүй. Бид зүгээр л зочдынхоо өрөөнд суугаад салхины дууг чагнаж, цахилгаан цахилахыг харж байлаа.

Цагийн дараа салхи дахин ширүүсч эхлэв.

Өмнөх гурван долоо хоногийн турш хорин таван хэм халуун байсан, бас энэ хорь гаран хоногийн зургаад нь Портлэнд-Жетпортын Үндэсний Цаг Уурын Албанаас халуун гучин хэм давсан тухай зарлаж байсан. Итгэмээргүй халуун. Дээр нь хатуу өвөл, бас оройтсон хавар, ингээд л хүмүүс энэ бүхэн бол тавиад оны атомын бөмбөгийн туршилтын үр дүн гэж ярьцгааж эхэллээ. Үүний тухай, бас ертөнцийн сөнөлийн тухай. Бүх хоосон ярианы хамгийн эртнийх. Салхи нэг их хүчтэй биш байсан ч, дахин хэдэн мод унах чимээ гарч, бүр намдаж эхэлж байх үед нэг нь манай байшингийн яг дээвэр дээр уналаа. Билли босон харайж айсан шинжтэй дээвэр рүү харав.

-Хүү минь зүгээр, дээвэр тэснэ гэж би хэллээ.

Билли айсан ч инээмсэглэх аядаж байна.

Арван цагийн үед салхи эцсийн удаа ширүүслээ. Эхний удаагийнх шиг шуугин исгэрч, цахилгаан байшинг тойрон маналзав. Модод унасаар л байна. Усны ойролцоо юу ч юм тасхийн унаж, Стефф дуу алдав. Харин Билли сэrsэнгүй, өвөр дээр нь унтана.

-Дэвид, энэ юу байсан бэ?

-Манай завины саравч л бололтой.

-Бурхан минь...

-Доош бууя гээд би босч, Биллиг гартаа авлаа. Стефф айсан том нүдээрээ намайг ширтэнэ.

-Дэвид, бүх юм зүгээр гэдэгт чи итгэж байна уу?

-Тиймээ.

Бид доош буулаа. Арван минутын дараа салхи дахин ширүүсэхэд дээр тас нясхийх дуу гарч, том цонх хага үсэрлээ. Миний урьд нь айж болгоомжилсон нь зөв байсан бололтой. Унтаж эхэлж байсан Стефф хаштиран сэрэв. Зочдын орон дээр унтаж байсан Билли тийчиллээ.

-Өрөөнд ус ороод хамаг юм баллачих байхдаа...

-Одоо яая гэхэв. Мебель тавилгуудыг даатгасан шүү дээ.

-Энэ ч намайг тайвшруулахгүй дэг гэж Стефф гоморхлоо. -Ээжийн чинь хувцасны шүүгээ... Манай шинэ буйдан... Өнгөт зурарт.

-За унт унт.

-Чадахгүй нь гэж тэр хэлсэн ч таван минутын дараа унтчихав,

Би гучаад минут унтсангүй, нэг лаа өөртөө үлдээгээд гадаа шуурга улин исгэрч байгааг чагнан суув. Маргааш нуурын эргэн тойронд амьдардаг олон хүн өөрсдийн даатгалын агентуудыг дуудаж, унаж байгаа модонд дээвэр, цонхoo хэмхлүүлсэн байшигийн эздийн цахилгаан хөрөнүүд хангинаж, замаар эрчим хүчний компаний ягаан машинууд давхилдаж эхлэхийг би дотроо төсөөлөн бодож байлаа.

Шуурга намдаж, дахин ширүүсэхгүй байх гэж бодогдов. Стефф, Билли хоёрыг би орхин дээшилж, байшин хэр хэмхэрснийг хархаар шийдлээ. Хаалга эвдэрсэнгүй, харин том цонх байсан газар эвгүй онгойж, аль эртнээс ургаж байсан хусны мөчрүүд нүхээр нь цухуйна. Энд би Стеффийн даатгуулсан гээд тайвширч чадахгүй гэж хэлснийг саналаа. Би энэ модонд хайртай байсан. Энэ модыг би хэзээ ч хөрөөдөх тухай бодож байгаагүй, бид хоёр олон ширүүн өвлийг хамтдаа өнгөрүүлсэн билээ. Шалаар нэг тархсан шилнүүд лааны гэрэлд гялалзаж, би өглөө Стефф, Билли хоёрт хөл нүцгэн явж болохгүй гэж хэлэх хэрэгтэй юм гэж бодлоо.

Би доош буулаа. Тэр шөнө бид гурав бүгд нэг орон дээр, Стефф бид хоёрын дунд Билли хэвтэн хоноцгоов. Тэгээд шөнө нь би нуурын нөгөө эргээр, Харрисоноор Бурхан явж байна хэмээн зүүдэллээ. Бурхан аварга том, цээжин бие нь цэнхэр тунгалаг тэнгэрт тээр дээр харагдана. Нойрон дундаа би Бурхан газар гишгэхдээ мод мөчрийг хуга дарж явааг сонсож байв. Тэр эргээр тойрон явж, бидэнд, Брижтонд улам ойртож байна. Байшигууд, амбаар саравч, сүүдрэвчүүд түүний өмнө цахилгаан мэт хөхөлбөр цагаан өнгөөр гялалzan шатаж, удалгүй ойр хавьд бүгд утаанд далд орлоо. Манан мэт цагаан утаанд бүрхэгдлээ.

2. Шуурганы дараа. Нортон. Хот орсон нь.

-О-о-о гэж Билли дуу алдав.

Тэр манай газрыг Нортоныхоос тусгаарладаг хашааны дэргэд зогсоод байшингийн зүг чиглэсэн модот гудамжийг харна. Дөчөөд метр урт энэ модот гудамж шороон замд хүрч, тэр зам нь километр илүү үргэлжилсний дараа Канзас-роуд гэдэг засмал замд нийлдэг юм. Тэндээс та ядаж Брижтон хуртэл дуртай зүгтээ явж болно. Би Биллийн харж буй зүг хараад дотор хүйтэн оргив.

-Тийш бүү яваарай хүү минь. Бүр энд ч хэтэрхий аюултай байна.

Билли маргасангүй.

Энэ өглөө яг хонхны дуу мэт цэвэр, тунгалаг байлаа.

Халуун болж байхад нэг л уранхай цоорхой мэт санагдаж байсан тэнгэр харин одоо бараг л намрын цэнхэр өнгөөр туяарна. Хөнгөн салхи салхилж, замаар нарны гэрэл, модны сүүдрийн хар толbonууд хөгжилтэй жирэлзэнэ. Биллийн зогсож буй газраас холгүй исгэрэх мэт чимээ гарч байлаа, тэнд зэрвэс харахад могоян чуулган болж байгаа мэт, энэ нь манай байшингийн цахилгааны утас тасарч, одоо хорьхон метрийн цаана овоорон хэвтэнэ. Заримдаа утаснууд залхуутайгаар хөрвөн эргэж, цахилгааны дөлөөр тургиж байлаа. Хэрэв аадар орж, байшинг сайтар норгож өгөөгүй бол байшин шатаж ч болох байв. Харин одоо бол цахилгаан утас овоорсон тэр хэсэгт л зүлгийг харлатаал нь шатаажээ.

-Ааваа, цахилгаан хүнийг алж чадах уу?

-Чадна, хүү минь.

-Тэгвэл бид яах вэ?

-Яах ч үгүй. Эрчим хучний компаний машиниг хүлээнэ дээ.

-Тэд хэзээ ирэх юм бэ?

-Мэдэхгүй.

-Таван настай хүүхдийн асуултуудад бүгдэд нь хариулах арга байхгүй. -Өнөөдөр тэд маш их ажилтай байгаа. Миний хүү автайгаар гудамжаар явах уу?

Тэр миний араас явснаа цахилгаан утсыг айсан шинжтэй ширтэн зогслоо. Утасны нэг нь овойж ирснээ өөрийн зүг дуудах мэт удаан нумран эргэлээ.

-Аав, цахилгаан газраар явж чадах уу?

Зөв л асуулт байна.

-Чадна, гэхдээ санаа бүү зов. Цахилгаанд чи биш, газар хэрэгтэй. Хэрэв ойртоож очихгүй л бол яах ч үгүй.

-Газар хэрэгтэй... -гэж тэр бувтнаад гүйн ирж, бид хөтлөлцөн гудамжаар цааш явлаа.

Миний бодсоноос бүх зүйл муу байлаа. Зам дээр дөрвөн мод унасны нэг нь жижиг, хоёр нь дунд зэргийн, тэгээд бүр хөгшин аварга том, илжирсэн хувцас өмссөн мэт хөвдөөр хучигдсан, өргөнөөр лав метр хагас хүрэх аварга мод хэвтэнэ.

Навч нь хагас дутуу халцарсан мөчир хаяагүй хэвтэхтул Билли билд хоёр жижиг мөчрүүдийг замаас холдуулан шидэлж явав. Энэ бүхэн хорин таван жилийн өмнө болсон явдлыг надад санагдууллаа. Би тэр үед Билли шиг л байж. Тэр өдөр манай хамаатан эрчүүд бүгд цуглаж, хурц сүх, мод тас цавчдаг сэлэм аван бургас тайрахаар ойн зүг одсон юм. Ажлын дараа билд манай эцэг эхийн барьсан байшингийн гадаах сүүдрэвчтэй урт ширээнд зэрэгцэн суугаад зайдас, махтай пирожки, төмсний салат хэмжээгүй их идэж билээ. Пиво гол мэт урсаж, эцэст нь манай Рубен ах хувцас гуталтайгаа нууранд шумбаснаар найр дууссан юм. Тэр цагт ойд буга хүртэл явдаг л байлаа.

-Аав, би нууранд очиж болох уу?

Тэр мөчир шидэлсээр залхчихаж, харин бага хүүхэд ямар нэг зүйлээс залхвал түүнийг саатуулах хамгийн найдвартай арга бол өөр нэг зүйлээр тоглохыг санал болгох юм.

-Болноо, хүү минь.

Бид хамт байшинд эргэн ирэхэд Билли унасан цахилгаан утсыг холуур гэгч нь тойрсоор баруун тийш гүйж, харин би зүүн тийш явлаа. Энд, гаражинд миний "Макколох" хөрөө байгаа юм. Яг л миний мэдэж байснаар нуурын эргээр нэг цахилгаан хөрөөний дуу хангинаж эхэллээ. Би хөрөөний баканд бензин хийгээд цамцаа тайлж модот гудамжны зүг хөдлөх үед унасан моддыг гайхан харсаар байшингаас Стефф гарч ирлээ.

-Гайгүй юу?

-Аргална аа. Гэрт ямар байна?

-Би шилний хэлтэрхийнүүдийг цэвэрлэчихсэн, гэхдээ Дэвид, чи тэр хус модыг аргалаач. Зочдын өрөөнд мод байх чинь эвгүй шүү дээ.

-Чиний зөв байх аа.

Бид бие биесээ хараад инээлдэж, харин өглөөний нар хурцаар гэрэлтэж байлаа. Би хөрөөгөө үүдний асфальтан дээр тавиад Стеффийг өгзөгнөөс нь атган чанга үнслээ.

-Хэрэггүй гэжтэр шивнэлээ. -Билли...

Яг энэ үед Билли булангаас давхин гарч ирэв.

-Аав! Аав! Тэрийг хараач...

Газар хэвтэх утаснуудыг харсан Стефф болгоомжил хэмээн хашгираа. Цахилгаан утаснаас хангалттай холуур гүйж явсан Билли зогсож ээжийнхээ зүг тэнэг юм хэлсэнд гайхах мэт харлаа.

-Зүгээр л байна шүү дээ, ээжээ гэж Билли хөгшин, тэнэг хүмүүсийг тайтгаруулдаг яг тэр онгөөр хэлээд бидний зүг явав.

Стефф чичирж байна.

-Тайвшир гэж би түүний чихэнд шивнэв. -Би түүнд бүгдийг хэлж өгсөн.

-Тийм л дээ, гэхдээ хүмүүс байнга тогонд цохиулж үхдэг... -гэж Стефф дуугарав. -Зурагтаар үргэлж л тогноос болгоомжлохыг сануулж байдаг, гэтэл хүмүүс... Билли бушуухан гэртээ ор.

-Байз л даа, ээж! Би аавд завины саравчийг харуулах гэсэн юм. -Түүний нүд гомдсон, хөөрснөөс гялалзана. Шуурганы ийм агуу хүчийг мэдэрсэн хүү үзсэн харснаа бусадтай хуваалцахыг хүсч байгаа нь илт.

-Гэртээ ор! Энэ утаснууд аюултай, тэгээд...

-Тэдэнд би биш, газар хэрэгтэй гэж аав хэлсэн...

-Билли, үгэнд ороорой!

-Аав нь одоохон очлоо, харин чи гүй, гүй! -гэж би хэллээ. -Стеффийн бие чангарахыгби мэдрэв. -Байшингийн нөгөө талаар тойрч гүйгээрэй.

-За, за.

Тэр шат алгасан үсэрсээр байшингийн баруун талаар давхин одов. Гүйснээс түүний цамц өмднөөсөө мултарчихсан, булан тойрмогц шуурганы эвдрэлийг дахин олж харсныг нь илтгэх "О-о-о!" гэж хашгирах сонсогдлоо.

-Стефф, тэр мэдэж байгаа гэж би түүний мөрөн дээр нь гарaa тавин хэллээ. -Тэр цахилгаанаас айдаг, тэгэхээр аюулгүй гэсэн үг.

Стеффийн нүдэнд нулимс цийлэгнэв.

-Дэвид, би ч бас аиж байна.

-Юу гэсэн үг вэ? Бүгд сайхан дууссан шүү дээ.

-Чи итгэлтэй байна уу? Хачин хүйтэн өвөл болсон... дараа нь хавар оройтсон... хотынхон энэ хаврыг Хар Хавар гэдэг, ийм хавар энд бүр 1888 оноос хойш болж байгаагүй гэж ярыцгааж байна...

"Ярьцааж байна" гэдэг нь Стефф хааяа ордог элдэв хуучны хог новшны "Брижтоны ховор хуучны эдлэл" гэдэгдэлгүүрийн эзэн хатагтай Кармоди л даа. Билли эхтэйгээ энэ дэлгүүрт орох их дуртай. Тэр дэлгүүрийн тоос шороотой арын өрөөнүүдийн нэгэнд алтаар нүдийг нь эмжсэн, далавчaa дэлгэн модон дээр сууж буй шар шувууны чихмэл, тоос болсон толиор хийсэн голын дэргэд зогсож буй гурван илбэнх, тэр бүү хэл араа шүдээ аймшигтайгаар үүрд мөнх яrzайлгасан, гэхдээ амнаас нь шүлсний оронд модны үртэс гоожиж байдаг чонын чихмэл хүртэл бий. Хатагтай Кармоди энэ чоныг 1901 онд Стивен-Брук голоос ус ухаар ирэхэд нь аав нь буудаж агнасан гэж ярьдаг.

Хуучны энэ дэлгүүрээр орох нь Стефф, Билли хоёрт бөөн таашаал авчирдаг байв. Стефф элдэв шилэн гоёл үзэж харан саатаж, энэ үед Билли "чихмэл болохын төлөөх үхлийг харна". Гэхдээ надад дэлгүүрийн эзэн эмгэн Стеффийн сэтгэл санаанд сүрхий муугаар нөлөөлж байх санагддагбайлаа. Өөр бусад талаар ухаалаг, сэргэлэн Стефф эмгэний урхинд орсон олон хүний адил эртний готуудын элдэв зурхай, бөө, домын арга чарганд (түүнийгээ үргэлж Бурханы сургааль гэдэг) орчих гээд байсан юм.

Хэрэв нөхөр чинь гурван стакан уусны дараа эхнэрээ зодчих гээд байдаг бол өмхөрсөн хожуулын ус хөхрөлтийг дорно арилгана. Долдугаар сард өтний үрчлээсүүдийгтоолоод, эсвэл наймдугаар сард зөгийн сархинагийн зузааныг хэмжээд өвөл хэзээ ирэх, ямар болохыг хэлж болно. Харин одоо, бурхан минь, 1888 оны хар хавар дахин ирлээ (анхаарлын тэмдгийг та хүссэн хэмжээгээрээ тавьж болно). Би ч бас энэ түүхийг сонссон. Энд хэрэв хавар хүйтэн байвал голын мөс хорхойтсон шүд шиг хар өнгөтэй болно гэдэг.

Мэдээж, ховор үзэгдэл, гэхдээ зуун жилд ганц удаа нь ч юу юм. Гэхдээ л энэ тухай ярьсаар байдаг, харин би хатагтай Кармодигаас өөр ингэж итгэлтэй ярьдаг хүн ховор гэж боддог.

-Зүгээр л хүйтэн өвөл болсон, дараа нь хавар оройтсон гэж би хэллээ. -Одоо халуун зун болоод байна. Шуурга намдаад бүх зүйл дууслаа. Чи ухаалаг хүн шүү дээ, Стефени.

-Энэ зүгээр шуурга байгаагүй гэж Стефф сөөнгө дуугаар хэллээ.

-За яахав, үүнийг би зөвшөөрч байна.

Хар Хаврын тухай би Каско Виллиж дэх "Мобиль Жости"-ийн эзэн, бас удирдагч Билл Жостигоос сонссон юм. Түүний удирдлагын дор гурван архичин хүү нь ажилладаг байсан. Тэдэнд нь өөрсдийн мотоцикл, цасны моторт чарганаасаа салсан үедээ дөрвөн архичин ач нар нь тусална. Билл дал хүрсэн, гаднаас нь хараад наятай юм шиг, гэхдээ онгод нь орсон үед хорин гуравтай юм шиг ууж чаддаг эр. Манай нутагт нэг удаа тавдугаар сарын дундуур нялх зүлэг, цэцгийг бүрхсэн өвдгөөр татам нойтон, хүнд цас ороход Билл Жости бид хоёр тэдний шатахуун түгээгүүрийн газрын тийш би "Скaut"-аа жолоодоод хамт явж байсан юм. Билл татчихсан явсан болохоор Хар Хаврын тухай дуртай ярьсан. Гэхдээ энэ нутагт үнэхээр заримдаа тавдугаар сард цас ороод хоёр хоногийн дараа хайлчиҳдаг. Гайхаад байх юм ер байхгүй.

Стефф унасан цахилгаан утсыг дахин түгшин ширтэв.

-Эрчим хүчнийхэн хэзээ ирэх юм бэ?

-Чадах болмогц л ирнэ биз. Удахгүй. Бас Биллид санаа бүү зов. Тэр чинь ухаантай хүү байгаа юм. Тэр заримдаа хувцсаа эвхэж хураахаа мартдаг л биз, гэхдээ хэзээ ч тогтой утсан дундуур гүйхгүй. -Би Стеффийн уруулд хуруугаа зөөлөн хүргэхэд тэр инээмсэглэв.

-Арай дээрдэв үү?

-Чамтай ярихаар үргэлж л дээрддэг гэж Стефф хэлэхэд надад ч бас дээрдэх шиг боллоо.

-Тэгвэл явж нурангийг үзье.

-Үүний тулд надад зочдын өрөөндөө ороход л хангалттай гэж Стефф гунигтай өгүүлэв.

-Үгүй ядаж хүүгээ очиж харъя л даа.

Бид хөтлөлцсөер чулуун шатаар бууж, дөнгөж булан тойртол Билли үсрэн гарч ирээд золтой л мөргөчихсөнгүй.

-Чи юу болоод л давхиад байна аа? -гэж Стефф хөмсөг зангидал асуулаа. Билли хальтираад өнөөх утаснууд руу яваад орчихно гэж тэр айсаар л байгаа бололтой.

-Хурдлаарай! -гэж Билли аахилан хашгичлаа. -Завины саравчийг бяц дарчихаж! Зогсоолыг эрэг дээр шидээд, манай буланд нэл мод дүүрчихсэн байна! Чөтгөр гэж, юу болж байна аа?

-Билли Дрэйтон! -гэж Стефф дуу алдлаа.

-Ээ, дахиж ингэхгүй, ээжээ... Хурдлаарай... -тэр дахин алга болов.

-Би зам дээрх моддыг огтолж, цэвэрлээд Портлэнд-роуд орж "Мэн мужийн Эрчим хүчний компани"-д хандаад энд юу болсныг хэлээд өгье, за юу гэж би хэллээ.

-О'Кей. Хэзээ явах вэ?

-Өнөөх аварга том хөгшин модыг эс тооцвол цагийн дотор л замыг цэвэрлэчихнэ. Харин тэр модтой ч би лав арван нэг хүртэл ноцолдох байх.

-Тэгвэл би чамд өглеөний цай аваад ирье. Харин чи дэлгүүр орж ганц нэг юм авах хэрэгтэй. Манай сүү, масло бараг дуусч байна. Бас... Ер нь би чамд бичээд өгчихье.

Байгалийн гамшиг дуусмагц л эмэгтэй хүн хэрэм мэт загнаж, хоол хүнс цуглувулж, нөөцөлж эхэлдэг. Би Стеффийн мөрөөр тэврэн, хоёул байшингийн буланг тойрлоо. Энд Билли яагаад тэгж сүйд болсны учир анхны харцаар л тайлгадав.

-Бурхан минь гэж Стефф сулхан дуугарлаа.

Бидний зогсож байгаа газраас эргийн бараг километр газар харагдаж байлаа: манай зүүн

талд Бибберийн эдлэн газар, манай өөрийн газар, тэгээд Нортоны газар баруун талд.

Манай завины зогсоолын дэргэд ургасан аварга том нарс тэг дундуураа хугарчээ. Модноос үлдсэн хэсэг нь муу үзүүрлэсэн аварга том харандаа мэт газраас ёрдойж, харласан хальсыг нь бодвол хугарсан хэсэг хачин арчаагүй цагаан харагдана. Гучаад метр өндөр энэ модны нөгөө хэсэг нь унаж, манай булангийн усанд хагас нь далд оржээ. "Стар-Крузер" гэдэг завь маань сурхий азтай юм: долоо хоногийн өмнө түүний мотор эвдрээд би засуулахаар Нейплэд аваачсан байлаа.

Манай бяцхан газрын нөгөө буланд аавын маань барьсан завины саравч модонд бяц даруулчихсан харагдана. Дрэйтоны гэр бүлийн хөрөнгө одоогийнхоос их байсан үед барьсан саравчинд тэр цагт хорин метр урт "Крис-Крафт" зогсдог байсан. Унасан мод харин Нортоны газарт ургадагбайсныг хараад миний уур хүрэв. Энэ мод бүр таван жилийн өмнө үхэж хатаад, түүнийг Нортон хэдийнэ тайрч унагах ёстой байсан. Харин одоо мод унаж, түүнийг яжийж хонхойсон дээврээрээ манай саравч тулж байв. Билли бяц даруулсан гэхдээ нэг их хэтрүүлсэнгүй.

-Энэ чинь Нортоны мод байна шүү дээ! -гэж Стефф дуу алдахад хоолойнд нь жигтэйхэн уур хилэн сонсогдож, би сэтгэл өвдөж байсан ч өөрийн эрхгүй инээмсэглэлээ.

Туг ишний хамт усанд хөвж явна. Би Нортоны "Тэгээд чи намайг шүүхэд өг л дөө" гэж хариулж байгааг дотроо төсөөлөв. Билли давалгаа бутлагч дээр гарчихсан цэнхэр, шар өнгөөр будсан зогсоол эрэг дээр хэвтэж байгааг харж байна. Эргэж хараад тэр баяртайгаар хашгирав:

-Энэ Мартинсын зогсоол, тиймуү?

-Яг зөв гэж би хэллээ. -Их Билл, усанд орж, тугийг авбал ясан юм бэ?

-Одоохон.

Давалгаа бутлагчийн баруун талд бяцхан элсэн шарлагын газар байдаг. 1941 оны Пёрл Харборын сүйрлийн өмнөхөн аав маань бүтэн зургаан ачааны машин элс энд авчирж, ус миний цээжээр татахаар байлгахын тулд нуурын яг энэ хэсэгт асгах хүн хөлслөх гэжээ. Цаадах нь тэр үеийнхээр лут мөнгө болох наян доллар авна гэж, тэгээд л элс эрэг дээр үлдсэн гэдэг. Харин одоо эдлэн газартаа наран шарлагын газар байгуулахыгхориглодог болсон, энэ ч зөв байх. Үйлдвэрүүдийн хаягдал ус нуурын бараг бүх загасыг устгаж, амьд үлдсэнийг нь идэхэд аюултай болсон энэ үед Байгаль орчныг хамгаалах газрынхан хувийн наран шарлагын газрууд барьж байгуулахыг хоригложээ.

Билли тугийг аврахаар ус руу зүтгэнээ зогслоо. Стефф хэрхэн харж байгааг анзаарсан би ч нуурын зүг хараад учрыг ойлгов.

Харрисоны талын бүх эрэг нарлаг өглөө дошилдог цагаан үүлтэй төстэй мананд хучигдан үзэгдэхээ байжээ. Өчигдөр шөнийн зүүд дахин санаанд орж, энэ юу байж болох тухай Стеффиг асуухад би золтой л "Бурхан" гэчихсэнгүй.

-Дэвид?

Эргийн шугамын бараа ч алга, гэхдээ би Лонг-Лэйк нуурын эсрэг талын эргийг наснаасаа олон удаа харж байсан болохоор шугамдсан мэт тэгш цагаан манан нуурын усанд ердөөл хэдхэн метр орсон мэт санагдлаа.

-Аав, энэ юу вэ? -гэж өвдгөө хүртэл усанд зогсоод тугийг авахаар гараа сарвайх Билли хашиграа.

-Манан.

-Нууран дээр үү? -гэж Стефф эргэлзсэн шинжтэй асуухад нүдэнд нь хатагтай Кармоди харагдах шиг болов. Энэ эмгэнийг чөтгөр аваасай. Харин би өөрөө бараг л айхаа болжээ, зүүд гэдэг бас л манан шиг хийсвэр эд.

-Тэгээд яагаав. Чи нууран дээрх мананг хэзээ ч үзээгүй юм уу?

-Иймийг хэзээ ч үзээгүй. Энэ чинь үүл шиг юм.

-Нарны хурц гэрлээс ингэж харагдаж байгаа юм гэж би хэллээ. -Үүлэн дээгүүр онгоцоор нисэхэд иймэрхүү байдаг шүү дээ.

-Гэхдээ энэ манан хаанаас гараад ирсэн юм бэ? Энд манан зөвхөн бороотой чийглэг өдрүүдэд л байдаг шүү дээ.

-Зөвхөн чийглэг үед биш гэдгийг чи өөрөө харж байгаа биз дээ. Ямар ч байсан Харрисонд. Энэ бол ердөө л шуурганы үр дүн. Агаарын хоёр фронт мөргөлдөөд. Эсвэл нэг тиймэрхүү л юм болсон биз.

-Дэвид, чи итгэлтэй байна уу?

Би түүний хүзүүгээр тэврэн инээд алдлаа.

-Үгүй, үнэндээ бол би санаанд орсноо л бурж байна. За тэр ч яахав. Явж авах юмныхаа бүртгэлийг гарга даа.

Стефф дахин намайг итгэл муутайхан хараад дараа нь нарнаас гараараа халхлан байж мананг ширтэв. Тэгээд толгой сэгсэрлээ.

-Энэ бүхэн нэг л хачин санагдаад байна гээд тэр гэрийн зүг явлаа.

Биллийн хувьд энэ байгалийн хачин үзэгдэл тун хурдан сонирхолгүй болжээ. Тэр тугийг уснаас чирэн гаргаж ирээд зүлгэн дээр хатаахаар дэлгэлээ.

-Аав, тугийг газар дэлгэж болдоггүй гэсэн тиймээ гэж тэр ажил хэрэгч хүний асуудлыгхурдан нэг тийш болгох эргэлзээгүй өнгөөр асуулаа.

-Тийм үү?

-Тийм. Ийм хэрэг хийсэн хүнийг цахилгаан сандалд суулгадаг гэж Виктор Макалистер хэлсэн.

-Чи тэр Виктортоо толгойд нь тархины оронд зүлэг сайн ургадаг нэг юм дүүрэн байна гэж хэлээрэй.

-Шавар уу? -Билли сэргэлэн хүү, харин тоглоом наадмыг ойлгохдоо жаахан тиймэрхүү.

Энэ насанд тэд бүхнийг тун анхааралтай, үнэнэсээ хүлээн авдаг, гэхдээ тэр энэ хорвоод хангалттай удаан амьдарч, манай өртөнцөд тэгж амьдрах нь аюултай гэдгийг ойлгож авна гэж би итгэжбайгаа юм.

-Хм, тийм, гэхдээ ээждээ намайг ингэж хэлсэн гэж битгий хэлээрэй. Туг хатахаар хоёулаа эвхээд авчихна. Бүр найдвартай хадгалахын тулд ковбой малгайнд хийгээд тавьчихсан ч болно шүү дээ.

-Аав, бид саравчаа засаад, тугаа хатгана тиймээ? -Энэ өглөө тэр анх удаа санаа зовсон шинжтэй харагдлаа. Эвдрэл сүйтгэлийн дүр зураг түүнд эвгүй санагдаж эхлэв бололтой.

-Хүү минь, бүү яар гэж би мөрөн дээр нь гараа тавин хэллээ.

-Би Бибберийнд очиж, тэднийх ямар болсныг хараад ирж болох уу?

-Удахгүй шүү, таван минут л байгаарай.

Тэд ч бас засвар хийх гэж байгаа, энэ үед хүмүүс тун ууртай байдаг. Би өөрөө ч одоо Нортонд тиймэрхүү л хандаж байна.

-О'Кей, би явлаа тэр гүйхээр завдав.

-Битгий олон юм яриад, ажилд нь саад болоод байгаарай, за юу. Бас... цахилгаан утаснаас холуур явна шүү.

-За, ааваа.

Би эвдэрсэн саравчийг, дараа нь манангийн цагаан зурvasыг харлаа. Манан ойртсон ч юм шиг, гэхдээ баталгаатай хэлэх арга алга. Хэрэв тэр ойртоож байгаа бол байгалийн хамаг хуулийг зөрчиж байна гэсэн үг, учир нь хөнгөн сэвэлзүүр салхи бидний зүгээс үлээж байсан, тэгэхээр манан ойртох ямар ч боломжгүй. Манан дун цагаан өнгөтэй юм. Ерөөсөө л дөнгөж саяхан унасан шинэ цас цэнхэр тэнгэрийн наана тун содон харагддаг шиг. Гэхдээ л цас нарны туяанд түмэн оддоор гялалзаж байдаг, гэтэл энэ хачин хурц цагаан манан огтхон ч гялалзахгүй юм. Стефф гайхаж байсан ч ийм цэлмэг тунгалаг өдөр манан татах нь тийм ч ховор үзэгдэл биш, гэхдээ манан өтгөн бол агаарын чийгнээс бараг үргэлж солонго татдаг, харин энэ удаа солонго ч алга.

Бас дахиад л сэтгэлд түгшүүрийн дохио хангинах шиг болсон ч тэр бүхнийг эзэмдэж амжсангүй, гэнэт "чух-чух-чух" гэсэн төмрийн дуу хадаж, араас нь "Чөтгөр!" гэж хараах сонсогдов. Моторын дуу дахин дуугараад чимээгүй болоход эзэн нь юм хэлсэнгүй, гуравдах удаа хахаж цацан чимээгүй болоход эзэн нь өнөөх өнгөөр "Муу новшийг..." гэх сонсогдлоо. Асуудлыг хурдхан шийдэх гээд мөн л хурдан сэтгэлээр унасан хүний өнгөөр.

"Чух-чух-чух-чух..."

Чимээгүй.

Тэгснээ: "Хар үмхий!"

Би өөрийн эрхгүй инээмсэглэлээ. Энд юм сайн сонсогддог, тэгээд ч жунгинах моторт хөрөөнүүд хол байсан, харин би хажуухандаа миний хөрш, нэртэй өмгөөлөгч, бас нуурын эрэг дээрх газрын эзэн Брент Нортоны нэг их сайхан гэмээргүй хоолойг сонслоо.

Эрэгт ойртоод би зүгээр л зугаалж яваа дүр үзүүлэн эрэг дээр хэвтэх зогсоолын зүг явлаа. Эндээс Нортон харагдаж байна. Тэр будаг болсон жинс, футболк өмсчихсөн байшигийнхаа гадаа зогсоно. Дөчин доллар төлж засуулсан ганган халимаг нь сэгсийж. нүүрээр нь хөлс урсаж харагдана. Тэр өрөөсөн хөл дээрээ өвдөглөн суугаад моторт хөрөөгөө асаах гэж оролдож байна. Түүний хөрөө миний 74,95 долларын хөрөөнөөс хамаагүй мундаг, хүчтэй харагдав. Тэнд старчериин товчлуураас бусад нь бүгд байх шиг, тэгээд Нортон оосроос татаж, "чух-чух-чух" гэсэн дуу гаргаж байлаа. Түүний агаарт хооллож байх гэж барьсан саравчин дээр хус мод унаад бяц дарчихсныг хараад би сэтгэлийнхээ гүнд баярлах шигболов.

Нортон дахин олсноос угзарлаа.

"Чух-чух-чух-чух-чух-чох-чох-чох! Чух-чух".

Барагл асаачих шахлаа даа, анд минь.

Бас дахин Херкулесийн угзралт.

Чух-Чух-Чух.

-Үмхий чөтгөр! -гэж Нортон ганган хөрөөгөө яrzайн харж хилэгнэн шивнэлээ.

Би гэж энэ өглөө анх удаа сэтгэл амарчихсан амьтан байшиндаа эргэн ирэв. Миний хөреө ганц угзрахад л хүржигнэн асч, би ажилдаа шамдан орлоо.

Арван цагийн үед хэн нэгэн мөрөн дээр минь алгадлаа. Эргэж хараад Билли ард нэг гартаа лааз пиво, нөгөө гартаа Стеффийн бичсэн цаасыг барин зогсож байхыг харав. Худалдаж авах зүйлсийг тоочсон цаасыг хумхиж арын халаасандаа хийгээд би лаазыг авч мөс шиг гэхэд хаашаа юм, гэхдээ л хүйтэн пивыг авч Биллийн зүг дохиод балгалаа.

-Баярлалаа, жаалхан минь.

-Би жаахан ууж болох уу?

Би түүнд ганц балгууллаа. Билли ярвайгаад лаазыг буцаан өгөв.

-Ээж бас нэг юм бичээд байсан, би уншиж чадаагүй гэж Билли хэллээ.

"Радиогоор ВОКСО-г ерөөсөө барьж чаддаггүй, шуурганаас болоод нэвтрүүлэг хийхгүй байгаа юм болов уу?" -гэж Стефф бичжээ.

"ВОКСО" - гэдэг бол урт долгион дээр рок - хөгжим явуулдаг орон нутгийн автомат радиостанц. Станц хойд зүгт гуч гаран километрийн зайд орших Норвей хотоос нэвтрүүлэг явуулдаг тэгээд ч энэ нь манай хуучин радиогийн барьж чадах ганц нэвтрүүлэг юм.

-Ээждээ "Тийм байх" гэж хэлээрэй хэмээн асуултыг уншиж өгсний дараа Биллид даалгавар өглөө. -Тэгээд ээж нь богино долгиноор Портлэндийг барих гээд үзэг.

-О'Кей. Аав, би тантай хамт хот явж болох уу?

-Бололгүй яахав. Ээж нь ч хүсвэл хамт явж болно.

-О'Кей. -Билли гэрийн зүгухасхийв.

Аварга том модонд хурмэгц би эхний хөрөөдөлтийг хийж дуусгаад бага зэрэг хөргөхийн тулд хөрөөг унтраав. Үнэндээ энэ мод миний хөрөөнд дэндүү том байсан боловч эвийг нь олж, тайван үзвэл би аргалж чадна гэж бодсон юм. Дараа нь Канзас-роудын замыг цэвэрлэсэн болов уу гэж дөнгөж бодтол моддын дундаас эрчим хүчний компаний ягаан машин манай богинохон замын эцэст хүрэх бололтой гарч ирлээ. Тэгэхээр бүх юм зүгээр, үд дунд гэхэд манай байшингийн цахилгааныг засварчид янзалж эхэнэ гэж найдаж болох нь. Дараа нь би том гэгчийн тайрдас хөрөөдөж, замын хажуу руу чирэн аваачаад доош түлхэв. Тайрдас өнхөрсөөр бас над шиг зураач аав, ах нар маань тайрснаас хойш дахин өтгөн ургасан бургасан дунд далд орлоо. Дрэйтоныхон бид бүгд зураачийн гэр бүлийн улс.

Би хөлсөө арчаад ганц лааз пиво сэтгэлийг улам бухимдуулдаг юм байна, дахиад уухсан гэж бодлоо. Дараа нь би дахин хөрөөдөж эхэлсэн ч ВОКСО-гийн тухай бодол сэтгэл түгшээж байв. Яг тэндээс энэ хачин манан наашилж эхэлсэн юм. Тэгээд бас тэнд "Сум" төсөл" байрладаг Шеймор хотхон байдаг.

Энэ "Сум" төсөл" нь Билл Жостиин хувьд Хар Хаврын бас нэгэн нотолгоо байлаа. Хотхоны баруун талд, Стонхэмтэй хиллэдэгтэр хэсэгт үнэхээр өргөст торон хашаагаар хүрээлсэн Засгийн газарт хамаардаг хэсэг газар байдаг. Бүсийг тойроод цэргүүд хамгаалдаг, бас телекамер энэ тэр гээд бурхан л мэдэх элдэв хамгаалалттай. Ямар ч байсан би тэгж сонссон.

Хориотой бүсийн зүүн талаар бараг бүтэн хагас километр хэр Шеймор орох хуучин засмал зам үргэлжилдэг ч би өөрөө тэнд очиж үзээгүй. Хэн ч энэ "Сум" төсөл" гэдэг нэрийг яагаад өгснийг хэлж чаддаггүй, бас хэн ч энэ нэр үнэхээр төслийн нэр мөн эсэхийг мэддэггүй, тэнд ямар нэгэн ажил явагдаж байгаа эсэхийг ч хэлж чаддаггүй. Билл Жости тэнд ажил явагдаж байгаа гэдэг, чи хаанаас, яаж олж мэдсэн юм гэхээр элдэв юм яриад, бултаад эхэлдэг. Түүний

хамаатан бүсгүй "Континенталь" телефон утасны компанид ажилладаг, тэгээд заримдаа сонин юм сонсдог, энэ тэр гээд л.

-Энэ бүхэн атомын ажил гэж тэр нэг удаа "Скаут"-ын цонхыг налж над руу пивоор амьсгалан хэлж билээ. -Түүн дээр л тэнд ажилладаг. Агаарт атомаар буудаж бариад л.

-Ноён Жости, агаарт тэртэй тэргүй дүүрэн атом байгаа гэж ярианд Билли оролцлоо. -Хатагтай Нири тэгж хэлсэн. Атом хааяагүй, дүүрэн байдаг гэж Нири эгч хэлсэн.

Билл Жости улайрсан нүдээрээ миний хүүг удаан ширтсэний эцэст хүү маань айчих шиг болсон.

-Хүү минь, тэр чинь шал өөр атом.

-Ө-ө-ө, тиймүү гэж Билли бувтнаж билээ.

Манай даатгалын агент Дик Мюллер болохоор "Сум" төсөл" бол ердөө л Засгийн газрын Хөдөө аж ахуйн туршилтын станц гэж хэлж байсан.

-Илүү удаан үр өгч чадах том улаан лоольнууд гэж Дик гүн бодолд автан байж хэлээд, хэрэв би залуугаараа үхвэл гэр бүлдээ ямар их туслахыг тайлбарлах ажилдаа эргэн орсон билээ.

Шуудан зөөгч Женина Лоулес тэнд геологийн ажил явагдаж байгаа, занарын тос олборлох юм гэнэлээ гэж ярьсан. Тэр энэ тухай яг мэднэ, яагаад гэвэл нөхрийн нь ах...

Хатагтай Кармоди... тэр Билл Жостийн бодолд илүү ойр байх шиг. Зүгээр атом биш, өөр атом.

Аварга модноос би хоёр тайрдас огтлоод байхад Билли нэг гартаа лааз пиво, нөгөө гартаа ээжийнхээ бичсэн цаасыг барьчихсан дахин ирэв. Их Билл ингэж нааш цааш гүйхээс өөр ямар ажилд илүү дуртайг нь би төсөөлж ч чаддаггүй юм.

-Баярлалаа гээд би түүнээс цаас, пиво хоёрыг авлаа.

-Би нэг балгаж болох уу?

-Ганц л балгыг. Түрүүн чи хоёр балгасан. Би чамайг өглөөний арван цагт согтуу гүйж явахыг чинь хармааргүй байна.

-Арав хорь болчихсон шүү дээ гэж Билли лаазны ам руу муухан инээмсэглэн хэллээ. Би ч бас инээмсэглэлээ. Сүйтэй инээдтэй ч юм хэлээгүй л дээ, гэхдээ хүү маань ховорхон алиялж тоглодог юм. Дараа нь би бичгийг уншлаа.

"Жей-Ви-Кью"-г барилаа гэж Стефф бичжээ. -Хот явахаасаа өмнө битгий согтчихоорй. Би чамд дахиад нэг лааз явуулна, тэгээд л болоо. Зам чөлөөлөгдсөн болов уу?"

Би хүдээ бичгийг өгөөд пивоо буцааж авлаа.

-Зам чөлөөтэй, эрчим хүчнийхэн өнгөрөхийг харсан, тэд удахгүй манайд ирнэ гэж ээждээ хэл.

-О'Кей.

-Хүү минь...

-Юу вэ, ааваа?

-Ээждээ бүх зүйл сайхан гэж хэлээрэй.

Билли бүхнийг эхнээс нь давтах мэт дуугүй инээмсэглээд "О'Кей" гэж хэлээд гүйн одлоо. Би түүнийг ширтэж, тэр хөлөөрөө газрыгхүчлэн жийж байгааг, гутлын нь ул гялалзаж байгааг харан зогслоо. Би хүүдээ хайртай. Түүний царайнд юу ч юм байдаг, тэгээд тэр заримдаа над руу харж байхад энэ амьдралд бүх зүйл сайхан байгаа мэт надад санагддаг. Мэдээж хэрэг, энэ худлаа, бидний ертөнцийн амьдралд хэзээ ч бүх зүйл сайхан байдаггүй, хэзээ ч тийм байгаагүй. Гэхдээ миний хүү энэ худалд намайг заримдаа итгүүлдэг юм.

Би жаахан пиво уугаад лаазыг чулуун дээр болгоомжтой тавьсны дараа дахин хөрөөгөө авлаа. Хориод минутын дараа дахин хэн нэгэн мөрөн дээр зөөлөн алгадаад би Билли ирчихлээ гэж бодсоор эргэлээ. Гэтэл энэ бол Брент Нортон байсан тул би хөрөөгөө унтраав.

Тэр ердийнхөөсөө шал өөр болчихож. Тэр хөлөрчихсөн, ядарсан, зовсон, бас жаахан балмагдсан харагдана.

-Сайн уу, Брент гэж би хэллээ.

Сүүлчийн удаа бид хэрэлдэх дөхөж ширүүхэн салсан болохоор одоо би яахаа мэдэхгүй байлаа. Тэр миний ард таван минут зогсоод хөрөөний нижигнэх дуун дор хоолойгоо засаж байгааг би төсөөлөн бodoод инээчих шахав. Энэ зун би түүнийг олигтой хараа ч үгүй. Тэр турсан боловч дээр харагдахгүй л байна. Уг нь тэр долоо-найман килограмм илүү жин хаясан болохоор дээрдэх л ёстой байсан. Түүний эхнэр өнгөрсөн арван нэгэн сард нас барсан юм. Хорт хавдар гэж тойргийн бүхнийг мэдэгч нэг авгай ярьж байсан. Тойрог бүрд нэг тийм авгай байдаг. Эхнэрээ хэрхэн зовоодгийг (хөгширч ядарсан буханд ар араас нь жад зоож байгаа хашир туршлагатай матадор мэт) тэр үүнд бараг л баярлах байх гэж би бодсон. Хэрэв надаас цааш юу болохыг асуусан бол би ирэх зун тэр өөрөөс нь хорь дүү хүүхэнтэй, нүүрэндээ царцсан тос шиг тэнэг инээмсэглэлтэй ирнэ гэж хэлэх байлаа. Гэтэл тэнэг инээмсэглэлийн оронд нүүрэнд нь үрчлээс, хаван нэмэгдэж, тэдгээр нь шал өөр түүх өгүүлж байв. Хэдэн хором надад түүнийг нартай газар аваачиж суулгаад лаастай пивоороо дайлж, бас хөргийг нь нүүрсээр зурах хүсэл төрлеө.

-Сайн уу, Дэйв гэж тэр хөрөөний пижигнэхээс ч чанга мэт надад санагдсан хэдэн хормын дараа дуугарав. Дахиад хэсэг дуугүй зогссоны дараа тэр бувтнав. -Энэ новшийн мод... Учлаарай. Чиний зөв байж.

Намайг мөрөө хавчихад тэр бувтнав:

-Бас нэг мод миний машин дээр унасан.

-Харамсалтай байна гэж би эхэлснээ гэнэт аймшигт сэжиглэлд автан дуугүй боллоо. -"Ти-бёрд" гэжүү?

-Тиймээ, түүн дээр.

Нортонд дөнгөж тавин мянга явсан маш сайхан "Тандербёрд" байдаг юм. Гадна, дотроо бараан цэнхэр өнгөтэй машинаа тэр зөвхөн зун, тэгэхдээ тун бага унадаг байсан. Өөрийнхөө "Бёрд" -ыг тэр зарим хүн сайхан морь, жижиг галт тэрэг, ангийн ховор буундаа ханддаг шиг хайлрадаг байлаа,

-Ээ, балар гэж би үүнийг чин сэтгэлээсээ хэлсэн юм.

Тэр толгой сэгсрэв.

-Уг нь би өөр машинаар нааш ирэх гэж байгаад "Чөтгөр гэж, яагаад болохгүй гэж" гээд л "Бёрд" -аа унаад ирсэн. Тэгээд хуучин ялзарсан нарс мод дарчихлаа. Дээд хэсэг байхгүй, дотогш нь чихээд хаячихаж. Би тас хөрөөдье гэж бодсон. Тэр, нарсыг. Гэтэл новшийн хөрөө асдаггүй. Би хоёр зуун доллар төлсөн, тэгэхэд...

Түүний хоолойноос хачин чимээ гарч, уруул нь өнгөрснөө зажилж буй шүдгүй эмгэнийх шиг хөдлөв. Тэр хүүхэд шиг уйлж орхих нь гэж би бодсон боловч тэр биеэ барьж, мөрөө хавчаад миний хөрөөдсөн тайрдсуудыг харж байгаа дүр үзүүлэн эргэлээ.

-За яхав, хөрөөг чинь үзье гэж би хэллээ. -Чи "Ти-бёрд"-аа даатгасан уу?

-Тиймээ гэж тэр хэлэв. -Чиний саравчтай адилхан.

Стефф даатгалын тухай хэлэхдээ юу бодож байсныг би одоо мэдэрлээ.

-Дэйв, сонсооч, чи надад "Сааб" -аа нэг унуулчихгүй юу. Би хот орж, дэлгүүрээс жаал жуул юм авмаар байна. Талх, жаахан идэх юм, тэгээд пиво. Их пиво авна.

-Билли бид хоёр "Скаут" -аараа хот орох гэж байгаа гэж би хариуллаа. -Хүсвэл бид хоёртой цуг яв. Харин эхлээд энэ хэдэн тайрдсыг замаас зайлцуулах хэрэгтэй, чи туслах уу?

-Дуртай туслана.

Тэр модны нэг үзүүрээс барьж авсан ч хөдөлгөж ч чадсангүй, хамаг ажлыг би ганцаар шахам хийж дуусгалаа. Гэхдээ л ямар ч байсан бид том модыг замаас зайлцуулж доош унагав. Нортон учиргүй аахилж, амьсгaa нь ер дарагдаггүй, нүүр нь час улаан болжээ. Үүнээс өмнө хөрөөнийхөө старчериyg очнөөн удаа чангаасан, тэгээд би Нортоныг цус харваж орхих вий гэж айв.

-Зүгээр биз? -гэж намайг асуухад тэр уухилан толгой дохив. -Тэгвэл манайд очьё. Чамайг пивоор дайлна.

-Баярлалаа гэж тэр хэллээ. -Стефени сайн биз дээ?

Миний дургүй хүрээд байдаг өнөөх өөгүй гялтайсан соёлтой байдал нь түүнд эргэн ирж байгаа бололтой.

-Зүгээр, баярлалаа.

-Хүү чинь?

-Тэр ч сайн.

-Сонсоход таатай байна.

Байшингаас Стефф гарч ирээд намайг хэнтэй ирж явааг хараад гайхсан шинжтэй зогтуслaa. Нортон ч түүний бариу нимгэн цамцны цаанаас товоих цээжийг нь харцаараа илж таалан инээмсэглэв. Тэр хуучнаасаа үнэхээр нэг их өөрчлөгдөөгүй л бололтой.

-Сайн уу, Брент гэж Стефф болгоомжтой дуугарахад тэр дороо суган дороос нь Билли толгойгоо цухуйлгалаа.

-Сайн уу, Стефени, сайн уу, Билли.

-Брентын "Тандербёрд" -ыг шуурга баллаад хаячихаж гэж би хэллээ. -Бүхээгийг нь нь цөм цохичихсон гэнэ.

-Юу гэсэн үг вэ...

Бидний дайлсан пивыг балган байж Брент болсон явдлыг дахин ярилаа. Би гуравдахъ лаазтайгаа ууж байсан ч толгойд ч шуутисангүй, энэ халуунд хамаг юм хөлсөөр урсаж гараад байгаа бололтой.

-Брент бидэнтэй хамт хот явна.

-Жаахан удах л байх даа. Та нар Норвейн дэлгүүр ч орох хэрэг гарч магад.

-Яагаад?

-Хэрэв Брижтонд цахилгаан байхгүй бол...

-Дэлгүүрийн кассны бүх аппаратууд цахилгаанаар ажилладаг гэж ээж хэлсэн Билли.

-Зөв л хэлж байна...

-Чи миний өгсөн цаасыг хаячихаагүй биз?

Би арын халаасаа алгадлаа, харин Стефф харцаа Нортонд шилжүүлэв.

-Би Карлагийн тухайд маш их харамсаж байна, Брент. Бидэнд бүгдэд маш их харамсалтай

байна.

-Баярлалаа гэж Брент хариуллаа. -Та нарт баярлалаа.

Хэсэг чимээгүй болсны дараа Билли дуугарлаа.

-Аав, бид явах болсон уу? -тэр жинс, пүүзээ өмсөж амжжээ.

-Бэлэн, Брент, чи бэлэн үү?

-Дахиад ганц лаазыг уучихвал бэлээн...

Стефф үл мэдэг хөмсгөө зангидаа. Тэр хэзээ ч иймэрхүү уг, салтаандаа пиво хавчуулаад машин жолоодож явдаг эрчүүдийг таашаадаггүй. Би түүнд нүд ирмэхэд эргэн явж, лааз пиво авчирлаа. Яг одоо надад Нортонтой муудалцах сонирхол алга.

-Баярлалаа гэж Нортон дуугарсан ч огг Стеффид биш, зүгээр л ресторанд үйлчлэгчид хэлдэг шиг амандаа бувтнав. Дараа нь над руу эргэлээ. -За явах уу, анд минь!

-Одоохон гээд би зочдын өрөө рүүявлаа. Нортон миний араас машиныхаа тухай үглэн дагасан ч надад түүний яриа сонин биш байлаа. Би цонхоор нуурын зүг ширтэв. Салхи багахан чангарсан ч хоёр, гурван хэмээр дулаарчээ. Өглөө харагдаж байсан хачин манан одоо алга болсон байх гэж бодсон нь алдаа болжээ. Харин ч бүр улам ойртож, нуурын голд дөхөөд ирчихэж.

-Би ч бас анзаарсан гэж Нортон хэлэв. -Энэ ямар нэгэн агаарын халуунаас үүссэн байгалийн үзэгдэл байх.

Энэ бүхэн надад таалагдсангүй. Би амьдралдаа хэзээ ч ийм зүйл үзээгүй. Манан хачин тэгш хэлбэртэй нь миний гайхашралыг төрүүлж байв. Байгальд ийм тэгш зүйл байдаггүй, тэгш шугам гэдэг чинь хүний бүтээл. Бас түүний ямар ч өөгүй дун цагаан, гялбаангүй, нүд сохлом жигд цагаан өнгө. Одоо манан хүртэл хагас километр л үлдэж, түүний цагаан өнгө, тэнгэр, нуурын хоорондох ялгаа улам тод болжээ.

-Аав, явъя Билли миний өмднөөс татлаа.

Буцах замд Нортон манай зочдын өрөөний дээврийг цөм цохисон модыг харлаа.

-Алимны мод биш байсан нь харамсалтай гэж Билли дуугарав. -Ээж тэгж хэлсэн. Гоё байгаа биз?

-Чиний ээж ч мундаг шүү гээд Нортон хүүгийн толгойг илэхэд, түүний харц дахин Стеффийн цээжийг хайлаа. Үгүй, энэ хүн хэзээ ч надад таалагдахгүй.

-Стефф, чи бидэнтэй явахгүй юмуу? -гэж би асуув. Яагаад ч юм, түүнийг гэнэт ганцаар үлдээмээргүй санагдаад явчихлаа.

-Үгүй, би үлдэж, цэцэрлэгийн хог ургамлыг янзлахаас гэж Стефф хариулав. Тэр Нортоныгхарснаа над руу эргэлээ. -Өнөөдөр энд цахилгаан шаардахгүй ганц машин нь би л байх шиг.

Нортон худал, чанга инээлээ. Би түүний юу хэлээд байгааг ойлгосон ч дахин нэг оролдоод үзлээ.

-Чи үнэхээр явахгүй юм уу?

-Явахгүй гэж Стефф хатуу хэллээ. -Тэгээд ч жаахан хөдлөх надад сайн.

-За яхав, харин наранд удаан суух хэрэггүй шүү.

-Би сийрсэн малгайгаа өмсөнө. Ирэхэд чинь сэндвич бэлтгэчихнэ.

-Маш сайн.

Стефф надад үнсүүлэхээр хацраа өгөв.

-Болгоомжтой яваарай... Канзас-роудын замд унасан модод байгаа шүү.

-Ойлголоо.

-Чи ч бас гээд тэр Биллийн хацар дээр үнслээ.

-За ээжээ Билли гүйхээрээ хаалга саван гарч одов.

Нортон бид хоёр араас нь гарлаа. .

-Хоёулаа танайд очиж, машиныг чинь дарсан модыг хөрөөдөх үү? -гэж би асуулаа. Яагаад ч юм, эндээс явахгүйн тулд би мянган шалтаг хайж эхэллээ.

-Юм идэж, хоёр ийм юм уухаас нааш түүнийгхарах ч сонирхол алга Нортон барьсан лаазтай пивоо өргөв. -Нэгэнт болсон юмыг одоо яадгийн ч арга алга даа, хөгшөөн.

Намайг ингэж дуудсан нь надад бас л таалагдсангүй.

Бид гурвуул "Скаут" -ын урд сууцгааж, би ухрах араандаа хийн, буланд нь Зул сарын баярыг санагдуулан шаргалтах хуучин сүх өлгөсөн гаражнаасаа ухран гарлаа. Машины дугуйн дор шуурганаар хугарсан мөчрүүд тачигнана. Стефф манай газрын баруун талд байдаг цэцэрлэгийн дэргэд зогсоно. Бээлий өмссөн нэг гартаа цэцэрлэгийн хайч, нөгөө гартаа хог ургамал огтлох жижиг хутга барьсан харагдана. Өргөн хүрээтэй хуучин малгай өмссөн тул нүүр нь сүүдэрт халхлагджээ. Би хоёр удаа богино сигналдахад Стефф хайч барьсан гараараа даллав. Бид замд гарлаа.

Дахиж би эхнэрээ хараагүй.

Канзас-роудын зам хүрэхээс өмнө бид зогсооос аргагүй болов. Эрчим хүчний компаний машин явж өнгөрсний дараа зам дээр дажгүй том нарс унажээ. Нортон бид хоёр машинаас гарч, хамаг хувцсаа давирхайнд завааруулж байж модыг замаас багахан, "Скаут" явж болохоор зайлуулав. Билли туслана гэж зүтгэсэн боловч би түүнийг мөчрийн хугархайнд нүд амаа сохолчихно гэж айгаад машиндаа сууж байхыг тушаасан юм. Хугарч унасан хөгшин модод надад үргэлж Толкиены гайхамшигт "Бөгжний эзэн" -ий энтуудийг, гэхдээ зөвхөн муухай ааштай, хорлохыг л оролддог энтуудийг санагдуулдаг. Цанаар ойд явж байхад ч, зүгээр зугаалж явахад ч ялгаагүй, тэд хорлохыг л оролдоно, тэгээд хэрэв чаддаг байсан бол алахыг оролдоно гэж би боддог юм.

Канзас-роудын засмал замд саад таарсангүй, гэхдээ замын хажуугаар тасарсан цахилгааны утас харагдаж, эцэст нь "Викки-Линн" жуулчны баазын хажууханд утсанд орооцолдсон толгой нь галзуу эмэгтэйн үс мэт харагдах шонгийн мод тэр чигээрээ хэвтэж байв.

-Энэ шуурга ч биднийг баллаж тавилаа шүү гэж Нортон шүүх хурал дээр зүлгэж авсан жигд хоолойгоороо дуугарлаа. Харин энэ удаа тэр гангарч барьсангүй, үнэхээр балмагдсан бололтой.

-Харин тиймээ.

-Аав, хараач!

Билли гараараа Элличийн саравчийг зааж байлаа. Арван хоёр жил саравч Томми Элличийн фермийн хажууд, багваахай, алтаргана, хонин зангуу цэцгэнд хучигдан ядарсан мэт навсайж байсан. Намар бүр би саравч өвлүүг давахгүй гэж боддог, харин хавар бүр саравч байрандаа байж байдагсан. Одоо тэр байхгүй болжээ. Нуранги, нүцгэн, бэнзгүй шахам дээвэр л үлдэж. Цаг нь ирж дээ, хөөрхий. Ингэж бодмогц надад нэг л эвгүй санагдаад явчихав. Шуурга ирээд, тэр байхгүй болжээ.

Нортон пивоо ууж дуусгаад лаазыг шалчийтал базаж, огтхон ч зовсон шинжгүй машины шалан дээр шидэв. Билли юм хэлэх гэсэн мэт амаа ангайснаа больчихов. Эр хүн. Нортон шил, лаазны тухай тогтоол байдаггүй Нью-Жерсид амьдардаг хүн. Тэгээд ч би өөрөө заримдаа мартчихаад байдаг болохоор таван центийн шагналын тухай юу ярих вэ.

Билли радионы чихийг мушгиж эхлэхэд нь би "ВОКСО" ажиллаж байгаа эсэхийг мэдэхийг гуялаа. Хүү урт долгионыг эцсийг нь хүртэл шалгасан ч юу ч олж чадсангүй. Энэ манангийн цаанаа өөр ямар радиостанц байдаг билээ?

-"ВБЛМ" -ийг хайгаад үз гэж би хэллээ.

Билли дахин хайж, нөгөө эцэст нь тулсан ч бас л юу ч олсонгүй.

-Хачин юм гэж би дуугарлаа.

-Юу хачин гэж? -Нортон.

-Үгүй зүгээр л...

Билли өөр мужийн нэвтрүүлэгт шилжиж, удалгүй бид хотод орж ирлээ.

Худалдааны төвийн "Норж" хими цэвэрлэгээ хаалттай байна, энэ ч мэдээж, цахилгаан байхгүй, харин Брижтоны агстек, "Федерал Фудс" супермаркет ажиллаж байлаа. Зуны дунд сард энд ийм л байдаг. Дүүрэн машин, өөр мужийн дугаартай машинууд ч олон байна. Хүмүүс хэсэг хэсгээрээ наранд зогсож ярилцана. Шуурганы тухай л биз.

Тэдний дунд би ялзарсан хожуулыг сурталчлагч, чихмэлүүдийн хатан хаан хатагтай Кармодиг олж харлаа. Нүд сохлом хурц шар хослол өмссөн хөгшин авгай Кармоди дэлгүүрийн хаалгаар ихэмсгээр орж явчихав. Цүнх гэхээс чөмодан гэмээр юм гартаа барьжээ.

Жинсэн хүрэмтэй, нүдний толин шилтэй, дуулга өмсөөгүй нэг новш "Ямаха" -гаа хүржигнуулэн, урд бамперыг шургэх шахан өнгөрөв.

-Тэнэг новш! -гэж Нортон архирлаа.

Аятайхан газархайн би машины зогсоолыг тойрлоо. Тавих газар олддоггүй, хол тавиад алхах хэрэг гарах нь дээ гэж бодож явтал аз таарч, дэлгүүрт хамгийн ойрын эгнээнээс автобус шиг том "Кадиллак" хөдлөв. Түүний газар сулармагц би түргэхэн машинаа тавьж авлаа.

Худалдаж авах зүйлийн жагсаалтыг би Биллид бариуллаа. Тэр тавхан настай ч дармалдаж бичсэн бол уншихдаг юм.

-Тэргэнцэр аваад юмаа ав. Би ээжтэй нь утсаар ярина. Ноён Нортон чамд туслана. Би удахгүй.

Бид машинаас буумагц Билли Нортоны гараас барьж авлаа. Бид хүүгээ автозогсоол дээр ганцаар гүйж болохгүй гэж сургасан, тэр үүнийгээ мартаагүй л байна. Нортон эхлээд гайхсан бололтой харснаа инээмсэглэхэд нь би Стеффиг нүдээрээ идэж байсныг нь училж орхих дөхлөө.

Аптек, хими цэвэрлэгээний дунд байдаг утасны зүг би явлаа. Халууцаж сүйд болж байгаа бололтой, ягаан усны хувцастай тарган эмэгтэй зогсоо зайлгүй утасны хонхыг дарж байна. Би түүний ард гараа халаасандаа хийн зогсоод чухам ягаад тэр хачин манангаас, чимээгүй болсон радиостанц, бас "Сум" төсөл" -өөс болж Стеффид учиргүй сэтгэл зовоод байгаагаа ойлгохыг оролдов. Наранд борлосон сэвхтэй бондгор мөртэй, ягаан усны хувцастай эмэгтэй эгээ л хөлөрсөн ягаан хүүхэд мэт харагдана. Тэр харилцуурыг дэгээнд шидэх шахам өлгөөд эргэж, намайг олж харав.

-Мөнгөө үрэх хэрэггүй. "Дүү-дүү"-гээс өөр юм алга гэж тэр ууртай хэлээд зөрөн өнгөрлөе.

Би духаа алгадаад авах шахлаа. Мэдээж хaa нэг газар утасны шугам тасарсан байгаа. Газар доогуур тавьсан хэсэг нь зүгээр, харин үлдсэн хэсэг нь... Ямар ч байсан утасдаад үзлээ. Эндхийн утасны аппаратууд нь Стеффийн "галзуу" гэж нэрлэдэг утаснууд байдаг. Шууд

арван цент хийхийн оронд та эхлээд дуудлагыг чагнаж, дараа нь дугаараа авна. Хэн нэгэн утсыг авмагц утас автоматаар таслагдаж, та хурдхан арван цент хийхгүй бол цаад хүн чинь утсаа тасалчихаж мэднэ. Ядаргаатай, гэхдээ тэр өдөр би үнэхээр арван цент хэмнэлээ. Ягаан усны хувцастай хатагтайн хэлснээр зөвхөн "дүү-дүү".

Би харилцуурыг өлгөж, дэлгүүрийн зүг яаралгүй алхалсаар очоод нэгэн инээдтэй явдалтай яг таарав. Хоёр хөгшин хос ярилцаар "Гарах" гэсэн бичигтэй шилэн хаалганд тулж ирлээ. Тэгээд ярьсаар яваад шилэн хаалгыг мөргөж орхилоо. Эмэгтэй нь аиж гайхсан шинжтэй дуу алдав. Дараа нь тэд бие биесээ харж, инээцгээгээд, хөгшин нилээд хүч гаргаж байж хаалгыг нээн эхлээд эхнэрээ гаргаад, дараа нь өөрөө гарлаа. Фотоэлемэнтүүдтэй, хүн ойртож ирэхэд өөрөө нээгддэг энэ автомат хаалганууд хүнд, тэгээд тог байхгүй бол ёстой дэмий эд.

Мөн л хаалгыг хүчлэн нээгээд би дотогш орж, юуны өмнө агааржуулагчууд ажиллахгүй байгааг анзаарлаа. Зун агааржуулагчуудыг дэлгүүрт удаан байх юм бол ямар нэг эрхтнээ хөлдөөчих хэмээр ажиллуулдаг юм.

Орчин үеийн бүх супермаркетуудын адил, "Федерал Фудс" төв худалдааны орчин үеийн технологийг нэвтрүүлж, үүний үр дүнд бүх худалдан авагчид туршилтын туурай болдог төөрдөг байшин мэт болжээ. Талх, сүү, мах, пиво, бэлэн хоол зэрэг танд үнэхээр хэрэгтэй бүтээгдэхүүнүүд дэлгүүрийн хамгийн цаад буланд байдаг тул тийш ирэх, очихдоо та зүгээр л санаандгүй авчихаар асаагуураас авахуулаад оймс хүртэл түмэн зүйлийн хажуугаар өнгөрөх хэрэггэй болно.

Хаалганы дэргэдээс шууд жимс, ногооны тасаг эхэлжээ. Тэнд Билли ч, Нортон ч алга, Би тавиуруудын дундуур яваар зүүн тийш эргэж, гуравдахь эгнээнд Билли баахан боодлуудын өмнө бодлогошрон зогсож байхыг харлаа. Нортон ард нь авах зүйлийн жагсаалтыг аргаа барсан шинжтэй харан зогсож байхыг хараад би золтой л инээчихсэнгүй. Дүүрэн шахам тэргэнцруүд түрсэн хүмүүсийн дундуур ("хэрэмний инстинкт" ганц Стеффид төрөөгүй бололтой) би урагш зүтгэж гарлаа. Нортон хоёр боодол бялууны амт оруулагч аваад тэргэнцэрт хийж харагдана.

-За ажил ямар байна? -гэж намайг асуухад Нортон эргэж хараад ихээхэн санаа нь амарсан шинжтэй инээмсэглэв.

-Дажгүй, тиймээ Билли?

-Тийм гэж Билли хэлээд тэссэнгүй бололтой гэхдээ энд ноён Нортон ч бас уншиж чадахгүй юм нилээд байна гэж ёжтой хэллээ.

Билли тэр хоёрын авсан бүрийн ард Нортон аргагүй л өмгөөлөгч хүний нямбай зангаар чагт зурж тэмдэглэжээ. Зургаа долоон бүтээгдэхүүн, кока-кола, сүү авчихаж. Одоо арваад юм авчихвал болох нь тэр.

"Жимс ногоо" —ны тасагт очих хэрэгтэй гэж би хэллээ. -Ээж нь өргөст хэмх, улаан лооль ав гэсэн.

Билли тэргэнцийг эргүүлж эхлэх үед Нортон дуугарлаа:

-Дэйв, тэнд ямар дараалал байгааг-хараач.

Би харахаар явлаа. Энд хошин шогийн сэтгүүлийн зураг шиг юм болж байлаа. Зөвхөн хоёр касс ажиллаж, хоосорсон тавиуруудын дундуур хоёр эгнээ дараалал мушгиран, хөлдөөсөн бүтээгдэхүүн хадгалдаг том хөргөгчүүдийн дундуур орж алга болжээ. Цоо шинэ, компьютержүүлсэн кассны аппаратуудад савхин уут угласан харагдана. Кассны хоёр бүсгүй тооны машин урдаа тавьчихсан, туйлын ядарсан шинжтэй ажиллаж байлаа. Хажууд нь Бад Браун, Олли Викс гэдэг дэлгүүрийн хоёр менежер зогсоно. Надад өөрийгөө дэлгүүрийн ертөнцийн Шарль де Голль гэж үздэг Бад Браунаас Олли Викс нь хамаагүй таалагддаг юм.

Кассны охидынхэн нэгнь тооцоогоо дуусмагц Бад, Олли хоёрын нэг нь үнийн дүнтэй хуудсыг худалдан авагчийн мөнгөн дэвсгэртэд, эсвэл чекэнд хадаад тусгай хайрцаг руу чулуудаж байв. Тэд дөрвүүл хөлөрч, ядарчээ.

-Чи аятайхан ном авсан биз дээ гэж Нортон надад дөхөж ирэн хэллээ. -Бид ч удаан зогсох бололтой.

Би гэртээ ганцаараа үлдсэн Стеффиг бодож, бас дахин сэтгэл түгшээд явчихлаа.

-Чи яваад өөртөө хэрэгтэй юмаа ав гэж би хэллээ. -Билли бид хоёр энд юмаа цуглувулна.

-Чамд пиво авах уу?

Хэдийгээр өдөр бид хоёр гайгүй эвлэрсэн ч үдшийг Нортонтой ууж өнгөрүүлэхийг би огт хүссэнгүй. Гэрт хийх ажил ч хангалттай их байгаа.

-Баярлалаа, зүгээр, дараа больё, Брент.

Нортоны царай үл ялих ширүүн төрхтэй боллоо.

-О'Кей гэж тэр хурдан хэлээд эргэж, юмаа авахаар явлаа. Би түүний араас харж зогстол Билли өмднөөс чангаав.

-Та ээжтэй ярьсан уу?

-Үгүй. Утас ажиллахгүй байна. Шуурганаар таслаад хаячихсан байх.

-Таны санаа зовж байна, тиймээ?

-Үгүй зүгээр гэж би худал хэллээ. -Харин чи?

-Би зүгээр түүний сэтгэл зовж байгаа нь царайгаар нь мэдэгдэж байв.

3. Манан

Эргээд жимс, ногооны тасаг руу явахдаа би урсгал сөрөх хулд загас мэт боллоо. Таньдаг улс ч таарч эхэллээ: хотын удирдах зөвлөлийн гишүүн МайкХатлен, бага ангийн багш хатагтай Репплер, (хэдэн үеийн сурагчдын аянга одоо шийгүүтэй тавиуруудыг инээмсэглэн харж байна), Стефф бид хоёр хаашаа ч юм хамт явахад заримдаа Биллиг харж үлддэг байсан хатагтай Терман. Гэхдээ гол төлөв энд амрах гэж ирсэн хүмүүс цугларч, бэлтгэх хэрэггүй, бэлэн хоол унд цуглуулж, "хүнд хэцүү нөхцөлд амарч" байгаа тухай инээлдэн ярилцаж байв. Хиам, утсан мах, талх, боов боорцог, бэлэн хоолны тасгийг тэд бүрэн хоосолж, тэнд зайдас, шанз, бас ганц гонзгой, тун муу харагдах хиамнаас өөр юу ч үлдсэнгүй.

Би улаан лооль, өргөст хэмх, савтай майонез авлаа. Стефф бас гахайн утсан мах ав гэсэн, даанч утсан мах огт алга, тиймээс би оронд нь хэдийгээр ФДА -аас боодол болгонд нь тодорхой хэмжээний шавьж байдаг (үнэгүй амтлагч) гэж бичсэн болохоор идэх дургүй ч хиамны шанз авлаа.

-Аав, хараач гэж Билли дөрөвдэх эгнээнд орох үед хэллээ. -Цэргүүд явж байна.

Хоёр цэргийн саарал өмсгөл хамаагүй хурц өнгийн хувцас өмссөн амрагчид, худалдан авагчдын дунд маш содон харагдаж байлаа. Энд гудамжинд цэргүүд үзэгдэхэд хүмүүс дасаад тоохоо байчихсан, учир нь эндээс тавиадхан километрийн зайд "Сум" төсөл"-ийн хотхон оршдог. Энэ хоёр залуухан цэргүүд сахлаа саяхнаас л авч эхэлсэн мэт харагдаж байв.

Би жагсаалтаа хараад авах ёстой юмаа Билли бид хоёр бүгдийг авч гэж дүгнэлээ... арай ч үгүй юмаа, хамгийн эцэст, гэнэт санасан мэт Стефф: "шил "Лансерз"?" -гэж нэмжээ. Энэ ч зөв, орой, Билли унтсаны дараа хоёр стакан дарс, тэгээд ганц нэг цагийн янаглал.

Тэргэнцрээ орхиод би зүтгэсээр дарсны тавиурууд руу явж, хэрэгтэй дарсаа аваад хоёр талаас хаагддаг хаалганы цаана хүчирхэг генератор жигд дүнгэнэхийг сонсон буцахаар алхлав. Гэхдээ генераторын хүч нь хөргөгчнүүдийг л ажиллуулахад хүрдэг, харин автомат хаалга, кассны аппаратууд болон бусад цахилгаан хэрэгсэлийг ажиллуулахад хүч нь хүрдэггүй бололтой. Хаалганы цаана мотоцикл асаасан мэт дуугарч байлаа.

Бид дараалалд зогсож байхад Нортон хоёр боодол хөнгөн пиво, талх, өнөөх царай муутай хиамыг барьсаар ирж, бидний хамт зогсов. Агааржуулагчгүй танхимд халуун байлаа. Ажилчдын нэг нь ядаж хаалгануудаа онгойлгоод тогтоож орхихгүй дээ гэж бодогдов. Ард, хоёр тавиурын цаана би улаан халаадтай Бадди Иглтоныг харсан боловч тэр залхуурч, суудлаасаа өндийх шинжгүй байгаа нь илт харагдаж байв. Генераторын жигд дуунаас миний толгой өвдөж эхэллээ.

-Наадуулаа тэргэнцэрт хийчих гэж би Нортонд хэлэв.

-Баярлалаа.

Одоо дараалал хөлдөөсөн бүтээгдэхүүний тасгийн дэргэдүүр зурайж, хүмүүс хэрэгтэй зүйлээ авахын тулд учлал гуйн байж хоёр эгнээ дарааллын дундуур зүтгэцгээнэ.

-Энд ёстай үхээрийн амьтан болтлоо зогсох нь дээ гэж Нортон ууртай хэлэхэд нь Биллид иймэрхүү үг яриа сонсгохгүй байхыг хичээдэг тул би хөмсгөө зангидаа.

Дараалал бага зэрэг урагшилж, генераторын нүргэлэх дуун намсаад Нортон бид хоёр шүүхэд хоёулаа очих болсон муухай хэрүүлийг аль болох тойрон, зөвхөн цаг агаар, "Рэд Сокс" багийн ялалтуудын тухай ярьж эхлэв. Хэнд ч хэрэггүй энэ яриагаа дуусгаад бид дахин дуугүй боллоо. Билли хөлийн дэргэд эргэлдэнэ. Дараалал удаан боловч урагшилсаар байв. Одоо бидний баруун талд хөлдөөсөн бэлэн хоол, зүүн талд үнэтэй дарс, шампан дарсууд өржээ. Хямд дарстай лангууны дэргэд хүрч ирэхэд би ганц шил "Рипл" авдаг юмуу, энэ чинь миний галзуу залуу үеийн дарс гэх шүү юм бодсон ч удалгүй мартжээ. Тэгээд ч миний залуу нас тийм ч галзуу байгаагүй.

-Ягаад ийм удаан юм бэ, аав? -гэж царайнд нь санаа зовсон байдал хадгалагдсан хэвээр Билли надаас асуулаа. Түүнийг хараад миний түгшүүрийн манан ч дорхноо арилав. Оронд нь хамаагүй аймшигтай нэгэн зүйл шагайх шиг боллоо, энэ бол темөр мэт гялалзсан айдсын гөлтгөр нүүр байлаа.

-Хүү минь, тайван бай гэж би хэллээ.

Одоо бид талхны тавиуруудын дэргэд ирж, энд дараалал зүүн гар тийш эргэж байв. Энд "Өөр дараалалд зогсоно уу" гэсэн бичиг, хажууд нь "Уинстон"-ы реклам харагдана. Кассны цаана аварга том, автозогсоолын зүг харсан хэд хэдэн хэсгээс бүрдсэн үзмэрийн цонх байна. Бидний дараалал дэргэд нь Бадди Браун зогсох кассчин бүсгүйн зүг явж байлаа. Урд гучаад хүн үлдсэн байна. Дарааллын дунд канар бялзуухай шиг хурц шар хослолтой хатагтай Кармоди тун содон харагдана. Миний бодлоор тэр яг шар халуун хумхааны сурталчилгаа реклам шигхарагдаж байлаа.

Гэнэт хаана ч юм хүн хаширах мэт чимээ гарлаа. Тэр аажмаар чангараар цагдаагийн машины дохиоллын орилоон болж хувирav. Замын уулзварын зүгээс машин сигналдах, дараа нь тормозны чарлаан, дугуйн хаймар хяхтнах сонсогдлоо. Миний зогсож байгаа газраас юм харагдсангүй, харин удалгүй дохиоллын дуу чангараар дээд цэгтээ хүрч, машин дэлгүүрээс давхин холдохын хэрээр намдаж эхэллээ. Дараалалд зогсож байсан хэдэн хүн юу болоод байгааг харахаар ухасхийн цонхны зүг гүйлдэж, ихэнх нь дарааллаа алдахаас болгоомжлон байрандаа үлджээ. Юм нь миний тэргэнцэрт байгаа тул Нортон юу болсныг харахаар явав. Хэдэн хормын дараа тэр эргэн ирж байрандаа зогслоо.

-Эндхийн цагдаа нар байна гэж тэр мэдээлэв..

Гэтэл аажмаар чарлаан болон, дараа нь дахин намсаар хотын гал командын машин давхив. Билли миний гараас барилаа. Шүүрч авлаа гэж ч болно.

-Энэ юу вэ, ааваа? -гэж асууснаа шууд Ээж зүгээр гэж та итгэж байна уу? -гэлээ.

-Канзас-роудын зам дээр түймэр гарав бололтой гэж Нортон хэлэв. -Энэ чөтгөрийн тасарсан утаснууд... Гал командынхан явж байх шигбайна.

Энэ тайлбар миний түгшүүрийг нэг цэг дээр төвлөрүүллээ: манай байшингийн дэргэд бас тасарсан цахилгаан утаснууд байгаа.

Кассчин бүсгүй юу болж байгааг хархаар эргэхэд Бад Браун нэг юм хэллээ. Бүсгүйн царай улайж, хурдан эргэн тооны машинаа тогшиж гарав.

Би энэ дараалалд зогсмооргүй байлаа. Гэнэт энд зогсооос дургүй хүрсэн боловч урагшилж байгаа дарааллыг хаяад явчих бас утгагүй юм. Бид тамхины тавиуруудад тулаад иржээ.

Нэг залуу хаалга нээн орж ирэхэд надад энэ нөхөр бол өнөөх бидний машиныг шургэх шахсан "Ямаха" унаж явсан залуу мөн шиг санагдав.

-Манан! -гэж тэр хашгирлаа. -Юу болж байна аа! Ёстай хачин юм! Тэр зүгээр л Канзас-роудаар гулсаж явна.

Хүмүүс түүний зүг ханаан эргэлээ. Тэр удаан гүйсэн мэт уухилан амьсгаадна. Харин хүмүүс дуугарсангүй.

-Үнэхээр хачин юм гэж тэр энэ удаа өөрийгөө өмөөрөх мэт дуугарлаа.

Хүмүүс түүнийг дуугүй харцгаан, хэн нэгэн хөлөөрөө юм өшиглөж, хэн нэгэн ханиавч хэн ч дарааллаа орхихыг хүссэнгүй. Дараалалд зогсож амжаагүй хэд хэдэн хүн тэргэнцрээ хаяад ажилгүй касснуудын дундуур гүйлдэн юу болж байгааг хархаар хаалганы зүг явцгаав. Хачин инээдтэй, одоо хэн ч өмсдөггүй, эрээн бүстэй зуны бүрх малгай өмссөн булиа эр "Гарах" гэсэн бичигтэй хаалгыг нээн гадагш ухасхийхэд түүнийг даган арав гаран хүн гарч явлаа. Орж ирэн хашгичсан залуу ч гаран алга болов.

-Ингээд байвал хамаг цэвэршүүлсэн агаар алга болчих юм байна даа гэж нэг цэрзг тоглолоо.

Хэн нэгэн инээлээ. Харин би дуугарсангүй: би манан нууран дээгүүр ойртож байгааг харсан хүн.

-Билли чи явж харахгүй юмуу? -гэж Нортон хэллээ.

-Үгүй гэж би өөрөө яагаад хэлснээ ч мэдэхгүй өмнөөс нь хариулав.

Дараалал дахин урагшилж эхлэв, Хүмүүс хашгирсан залуугийн хэлээд байсан мананг хархыг хичээн өлмий дээрээ зогсож, хүзүүгээ сунгавч цонхоор зөвхөн цэнхэр тэнгэр л харагдана. Залуу зүгээр л тоглосон байх гэж нэг эр хэллээ. Бас нэг эр цаг хүрэхгүйн өмнө нууран дээр манангийн зураас харсан гэв. Гал командын машины дохиолол орилсоор. Энэ бүхэн надад огтхон ч таалагдсангүй. Маш том гай гамшигаар энэ бүхэн ханхалж байлаа.

Дахин хэдэн хүн гадагш гарлаа. Зарим нь бүр дарааллаа хаяж явсан тул бид овоо урагшлав. "Тексако"-гийн шатахуун түгээх станцад ажилладаг хөгшин, буурал Жон Ли Фровин дэлгүүрт гүйн орж ирээд:

-Хөөе, зургийн аппараттай хүн байна уу? -гэж хашгирлаа.

Хэн ч дуугарсангүй. Тэр танхимыг тойруулан хараад буцан гадагш гарлаа. Одоо л хүмүүс хөдөлж эхэллээ: хэрэв үзэгдлийн фото зургийг авахаар сонин юм бол ядаж нүдээрээ үззх хэрэгтэй.

Гэнэт өөрийн чахарсан, гэхдээ хүчтэй, хөгшин хоолойгоороо хатагтай Кармоди хашгираа:

-Тийшээ явж болохгүй!

Хүмүүс түүний зүг эргэцгээв. Урт дараалал замбараагаа алджээ: зарим нь мананг үзэхээр явж, хэдэн хүн хатагтай Кармодигаас зайлан гүйлдэж, бас зарим нь найз нөхдөө хайхаар дарааллаас гаржээ.

Улаан цамц, хар ногоон өмд өмссөн царайлаг залуу бүсгүй хатагтай Кармодиг шинжих мэт бодлогошронгуй харна. Зарим нь энэ бүхнийг ашиглан кассанд бүр ойртоод оччихсон харагдлаа. Бад Брауны дэргэдэх кассчин бүсгүй дахин эргэн хараад цаадах нь нурууг нь урт хуруугаараа тогшив.

-Салли, ажлаа хий.

Хатагтай Кармоди дахин хашгираа:

-Тийшээ явж болохгүй! Тэнд үхэл байгаа! Би мэдэрч байна, тэнд үхэл байгаа!

Түүнийг сайн мэдэх Бад, Олли хоёр зөвхөн царайгаа үрчийлгэлээ, харин холоос ирсэн хүмүүс дараалалд зогсож байсан ч хамаагүй эмгэнээс холдохын түүс болцгоожээ. Ийм орилоо эмгэдэд том хотуудад ч адилхан ханддагбололтой. Яг л тэд ямар нэгэн- халдварт өвчин тээгчид мэт. Хэн мэдэх вэ, үнэхээр тийм байж ч магад.

Дараа нь үйл явдал хурдан, эмх замбараагүй өрнөлөө. Хаалгаар хамраас нь цус гарсан эр гүйн орж ирэв.

-Манан дотор нэг юм байна! -гэж тэр хашгираа.

Билли энэ хамраас нь цус гоожих эрээс, эсвэл түүний ярьснаас айх мэт надад наалдав.

-Тэр манан дотор нэг юм байна! -гэж өнөөх эр дахин хашгирав. -Манангаас нэг юм Жон Лиг бариад авсан! Нэг юм... -Тэр гүйвж, зүлэгний бордоо өрсөн тавиурыг нуруугаараа мөргөөд доош суулаа. -Нэг юм манан дотроос Жон Лиг бариад авсан, би түүний хашгирч байгаагсонссон!

Байдал эрс өөрчлөгдлөө. Шуурганаас, дараа нь цагдаагийн, гал командын дохиоллоос үүссэн түгшүүр, цахилгаан тасарснаас дундаж америк хүний автдаг сандрал, эргэн тойронд гарч буй гэнэтийн өөрчлөлтүүд, аиж эмээсэн байдал, энэ бүхэн бүх хүнийг зэрэг хөдлөхөд хүргэжээ.

Тэд гүйлдсэнгүй. Тэгж хэлвэл би байдлыг буруу дүрслэх болно. Хүмүүс паникт автсангүй. Хэн ч гүйсэнгүй, ямар ч байсан ихэнх хүмүүс гүйсэнгүй. Тэд зүгээр л явцгаасан. Зарим нь кассны дэргэдэх том үзмэрийн цонхны зүг, зарим нь шууд хаалга руу, тэдний зарим нь авсан

Зүйлийнхээ мөнгийг төлөлгүй явцгаалаа. Бад Браун өөрийн шаардлага тавьж сурсан хоолойгоор хашгирав:

-Хөөе, та нар төлбөрөө хийгээгүй! Хеөе, та нар! Зайдастай пирожкинуудаа хурдан буцааж тавь!

Хэн нэгэн түүний үгэнд учиргүй инээж, энэ галзуу инээднээс олон хүн инээмсэглэлээ. Гэхдээ инээмсэглэж байсан ч тэд айж эмээсэн нь мэдрэгдэж байлаа. Дараа нь бас нэг эр инээж, Брауны царай улайв. Тэр ухасхийн хүмүүс шавсан цонх руу зүтгэж байсан настай авгайн мөөгтэй хайрцгийг булаан авлаа.

-Миний мөөгнүүдийг өгөөдөх! -гэж авгай хашгирахад хүмүүс тачигнатал инээлдлээ.

Болж буй үйл явдал галзуугийн эмнэлгийг санагдуулж эхэллээ.

Хүмүүс гудамжинд гарч болохгүй гэж хатагтай Кармоди орилсон хэвээр. Гэртээ хулгайч байгааг мэдсэн сүрхий чийрэг авгай мэт гал командын дохиолол ч зогсоо зайгүй чарлана. Билли уйллаа.

-Ааваа, энэ ах яагаад цус болчихсон юм бэ?

-Зүгээр, Их Билл минь, тэр зүгээр л хамраа авчихаж. Санаа зовох хэрэггүй.

-Энэ нөхөр ямар манан ярьсан бэ? Дотор нь юу байсан юм бол? -гэж Нортон гайхсанаа илэрхийлж байгаа бололтой хөмсгөө байдгаар нь зангидан асуув.

-Аав, би аиж байна гэж Билли нулимсандаа хахан хэллээ. -Ааваа, гэртээ харья.

Намайг хүчтэй түлхэн хэн нэгэн гүйн өнгөрөхөд би Биллиг тэврэн өргөлөө. Би ч бас аижээ. Үймээн уlam өргөжсөөр. Бад Брауны дэргэд сууж байсан кассчин Салли өндийхөд Бад түүний улаан даашинзны захаас зуурав. Зах ханзарч, кассчин бүсгүй Брауныг самардан хашгираа:

-Наад үмхий гараа ав!

-Дуугаа тат, гичий минь гэж Бад хэлсэн ч туйлын балмагдсан нь хоолойны нь өнгөөр мэдэгдэж байв.

Тэр дахин бүсгүйн зүг ухасхийсэн боловч Олли Викс түүнийг татан зогсоов:

-Бад! Тайвширч үз!

Бас дахиад хэн нэгэн хашгираа. Хэрэв үүний өмнө паник байгаагүй бол одоо байдал паникт тун ойрхон очжээ. Хүмүүс хоёр хаалгаар гүйн гарцгаана. Шил хагарах дуу гарч шалаар кокакола хөөсрөн урслaa.

-Бурхан минь, юу болж байна аа? -гэж Нортон дуу алдлаа.

Яг энэ үед харанхуйлж эхэллээ. Би танхимиын гэрэл тасарчихлаа гэж бодон өөрийн мэдэлгүй дээш харлаа. Ганц би ч тэгж бодоогүй бололтой. Дараа нь би тог байхгүй, бидний танхимд байх бүх хугацаанд гэрэлгүй байсныг гэнэт саналаа. Гэхдээ хангалттай гэрэлтэй байсан шүү дээ? Гэнэт би цонхны дэргэд шаваарсан хүмүүс хашгиралдаж, гадагш гараараа зааж эхлэхээс ч өмнө бүхнийг ойлголоо.

Манан ирж байна...

Манан Канзас-роудаас автозогсоолын зүг гулсаж, ийм ойрхон зайнаас ч анх нуурын нөгөө эрэгт байхад нь харсан шиг дун цагаан өнгөтэй хэвээр харагдана. Цэвэрхэн, жигд цагаан өнгөтэй, гэхдээ гялалзаж гэрэлтдэггүй манан. Тэр нарыг бараг халхалж, хурдан ойртоож байна. Нарны оронд одоо тэнгэрт өвөл нимгэн үүлний цаанаас харагдах тэргэл сар шиг жижигхэн мөнгөн зоос л үлджээ.

Манан хурдан ойртоож байсан ч надад тэр ердөө л залхуутай мөлхөж байгаа мэт харагдаж, энэ нь хоногийн өмнө нуураар гулсаж явсан усан хуйг санагдууллаа. Байгалд бид тун ховор тааралддаг газар хөдлөлт, хар шуурга, торнадо буюу аварга хий салхи зэрэг аймшигт хүчтэй үзэгдлүүд байдаг. Би тэднийг бүгдийг нь ажиглаж байгаагүй, гэхдээ тэд бүгд ийм залхуу, удаанаар ховсдогч хурдтай өрнөдгийг мэдэхээр олныг үзсэн. Энэ үзэгдлүүд цонхны дэргэд зогсож байсан Стефф, Билли хоёрыг татсан шиг өөртөө хүнийг татдаг.

Манан энэ үед хоёр эгнээ замаар гулсаж, замыг залгиж байлаа. Маккеонсуудын засвар хийсэн голланд байшин үзэгдэхээ байжээ. Хажууд нь хуучин хоёр давхар байшингийн дээвэр манан дунд сүүмэлзэж байснаа удалгүй үзэгдэхээ болив. "Баруун гараа барь" гэсэн бичиг бүхий автозогсоолд орох ба гарах замын хажуу дахь самбар агаарт хөлгүй мэт сүүмэлзэж байснаа алга боллоо. Дараа нь машинууд ар араасаа алга болж эхлэв.

-Бурхан минь, юу болоод байна аа? -гэж Нортон дахин асуухад энэ удаа түүний хоолой чичрэх шиг боллоо.

Манан цэнхэр тэнгэрийг ч, хар асфальтыг ч адилхан хөнгөн залгин давшина. Бүр зургаа, долоон метрийн зайнаас ч манангийн шугам шиг тэгш зах тодхон харагдаж байв. Виллис О Брайен, эсвэл Дуглас Тримбуллын гайхамшигт кинонуудын зохиомол хэсгээс үзэж байгаа мэт хачин сэтгэгдэл надад төрлөө. Энэ бүхэн итгэхийн аргагүй хурдан явагдаж байв. Хөх тэнгэр эхлээд өргөн зураас байснаа тууз болж, дараа нь харандаа болж, тэгээд үзэгдэхээ болилоо. Үзмэрийн цонхыг жигд цагаан өнгө битүү бүрхэв. Цонхноос ганц метрийн зайд тавьсан хогийн савнаас цааш би юу ч олж харж чадсангүй. Миний "Скаут"-ын хамар л чүү чамай харагдаж байна.

Эмэгтэй хүн удаан хашгирах дуу сонсогдоо. Билли надад улам наалдав. Тэр байдгаараа чичирж байлаа. Нэг эр гэнэт дуу алдан хашгираад хоосон кассны дэргэдүүр хаалганы зүг гүйлээ. Үүнээс л ухаангүй зугталт үүссэн байх. Хүмүүс хаалганы зүг эмх замбараагүй сүрэг болон ухасхийлээ.

-Хөөе! -гэж Браун орилов. Тэр айснаас уу, уурласнаас уу, эсвэл аль алинаас уу, царай нь минчийтэл улайж, хүзүүний нь судас аккумуляторын холбогч утас мэт гүрийжээ. -Хөөе, та

нар бүгдээрээ! Та нарт ингэх эрх байхгүй... Алив наад юмнуудаа буцааж тавь! Энэ бол хулгай!

Хүмүүс зогссонгүй, гэхдээ зарим нь авсан зүйлээ хажуу тийш шидэллээ. Хэн ч юм, бүр хөгжилтэй инээж байна, гэхдээ ингэж хөгжиж байгаа хүн цөөхөн байлаа. Тэд мананд шингэн алга болцгоосон, харин үлдсэн бид тэднийг д ахиж хэзээ ч хараагүй. Нээлттэй хаалгаар эхүүн үнэр сулхан ханхалж байв.

Хаалганы дэргэд хүмүүс шахцалдаж эхэллээ. Нэг нь нэгийгээ түлхэж, хэн ч юм, нэгийгээ цохилоо. Миний мөр, гар чинэрэн өвдөж байна: Билли сүрхий том биетэй хүү. Стефф заримдаа түүнийг залуу тугал гэж өхөөрддөг юм.

Нортон бодлогоширч, бас балмагдсан царайтай болчихсон хажуу тийш эргэж, хаалганы зүг алхлаа. Би Биллиг хурдан нөгөө гартаа тэврээд, холдоогүй дээр нь Нортоны гараас барьж авав.

-Одоохондоо хэрэггүй.

-Юу хэрэггүй гэж? -гэж Нортон эргэн асуулаа.

-Хүлээсэн нь дээр.

-Юу хүлээх гэж?

-Мэдэхгүй гэж би хэллээ.-

-Чи арай өөрийгөө... -гэж тэр эхэлтэл манан дунд хэн нэгэн муухай орилон дууг нь таслав.

Хаалганы дэргэдэх чихэлдээн намжиж, хүмүүс эргэн гүйлдэв. Шуугиан, хэрүүл, хашгираан бүгд намжлаа. Хүмүүсийн царай гэнэт цонхигор, хавтгай, гамбир мэт хавтгай болчих шиг харагдана. Орилох дуун гал командын машины дохиололтой уралдан, огт үл тасарна. Хүний уушигт ийм удаан, чанга орилох агаар багтана гэдэг байж боломгүй мэт.

-О-о, бурхан минь хэмээн Нортон хоёр гараараа толгойгоо базлан үсээ сэгсийлгэлээ. Орилох дуун гэнэт тасарлаа. Зүгээр намжсангүй, тас цавчуулсан мэт гэнэт тасрав. Бас нэг эр гадагш гарлаа - ажлын өмдтэй булиа эр. Тэр гадаах эмэгтэйд туслахыг хүсэн бололтой. Хэдэн хором түүний урагшилж байгаа нь цагаан манан дунд сүүмэлзэн харагдаж байв. Дараа нь ямар нэгэн саарал сүүдэр, дун цагаан манан дунд саарал сүүдэр түүний араас хедөлж, өнөөхөн эр мананд аажмаар шингэхийн оронд гэнэтийн явдлаас хоёр гараа сарвайн мананд шингэн алга болов. Хэн нэгэн, эсвэл ямар нэгэн амьтан түүнийг манан руу зүгээр угз татаад оруулчихлаа.

Супермаркет дотор нэг хэсэг нам гүм болов. Гэнэт гадаа хэдэн арван саран мандлаа: автозогсоолын гэрэлтүүлгүүд асчээ, тэдний цахилгаан шугам нь газар доогуур явдаг юм.

-Тийшээ явж болохгүй гэж хатагтай Кармоди өнөөх хэрээнийх шиг чахарсан хоолойгоороо хашгирав. -Тэнд үхэл байна!

Маргах, шоолох хүн гарсангүй.

Гадаа нилээд хол дахин хүн хашигирч гарагад Билли бондгосхийн цочиж надад наалдав.

-Дэвид, юу болоод байна аа? -гэж Олли Викс кассаа хаян над дээр ирж-асуув. Түүний толигор дугариг нүүрэн дээр нь хөлсний том дуслууд бөнжигнөнө. -Энэ юу вэ?

-Чөтгөр гэж, хэрэв би мэдэж байсансан бол... -гэж би хэллээ.

Олли их айсан шинжтэй харагдана. Тэр Хайлэнд нуурын эрэг дээрх жижигхэн хөөрхөн байшинд ганцаар амьдардаг, Сайхан Уулын өвөрт байдаг бааранд суух дуртай эр.

Зүүн гарынхаа чигчий хуруунд Олли од хэлбэрийн индранил чулуутай бөгж зүүдэг, түүнийг хашир өнгөрсөн хоёрдугаар сард сугалаанд хожсон мөнгөөрөө авсан юм. Тэр охид, бүсгүйчүүдээс жаахан айдаг юм шиг надад санагддаг.

-Юу ч ойлгохoo байлаа гэж тэр үглэв. ?

-Би ч бас. Билли аавын нь гар тасарлаа. Миний хүү зогсож бай, за юу. Би гараас чинь барьж байх болно. За юу?

-Ээж... -гэж тэр шивнэв.

-Ээж нь зүгээр гэж би хэллээ. Нэг юм хэлэхээс өөр аргагүй байлаа.

Бидний хажуугаар "Жоны ресторан"-ы дэргэдэх комиссын барааны дэлгүүрийн эзэн өвгөн өнөөх л жил тойрон өмсдөг коллежийн нэр бүхий ноосн цамцтайгаа явж өнгөрөв.

-Энэ чинь өнөөх хорт үүл. Рамфорд, Саут-Паркийн үйлдвэрүүд. Химиин хорт утаа.. .-гэж өвгөн тайлбарлаад эм, нойлын цаас өрсөн дөрөвдүгээр эгнээгээр цааш явав.

-Эндээс зайлах хэрэгтэй, Дэвид гэж Нортон ямар ч итгэлгүй хэллээ.-Хэрэв бид...

Гэнэт бид донсоллоо. Байшин хагас метрийн өндрөөс гэнэт газар буучихсан мэт лүсхийн, хүмүүс суун тусацгаав. Тавиурууд дээрх шилнүүд жингэнэлдэн дуугарч, захын шилнүүд газар унан хага үсэрцгээлээ. Үзмэрийн цонхны шилэн чимэглэлээс зүсэм бялууны хэлбэртэй чимэглэлийн шил хуурч унасан харагдана. Шилийг тогтоож байсан модон бэхлээсүүд хугарсныг би ажиглалаа.

Гал командын машины дохиолол гэнэт чимээгүй болов. Чимээ аниргүйн дунд хүмүүс өөр ямар нэг, бүр доор юм болохыг хүлээх мэт зогсоцгоно. Гайхаж балмагдан чулуу мэт хөдөлгөөнгүй болсон би ч зогсон, яагаад ч юм, өнгөрснийг дурсаж байлаа. Брижтон хот гэж замын уулзвар дээрх хэдхэн байшин байхад аав дэлгүүр явахдаа заримдаа намайг авч явдаг, тэгээд түүнийг худалдагчтай ярьж байхад би шилэн лангууны дэргэд зогсоод хямд чихэр, хоёр пенсийн бохь хардагсан... Нэгдүгээр сар. Дулаахан өдөр. Гадаа ямар ч чимээ аниргүй, хайлж буй цас л байшингийн дээврээс борооны усны сувгаар байшингийн хоёр талд тавьсан поошибинд под подхийн дусална. Би зогсоод "шүд бутлагч", "дэрнүүд", "дугуйнууд"-ыг харна.

Таазанд өлгөсөн шар чийдэн чөтгөрийн гэрэл мэт ёлтойж, өнгөрсөн зуны үхсэн ялаануудын сүүдэр аварга том амьтад мэт хананд тусна. Дэвид Дрэйтон гэдэг бяцхан хүү, түүний аав, алдарт зураач, Танцаардсан Кристина" гэдэг зураг нь Цагаан Ордонд өлгөөтэй байдаг, бяцхан хүү Дэвид, чихэр, бохь харж буй бяцхан хүү. Хүү шээхийг хүсч байна. Харин гадаа зогсоох аргагүй нөмрөн орж ирдэг хүнд, нойтон нэгдүгээр сарын манан...

Дурсамж тун удаан ариллаа.

-Хүмүүсээ! -гэж Нортон хашгирлаа. -Бүгд сонсоцгоо!

Хүмүүс эргэн харцаав. Нортон тангарагийн үг хэлж буй улстөрч мэт алгаа дэлгэн гараа дээш өргөжээ.

-Гадагш гарч болохгүй, тэнд одоо аюултай байх шиг байна! -гэж тэр хашгирлаа.

-Яагаад? -гэж нэг эмэгтэй хашгирав. -Миний хүүхдүүд гэртээ байгаа. Би хүүхдүүдээ очих ёстой.

-Тэнд, гудамжинд үхэл явж байна! -гэж хатагтай Кармоди зүтгэв. Тэр давхарлан өрсөн арван килограммын шуудайтай бордоонуудын дэргэд зогсоно. Царай нь хавагнаж бамбайжээ. Өсвөрийн насны нэг банди гэнэт түүнийг огцом түлхэхэд Кармоди гайхсан мэт хачин шуухитнан дуугараад бордоонууд дээр суучихав.

-Муу хөгшин хэрээ минь дуугаа тат! Дэний балай юм солиороод!

-Би та нарыг гүйж байна! -хэмээн Нортон хашгирлаа. -Энд, бүгдээрээ жаахан хүлээе. Манан арилахаар бид...

Хүмүүс дор бүрдээ эсрэг тэсрэг үг хашгирцгаалаа.

-Тиймээ, энэ хүн зөв ярьж байна гэж би шуугианаас болж байдгаараа хашгирав. -Жаахан тэвчиж, хүлээх хэрэгтэй.

-Миний бодлоор энэ газар хөдлөлт байсан бололтой гэж нүдний шилтэй эр зөөлөн хэлэв. Тэр нэг гартаа махтай пирожки, боов хийсэн уут, нөгөө гартаа Биллигээс дүү болов уу гэмээр бяцхан охин хөтөлжээ. -Үнэхээр газар хөдлөлт, барьсан ч алдахгүй.

-Дөрвөн жилийн өмнө Неапольд яг ингэсэн гэж эндхийн нэг бүдүүн эр хэлэв.

-Тэрчинь Каскод болсон юм гэж эхнэр нь мөнхийн маргаанчийн андашгүй хоолойгоор зөрлөө.

-Неапольд гэж бүдүүн эр арай л итгэл муутай хэллээ.

-Каскод гэж байна шүү гэж эхнэр нь зүтгэхэд бүдүүн эр дахин дуугарсангүй.

Тавиур дээрээс гэнэт том лааз тасхийн унаж хүмүүсийг цочоов. Билли дахин уйлж эхэллээ.

-Би гэртээ харимаар байна, ээждээ очмоор байна!..

-Наад орилоогоо дуугүй болгоодхооч гэж Бад Браун дуугарлаа. Түүний нүд хурдан, гэхдээ ямар ч зорилгогүй ийш тийш бүлтэгнэнэ.

-Эрүүгээ хуга цохиулмаар байна уу, новшоо? -гэж би асуув.

-Дэйв, хэрэггүй. Ингэлээ гээд ямар дээрдэх биш гэж Нортон өөр ямар нэг юм бодон хэллээ.

-Маш харамсалтай байна гэж хүүхдүүдийн тухай хашгирч байсан эмэгтэй хэлэв. -Би маш их харамсч байна, гэхдээ би энд үлдэхгүй. Би гэртээ харих, хүүхдүүдээ очих ёстой.

Тэр хүмүүсийг тойруулан харлаа. Ядарсан, гэхдээ царайлаг, шар үстэй эмэгтэй.

-Ванда бяцхан Викторыг харж байгаа. Та нар ойлгов уу? Ванда дөнгөж найман настай, тэгээд заримдаа мартчихдаг... Дүүгээ харахаа мартчихаад байдаг... Харин бяцхан Виктор... Тэр хөгжим асаах дуртай... бас чүдэнзээр тоглоно... Гэрэл асаах дуртай... Чийдэнд дуртай... Харин Ванда... Заримдаа өөрөө тоглоод, мартчихдаг... Дөнгөж наймтай болохоор... -Тэр дуугүй болж бүгдийг дахин тойруулан харлаа. Бид түүнд эгнэсэн өрөвдөх сэтгэлгүй нүднүүд, нүүр биш, нүднүүд л болж харагдсан байх. -Хэн ч надад туслахгүй юмуу? -гэж тэр хашгирлаа. Эмэгтэйн уруул чичрэв. -Та нар чинь... Эмэгтэй хүнийг гэрт нь хүргээд өгөх хүн алга уу?

Хэн ч хариу дуугарсангүй. Ганц нэг хүн хөлөөрөө шал үрнэ. Эмэгтэй өрөвдмөөр болсон нүдээрээ хүн бүрийг ээлжлэн харна. Бүдүүн эр итгэлгүйхэн урагш алхтал эхнэр нь түүний гараас шүүрэн авч, угз татан арагш болгоод гарыг нь гавлах мэт сугадаж авлаа.

-Ta? -гэж эмэгтэй Оллигоос асуув.

Олли толгой сэгсэрлээ.

-Ta? -гэж тэр Бад Браунд хандлаа.

Бад тооны машинаа ширтэн дуугарсангүй.

-Ta? -гэж эмэгтэй Нортонд хандахад тэр өмгөөлөгчийн эвсэг хоолойгоор ингэж хамаагүй гарч болохгүй, манан... энэ тэр гээд ярьж гарав. Эмэгтэй найдвар алдан гараа савахад Нортон зовсон шинжтэй дуугүй боллоо.

-Ta? -гэж эмэгтэй надад хандахад би байгаа бүхнээ алдаж байгаа энэ эмэгтэйн аймшигт харцнаас бамбай мэт халхлан Биллиг урдаа тэврэв.

-Ta нар бүгдээрээ тамд шатаарай! -гэж эмэгтэй хэлэв. Тэр хашгирсангүй, харин ядарсан хоолойгоор зүгээр л хэллээ.

Дараа нь явсаар хаалганд хүрч, хоёр гараараа нээв.

Би юм хэлэх гэсэн боловч хатсан хоолойноос ямар ч дуу авиа гарсангүй.

-Хөөе, хатагтай, та сонсооч... -гэж Кармодиг түлхэж унагасан хүү хэлээд гараас нь барьж авлаа. Эмэгтэй түүний гарыгхарахад хүүгийн царай нь улайн гараа тавив. Эмэгтэй гадагш гарлаа. Хэн ч, юу ч дуугарсангүй, эмэгтэйн явж байгааг харцгааж байв. Манан түүнийг аажмаар залгиж, биеийг нь улам бүдгэрүүлэн, хүний оронд дэлхий дээрх хамгийн цагаан цаасан дээр зурж эхэлж байгаа хүний дүрс болголоо. Хэсэг хугацаанд эмэгтэйн толгой, гар нь хөдлөн харагдаж байснаа зөвхөн орон зайд хөвж буй улаан цувны бараан цэг л үлдэв. Тэгээд энэ бараан цэг ч алга боллоо. Хэн ч, юу ч дуугарсангүй.

4. Агуулах. Генератор. Зөөгч яасан бэ?

Хоёр насандаа хормын дотор эргэн очсон Билли чанга, ухаангүй уйлж, ээжийгээ дуудаж гарлаа. Нүд, хацар нь нулимс, уруул ам нь нус, шүлс болсон түүнийг би чанга тэврэн арын эгнээнүүдийн дундуур явж, тайвшруулахыг оролдов. Бид хоёр дэлгүүрийн арын ханыг бүхэлд нь эзэлсэн махны урт цагаан хөргөгчний дэргэд зогслоо. Махны худалдагч ноён Маквей лангууныхаа ард зогсоор. Бид зүгээр л бие биесдээ толгой дохин мэнд хүргэлээ. Энэ нөхцөл байдалд өөр яах ч билээ.

Би шалан дээр сууж, Биллиг өвөр дээрээ аваад өөртөө нүүрээр нь наан элгэндээ тэвэрч тайвшруулж, юм ярьж эхэллээ. Би түүнд худал ярьж гарлаа, эцэг, эх хүүхэддээ хамгийн хүнд үед ярихаар нөөцөлдөг, тэгээд хүүхдэд асар үнэмшилтэй сонсогддог тэр худал яриаг би хүүдээ тун тайван ярилаа.

-Энэ манан бол зүгээр манан биш, тиймээ, ааваа? -гэж Билли намайг өнгө нь харлаж, нулимс дүүрсэн нүдээрээ ширтэн хэлэв.

-Тиймээ, энэ манан зүгээр нэг манан биш гэж аав нь бодож байна.

Хүүхэд гэнэтийн цочролтой томчуудаас өөрөөр тэмцдэг. Тэд цочролтой эвлэрэхийг оролддог, учир нь хүүхэд арван гурав орчим нас хүртлээ тэртэй тэргүй бараг л байнгын гэмээр шоконд амьдардаг. Билли зүүрмэглэж эхэллээ. Би түүнийг сэрчих вий хэмээн болгоомжилж тэвэрсээр байсан ч удалгүй тэр унтаад өгөв. Бүр жаахан байснаас нь хойш анх удаа л бид гурав хамт унтсан өчигдрийн шөнө хүү маань олигтой унтаж чадаагүй байх. Эсвэл, ингэж бodoход миний дотор хүйт орих шиг болж байлаа, эсвэл тэр ямар нэг юм урьдчилан мэдэрч байсан биз.

Биллиг бөх унтаж байгааг мэдээд би түүнийг шалан дээр тавьж, хучих юм хайн явлаа. Дэлгүүрт үлдсэн хүмүүс мананг харан цонхны дэргэд шавааралдсан хэвээр. Нортон хэдэн сонсогчид цуглуулж аваад ярьсаар, эсвэл ярихыг оролдсоор байна. Бад Браун байрандаа хатуу зогссон хэвээр, харин Олли Викс кассны дэргэдэх өөрийн байраа аль хэдийнэ хаяжээ. Айж сандарсан царай зүстэй хэдэн хүн тавиуруудын дундуур сүг мэт холхицгоноо.

Махны том хөлдөөгч, пивоны хөргөгч хоёрын дундах хоёр тийш онгойдог том хаалгыг нээн явааар би фанеран хананы цаана генератор жигд дүнгэнэн дуугарах агуулахын танхимд орлоо. Энд байдал нэг л биш. Дизелийн утaa дэндүү хүчтэй ханхалж байна. Би амьсгалаа барин фанеран хаалга руу явлаа. Дараа нь ам хамраа хуучин даавуугаар таглав.

Урт, нарийхан агуулахыг хоёр эгнээ аваарын чийдэнгүүд муухан гэрэлтүүлж байна. Хааяагүй давхарлан өрсөн хайрцагнууд харагдана: нэг талд нь будагтай хайрцагнууд, нөгөө талд нь элдэв ундаанууд, цаана нь гоймон, кетчуп... Нэг хайрцаг газар унаж, дотроос нь улаан шингэн асгарч байгаа харагдav.

Би генераторын өрөөний түгжээг мулталж дотогш орлоо. Цахилгаан үүсгүүрийг тослог цэнхэр утaa бүрхжээ. Уг нь яндан ханан дахь нүхээр гадагш гарсан байна, гэхдээ гадна талд ямар нэг зүйл түүнийг бөглөж, эсвэл таглаж орхисон бололтой. Генераторыг энгийн

товчлуураар асааж унтраадаг ажээ. Би товчлуурыг дарлаа. Генератор найтааж, үмхий утаагаар тургиад, хэд бөгшүүлэн чанга ханиасны дараа Нортоны зөрүүд хөрөө шиг аажмаар намдах бөглүү ханиадаар хэд ханиагаад таг болов.

Аваарын гэрэлтүүлэг унтарч, харанхуйд ганцаар үлдсэн би айж, тэр дороо зүг чигээ алдчихав. Миний өөрийн амьсгал сүрлэн дунд шуугих салхийг санагдуулна. Өрөөнөөс гарахаар тэмтчиж яваад би нимгэн фанеран хаалгыг хамраараа мөргөж, зүрх палхийв.

Агуулах орох хаалга нь шилэн цонхтой боловч яагаад ч юм, түүнийг нь хараар будчихсан, иймээс тасалгаанд тас харанхуй ноёлж байлаа. Би зүг чигээ алдаж, будагтай хайрцагнуудыг мөргөж, нураав. Нэгхайрцаг яг миний нүүрний урдуур доошунаж, би арагш алхаад өөр нэг хайрцагт тээглэн тас гэдэргээ уналаа. Би тархиа шаланд маш хүчтэй цохисноос нэг хэсэг нүдэнд хурц одод гялалзав. Сайхан юм болж байна даа!

Хэсэг хугацаанд би зүгээр л дээш харж хэвтээд өөрөө өөрийгөө харааж, тайвширч, босоод болгоомжтой явсаар гэрэлд гарахийг, Биллид очихыг хичээн цохисон газраа илж байлаа. Харанхуйд мөлхсөн, нойтон амьтан миний хөлийг ороогоод авах юм байхгүй хэмээн өөрийгөө тайвшруулж, хэрэв биеэ барьж чадахгүй сандарч, ийш тийш ухасхийх юм бол энд байгаа бүхнийг мөргөж, өөрөө өөртөө шинэ саад бэрхшээл тарих болно гэж бодов.

Дараа нь би аажмаар босч, хаалганы завсраар тусах харандаа шиг нарийхан гэрлийг нүдээрээ хайн, ханан дээр байгаа цагаан шохойн зураасыг бас арайхийн олж, хаалганы зүг удаан хөдөлснөө гэнэт нэг чимээ олж сонсоод дороо хөдөлгөөнгүй зогслоо.

Зөвлөн гулсах чимээ. Чимээгүй болсноо дахин гулсаж эхэллээ. Миний дотор хачин болж, зүрх хүчтэй цохилон, энэ харанхуй жижиг өрөөнд би дахин дөрвөн настай хүүхэд болон хувирлаа. Гулсах чимээ дэлгүүрийн зүгээс биш, араас сонсогдож байна. Гаднаас. Манангаас. Юу ч юм бетонон ханаар гулсаж, маажиж байна. Магадгүй, дотогш орохыг оролдож байна.

Эсвэл тэр ороод ирчихсэн, одоо над руу гулсаж явна. Хормын дараа энэ зөвлөн гулсагч миний хөлийг ороож авахыг би мэдрэх байх. Эсвэл хүзүү ороохыг.

Дахин гулсах чимээ гарлаа. Харин одоо би энэ чимээ гаднаас гарч байгаад итгэлээ. Гэхдээ сэтгэл тайвширсангүй. Би урагш явах гэсэн боловч хөл хөдөлж өгдөггүй. Дараа нь чимээ өөр болж, нэг юм харанхуйд ширчигнэн мөлхөх шиг болов.

Зүрх амнаас гарах шахаж, би урагш, нарийхан гэрэл рүү ухасхийн, урагш сарвайсан гараараа хаалгыг түлхэн, дэлгүүрийн танхимд үсрэн орлоо.

Хэдэн хүн, тэдний дунд Олли Викс хаалганы дэргэд зогсоно. Тэд айсан шинжтэй арагш ухасхийцгээж, цочсон Олли зүрхнээсээ барьж авав.

-Дэвид! -гэж тэр сандран дуу алдлаа. -Бурхан минь... Чи яаж байна аа? Намайг үхүүлэх гээ юу... -Тэр миний царайг харлаа. -Юу болоо вэ? Чи яачихав аа?

-Чи сонссон уу? -гэж би асуухад миний хоолой надад хачин нарийхан, чарлах мэт сонсогдов.

-Та нар юу ч сонсоогүй юу?

Мэдээж хэрэг, тэд юу ч сонсоогүй. Тэд генератор яагаад унтарсныг мэдэхээр энд иржээ. Олли энэ бүхнийг надад тайлбарлаж байтал хэдэн зайгаар ажилладаг гар чийдэн барьсан зөөгч хүрч ирээд эхлээд Оллиг, дараа нь намайг сониучирхан харав.

-Би генераторыг унтраасан гэж би хэлээд яагаад унтрааснаа тайлбарлалаа.

-Тэгээд, чи юу сонссон юм бэ? -тэж хотын автозамын удирдлагын газар ажилладаг нэг эр асуув. Түүнийг Жим гэдэг... Харин овгийг нь би санасангүй.

-Мэдэхгүй. Нэг тийм үрж, маажиж байгаа юм шиг. Гулсаж байгаа юм шиг. Дахиж л тийм юм сонсохгүй юмсан.

-Нерв л байхгүй юу гэж Оллитой хамт ирсэн нэг эр хэллээ.

-Үгүй. Нерв энд ямар ч хамаагүй.

-Чи энэ чимээг гэрэл унтрахаас өмнө сонссон уу?

-Үгүй, дараа нь. Гэхдээ... -Надад хэлэх үг олдсонгүй. Тэд намайг яаж харж байгааг би юу гэх вэ. Тэд муу мэдээ сонсохыг хүсэхгүй байна. Аймаар юм, бүр хачин сонин юм ч сонсох, харахыг тэд хүсэхгүй байна. Хачин юм хангалттай болсон. Ганц Олли надад итгэсэн шинжтэй харагдана.

-Генераторыг асаах хэрэгтэй гэж зөөгч гар чийдэн тараангаа хэллээ.

Олли гар чийдэнг авч, эргэлзсэн шинжтэй эргүүлж тойруулж үзэв. Зөөгч надад ч бас нэгийг өгөхдөө сүрхий үл тоосон шинжтэй харж байлаа. Арван найм орчим наслын залуухан хархүү. Хормын зуур эргэлзээд би гар чийдэнг авлаа. Биллиг хучих юм ч хайх хэрэгтэй.

Олли хаалгыг нээгээд байнга гэрэлтэй байлгахын тулд хайрцаг будгаар тээглүүлж орхив. Бүдэгхэн гэрэлд би агуулахын шалан дээр энд тэнд хэвтэх хайрцагнуудыг олж харлаа.

Жим хамраараа агаар сороод:

-Үнэхээр эвгүй муухай ханхалж байна. Чи яг зөв хийсэн бололтой гэлээ.

Гар чийдэнгийн гэрэл лаазалсан мах, нойлын цаас, нохойн хоол зэргийг хийсэн цаасан хайрцагнуудыг гэрэлтүүллээ. Гэрэлд утаа манаарна. Энэ бол яндан нь бөглөрснөөс дизелийн түлшний шаталтаас хуралдсан утаа. Зөөгч гар чийдэнгээр ачаа буулгах, ачихад зориулагдсан өргөн хаалгыг гэрэлтүүлэв. Олли хоёр эрийн хамт генераторын өрөөнд явж орлоо. Тэдний гар чийдэнгийн гэрэл хүүхдүүдийн адал явдалт зохиолд гардаг шиг ийш тийш үсчинэ. Коллежид оюутан байхдаа иймэрхүү маягаар олон аймшигт домгуудыг тоглодог байж билээ. Шөнө дунд цуст алтаа булж байгаа дээрэмчид, туршилт хийх хүүр хулгайлдаг галзуурсан профессор, түүний туслах хоёр... Гар чийдэнгийн гэрэл хананд хачин сонин, аймаар хэлбэр дүрс гаргаж байлаа. Генератор хөрч, хааяа тас няс хийх дуу гаргаж байв.

Зөөгч залуу ачаалах хаалгыг чиглэн явлаа.

-Би ч гадагш гарахгүй л байсан даа гэж би дуугарлаа.

-Чамайг гарахгүй гэдгийг чинь би мэдэж байна л даа.

-Олли, одоо нэг үз дээ гэж нэг эр хэлэв.

Генератор найдааснаа хүржигнэн асав.

-Фүү, чөтгөр! Унтраа! Ямар балиар новш вэ!

Генератор унтарлаа.

Зөөгч ачаалах хаалганаас эрчүүдийг генераторын өрөөнөөс яг гарцгааж байхад эргэж ирлээ.

-Тэнд үнэхээр яндан нь бөглөрсөн юм шиг байна гэж нэг эр хэлэв.

-Тэгэхээр ингээ гэж зөөгч хэллээ. Гар чийдэнгийн гэрэлд түүний нүд гялалзаж, нүүр нь өнөөх адал явдалт зохиолуудад би өчинөөн удаа зурж байсан тэр хүмүүстэй адилхан болов. -Та нар наадахаа тэр ачаалах хаалгыг нээхэд хангалттай хугацаанд л ажиллуулчих. Би гялс гадагш гараад, бөглөөсийг нь авчихъя.

-Норм минь, энэ ч зөв санаа гэж би бодохгүй л байна шүү гэж Олли эргэлзэн хэллээ.

-Энэ хаалга цахилгаан мотороор нээгддэг юмуу? -гэж Жим асуулаа.

-Яг тийм гэж Олли хэлэв. -Гэхдээ энэ ч яах аргагүй зөв санаа биш...

-Зүгээр гэж хоёр дахь эр бейсболын малгайгаа гэдэргээ болгонгоо хэллээ. Би чадна.

-Та нар ойлгохгүй байна.,. -гэж Олли дахин хэллээ. -Би үнэхээр хэн нэгнийг...

-Санаа бүү зов гэж өнөөх эр үл тоосон шинжтэй хэлэв.

Гэнэт зөөгч Норм уурлаад явчихав.

-Хөөе, наадах чинь миний санал шүү!

Тэд хэн нь гадагш гарах тухай маргаж гарлаа. Ерөөсөө гадагш гарах хэрэг байна уу, үгүй юу гэдгийг шийдэж ч амжаагүй байж шүү.

-Больцгоо! -гэж би чанга хэллээ.

Бүгд миний зүг эргэцгээв.

-Та нар энэ манан бол жирийн нэг манан биш гэдгийг ойлгоогүй л явцгааж байгаа бололтой. Тэгээд ойлгохыгхүсэхгүй байна. Энэ манангаас хойш дэлгүүрт гаднаас нэг ч хүн орж

ирээгүй. Хэрэв та нар энэ хаалгыг нээгээд, тэгээд ямар нэг юм ороод ирвэл...

-Юу орж ирэх юм? -гэж арван найман насны онгиргон зан нэвт шингэсэн хоолойгоор Норм асуув.

-Миний сонссон тэр чимээний эзэн.

-Ноён Дрэйтон гэж Жим хэллээ. -Та учлаарай, гэхдээ таныг ямар нэг юм сонссон гэж би бодохгүй байна. Таныг Нью-Йорк, Холливудад холбоо нөлөөтэй мундаг зураач гэдгийг би мэднэ, гэхдээ энэ чинь таныг бусад хүнээс өөр, онцгой болгохгүй шүү дээ. Та зүгээр л харанхуйд ганцаараа үлдээд, тэгээд... ээ... жаахан айчихсан байх гэж бодож байна.

-Магадгүй гэж би хэллээ. -Гэхдээ хэрэв та нар тэгж их гадагш зүтгээд байгаа юм бол эхлээд тэр хүүхдүүд нь гэртээ үлдсэн эмэгтэйг хүргээд өгчихгүй яасан юм бэ?

Түүний байдлыгойлгохгүй байгаа нь, бас түүний найз, бас зөөгч Норм нар бүгд байдлыг огт төсөөлөхгүй байгаа нь намайг бүр ч ихээр айлгаж байлаа. Тэдний нүд зарим эрчүүдийн нүд хог дээр харх буудахдаа гялалзаг шиг гялалзаж байв.

-Хөөе, залуу гэж Жимиийн найз хэлэв. -Бидэнд таны зөвлөгөө хэрэгтэй болвол бид танаас асууна, за юу!

-Генератор үнэхээр нэг их хэрэгтэй ч биш гэж Олли эргэлзэнгүй дуугарлаа Хөргөгчинд байгаа хүнсний бүтээгдэхүүн арван хоёр цаг, бүр түүнээс ч удаан хэвтэж байхад алзахгүй, ямар ч тог, элдэв...

-О'Кей залуу, урагшаа гэж Жим зөөгч залууд Оллиг үл тоон хэлэв. -Би генераторыг асаана, чи хаалгыг гялс нээгээрэй, энд утаа манаарчихаас өмнө, хурдхан нээнэ шүү. Майрон бид хоёр яндангийн дэргэд байна, чи бөглөөг нь авангут хашгираарай.

-О'Кей гэж Норм хөөрсөн шинжтэй хэлээд хаалга руу явлаа.

-Энэ чинь ёстой галзуурал гэж би хэллээ. -Та нар тэр эмэгтэйг ганцааранг нь явуулчихаад...

-Чи өөрөө явах чинь яасан юм?

-... одоо энэ хүүхдийг хэнд ч хэрэггүй генераторын төлөө үхлийн аюулд аваачиж байна.

-Чи дуугүй болох уу, үгүй юу? -гэж Норм хашгирлаа.

-Ноён Дрэйтон та сонс гэж Жим хэлэхэд нүүрэн дээр нь зэвүүн инээмсэглэл тодров.

-Хэрэв та дахин юм хэлэх гэж байгаа бол эхлээд аман дахь хэдэн шүдээ тоолоорой, эс тэгвэл энэ баасыг чинь сонсохоос дургүй хүрч эхэлж байна шүү!

Олли миний зүг айсан шинжтэй харлаа. Би мөрөө хавчив. Тэд бүгд зүгээр л галзуурчихаж. Тэд харьцангуйн төсөөллөө алдсан байна. Тэд айж, учраа олохoo байсан, гэтэл тэдний өмнө

цэвэр механик асуудал - генератор гараад ирлээ. Үүнийг тэд шийдэж чадна, тэгээд бага ч гэсэн айдас, арчаагүй байдлаасаа ангижрана. Тиймээс тэд энэ асуудлыг шийдэх болно.

Жим, түүний найз хоёр намайг буулгаж авлаа гэж шийдсэн бололтой, генераторын өрөөний зүг явлаа.

-Норм, чи бэлэн үү? -гэж Жим асуув.

Норм толгой дохисноо үүнийг нь хэн ч хараагүйг ойлгосон бололтой:

-Тийм гэлээ.

-Норм гэж би хэлэв. -Бүү тэнэглэ.

-Энэ ч буруу шүү гэж Олли нэмлээ.

Норм биднийг харахад царай нь гэнэт арван найман настай хүүхдийнхээс огт өөр болов. Түүний нүүр жаахан хүүхдийнх шиг болжээ. Түүний төвөнх гүлсхийн хөдөлж, тэр ухаан алдталаа айсныг би ойлголоо. Тэр амаа ангайн нэг юм хэлэх, магадгүй татгалзах гэтэл генератор хүржигнэн асав. Дуу нь жигд болмогц Норм хаалганы баруун талд харагдах товчлуурыг дарлаа. Хаалга удаан, хяхтнан, хоёр төмөр ховилыг даган дээшлэв. Генератор асмагц аваарын гэрэлтүүлэг ассан боловч одоо хаалга нээгдэхэд эрчим хүч шаардагдаж байгаа тул чийдэнгүүд муухан ёлтойн гэрэлтэж байлаа.

Сүүдэр арагш ухран, уусан алга болов. Агуулах бүрхэг өвлийн өдөр шиг бүүдгэр гэрлээр дүүрч, би өнөөх хачин эхүүн үнэр ханхалж байгааг дахин мэдэрлээ.

Хаалга эхлээд хагас метр, дараа нь метр нээгдэж, би хаалганы цаана шар зураастай бетонон талбай байгааг харлаа. Хаалганаас хагас метрийн цаана л юу ч харагдахгүй, бүгд сүүн цагаан мананд умбажээ.

-Оопаа! -гэж Норм хашгирлаа.

Манангийн дун цагаан "дөлүүд" хээ угалз мэт мушгиран хүйтэн агаартай хамт агуулахад орж ирэв. Өглөө сэргүүхэн байсан, тэр тусмаа өмнө нь олон хоног аймшигтай халуун байсан болохоор хүмүүс үүнд баярлаж байсан, харин одоо гадаа үнэхээр хүйтэн, гуравдугаар сарынх шиг хүйтэн болжээ. Би цочин давхийж, Стеффийн тухай бодлоо.

Генератор яг Нормыг хаалган доогуур шурган ухасхийхэд унтарлаа. Жим хаалганы цаанаас гарч ирэв. Тэгээд тэр харсан. Би ч харсан. Олли ч бас.

Ачаа буулгах, ачих бетонон талбайн цаанаас урт гэгчийн тэмтрүүл суналзан гарч ирээд Нормын баруун хөлийг ороолоо. Миний эрүү тагхийн унах шиг болохыг би мэдэрлээ. Олли цочсондоо хоолойгоо хачин хяхтнуулан дуугаргав. Тэмтрүүл Нормын хөлийг өвдөгнийх нь доохнуур ороож авсан тэр хэсэгтээ гучин сантиметр орчим бүдүүн, харин мананд далд орсон тэр хэсэгтээ метр, метр хагас байсан байх. Дээд талаараа саарал, дотор тал нь нялх хүүхдийн бие шиг зөөлөн ягаан, тэгээд дотор талаар нь хоёр эгнээ соруулууд хэдэн зуун жижигхэн ам

мэт хөдөлж байлаа. Норм доош тонгойж, хөлийг нь юу татаад байгааг харлаа. Түүний нүд ухаангүй айснаас дугариг болжээ.

-Үүнийг зайлцуул! Хөөе үүнийг аваач! Чөтгөр гэж үүнийг салгаад өгөөч!

-Бурхан минь гэж Жим арай ядан дуугарлаа.

Норм хаалганы доод талын хөндлөвч төмөрнөөс барьж аваад буцан зүтгэв. Тэмтрүүл гарын булчин мэт бага зэрэг бамбайж, Нормыг хаалгаар буцаан угз татахдаа толгойг нь хаалганд цохилоо. Дараа нь тэмтрүүл дахин чангарч Нормыг тал биеийг нь гадагш чирэн гаргав. Нормын цамц хаалганы доод талд тээглэж, өмднөөсөө мултарчээ. Норм дахин урагш зүтгэж, турникэн дээр суниаж байгаа тамирчин мэт өөрийгөө дотогш таглаа.

-Туслаарай, туслаач дээ! -гэж тэр уйлан гуйна -Хөөе, та нар, надад туслаач! Гуйя, туслаач дээ!

-Ийсүс, Мария, Иосиф... -гэж генераторын өрөөнөөс гарч ирээд юу болж байгааг харсан Майрон амандаа бувтнаж гарлаа.

Би Нормд бусдаас ойрхон зогсож байв. Түүний бүснээс атгаж аваад би хар хүчээрээ, өсгийн дээрээ тэнцэж ядан арагш чангаав. Хормын төдийд үнэхээр бид хоёр арагш ухарлаа, гэхдээ ердөө л хормын төдийд. Энэ нь зузаан хаймар, эсвэл маш хатуу эспандер татахтай адил ажээ. Тэмтрүүл сунасан ч тавьсангүй. Манан дундаас дахин гурван тэмтрүүл гарч ирээд бидний зүг мушгиран ойртлоо. Нэг нь салбайн унжих улаан хормогчийг нь Нормаас угз татан аваад алга болов. Тэмтрүүл энэ улаан хормогчийг ороож аваад мананд далд ороход яагаад ч юу миний толгойд ах бид хоёр багадаа ээжээс элдэв юм гуйхаар ээж юу гэж хариулдаг байсан нь санаанд орлоо. Ах бид хоёр чихэр, зурагтай ном мэтийн юм авч өгөхийг гүйхад авч өгөх шаардлагагүй үед ээж маань чамд наадах чинь тахианд туг шиг л хэрэггэй байх" гэдэгсэн. Тэмтрүүл Нормын улаан хормогчоор даллаж байхыг хараад би энэ бүхнийг санаж инээлээ. Гэхдээ миний инээх, Нормын уйлах 2 бараг л адилхан сонсогдсон байх. Магадгүй хэн ч намайг инээж байна гэж ойлгоогүй биз.

Нөгөө хоёр тэмтрүүл яг миний сонссон шиг чимээ гарган бетон дээгүүр урагш хойш гулсаж байв. Дараа нь нэг нь Нормын зүүн хөлийг мөргөж, гэдсээр нь ороож авлаа. Ингэж ороохдоо тэмтрүүл миний гарыг шургэсэн ч тоосонгүй. Тэмтрүүл булээн, гөлгөр, цус гүйж буй мэт бамбалзах ажээ. Хэрэв тэр миний гарыг соруулзуудаараа зуураад авсан бол би ч гудамжинд гарчих байсан биз.

Гуравдахь тэмтрүүл Нормын хөлийг шагайгаар нь ороон авч, одоо гурван тэмтрүүл хөөрхий залууг зэрэг татаж эхлэв.

-Туслаарай! -гэж би ориллоо. -Олли! Хөөе, та нар! Туслаарай!

Хэн ч ойртсонгүй. Тэд чухам юу хийж байсныг би мэдэхгүй, гэхдээ бидэнд туслахаар хэн ч ирсэнгүй.

Би доош тонгойгоод Нормыг гэдсээр нь ороосон тэмтрүүл арьсанд нь шигдэж байгааг харав. Цамц өмднөөс нь мултарсан нүүцгэн биенд соруулууд шигдэн оржээ. Бамбалзах тэмтрүүл арьсанд улам гүн шигдэж, өнөөх улаан хормогч шиг цус дусалж эхэллээ. Би толгойгоороо хаалганы доод хөндлөн төмрийг цохиж, Нормын хөл дахиад л гудамжинд гарав. Нормын нэг пүүз хөлөөс нь мултран унахад манангаас бас нэг тэмтрүүл гарч ирээд үзүүрээрээ пүүзийг ороон авч, эргэн алга болов. Нормын цайрсан гар хаалганы доод төмрөөс үхсэн мэт зуурчээ. Тэр хашгирахаа больчихсон, зөвхөн толгой нь зогсоо зайгүй "үгүй" гэх мэт хоёр тийш савчиж, урт хар үс нь сэгсэлзэж байв.

Би манангаас тэмтрүүлүүд гарч ирж байгааг харлаа: эхлээд арваад, дараа нь ерөөсөө л ойн мод мэт тоолохын аргагүй олон тэмтрүүлүүд гарч иржээ. Тэдний дийлэнх нь жижигхэн, гэхдээ хэдэн тэмтрүүл аварга том, өглөөний зам дээр хэвтэж байсан хөгшин мод шиг, тэгээд траншейны ам шиг том, зөөлөн ягаан соруулууд нь хүнийг бүхлээр нь залгичихаар харагдана. Нэг тийм тэмтрүүл бетонон талбай дээр түсхийн унаад бидний зүг сохор өт мэт мөлхөж эхэллээ. Би дахин хар хүчээрээ угзрахад Нормын баруун хөлийг ороосон тэмтрүүл багахан тавьснаас илүү юм болсонгүй. Тэгээд дахин хөлийг чанга ороож авахын өмнө би энэ тэмтрүүл ч соруулуудаараа Нормыг амьдаар нь сорж байгааг олж харлаа.

Нэг тэмтрүүл миний хацрыг шүргээд бодлогошрох мэт агаарт чичирж гарав. Би ноён Маквейн махны урт цагаан хөлдөөгчний дэргэд унтаж байгаа Биллиг, энд би өөрөө түүнийг хучих юм хайж ирснээ саналаа. Хэрэв энэ тэмтрүүлүүдийн нэг нь намайг ороогоод авбал түүнд санаа тавих хүн магадгүй, Нортоноос өөр байхгүй...

Би Нормыг тавиад өвдөгдээрээ уналаа. Тэмтрүүл миний зүүн талаар соруулуудаараа явах мэт гулсан өнгөрч, Нормын гарыг шүргэж, хормын төдийд хөдөлгөөнгүй болсноо ороож авав.

Норм одоо могоян тухай аймшигт зүүдний дүр зураг мэт болжээ. Тэмтрүүлүүд түүнийг бараг л битүү ороож, одоо намайг тойрон гулсаж байлаа. Би арайхийн хажуу тийш үсрэн, өнхрөн зайллаа. Жим, Олли, Майрон гурав гэж хатагтай Тюссогийн лааны тосон музейн үзмэрүүд шиг цонхигор царайтай, гялалзсан нүдтэй нөхдүүд хөшсөн мэт зогсоцгоно. Жим, Майрон хоёр генераторын өрөөний хаалганы хоёр талд зогсчээ.

-Генератораа асaa! -гэж би ориллоо.

Хэн ч байрнаасаа хөдөлсөнгүй.

Тэд ховсдуулчихсан мэт ачаалах хаалгыг гөлрөн ширтэцгээж байна. Би шал тэмтчиж, гартаа тааралдсан эхний зүйлийг шүүрч аваад (хайрцаг будаг) Жимиийн зүг шидлээ. Хайрцаг түүний яг гэдсэн дээр, бүснийх нь толины дээхнэ бууж, Жим "хэг" гэж дуугараад гэдсээ барьж авлаа. Түүний харц бага ч гэсэн хүний ухаантай болжээ.

-Тэр новшийн генератораа асаагаач! -гэж би хоолойгоо өвдтөл чанга хашгирав.

Тэр байрнаасаа хөдөлсөнгүй, харин манангаас аймшигийн чөтгөр гарч ирээд Нормыг бараг л амьдаар нь идэж байхад үүнд хэн буруутайгтоогох цаг ирлээ гэсэн шиг өөрийгөө хамгаалж гарлаа.

-Би буруугүй гэж тэр нарийхан чарлаа дуугаар хашгирав. -Би мэдээгүй... Чөтгөр гэж, би яаж мэдэх юм бэ? Чи юм сонссон л гэсэн, харин би чамайг юу яриад байгааг ойлгоогүй... Илүү сайн тайлбарлах хэрэгтэй байсан юм. Би бодохдоо... Мэдэхгүй... Шувуу ч юмуу...

Ухаан орсон Олли түүнийг мөрөөрөө түлхэн зайлзулаад генераторын өрөөнд давхин орлоо. Жим будагтай хайрцганд бүдэрч миний харанхуйд унасан шиг шалан дээр годройтон унав.

-Би буруугүй гэж тэр давтлаа.

Түүний улаан үс духыг нь бүрхжээ. Хацар нь бяслаг шиг цагаан, нүдэнд нь жаахан хүүхдийн айдас шингэжээ. Хормын дараа генератор найтааж, дараа нь ажиллаж эхэллээ.

Би ачаалах хаалгыг харлаа. Норм бараг үзэгдэхээ байсан ч нэг гараараа хаалганы доод төмрөөс зуурсаар. Түүнийг тойрон тэмтрүүлүүд бужигнаж, шалан дээр арван центийн зоосны дайтай цус дусалж байв. Түүний толгой урдын адил хоёр тийш савчиж, мананг харж буй нүд нь ухархайнаасаа бүлтийн гарчээ. Өөр хэдэн тэмтрүүл хаалганы зүг гулсаж, байшин дотор ороод ирчихэж. Хаалганы механизмыг ажиллуулдаг товчуурын дэргэд тэмтрүүлүүд ойртохоос ч аймаар олон байлаа. Тэдний нэг пепсийн хагас литрийн савыг ороож аваад алга болов. Өөр нэг тэмтрүүл цаасан хайрцгийг ороон бяцаллаа. Картон түсхийн хагарч, дотроос нь нойлын цааснууд тал бүр тийш цацагдан шалан дээгүүр таран өнхрөлдлөө. Тэмтрүүлүүд тэднийг хэдхэн хормын дотор ороон авцгаав.

Хамгийн том тэмтрүүлүүдийн нэг бусдаас хол мөлхөж, үзүүр нь шалнаас баг зэрэг өндийгөөд , үнэрч нохой мэт Майроны зүг гулсав. Майрон нүдээ галзуу мэт эргэлдүүлэн үсрэн зайлхад түүний амнаас айснаас нарийхнаар чарлах дуу гарав. Би нүдээрээ ханан дахь товчуурт тэмтрүүлүүдийн дундуур яаж ийгээд хүрээд хатгачих зүйл хайн ийш тийш харлаа. Хана түшүүлэн тавьсан шалны мод миний харцанд өртөв.

Норм удаан тэсч чадсангүй, гараа тавьж, бетон шалан дээр өөр бариад авах юм хайж чөлөөтэй гараа сарвалзуулан уналаа. Бидний харц хормын төдийд тулгараход нүд нь гялалзаж байсан ч тэр өөрийг нь ямар төгсгөл хүлээж байгааг ойлгож байгаа мэт надад харагдлаа. Тэгээд овоорсон тэмтрүүлүүд Нормыг манан дотор чирэн оруулав. Тэр эцсийн, хагас боомилогдсон бөглүү дуугаар хашгираад алга боллоо.

Би шалны модын ишээр товчуурыг дарахад мотор орилон дуугарч, хаалга доош гулслаа. Хаалга доош буухдаа Майроны зүг гулсаж байсан бүдүүн тэмтрүүлийг эхлээд дарж, дараа нь арьс ч юмуу, юу тэдэнд байдаг юм гадаргууг нь хэрчээд аажмаар тэмтрүүлийг тэр чигээр нь тасалж орхив. Тасарсан тэмтрүүлээс хар шингэн цацаллаа. Тасархай тэмтрүүл галзуу мэт татваганаж, агуулахаар хачин муухай бүдүүн олс мэт мушгиран өнхөрч гарлаа. Дараа нь гэнэт нарийсч хаалган доогуур чихэн гараад алга болов. Бусад нь мөн л ухарч хаалган доогуур орон алга болцгоож эхлэв. Тэдний нэг нь хоёр килограммын лаазтай нохойн хоол чирж, түүнийгээ тавихыг ер хүссэнгүй. Хаалга түүнийг тас татан бууж, бетон шаланд тулан зогсов. Тасархай тэмтрүүл амь тавих мэт агшиж, лаазыг бяц базан, агуулахаар нохойн хоолны хүрэн хэрчмүүд цацагдлаа. Тэмтрүүл эрэг дээр гаргаж шидсэн загас мэт үсчив. Тэр мушгирч, тэнийж, өнхрөх нь аажмаар удааширсаар эцэстээ хөдлөхөө байлаа. Би түүнийг шалны модны ишээр хатгахад метр урт тэмтрүүлийн тасархай шунагаар ишийг ороон авснаа амь тавих мэт

улбайн нойлын цааснууд, нохойн хоол, лаазтай будагны дунд хөдлөхөө байлаа.

Нам гүм болж, зөвхөн генератор жигд дүнгэнэн, фанеран хананы цаана Оллийн уйлах сонсогдоно. Тэр сандал дээр хоёр гарынхаа алгаар нүүрээ даран суусныг би онгорхой хаалгаар харж байлаа.

Дараа нь би өөр нэг чимээ сонсож байгаагаа мэдрэв. Зөөлөн гулсах чимээ, энэ бол миний урд нь сонссон чимээ мөн байна, харин одоо тэр арав дахин хүчтэй сонсогдож байна.

Майрон миний зүг хэд алхлаа.

-Сонсооч гэж тэр хэллээ. -Чи ойлгож байгаа...

Би түүний нүүрэнд нударгаа буулгахад тэр балмагдсандаа гэнэтийн дайралтаас өөрийгөө хамгаалсан ч үгүй. Хага цохиулсан дээд уруулнаас нь цус урсаж эхэллээ.

-Чи түүнийг алчихлаа! -гэж би хашгирлаа. -Чи юу болсныг сайн харсан биз? Чи юу хийснээ харж байна уу?

Би түүнийг баруун зүүнгүй балбаж гарлаа, гэхдээ коллежид байхдаа боксын секцэнд сурсан шигээ биш, зүгээр л хоёр гараараа ээлжлэн нударгалж гарав. Айдас, гэмшлээс болсон биз, хачин хөдөлгөөнгүй, гөлрөө байдалд орсон Майрон ухарч, зарим цохилтыг хаан, заримд нь цохиулж байв. Харин би үүнээс нь улам уурлаж байлаа. Би түүний хамрыг нээж, нүдийг мъ хөхөртөл цохив. Энэ нүд харлаад ирэхээрээ лут сайхан харагдах ёстой. Би түүний эрүүнд цохисны дараа Майроны нүд манантаж, ухаан мэдрэлээ алдах шиг болов.

-Сонсооч гэж тэр үглэсээр. -Сонсооч, сонс л доо...

Би түүний элэг рүү цохиход тэр "хэг" -хэмээн амьсгалаа гаргаад нам болов. Хэр удаан би түүнийг нүдэх байсныг бүү мэд, гэнэт намайг нэг хүн араас барьж авлаа. Би ухасхийн мултарч, энэ Жим байх гэж найдан эргэлээ. Түүнийг ч би хэд цохиод авмаар байсан юм.

Харин энэ бол Жим биш, Олли байлаа. Үхдэл мэт цонхийсон дугариг царайтай, нулимс нь хатаагүй нүдэн доор нь хар хүрээ татсан Олли.

-Дэвид, хэрэггүй гэж тэр хэллээ. -Түүнийг одоо зодох хэрэггүй. Энэ чинь юу ч өөрчлөхгүй.

Балмагдаж, бүрэн хямралд орсон царайтай Жим холгүй зогсоно. Би цаасан хайрцаг түүний зүг өшиглөв. Хайрцаг Жимиийн хөлийг онолоо.

-Чи, чиний найз хоёр бол өөдгүй нохойн бааснууд гэж би хэлэв.

-Боль Дэвид гэж Олли ядарсан дуугаар хэллээ. –Тайвширч үз.

-Та хоёр, муу тэнэг хоёр новш, тэр хүүг алчихлаа.

Жим толгой гудайлган зогсож, Майрон бүдүүн, "пивоны" гэдсээ тэврэн сууна. Би хүнд

амьсгалж, чамархайд цус цохилж, бас салгалан чичирж байлаа. Би хоёр цаасан хайрцган дээр суугаад толгойгоо унжуулж, хоёр гараараа хөлөө шагайны дээхнүүр барив. Нэг хэсэг би хөдөлгөөнгүй суун, ухаан алдах, бөөлжихийн аль нь эхэлж ирэхийг хүлээж байлаа. Дараа нь дотор бага зэрэг онгойж, би Оллиг харлаа. Түүний ягаавтар бөгж аваарын гэрэлд бүдэгхэн гялалзана.

-За, за гэж би дуугарав. -Боллоо.

-Сайн байна Олли миний зүг ширтлээ. -Одоо цааш яахаа бодох хэрэгтэй.

Дахин дизелийн утгаа ханхалж эхлэв.

-Юуны өмнө генераторыг унтраах хэрэгтэй.

-Тийм, тэгээд эндээс зайлцгаая гэж Майрон нэмээд намайг гэмшингүй харлаа. -Энэ залуу үхсэнд би мэдээж харамсаж байна. Гэхдээ чи ойлгох хэрэгтэй...

-Юу ч ойлгохыг хүсэхгүй байна. Та хоёр дэлгүүрт очоод, пивоны хөргөгчний дэргэд хүлээж бай. Хүмүүсд юу ч ярьж болохгүй. Одоохондоо болохгүй.

Жим, Майрон хоёр маргасангүй, хаалгаар шахалдан гарав. Олли генератор унтрааж, харанхуй болохын өмнөхөн би ачигч нар хагарах зүйлийн дор дэвсдэг даавуун хөнжил мэт зөөлөн хивсэнцэр олж авлаа.

Хөлөөрөө хайрцаг өшиглөн, юунд ч юм бүдэрсээр Олли генераторын өрөөнөөс гарч ирэв. Бүх л тарган хүмүүсийн адил тэр хүндэвтэр, хяхтуулан амьсгаадна.

-Дэвид гэж тэр дуудахад хоолой нь бага зэрэг чичирж байв. -Чи энд байна уу?

-Байна, чи болгоомжтой, энд будагтай хайрцаг зөндөө байна шүү.

Би түүнд хaa байгаагаа хэлж, хормын дараа тэр миний мөрөн дээр гараа тавьж аваад тайвширан шинжтэй уртаар санаа алдлаа.

-Чөтгөр гэж, за эндээс гарья. Энд харанхуй, ёстой новшийн муухай байна.

-Тийм шүү гэж би хэллээ. -Гэхдээ хүлээ, Олли. Би тэр хоёр малыг байхгүйд чамтай ярих хэрэгтэй байна.

-Дэйв, тэд Нормыг хүчээр гаргаагүй шүү дээ. Чи үүнийг ойлгох ёстой.

-Норм бол хүүхэд, харин энэ хоёр бол том хүмүүс. За энэ ч яахав. Бид болсон явдлын тухай тэдэнд ярих хэрэгтэй болно. Дэлгүүрт байгаа хүмүүст.

-Хэрэв хүмүүс паникт орвол... -гэж Олли эргэлзсэн шинжтэй дуугарав.

-Орж ч магад, үгүй ч байж магад. Харин тэд гадагш гарагаа гэж зүтгэхийн өмнө сайтар

бодоцгооно. Бүгд л гарах гэж зүтгээд байна шүү дээ. Хүн бүрийг ар гэрт нь хүлээж байгаа. Намайг ч гэсэн. Тэд гадагш гарвал юу хүлээж байгааг тэдэнд ойлгуулах хэрэгтэй.

-За гэж Олли миний гарыг чанга атган хэллээ. -Харин би өөрөөсөө зогсоо зайгүй асууж байна... Энэ наймаалжийнх шиг тэмтрүүлүүд... Дэвид, тэр юуных вэ? Юунд ийм тэмтрүүл байдаг юм бэ?

-Мэдэхгүй. Гэхдээ тэр хоёр өөрсдөө бураад унахыг би хүсэхгүй. Тэгвэл хүмүүс ёстой паникт орно доо. Явъя.

Би харж харж хаалганы завсрын нарийхан гэрлийг оллоо. Бид хайрцааг, лаазанд бүдрэхгүйн тулд хөлөө гулсуулан урагшлав. Олли миний гараас барьсан хэвээр. Энэ үед би бүх гар чийдэнгээ хаячихснаа саналаа. Хаалганд тулж ирэхэд Олли гэнэт:

-Бидний харсан тэр зүйл... Ийм юм байж болохгүй шүү дээ, Дэвид. Тийм биз дээ? Бур Бостоны Далайн үзмэрийн ачааны машин ийм "Усан доогуур хорин мянган бээр" -ийнх шиг юм дэлгүүрийн дэргэд унагаж орхисон ч ийм юм байж болохгүй. Тэр нь зүгээр л үхэж орхих ёстой. Үхэх ёстой.

-Тийм гэж би хэлэв. -Зөвшөөрч байна.

-Тэгээд юу болов oo? Ямар чөтгөр нь энд ирчихээ вэ?

-Олли, би мэдэхгүй гэж би хэлээд хамтдаа дэлгүүрт явж орлоо.

5. Нортоны маргаан. Пивоны хөргөгчний дэргэдэх яриа. Баталгаа

Жим, түүний анд Майрон нар хаалганы дэргэд, гартаа нэг лааз "Будвайзер" бариад зогсож байв. Би Билли дээр очиж, унтарсаар байгааг нь хараад хивсэнцрээр хучив. Тэр нойрондоо хөдөлснөө дахиад унтаад өглөө. Би цагаа харлаа: 12:15. Гайхмаар юм. Биллиг хучих юм хайн явснаас хойш дор хаяж таван цаг өнгөрсөн шиг надад санагдаж байна. Гэтэл үнэн хэрэгтээ гучин таван минут ч хурсэнгүй.

Би Олли, Жим, Майрон нар дээр эргэж очлоо. Олли ч бас пиво барьчихсан, нэг лаазыг надад өглөө. Би өглөө мод хөрөөдөж байхдаа уусан шиг нэг балгаар лаазны талыг ууж орхив. Жаахан хөнгөрлөө. Жим бол Жим Грондин, харин Майроны овог нь Ляфлер гэнэ. Инээдтэй юм, гэвч яая гэхэв, Майронцэцгийн уруул, эрүү, хацар дээр нь хатсан цус харагдана. Цохиулсан нүд нь хавдаж эхэлжээ. Улаан хормогчтой бүсгүй хажуугаар нь өнгөрөхдөө түүнийг болгоомжилсон шинжтэй харлаа. Би бүсгүйд тэр зөвхөн залуухан хүү нарт л аюултай гэж хэлэх гэснээ болив. Эцсийн эцэст Олли зөв хэлсэн: тэд үнэхээр сайн л юм хийе гэж бодсон, гэхдээ үүнийг ямар ч бодлогогүй, бусдад тус болохоосоо илүү хор болохоор бодож, зохион байгуулсан.

Харин одоо энэ хоёр миний зөв гэсэн бодлоо хэрэгжүүлэхэд надад туслах болно. Ер нь тэд нэг их эсэргүүцээд байхгүй гэж би бодож байлаа, болж өнгөрсөн үйл явдал тэднийг маш хүчтэй цочроосон, тэд, ялангуяа Майронцэцг тодорхой хугацаанд шоконд байх болно. Нормыг яндан цэвэрлэхээр явуулахад гялалзаж байсан тэдний нүд одоо унтарчээ.

-Бид хүмүүст юу ч юм, хэлэх ёстой гэж би эхэллээ.

Жим эсэргүүцэхээр амаа ангайв.

-Хэрэв та хоёр бидний ярьсныг баталвал Олли бид хоёр ч та нарыг Нормыг гадагш гаргасан гэж яриад байхгүй. Тэгээд түүнийг... чирээд явчихсан гэж.

-Тэгэлгүй яахав гэж Жим долигоносон шинжтэй хэллээ. -Хэрэв бид хэлэхгүй бол хэн нэгэн бас л гадагш гарна. Яг өнөөх эмэгтэй шиг... Тэр лаазтайгаасаа хурдан балгав. -Бурхан минь, юу болоод байна аа?

-Дэвид гэж Олли эхэллээ. -Хэрэв юу явал... -Тэр дуугүй болсон ч хүчээр шахам үргэлжлүүлэв. -Хэрэв тэд дотогш ороод ирвэл яах вэ? Тэмтрүүлүүд?

-Яаж? -гэж Жим асуув. -Та нар хаалгыг хаасан биз дээ?

-Тийм гэж Олли хариуллаа. -Гэхдээ дэлгүүрийн нүүрэн тал чинь тэр чигээрээ үзмэрийн шилэн цонх шүү дээ.

Надад хорин давхраас цахилгаан шатны бүхээгэн дотор доош унаж байгаа мэт санагдаад явчихлаа. Мэдээж хэрэг, би үүнийг мэдэж байсан, гэхдээ яагаад ч юм саяхныг болтол үүнийг амжилттай мартаж явж. Би Биллийн унтаж байгаа зүг эргэж, Нормыг тэмтрүүл чирэн авч явсан шиг Биллиг ороон авч байгаагаар төсөөлөв.

-Үзмэрийн шил гэж Майрон шивнэв. -Гэгээн Бурхан минь!..

Би хоёр дахь лаазаа задалж эхэлсэн тэднийг хөргөгчний дэргэд үлдээгээд Брент Нортоныг хайхаар явлаа. Нортон хоёрдугаар кассын дэргэд Бад Браунтай ярилцан зогсож байв. Тэр хоёр, бууралтаж эхэлсэн ганган халимагтай, нас ахиж яваа ч идэвхтэй чадалтай эр хүний гоо үзэсгэлэнтэй Нортон, хатуу, зарчимч нүүр царайтай Браун хоёр хамтдаа эгээ л "Нью-Йоркер" сэтгүүлийн хошин зураг мэт харагдана.

Хорин тав орчим хүн үзмэрийн цонх, кассны шугамын хооронд урагш хойш хөлхөнө. Зарим нь цонхны дэргэд эгнэн зогсоод мананг харцаана: энэ нь надад шинэ барилгын ажлыг хашааны нүхээр харж байгаа улсыг дахин санагдууллаа.

Хатагтай Кармоди кассны дэргэдэх хөврөгч шугаман дээр суугаад тамхи татаж байна. Түүний харц над руу чиглэснээ хатагтай харцаа бурууллаа. Кармоди яг л сэргүүн зүүдэлж буй мэт харагдана.

-Брент гэж би дуудлаа.

-Дэвид? Чи хаашаа алга болчихов оо?

-Яг энэ тухай л би чамтай яримаар байна.

-Хөргөгчний тэнд хэдэн хүн пиво ууж байна гэж Браун сүмийн үдэшлэг дээр порно кино гаргаж байна гэж хэлж байгаа хүний хоолойгоор баргар царайлан дуугарав. -Би тэднийг тусгай толинд харж байна. Үүнийг болиулах хэрэгтэй.

-Брент?

-Уучлаарай ноён Браун, би одоохон.

-Тэгэлгүй яах вэ. -Браун гараа энгэртээ зөрүүлээд цүлхгэр толийг барайн ширтлээ. -Үгүй, энэ бүхнийг таслан зогсоох хэрэгтэй.

Нортон бид хоёр сав суулга, гал тогооны хэрэгсэл тавилсан тавиуруудын дэргэдүүр дэлгүүрийн цаад өнцгийг чиглэн алхав. Би эргэж хараад үзмэрийн шилний жааз мод ямар хүчтэй нумарч, зарим газраа хугарсныгсэтгэл өвдөн ажиглалаа. Раамны нэг хэсэг газар хөдлөлт мэт доргилтын дараа хугарч, зүсэм бялуу шиг өнгөт гоёлын шил хагаран унаж байсан. Гарсан нүхийг бид элдэв даавуу шаавуугаар, жишээ нь дарсны тавиурын дэргэд миний харсан 3 доллар 95 центийн үнэтэй эмэгтэй хүний цамцнуудаар бөглөж болох юм...

Энэ бодол гэнэт тасарч, би хэхрэлтээ нууж байгаа хүн мэт амаа гарынхаа алгаар дараахаас өөр аргагүй болов. Үнэн хэрэгтээ энэ бол Нормыг чирээд явчихсан тэмтрүүлүүдээс би цонхны хагархайг эмэгтэй хүний цамцаар халхлан хамгаалах гэж байгаа өөрийгөө шоолон инээсэн айсан хүний муухай инээдээ л нуух гэсэн хэрэг. Тэмтрүүлүүдийн нэг, гэхдээ хамгийн том нь биш шүү, лаастай нохойн хоолыг зүгээр л тал бүр тийш цацагдтал бяц базаж байхыг би өөрөө харсан.

-Дэвид, чи зүгээр үү?

-Яав?

Чиний нүүр чинь... чи нэг их сайн, эсвэл бүр аймшигийн зүйл бодож олсон юм шиг харагдаж байна.

Намайг гэнэт цохиод авах шиг болов?

-Брент, өнөөх манан дундаас гүйж гарч ирээд Жон Ли Фровиныг татаад аваад явчихлаа гэж хашгираад байсан хүн ясан бэ?

-Хамраас нь цус гарсан уу?

-Тийм, яг тэр чинь.

-Тэр ухаан алдчихсан, ноён Браун түүнийг анхан шатны тусlamжийн аптекны ямар ч гэнэ үү, давсаар ухаан оруулсан. Юу гэж?

-Тэр ухаан ороод юм хэлсэн үү?

-Өөрийнхөө хий харсан юмаа л үглээд байсан. Ноён Браун түүнийг өрөөндөө аваачсан, эмэгтэйчүүд аиж эхэлсэн юм л даа. Тэр өөрөө ч дуртай явсан. Шилний тухай нэг юм хэлээд байсан, тэгээд ноён Браун менежерийн өрөөнд гадна талаараа төмөр тортой жижигхэн ганцхан л цонх байдаг гэсэн чинь дуртай нь аргагүй явсан. Тэндээ л байгаа биз.

-Түүний ярьсан зүйл хий хоосон юм биш.

-Мэдээж хэрэг, биш.

-Тэгвэл тэр газар хөдлөлт шиг цохилт?

-Мэдээж, бас үгүй. Гэхдээ Дэвид...

Тэр айчихсан байна, гэж би өөртөө хэлэв. Бүү хэтрүүл. Өнөөдөртөө хангалттай. Түүнтэй зөвлөн харьцах хэрэгтэй, учир нь тэр өнөөх газрын тухай тэнэг маргаанд яг ингэж аяглаж байсан. Эхлээд жаахан хүүхэд сургаж байгаа юм шиг, дараа нь ёжтой, зэвүүн, тэгээд ялагдсанаа ойлгоод ирэхээр увайгүй, новшийн загнадаг. Бүү хэтрүүл, яагаад гэвэл тэр чамд хэрэгтэй. Тэр өөрийн моторт хөрөөг асааж чадахгүй байж магад, гэхдээ гаднаас нь харахад барууны ертөнцийн эцгийн үлгэр жишээ дүр, тэгээд тэр хүмүүст бүү сандарцгаа гэж хэлвэл тэд сандрахгүй. Тиймээс бүү хэтрүүл.

-Чи пивоны хөргөгчний цаана байгаа тэр хаалгыг харж байна уу?

Тэр хараад хөмсгөө зангидав.

-Тэр пиво ууж байгаа хүмүүсийн нэг... Тэр чинь менежерийн туслах шив. Викс гэдэг билүү?

Хэрэв Браун түүнийг харвал удахгүй энэ хүн шинэ ажил хайх хэрэгтэй болно гэдгийг чамд амлаж байна.

-Брент, чи намайг сонсож байна уу?

Тэр над руу хайнгадуухан ширтлээ.

-Уучлаарай Дэйв, Чи юу ярьж байлаа?

"Одоо түүнд хэцүү байх болно".

-Чи энэ хаалгыг харж байна уу?

-Мэдээж харж байна. Тэгээд юу гэж?

-Энэ хаалга байшингийн бүх баруун жигүүрийг эзэлсэн агуулахад хүргэдэг юм. Билли унтаад өгөхөөр нь би хүүгээ хучих юм юм... Битүүнд Нормыг гаргах эсэхээс үүссэн маргаанаас бусдыг бүгдийг ярилаа. Ачаалах хаалгаар юу орж ирсэн, тэгээд энэ бүхэн юугаар дууссаныг бүгдийг би ярилаа. Брент Нортон итгэхээс татгалзав. Үгүй, тэр ийм юм байж болно гэдэгт ч итгэж чадсангүй. Би түүнийг Жим, Олли, Майрон нар дээр аваачлаа. Хэдийгээр Жим, Майронцэцэг хоёр сүрхий согтуу байсан ч гурвуул миний хэлсэн үнэн хэмээн баталцгаав.

Нортон бас л итгэхээс татгалзлаа. Тэр зүгээр л гүрийчихэв.

-Үгүй гэж тэр хэлэв. -Үгүй, үгүй, үгүй. Уучлаарай ноёдоо, энэ үнэхээр уур хүрмээр юм болж байна. Эсвэл та нар nadaар тоглож байгаа байх тэр биднийг харан, тэр ч бас тоглоом наадам ойлгоно гэдгээ үзүүлж сайхан инээв. -Эсвэл та нар бүлэг ховсдолтонд орсон байна.

Би биеэ барьж чадахаа болж эхэлсэн ч энэ удаа тэвчлээ. Хэдийгээр би өөрийгөө тайван гэж үздэг ч одоо байдал шал өөрөөр эргэчихээд байна. Би Биллийн тухай бодож, бас Стефенид юу тохиолдож болох, эсвэл тохиолдсоныг бodoх ёстой.

-За яахав гэж би хэлэв. -Тийшээ явцгаая. Тэнд тэмтрүүлийн хэсэг үлдсэн. Хаалга хаагдаж байхдаа тасдаад хаячихсан юм. Бас тэнд чи тэдний гулсахыг чагнаж болно. Тэд нар хаалганы тэнд ороонго өвсөнд салхи исгэрч байгаа юм шиг л дуугарч байгаа.

-Үгүй гэж тэр тайван хэллээ.

-Юу гэнэ ээ? -Би үнэхээр өөрийгөө буруу сонслоо гэж бодов. Чи юу гэсэн бэ?

-Би "үгүй" гэсэн. Би тийшээ очихгүй. Тоглоом дэндэж байна.

-Брент, энэ тоглоом биш, чамд тангараглья.

-Мэдээж та нар nadaар тоглож байна гэж Нортон хатуу хэлээд Жим, Майрон, харцыг нь тайван, ямар ч сэтгэлийн хөдөлгөөнгүй угтсан Олли Викс нарыг тойруулан харав. Дараа нь тэр над руу харлаа. -Энэ та нарын "Элгээ хөштөл инээх" гэдэг мөн биз? Тийм үү, Дэвид?

-Брент, сонсооч...

-Үгүй, харин чи сонс! -түүний дуу шүүх хурал дээр мэт дэлгүүрээр хангинах, нервтэж гүйцэн дэлгүүрийн тавиуруудын дундуур тэнэж явсан хэдэн хүн юу болж байгааг хархаар бидний зүг эргэв. -Энэ бол тоглоом. Хальтирч унагах гадилын хальс. Тэгээд та нар намайг сонгосон. Гадны хүнийг та нарын хэн нь ч нэг их хайрлаад байдаггүй, тийм биз? Та нар энд бүгдээрээ бие биесээ дэмждэг. Би хуулиар өөрийн газрыг авах гэхэд чи намайг шүүхэд чирж аваачаад л өөртөө ашигтайгаар шийдүүлчихсэн. Тэгэлгүй яах вэ. Аав чинь мундаг зураач, энэ хот чиний хот, харин би энд татвар төлөөд мөнгө үрээд байж байдаг!

Тэр өнөөх сайхан өмгөөлөгчийн хоолойгоороо биднийг загнаж, сургаж тоглосонгүй, тэр биеэ барьж чадахаа бараг байж, хашгирч хэллээ. Олли Викс эргэж, пивоо бариад харсан зүгтээ яваад өгөв. Майрон, Жим хоёр Нортоныг үнэнээсээ гайхан харна.

-Тэгээд би ерэн найман центийн үнэтэй хаймар тоглоомыг нь очиж хараад, энэ хоёр тэнэг хажууд зогсоод инээж байх юм гэнэ!

-Хөөе, чи амаа мэдээрэй. Хэнийг чи тэнэг гээд байгаа юм, аа? -гэж Майрон хэлэв.

-Хэрэв чи мэдэхийгхүсч байгаа бол чиний завины саравч дээр мод унахад би зүгээр ажаргалтай болчихсон шүү. Хачин баярласан. -Нортон намайг доромжилсон харцаар ширтэн инээмсэглэнэ. -Түүнийг чинь гамбир болгоод хаячихсан гэсэн байх аа? Маш сайн! Харин одоо замаас зайл!

Тэр намайг түлхэн хажуугаар өнгөрөхийг оролдов. Би түүний гараас барьж аваад пивоны хөргөгч рүү түлхлээ. Зургаан лаастай хоёр боодол пиво газар уналаа.

-Чихээ цэвэрлээд сонсож бай, Брент. Үүнээс амьдрах эсэх шалтгаалах болоод байна. Миний хүүгийн амьдрал ч наддаа л чухал, ойлгов уу. Тиймээс чи сонс, эсвэл би чамайг баастай чинь хутгаад өгнө мэдэв үү?

-За, тэг тэг гэж Нортон өвчтэй юм шиг болсон харцаа гялалзуулан хэлэв. Түүний том, цус хурсан нүд байдгаараа бүлтийжээ. -Чи ямар хүчтэйгээ энэ улсад харуулж, зүрхний өвчтэй, аав шигээ хүнийг зод л доо.

-Хусаад өг наадахаа! -гэж Жим хашгирав. -Зүрх мүрх ч гэх шиг. Нью-Йоркийн адгийн муу шүүхийн хархад зүрх байх ч үгүй!

-Битгий оролц гэж би Жимд хэлээд Нортон руу бөхийв. Хөргөгч ажиллахаа байсан ч хүйтэн хэвээр байна.

-Битгий уурлаад бай. Би үнэнээсээ ярьж байгааг чи сайн мэднэ.

-Би... тийм... юу ч... мэдэхгүй... -гэж Нортон хүндээр амьсгаадан хэллээ.

-Хэрэв өөр газар, өөр цагт ингэж хэрэлдсэн бол би аль хэдийнэ яваад өгөх байсан. Харин одоо чиний айсан эсэх надад падгүй, тэгээд ч чиний нэг ч үгэнд би гомдохгүй. Би ч бас айж

байна, чөтгөр аваг гэж, гэхдээ чи надад хэрэгтэй, ойлгож байна уу? Чи надад хэрэгтэй!

-Намайг тавиадах!

Би түүний цамцнаас шүүрч аван хэд сэгсэрлээ.

-Чи ойлгохгүй байна уу? Хүмүүс дэлгүүрээс гарцгааж эхэлнэ, тэгээд яг тэр муухай амьтан дээр очицгоно! Чи ойлгов уу, чөтгөр гэж!

-Намайг тавь!

-Үгүй ээ, чи эхлээд надтай хамт очиж, тэмтрүүлийг үзнэ.

-Би чамд үгүй гээ биз дээ! Энэ чинь тоглоом, би тийм тэнэг...

-Тэгвэл би чамайг хүчээр, чирээд явна даа.

Би түүнийг мөр, хүзүүнээс нь барьж авлаа. Цамцны мөр оёдлоороо шархийн урагдав. Би түүнийг агуулахын хаалганы зүг чирлээ. Нортон нарийхан, бачимдсан дуугаар хашгирлаа. Ойролцоо арван тав, зургаан хүн цугласан ч хэн нь ч ойртож, хөндлөнгөөс хэрэгт орооцолдохыг хүссэнгүй.

-Туслаарай! -гэж Нортон нүдний шилээ гялалзуулан дахин хашгирлаа. Түүний үс нь бас дахиад л хэвээ алдаж, чихний нь ард хоёр бяцхан эвэр мэт сэгсийнэ. Хүмүүс хөлөө шалаар гулсуулан харцгаана.

-Чи юу гээд орилоод байгаа юм? -гэж би Нортоны чихэнд шивнэлээ. -Энэ чинь зүгээр л тоглоом. Иймээс л би чамайг гуйхаар чинь хот руу авч явсан, ийм учраас би чамайг Биллиг аваад дэлгүүрт оч гэсэн. Учир нь би энд чамаар тоглох гээд манан захиалчихсан, Холливудаас тусгай машин арван таван мянган доллараар захиалаад, авчрахын тулд бас найман мянгыг төлсөн.

-Нам-айг та-виач-эээ! -гэж бид бараг хаалганы дэргэд ирсэн хойно Нортон орилов.

-Хөөе, хөөе! Юу болоод байна? Та нар юу хийгээд байгаа юм бэ? -Хүмүүсийг хоёр тийш түлхэн Браун гарч ирлээ.

-Үүнийг тавиулаач, аллаа! -гэж Нортон сөөнгөтөн хэлэв. -Энэ галзуурчихаж.

-Үгүй. Тийм байсан ч болоосой, гэхдээ тэр зүгээр гэж Олли намайг өмөөрөн хэлэв. Би түүнд сөгдөж мөргөхөд бэлэн байлаа. Олли тавиур дундуур явж Брауны урд зогсов. Брауны харц Оллийн гартаа барьсан лаазтай пивон дээр буулаа.

-Чи ууж байна уу! -гэж Браун хэлэхэд хоолойнд нь гайхсан, бас давхар сэтгэл ханасан өнгө тод сонсогдлоо. -Чи ажилгүй болно доо!

-Бад, больж үз гэж би Нортоныг тавингаа хэллээ. -Одоо гэнэтийн аюул, гамшиг болоод

байна.

-Дүрэм журмыг одоохондоо хэн ч хүчингүй болгоогүй гэж Браун их л додигор хэллээ.

-Компаний удирдлага энэ бүхнийг мэдэх ёстай. Би үүнийг илтгэх ёстай, энэ ч миний үүрэг. Нортон хажуу тийш зугтан гүйж холдоод үсээ самнаж, цамцаа товчилж байна. Түүний нүд Браун бид хоёрыг ээлжлэн харна.

-Хөөе! гэж гэнэт Олли өөрийн бүдүүн чанга хоолойгоор хашгирлаа. Би энэ том, тарган, гэхдээ зөөлөн, даруухан хүн ийм чанга хоолойгоор хашгирч чадна гэж хэзээ ч бодоогүй юм байна. -Хөөе, бүгдээрээ! Наашаа ирцгээ! Тэгээд сонсоцгоо! Энэ та бүхэнд бүгдэд нь хамаатай! Тэр эргэж, Брауныг огтхон ч үл тоон над руу харлаа: -Би зөв хийж байна уу?

-Тийм шүү.

Хүмүүс цугларч эхэллээ. Нортон бид хоёрын ноцолдооныгхарж байсан хүмүүс эхлээд хоёр дахин, дараа нь гурав дахин олон боллоо.

-Та нар нэг юм мэдэж авах хэрэгтэй... -гэж Олли эхэллээ.

-Пивоо хурдан байсан газар нь тавь гэж Браун үгийг нь таслав.

-Амаа хамхи гээд би түүн рүү алхав.

Браун яаралтай ухарлаа.

-Та нарын зарим нь юу бодож байгааг би мэдэхгүй гэж тэр хэлэв. -Гэхдээ энд болж байгаа бүхнийг би "Федерал Фудс Компани"-ийн удирдлагад мэдэгдэх болно. Тэгээд магадгүй шүүхийн дуудлага ч та нарт ирж магад!

Браун хүйтэн инээмсэглэхэд түүний яйжгий шар шүднүүд нь цухалзаж, би түүнийг өрөвдөх шиг болов. Тэр зүгээр л нөхцөл байдлыг гараасаа алдахгүйг хичээж байна. Яг Нортон шигтэр өөрөө өөртөө сэтгэл санааны хаалт тавьчихаж. Майрон, Жим хоёр бүгдийг эр хүний эд хав, эр зориг болгох гэж оролдсон шиг. Генераторыг засчихвал манан арилна. Браун болохоор өөрийнхөөрөө, тэр "дэлгүүрийг хамгаалж" байна.

-Нэрсийг нь бичээд ав гэж би хэллээ. -Одоо харин дуугүй бай.

-Би олон нэр бичнэ гэж Браун хариулав. -Тэгэхдээ чинийх эхэнд нь байх болно. Чи бол богем, зайгуул дээд зиндааны этгээд шүү дээ.

-Ноён Дрэйтон та бүхэнд чухал зүйл хэлнэ гэж Олли зарлав. Тэгээд та бүхэнд энэ маш чухал, гэрээдээ явах гэсэн хүмүүст бүр ч чухал гэж би бодож байна.

Би болсон бүх явдлыг Нортонд ярьсан шигээ ярилаа. Эхлээд зарим нь инээж байснаа ярианы төгсгөлд хүмүүс гүн түгшүүрт автав.

-Энэ бүгд худал гэдгийг та нар ойлгож байгаа биз гэж Нортон хоолойныхоо өнгөөр улсыг өөртөө итгүүлэхийг хичээн хэлсэн боловч жаахан хэтрүүлчих шиг болов. Тэгээд энэ хүнд би найдаж, хамгийн түрүүнд ярьж байдаг. Яаж би ингэж алдав аа!

-Мэдээж хэрэг, энэ бол худал, хий хоосон зүйл гэж Браун зөвшөөрөв. -Хаанаас тэр тэмтрүүлүүд чинь гараад ирсэн юм бэ, ноён Дрэйтон?

-Би мэдэхгүй, тэгээд ч энэ хамгийн чухал асуудал биш. Тэд байгаа, тэгээд...

-Тэд энэ пивоны лаазнаас гараад ирсэн байх гэж би айж байна.

Энэ үг хүмүүсийг инээлгэсэн боловч тэр дороо хатагтай Кармодийн хүчтэй чахарсан дуунд дарагдав.

-Үхэл! -гэж тэр хашгирахад инээгсэд хурдан дууугүй боллоо. Ойртож ирсэн хүмүүсийн дунд тэр гарч ирлээ. Түүний канар бялзуухайн хурц шар өнгийн өмд өөрөө гэрэл цацуулах мэт, аварга том цүнх нь зааных шиг зузаан ташааг нь даран унжина, Хар нүд нь ихэмсэг, хэрээний нүд мэт хурц, зэвүүн гялалзана. Арван зургаа орчим насны, хоёулаа ижил "Ойн зуслан" гэсэн бичигтэй хиймэл торгон цагаан цамц өмссөн хөөрхөн охид айсан шинжтэй ухасхийн эмгэнээс холдоцгоов.

-Та нар сонсохгүй байна! Та нарын чих эрүүл, ажиллаж байгаа ч сонсохгүй байна! Сонсоод итгэхгүй байна! Та нарын хэн нь гадагш гарч өөрийн биеэр итгэхийг хүсч байна? -Тэр харцаараа тойрон хүрээлсэн хүмүүсийг гүйлгэн хараад над дээр харцаа тогтоов.

-Тэгээд та юу хийж болно гэж бодож байгаа юм бэ, ноён Дрэйтон? Та юу хийхээр төлөвлөж байгаа юм бэ?

Тэр канар бялзуухайн төрөн дээр тавьсан гавлын яс мэт инээмсэглээд цааш ярьж гарав.

-Энэ бол эцэс төгсгөл, би та нарт хэлээд байна шүү дээ, энэ бол төгсгөл! Бүхний төгсгөл! Бурханы гар шийтгэлийн бичгээ галаар биш, манангаар бичжээ. Газар хагарч, тэндээс аймшигийн ад чөтгөр, буг сүгнүүд гарч ирээд...

-Наадахаа дуугүй болгооч! -гэж хоёр охины нэг уйлан хашгирав. -Наад авгай чинь намайг айлгаад байна!

-Хонгор минь, чи айж байна уу? -гэж хатагтай Кармоди охиныг дайрлаа. -Энэ чинь айдас биш. Болоогүй байна! Харин Сатана газар дээр гаргаж тавьсан аймшигтай муухай адгийн амьтад чамайг барьж аваад...

-Хангалттай, хатагтай Кармоди гэж Олли авгайн гараас барин хэллээ.

-Одоо болно.

-Алив намайг тавь! Энэ бол төгсгөл гэж би та нарт хэлж байна! Энэ бол үхэл! Үхэл!

-Энэ бол бөөн нохойн баас гэж загасчны бүрх малгай өмссөн нүдний шилтэй эр хэлээд сэжиглэх мэт ярвайв.

-Үгүй ноёнтоон гэж Майрон хэлэв. -Үнэхээр энэ бүхэн хар тамхичны мансуурлын хэсэг мэт санагдаж байгаа байх, гэхдээ энэ үнэн. Би өөрөө харсан.

-Би ч бас гэж Жим нэмлээ.

-Би ч бас харсан гэж Олли дуугарав. -Тэр ядаж хэсэг хугацаанд хатагтай Кармодиг дуугүй болгож чаджээ. Гэхдээ эмгэн түүний хажууд аварга том цүнхээ бариад галзуу солиотой мэт инээмсэглэн зогсоно.

Хэн ч түүний хажууд зогсохыг хүссэнгүй. Хүмүүс хоорондоо юм дүнгэнэн ярыцгаана. Миний ярьсныг гурван хүн нэмж баталсан нь хэнийг ч баярлуулсангүй. Хэдэн хүн үзмэрийн шилэн ханыг бодлогошронгуй харсан нь надад найдвар төрүүлэв.

-Бүгд шал худал гэж Нортон хэллээ. -Та нар зүгээр л бие биесээ дэмжиж хуйвалдаж байна. Тэгээд л гүйцээ.

-Чиний ярьсанд үнэхээр итгэх арга алга гэж Браун хэллээ.

-Аа, энд зогсоод хоосон хэрэлдээд байх ямар ч хэрэг алга гэж би хэллээ. -Агуулахад очьё. Өөрөө хар. Бас сонс.

-Худалдан авагчид тийшээ орж болохгүй...

-Бад гэж Олли дуугарлаа. -Тийшээ оч. Энэ бүхнийг дуусгавар болгох хэрэгтэй.

-За яахав, ноён Дрэйтон гэж Браун хэллэв. -Энэ асуудлыг дуусгавар болгоё.

Хаалгыг түлхэн, бид харанхуйд явж орлоо.

Гулсах дуун эвгүй муухай, бүр аймаар сонсогдож байлаа. Браун ч бас үүнийг гэнэт мэдэрчээ. Тэр миний гараас шүүрэн авч, амьсгал нь боогдох мэт хэсэг чимээгүй болсноо гэнэт огцом, чанга, сөөнгөтөн амьсгалав.

Ачаалах хаалганы цаанаас намуухан шивнэх мэт, бараг энхрий зөөлөн гэмээр дуу зогсолтгүй гарч байв. Би хөлөөрөө шалан дээгүүр хайн тэмтчиж, нэг гар чийдэн олж аваад асаалаа. Браун юу ч хараагүй, зөвхөн сонссон боловч нүүр нь баг мэт хөдөлгөөнгүй болжээ. Харин би урт тэмтрүүлүүд хаалганы ган төмөр дээгүүр амьд ороонго мэт хэрхэн гулсаж байгааг дотроо төсөөлөн бодож байв.

-Чи одоо юу гэж бодож байна? Итгэх аргагүй байна уу?

Браун шалаар нэг тархсан хайрцаг, лаазнуудыг харлаа.

-Тэд энэ бүгдийг хийгээ юу?

-Тийм. Дийлэнхийг нь тэд. Нааш ир.

Браун дургүйхэн хүрч ирэв. Би гар чийдэнгийн гэрлийг шалны модны дэргэд атиралдан ороогдсон тэмтрүүлийн хэсэгт чиглүүлэв. Браун тонгойлоо.

-Битгий гар хүрээрэй гэж би хэлэв. -Наадах чинь амьд байж магад.

Браун хурдан дээш болов. Би шалны мод авч, ишээр нь тэмтрүүлийг хатгалаа. Гурав, дөрөв хатгасны дараа тэмтрүүл залхуурах мэт удаанаар тэнийж, хоёр бүтэн, нэг дундуураа тасарсан соруулаа харууллаа. Дараа нь тасархай гэнэт, маш хурдан хумигдан, хөдлөхөө болив. Браун огиудас нь хүрэх мэт хачин авиа гаргалаа.

-Хангалттай юу?

-Тийм гэж тэр хэлэв. -Явъя эндээс.

Бид хоёр гар чийдэнгийн үсчих гэрлийг даган хаалганы зүг явж, гараад худалдааны танхимд хүрч очлоо. Бүгд бидний зүг эргэж, дүнгэнэн ярих чимээ намдав. Нортоны царай хуучирч муудсан бяслагтай адил болжээ. Хатагтай Кармодийн нүд эрүүл бусаар гялалзана. Олли пиво уусаар, дэлгүүрт халуун байхаа больсон ч нүүрээр нь хөлс тасралтгүй урсана. Цамцан дээрээ "Ойн зуслан" гэсэн бичигтэй хоёр охин цахилгаантай бороонд цохиулсан залуу морьд адил бие биесдээ наалджээ. Нүднүүд. Mash олон нүднүүд. "Би энэ нүднүүдийг зурж чадна даа" - гэж би нуруугаар хүйт даахыг мэдрэн бодов. Нүүр байхгүй, зөвхөн бүрэнхийд чамайг ширтэх нүднүүд. Би энэ нүднүүдийг зурж чадна, харин энэ үнэхээр байсан гэдэгт хэн ч итгэхгүй.

Бад Браун урт хуруутай гараа алгаар нь нийлүүлэв.

-Анхаарал тавихыг хүсье гэж тэр хэллээ.

-Бид үнэхээр тун хүнд асуудалтай тулгарсан бололтой....

6. Хатагтай Кармодийн цаашдын яриа. "Дэлхий хавтгай гэдэгт итгэгсэдийн нийгэмлэг" яасан бэ?

Дараагийн хэдэн цаг зүүд мэт өнгөрлөө. Брауны үгийн дараа удаан, хагас истерик маягийн маргаан эхлэв. Миний бодсон шиг удаан биш ч байж магад. Зүгээр л хүмүүст авсан мэдээллээ сайтар "зажилж", түүнийг тал бүрээс нь харж, нохой яс мэрдэг шиг мэрж байж чөмгөнд нь хүрэх шаардлага гарчээ. Хүн гэгч ямарваа шинэ зүйлд удаж байж итгэдэг амьтан. Яг иймэрхүү маргааныг та Шинэ Английн ямар ч хотын хурал дээр харж болно.

Нортоны толгойлсон "Дэлхий хавтгай гэдэгт итгэгсэдийн нийгэмлэг" нь арваад хүнээс бүрддэг бөгөөд тэд нь бүгд миний ярьсанд огтхон ч итгээгүй хүмүүс байлаа. Нортон дахин дахин дөнгөж дөрвөн хүн зөөгчийг түүний хэлснээр "Икс гаригийн тэмтрүүлүүд" (анх удаа энэ үгийг хэлэхэд хүмүүс инээлдсэн, харин одоо залхаж эхэлж, харин Нортон үүнийг анзаарахгүй улам дэврэн чалчина) аваад явчихыг харсан, тэгээд хувьдаа энэ дөрвөн хүний хэнд нь ч тэр итгэж чадахгүй гэж зарлаж байв. Үүнээс гадна түүний зарласнаар гэрчүүдийн тавин хувь нь шал согтуу, энэ ч яах аргагүй үнэн, Жим, Майрон Ляфлер хоёр бүхэл бүтэн пивоны хөргөгч, басдээр нь дарсны тасгийг эзэгнэж аваад учиргүй муухай согттолоо ууцгаажээ. Гэхдээ Нормын үхэл, энэ үхэлд тэр хоёр ямар үүрэг гүйцэтгэснийг санаад тэднийг үнэндээ муулж чадахгүй байлаа. Тэд дэндүү хурдан эрүүлжинэ.

Олли ч бас Брауны загнаж үглэхийг үл тоон уусаар, цаадах нь сүүлдээ яршиг гэж бодов бололтой дуугарахаа ч болив. Хааяа өөрийгөө тайвшруулахын тулд Браун Компаний нэрийн өмнөөс Оллиг занан, айлгахыг оролдож байв. Хөөрхий тэр, Брижтон, Хойд Уиндем, Портлэндэд дэлгүүрүүдтэй "Федерал Фудс Инкорпорейтед" гэдэг компани одоо байхгүй гэдгийг ойлгохгүй байгаа бололтой. Ерөөсөө зүүн эрэг хавийн нутаг тэр чигээрээ сүйрсэн байж ч магад. Олли нэг хэмээр, согтохгүй, хөлсөөрөө хамаг спиртээ гарган ууж байлаа.

Эцэст нь "Дэлхий хавтгай гэдэгт итгэгсэдийн нийгэмлэг" -ийнхэнтэй явуулсан маргаан хэрүүл маягтай болж ирэхэд Олли тэссэнгүй:

-Ноён Нортон, та бидэнд итгэхгүй байж болно, энэ бол таны хэрэг. Та юу хийж чадахыг би хэлээд өгье. Та гол хаалгаар гараад дэлгүүрийг тойрч, ар талд нь оч. Тэнд пиво, ундааны уул овоо шиг хоосон лааз байгаа. Норм, Бадди бид гурав өглөө гаргаж овоолсон юм. Та хоёр шил аваад хүрээд ир, тэгээд л бид таныг тэнд байсан гэж итгээ. Хэрэв та үүнийг хийж чадвал би цамцаа тайлаад иднэ гэж танд тангараглаж байна.

Нортоны царай улайж эхлэв.

Олли өөрийн жигд, зөөлөн хоолойгоор түүнийг доошлуулсаар байв:

-Таны энэ хоосон яриа хүмүүст хор л хүргэнэ, өөр юу ч байхгүй. Гэр орон нь зүгээр байгаа гэдгийг очиж мэдэхийг олон хүн хүсч байгаа шүү дээ. Миний дүү ч гэсэн ойтой хүүхэдтэйгээ Нейплэд байшиндаа байгаа, түүнийг би очиж эргэмээр байна. Гэхдээ хүмүүс танд итгээд гарч яваад эхлэх юм бол тэднийг Нормын хувь тавилан л хүлээж байгаа.

Нортоныг тэр итгүүлж чадсангүй, харин эргэлзэж, яахаа мэдэхгүй, Нортоны талд орох эсэхээ

шийдэж ядан байсан хэдэн хүнийг хэлсэн үгээрээ биш, айж сандарсан нүднийхээ харцаар итгүүлж чаджээ. Нортон өөрийн онолоос зууралдсаар, учир нь энэ онолд л түүний хамаг эрүүл саруул ухаан оршиж байгаа, эсвэл оршиж байх шиг түүнд санагдаж байгаа бололтой. Гэхдээ тэр дэлгүүрийн араас баталгаа авч ирэхээс татгалзлаа. Бүгд татгалзсан юм. Тэд гадагш гарч зүрхлэхгүй, ямар ч байсан одоохондоо зүрхлэхгүй. Нортон, түүний бяцхан "нийгэмлэг" (саяхан бас хэдэн хүнээр цөөрсөн) биднээс аль болох холдож, махан бүтээгдэхүүн өрсөн тавиуруудын тэнд цуглажээ. Тэдний нэг миний хүүгийн хөлөнд хүрч, Билли сэргээхэд тэр миний хүзүүгээр тэвэрч, дараа нь би буцаан хэвтүүлэх гэтэл улам чанга наалдлаа:

-Аав, би унтахгүй, хэрэггүй ааваа.

Би тэргэнцэр олж, түүнийг хүүхдийн суудалд нь суулгалаа. Билли хүүхдийн суудалд томдож байна. Хүүгийн маань царай цонхигор, үс нь хөлөрсөн духыг нь бүрхэж, нүд нь хачин гунигтай харагдаж байгаагүйсэн бол энэ бүхэн бүр инээдтэй байхсан. Биллийг бид сүүлчийн удаа дор хаяж хоёр жилийн өмнө дэлгүүрт тэргэнцрийн хүүхдийн суудалд суулгасан байх. Энэ бяцхан үйл явдлууд мэдэгдэхгүй өнгөрч, дараа нь анзаарахад үргэлж гэнэтийн мэт байдаг.

Энэ үед "Дэлхий хавтгай гэдэгт итгэгсэдийн нийгэмлэг" -ийнхний байхгүйд маргаан өөр нэг аянга зайлцуулагчтай болж авсан нь хатагтай Кармоди байлаа. Тун ойлгомжтой шалтгаанаар Кармоди үргэлж ганцаарчилсан байр суурийг баримталж байв.

Бүдэг гэрэлд нар мэт гэрэлтэх шар өмдтэй, хурц өнгийн цамцтай, зэс, яст мэлхийн яс, чулуун чимэглэл хүзүүнээсээ зүүсэн энэ авгай шулам мэт харагдана. Нуурийг нь гүнзгий хөндлөн үрчлээсүүд огтолжээ. Буржгар саарал үсээ тэр гурван ясан самаар тогтоож, ардаа хонины сүүл мэт бөөрөнхийлж уяжээ. Жимиисэн уруул нь барзгар сүлжмэл олсны тасархай мэт харагдана.

-Бурханы хүсэл шийдвэрийн эсрэг хамгаалалт гэж байдаггүй! Тиймээс ч болж байгаа бүхнийг би урьдчилан мэдэж байсан. Би мэргэлж, төлөг тавьж үзсэн. Би муу ёрын шинж тэмдгүүдийг олж харсан! Миний урьдчилан хэлж байсныг сонссон хүмүүс энд олон байна, харин одоо энэ бүхнийг өөрөө олж харж чадахгүй байгаа хүн сохортой адил!

-Тэгээд та ямар санал дэвшүүлж байгаа юм бэ? -гэж түүний үгийг хотын Удирдах зөвлөлийн гишүүн Майк Хатлен таслав. Далбаат завьчны малгайтай, борооноос хамгаалах ногоон хүрэм өмссөн Майк өндер албан тушаалтантай огтхон ч адилгүй харагдана. Тэр бусад бараг л бүх эрчүүдийн адил пиво ууж байна. Бад Браун эсэргүүцлээ зогсоосон, гэхдээ нээсийг нь бичиж авахыг хичээж харагдана.

-Ямар санал дэвшүүлж байна гэж үү? -хэмээн Кармоди давтаад эргэж, Майк Хатленыг ширтлээ. -Чи, Майк Хатлен өөрийн Эзэн бурхантай учрах цагт биеэ бэлдэхийг би сануулж байна. -Тэр хүмүүсийг тойруулан харав. -Өөрийн Эзэн бурхантай учрах цагт бэлдэцгээ!

-Бөөн нохойн баастай учрах цагт бэлдэцгээ! -гэж хөргөгчний цаанаас Майрон Ляфлер согтуу хоолойгоор гуншигнав. -Эмгэн минь, чиний хэл ч гэж хоёр талаараа зэрэг ярьдаг, дундуураа дүүжлэгдсэн лут эд юмаа!

Хүмүүс Майроныг дэмжиж, Кармодиг хараах үгс дуулдав. Билли айсан шинжтэй эргэж харахад нь би мөрөн дээр нь гарaa тавилаа.

-Үгүй, би ямар ч байсан үгээ хэлнэ! -гэж хатагтай Кармоди хашгирав. Түүний дээд уруул сөхөгдөж, тамхины бохинд шарласан шүднүүд нь ил гарахад би дэлгүүрийнх нь цаад буланд байдаг, тоосонд дарагдсан толин голоос ус уун мөнхөрсөн амьтдыг санав. Эргэлзэж байгаа хүмүүс ертөнцийн төгсгөл хүртэл эргэлзсээр байх болно! Гэхдээ аймшигт чөтгөрүүд энэ төөрсөн залууг барьж авна! Манангаас гарч ирэх аймшигт амьтад! Хар дарсан муухай зүүдний аймшиг! Нүдгүй шулмасууд! Цонхигор аймшгууд! Чи эргэлзэж байна уу? Гадагшаа гар! Гараад тэдэнтэй мэндэл!

-Хатагтай Кармоди, та боль гэж би хэллээ. -Та миний хүүг айлгаад байна.

Бяцхан охин хөтөлсөн нэг эр намайг дэмжив. Өвдөг нь шалбарсан булцгар хөлтэй бяцхан охин аавынхаа хөлийн гуянд нүүрээ нааж, чихээ хоёр гараараа таглажээ.

-Бидэнд ганц боломж бий гэж Кармоди зарлалаа.

-Ямар вэ, хатагтай? -хэмээн МайкХатлен зөөлөн асуув.

-Бид тахилга өргөх ёстой гэж эмгэн хариуллаа. Бүдэг гэрэлд тэр инээмсэглэх шиг надад санагдав. -Цуст тахилга өргөх ёстой.

"Цуст тахилга" -энэ үг агаарт дүүжлэгдэж орхих шиг, тэгээд аажуухан эргэлдэн байх мэт. Бүр одоо, үгүй гэдгийг мэдэж байсан ч би хатагтай Кармоди магадгүй ямар нэг нохойн тухай л ярьсан байх гэж өөрөө өөртөө хэлдэг. Хэдийгээр хориотой боловч одоо хэний ч юм, хоёр нохой дэлгүүр дотор гүйлдэж байна. Бүр одоо ч би өөрөө өөртөө ингэж хэлдэг. Бүрэнхийд эмгэн ямар нэгэн Шинэ Английн пуритан шашны үлдэгдлийн солиорсон биелэл мэт харагдаж байлаа, гэхдээ би пуритан шашнаас ч илүү харанхуй, гүнзгий зүйл энэ эмгэнийг удирдан хөдөлгөж байсан гэж одоо боддог. Пуритан шашинд өөрийн өвөг эцэг, цусан гарг хөгшин Адамс бий.

Хатагтай Кармоди дахин ярихаар амаа нээтэл спортын улаан өмд, цэвэрхэн футболк өмссөн намхан эр нүүр рүү нь цохилоо. Үсээ шугам шиг тэгшхэн хагалж самнасан, нүдний шилтэй эр -энд зун ирдэг жуулчдын сонгомол дүр.

-Наад бохир муухай яриагаа боль та гэж тэр зөөлөн, жигд хоолойгоор хэллээ.

Хатагтай Кармоди гараараа амаа арчаад үг дуугүй яллах мэт гараа дэлгэн бидэнд харуулав. Түүний гарын алга цус болж, харин хар нүд нь солиорсон баяр хөөрөөр гялалзана.

-Болж, муу шаар! -гэж хүмүүсийн дундаас нэг эмэгтэй хашгираа. -Тэгэх гээд байсан юм. Би өөрөө ч дуртай нь аргагүй цохихсон!

-Тэд та нарт хүрнээ гэж цус болсон гараа сарвайн Кармоди хашгираа. Уруулнаас нь цус борооны ус сувгаар урсах мэт үрчлээсийг нь даган урсана. -Магадгүй, одоо биш. Орой. Шөнө, харанхуй болмогц. Тэд шөнө хүрч ирээд хэн нэгнийг аваад явна. Шөнө тэд ирнэ! Тэгээд та нар аймшигүүд мөлхөж, маажиж байгааг сонсох болно. Тэгээд тэд шөнө ирэхэд та нар Кармоди Эхээсээ юу хийхээ асууж, гүйж гувших болно.

Спортын улаан өмдтэй эр дахин гараа өргөв.

-За, тэгээд цохь л доо, намайг гэж Кармоди шивнээд цус болсон уруулаараа инээмсэглэв. Намхан эрийн гар хөдөлсөнгүй.

-Чадах юм бол цохь л доо чи...

Гар доошлов. Хатагтай Кармоди эргэн цааш явлаа. Билли түрүүхэн жаахан охин уйлж байсан шиг миний цээжинд нүүрээ наан уйлав.

-Би гэртээ харимаар байна. Аав, би ээждээ очмоор байна!

Би хүүгээ чадлаараа тайвшруулж байлаа. Гэхдээ би даанч бага зүйл хэлж чадах юм.

Эцсийн эцэст ярианы сэдэв тийм ч аймаар, гайхмаар биш болж ирэв. Хэн ч юм, супермаркетын хамгийн эмзэг хэсэг, үзмэрийн шилэн нүүрний тухай ярилаа. Майк Хатлен дэлгүүрт орох өөр ямар хаалгууд байдгийг асуухад Олли, Браун хоёр тэр дор нь цээжээр хэлж гарлаа: Нормын гарснаас гадна ачих буулгах хоёр хаалга, гол хаалга, бас менежерийн өрөөний цонх (зузаан, хатуулгатай шил, маш сайн түгжээтэй).

Хамгаалалтын талаар ярьсан нь эсрэг тэсрэг үр дүнд хүргэлээ: хэдийгээр аюул улам бодитой харагдаж эхэлсэн ч хүмүүс илүү тайван, өөртөө итгэлтэй болцгоожээ. Бүр Билли ч үүнийг мэдрэв бололтой, Тэр надаас нэг шоколад авч болох уу гэж асуухад нь би цонх руу ойртохгүй бол авч болно гэж зөвшөөрөв. Түүнийг гүйн одсоны дараа Майк Хатлены дэргэд зогсож байсан эр:

-О'Кей. Тэгээд энэ том шилэн цонхыг яах болж байна? Хөгшин хатагтайг үнэхээр галзуу бясaa хазаж орхисон байх, гэхдээ шөнө ямар нэгэн чөтгөр дайраад ороод ирнэ гэдэг нь үнэний хувьтай байх шүү гэлээ.

-Шөнө болтол манан арилах байлгүй гэж нэгэмэгтэй хэлэв.

-Магадгүй гэж өнөөх эр хариуллаа. -Арилахгүй ч байж магадгүй.

-Ямар нэг санал байна уу? -гэж би Бад, Олли хоёроос асуув.

-Жаахан хүлээ гэж Хатлены дэргэд зогсож байгаа эр хэллээ. -Би Дэн Миллер, Линн хот, Массачусетс муж. Та нарын хэн нь ч намайг танихгүй, гэхдээ би Хайлэнд нуурын эрэг дээр байшинтай. Энэ жил л авсан юм. Намайг ч маллаж орхисон байх, чөтгөр шиг их мөнгө авсан, гэхдээ би тэр золигийн байшинг заавал авмаар санагдаад ер болоогүй юм л даа. -Хэн нэгэн

инээв. -Би юу хэлэх гээд байна гээч. Тэр буланд зүлэгний бордоотой шуудайнууд хичнээн их байгааг харцгаа. Арван килограммын шуудайтай юм байна. Түүгээр цонхыг битүүлэх хэрэгтэй. Харах нүх үлдээгээд хана шиг өрнө.

Хүмүүс саналыг хэлэлцэн, толгой дохицгоов. Би өөрийн саналыг хэлэх гэснээ арайхийн биеэ барьж дуугаа татлаа. Миллер зөв ярьж байна. Шуудайтай бордоогоор хамгаалалт хийж болно, хэнд ч саад болохгүй, тус болж ч магад. Гэхдээ тэмтрүүл нохойн хоолтой лааз бүхий цаасан хайрцгийг хэрхэн базаж байсныг би байнга эргэн санаж, том тэмтрүүл арван килограммын шуудайтай "Ногоон акр", "Вигоро" -г яаж чадахыг төсөөлж байлаа. Гэхдээ энэ тухай цэцэрхэх нь хэн нэгний сэтгэлийг явч баясгахгүй.

Хүмүүс ажилдаа орохоор тарж эхлэхэд Миллер хашгирав:

-Зогсоорой! Зогсцгоо! Нэгэнт цугласных, бусад асуудлыг ч шийдье!

Хүмүүс эргэн ирж, тавь, жараад хүн ноён Маквей хэнд ч хэрэггүй шахам бүтээгдэхүүн, гэдэс дотор, хонины тархи, шийр зэргийг овоолсон тавиуруудын дэргэд цуглав. Билли таван настай жаалууд том хүмүүсийн дунд олж авдаг сэргэлэн зангаар хүмүүсийг сүлжин гүйсээр над дээр ирж, боодол шоколад сарвайлаа.

-Аав, идэх үү?

-Баярлалаа, миний хүү би шоколаднаас хазав. Амттай, сайхан байна.

-Энэ тэнэг асуулт байж магад гэж Миллер үргэлжлүүлэв.

-Гэхдээ эцсийг нь хүртэл ярилцах хэрэгтэй. Хэн нэгэнд буу бий юу?

Бүгд мөрөө хавчин бие биесээ харцгаав. Амброз Корнелл гэж өөрийгөө нэрлэсэн буурал өвгөн машиных нь багажинд ангийн буу бий гэлээ.

-Хэрэв хүсвэл би аваад ирэхийг бодъё.

-Миний бодлоор гэж Олли хэллээ, энэ ч буруу санал байх, ноён Корнелл.

-Би ч бас тэгж бодож байна гэж Корнелл бувтналаа. -Гэхдээ хэлэх хэрэгтэй гэж бодсон юм.

-За яахав, яахав, би ерөөсөө найдаа ч үгүй гэж Миллер хэлэв зүгээр л магадгүй гэж...

-Хүлээгээрэй гэж эмэгтэй хүн дуугарлаа. Энэ бол улаан цамц, ногоон өмдтэй бүсгүй байлаа. Тэр цайвар, элсэн шаргал үстэй, тун сайхан бие галбиртай юм. Ер нь л тун аятайхан, сайхан бүсгүй. Тэр цүнхээ нээж, дунд гарын гар буу гаргаж ирэв. Хүмүүс нүдэн дээр нь илбэчин хачин сонин илбэ үзүүлсэн мэт гайхан дуугарцгаалаа. Эхнээсээ царай нь улайж эхэлсэн бүсгүй одоо бүр улаан болжээ. Тэр цүнхээ дахин ухаж, "Смит-энд-Вессон" -ы хайрцаг сум гаргалаа.

-Аманда Дамфрис гэж бүсгүй өөрийгөө танилцуулав. -Энэ гар буу... Энэ миний нөхрийн

санаа л даа. Тэр надад энэ бууг өөрийгөө хамгаалах хэрэгтэй гэж авч өгсөн юм. Би түүнийг цэнэглэлгүй хоёр жил авч яваа.

-Нөхөр чинь энд байгаа юу, хатагтай?

-Үгүй, тэр Нью-Йоркт байгаа. Ажил хэргээр. Тэр ажлаар байнга явдаг, тиймээс надад буу хэрэгтэй гэж үзсэн юм.

-Хэрэв та буудаж чаддаг бол танд байж байг гэж Миллер хэлэв. -Гучин найман калибрынх уу?

-Тийм, гэхдээ би үүгээр амьдралдаа ганц л удаа буудаж үзсэн. Буудлагын газар.

Миллер түүнээс бууг авч жаахан ноцолдож байгаад сумны хүрдийг нь нээв. Тэгээд цэнэгтэй эсэхийг шалгалаа.

-О'Кей гэж тэр хэллээ. -Бид гар буутай боллоо. Хэн сайн бууддаг вэ? Би харамсалтай нь чаддаггүй.

Хүмүүс бие биесээ харан дуугүй зогсоцгоно. Дараа нь Олли нэг их дуртай биш дуугарлаа:

-Би байнга бэлтгэл хийдэг юм. Манайд дөчин таван калибрын "Кольт", бас хорин тавын "Лама" бий.

-Чи юу? -гэж Браун гайхлаа. -Хаа, чи орой болоход хэнийг ч, юу ч харж чадахгүй болтлоо согтчихно.

-Чи дуугаа татаад нэрсээ бичээд суувал ясан юм бэ, аа? -гэж Олли ямар ч дультриагүй, тайван хэллээ.

Браун гайхсан шинжтэй түүнийг хараад юм хэлэх гэж амаа ангайснаа болив, тэр үнэхээр дуугаа татахаар шийдсэн бололтой. Миний бодлоор тэр зөв шийджээ.

-Та үүнийг ав гэж энэ маргааныг жаахан гайхсан шинжтэй сонссоны дараа Миллер хэлээд бууг Оллид өглөө. Олли бууг дахин шалгахад хамаагүй дөртэй нь мэдрэгдэж байв. Дараа нь бууг өмднийхөө баруун халаасанд хийлээ. Сумтай хайрцгийг тэр цамцныхаа энгэрийн халаасанд хийсэнд тэр нь яг л хайрцаг тамхи мэт харагдана. Энэ бүхнийг хийсний дараа тэр хөргөгчийг мөрөөрөө түшин зогсоод шинэ лааз пиво задлав. Түүний нүүрээр урдын адил хөлс цувсаар. Би өмнө нь мэддэг байсан тэр Олли Виксээс шал өөр, цоо шинэ хүнийг харж байгаа мэт надад санагдсан хэвээр.

-Танд баярлалаа, хатагтай Дамфрис гэж Миллер хэлэв.

-Зүгээр гэж бүсгүй хариуллаа.

Хэрэв би энэ сайхан ногоон нүд, тансаг биений эзэн, түүний нөхөр байсан бол тэгж их хол яваад байхгүй байсан даа гэж бодлоо. Эхнэртээ гар буу авч өгнө гэдэг инээдтэй, ёс төдий л

зүйл юм.

-Энэ ч бас инээдтэй, тэнэг санагдаж магад гэж Миллер эргэн, нэрсийн жагсаалт барьсан Браун, лаазтай пиво барьсан Олли нарт хандав. -Гэхдээ энд гал харвагч маягийн юм байж магад, тийм юм бий юу?

-Уу-уу, чөтгөр гэж Бадди Иглтон дуу алдаад дөнгөж саяхан Аманда Дамфрис улайсан шиг улайчихав.

-Юу вэ? -гэж Майк Хатлен асуулаа.

-Гм-мм, өнгөрсөн долоо хоногийг хүртэл манайх бүтэн хайрцаг жижигхэн паяльник худалдсан юм. Гэртээ ус гоожод байгаа хоолойг гагнах ч юм уу, машины цоорхой яндан ч юм уу, тиймэрхүү зориулалтын. Та санаж байна уу, ноён Браун?

Браун баргар царайлан толгой дохив.

-Худалдаад дуусчихсан уу?

-Үгүй, огт зарагдаагүй. Бид гурав, дөрвөн ширхэгийг л зарсан, тэгээд үлдсэнийг нь буцаачихсан.

-Өө цус гэж... Миний буруу, учлаарай... Их харамсалтай байна... -Хацар нь бүр хөхөлбөр улаан болтол минчийсэн Бадди Иглтон хүмүүстэй хутгалдав.

Бидэнд мэдээж хэрэг, чүдэнз, давс (Шумуул, хачиг мэтийн ёрын цус сорогчдыг давс цацаж алдаг гэж хэн нэгэн ярьжээ), янз бүрийн шалны мод байлаа. Олон хүн итгэж найдсан хэвээр, Жим, Майрон хоёр ухаантайхан үг хэлчих ямар ч тэнхээгүй согчихсон, харин Олли надтай харц тулгараход би түүний харцнаас айдсаас долоон дор ямар ч итгэл найдваргүй болж, үхлээ тайвнаар хүлээж байгааг ньхарлаа. Тэр ч, би ч тэмтрүүлүүдийг харсан. Тиймээс ч тэмтрүүл рүү давс цацаж, эсвэл шалны модны ишээр цохиж ална гэдэг инээдтэй, гэхдээ аймшигийн шог зураг мэт инээдтэй санагдаж байлаа.

-Майк гэж Миллер хэлэв. -Чи бидний бяцхан ажиллагааг ахлахгүй юу? Би Олли, Дэйв хоёртой нэмж яримаар байна.

-Тэгэлгүй яахав. Хатлен нөхөрсгөөр Дэн Миллерийн мөрөн дээр алгадав. -Хэн нэгэн удирдлагыг гартаа авах хэрэгтэй байсан, чи үүргээ маш сайн хийж гүйцэтгэлээ. Манай хотод тавтай морил.

-Энэ чинь надад хөнгөлөлттэй татвар ноогдуулна гэсэн үг үү?

Тэр гаднаас нь харахад азарган тахиархуу, намхан, туранхай, хурдан хөдөлгөөнтэй, халзарч эхэлж байгаа улаан үстэй эр юм. Тэр бол анх харахад огтхон ч таалагдахгүй, эсвэл жаахан хамт байвал дургүй хүрчихдэг эрсийн нэг бололтой. Танаас юм бүхнийг илүү хийж чаддаг хүмүүсийн нэг.

-Тийм үг ч арай л биш шүү гээд Хатлен инээсээр цааш явлаа.

Миллер миний хүүг ширтэв,

-Та Биллийн тухай санаа зовсны хэрэггүй гэж би хэлэв,

-Бурхан минь, би амьдралдаа үүнээс илүү санаа зовж байсангүй! -гэж Миллер хариуллаа.

-Тийм шүү гэж Олли зөвшөөрөөд хоосон лаазаа хөргөгчинд хийж, оронд нь шинийг аван задлав. Пиво шажигнан хөөсрөнө.

-Та хоёрын харц солилцохыг би анзаарсан гэж Миллер хэлэв.

Шоколадаа идэж дуусгаад би амаа зайлахаар лааз пиво авлаа.

-Би ингэж бодож байна гэж Миллер хэллээ. -Тав, зургаан хунийг шалны модны ишэнд даавуу ороож, хүлж бэхлэх ажилд томилох хэрэгтэй. Дараа нь хоёр гурван канистр нүүрс асаадаг шингэн бэлдье. Хэрэв савных нь дээд талыг тайрчихвал маш хурдан бамбар асааж болно.

Би толгой дохилоо. Энэ бол зөв санал. Мэдээж, Нормыг чирээд явсан тэмтрүүлийг харсан хүн голох л байх, гэхдээ л ямар ч байсан давснаас дээр.

-Ямар ч байсан хүмүүс хийх юmtай байх болно гэж Олли хэллээ.

Миллер уруулаа жимиийв.

-Байдал үнэхээр тийм хүнд байгаа хэрэг үү?

-Яг тийм гэж Олли баталлаа. Тэгээд пивоо ууж эхлэв.

Дөрвөн цаг гучин минут гэхэд бордоотой шуудайнуудыг өрж дууслаа. Харах жижигхэн нүхэн цонх үлдээн, бүх цонхыг битүүлжээ. Харах нүх бүрийн дэргэд хажуудаа нүүрс асаах шингэнтэй сав, гараар хийсэн бамбар хэд хэдийг тавьсан харуулууд сууна. Харах таван нүхэн цонх гаргаж, Дэн Миллер харуулуудын ээлжийг зохион байгуулжээ. Тав хагаст би харах нүхний нэгний дэргэд сууж байлаа. Билли миний хажууд суугаад мананг ширтэнэ. Цонхны яг хажууд хүмүүс худалдан авсан зүйлээ хажуудаа тавиад нэгнийгээ хүлээн суудаг урт улаан сандал харагдана. Түүний цаана автозогсоол бий. Битүү, хүнд манан аажмаар нүүнэ. Манан чийгтэй мэт боловч баргар.

Энэ мананг зүгээр харахад л хүн өөрийгөө өчүүхэн, ялагдсан мэт төсөөлөх ажээ.

-Аав, чи юу болж байгааг мэдэж байгаа тийм ээ гэж Билли асуув.

-Хүү минь, үгүй гэж би хариуллаа.

Билли өвдөг дээр нь хэвтэх гараа харан хэсэг дуутгүй суулаа.

-Яагаад биднийг хэн ч аврахгүй байгаа юм бэ? -гэж тэр эцэст нь асуулаа. -Цагдаагийнхан, Холбооны Мөрдөх Товчоо, өөр хэн ч юм?

-Аав нь мэдэхгүй.

-Ээж зүгээр гэж та бодож байна уу?

-Билли, хүү минь, аав нь мэдэхгүй. Би түүний мөрөөр тэвэрлээ.

-Би ээждээ очмоор байна гэж Билли нулимсаа барьж ядан хэллээ.

-Билли... -миний аманд гашуун нулимс амтагдаж, хоолой чичирлээ.

-Энэ бүхэн хэзээ нэгэн цагт дуусах уу? Аав? Дуусах уу?

-Аав нь үнэхээр мэдэхгүй гэж би хэлэхэд хүү миний мөрөнд нүүрээ наав. Би түүний өтгөн үсэн доорх шилэн хүзүүний хонхор дээр гарсаа тавьж, илээд, яагаад ч юм, Стефф бид хоёр сүй тавьсан өдрийн үдшийг саналаа. Сүй тавих ёслолын дараа сольж өмссөн энгийн хүрэн даашинаа Стефф хэрхэн тайлж байгааг би харж байж билээ. Стефф өдөр нь дутуу нээлттэй хаалганд цохисноос гуян дээр нь хөхөрчээ. Би энэ хөхрөлтийг ажиглан: "Тэр энэ хөхрөлтийг өөртөө тавихдаа Стефени Степанек байсан" гэж бодож, гайхаж байж билээ. Дараа нь бид зэрэгцэн хэвтэж, цонхны цаанаа арван хоёрдугаар сарын бүрхэг тэнгэрээс цас унаж байсан.

Билли уйллаа.

-Чшш-шш-шшш гэж би түүний толгойг зөөлөн бүүвэйлэн тайвшуулахыг оролдсон ч Билли уйлсаар. Хүүхэд ингэж уйлахад зөвхөн эхчүүд л тайвшуулж чаддаг.

"Федерал Фудс"-д цагаас эрт шөнө болж, Бад Браун нөөцөнд байсан бүх гар чийдэнгээ, хориод ширхэгийг тараалаа. Нортон өөрийн хамт олны зүгээс гар чийдэн өгөхийг чанга дуугаар шаардаж, хоёр ширхэгийг авав. Нарийхан гэрлийн толбонууд сандарсан сүгнүүд мэт тавиуруудын дундуур үсчинэ.

Биллиг биедээ наан тэврээд би шуудайнуудын дундах нүхэн цонхоор гадагш харсаар байв. Хэдэн удаа би юм олж харах шиг санагдсан ч энэ нь худал байсан байх. Гэвч удалгүй жижүүрүүдийн нэг өөртөө итгэл муутайгаар худал түгшүүр зарлалаа.

Билли хатагтай Терманыг дахин харсандаа учиргүй баярлаж, энэ зун ерөөсөө уулзаагүй ч гүйн очив. Хатагтай Терман гар чийдэн авсан, түүгээр нь Билли тоглож, нэрээ хөлдөөсөн бүтээгдэхүүн хийсэн хөргөгчин дээр бичиж гарлаа. Тэр хоёр бие биесээ харсандаа адилхан баярлаж байгаа бололтой, хэсэг хугацааны дараа тэд хоёул над дээр ирэв. Өндөр, туранхай, дөнгөж бууралтаж эхэлж байгаа сайхан улаан үстэй хатагтай Терманы цээжинд хээ угалзтай хүрээтэй, дундаж насны эмэгтэй л зүүх эрхтэй баймаар гоёмсог харааны шил гинжинд дүүжлээстэй харагдана.

-Стефени энд байгаа юу, Дэвид? -гэж хатагтай Терман надаас асуув.

-Үгүй, гэртээ байгаа.

Тэр толгой дохив.

-Алан бас гэртээ үлдсэн. Чи удаан жижүүрлэх үү?

-Зургаа хүртэл.

-Юм олж харав уу?

-Үгүй. Зөвхөн манан.

-Хэрэв хүсвэл би зургаа хүртэл Биллитэй цуг байж болно.

-Билли чи юу гэж бодож байна?

-Тийм, болохуу? -гэж Билли гар чийдэнгээ дээш өргөн, таазан дээр хээ угалз зурангаа асуулаа.

-Чиний Стефф, миний Алан хоёрыг бурхан өршөөж хайлраг гэж хатагтай Терман хэлээд Биллиг хөтлөн холдов. Хэдийгээр тэр чин сэтгэлээсээ хэлсэн ч хоолойны нь өнгөнд итгэл сонсогдсонгүй.

Тав гучийн үед дэлгүүрийн танхимын цаад буланд маргалдах чанга дуун сонсогдлоо. Хэн ч юм, инээд алдаж., бас хэн нэгэн, энэ Бадди Иглтон байсан байх, чанга хашгирлаа:

-Хэрэв та нар үнэхээр гарахаар шийдсэн бол бүгд галзуурчихаж. Гар чийдэнгийн хэд хэдэн гэрэл маргаж буй хүмүүсийн төвд гэрэлтэж, дараа нь гол хаалганы зүг хөдөллөө. Нидруүлгэн дээгүүр хуруугаар зурах мэт муухай хяхтнасан инээд сонсогдсон нь хатагтай Кармоди байв. Дараа нь олон хүний маргаан дунд Нортоны өмгөөлөгчийн чанга дуу сонсогдлоо.

-Биднийг явуулаадах! Алив, бидэнд зай тавиарай!

Миний хажуугийн нүхний дэргэд жижүүрлэж байсан эр юу болоод байгааг үзэхээр явлаа. Харин би байрандаа үлдлээ, тэртэй тэргүй хүмүүс намайг чиглэн ирж явна.

-Та сонсооч гэж Майк Хатлен гуйна, эхлээд бүхнийг сайхан ярьж хэлэлцэх хэрэгтэй шүү дээ.

-Бидэнд ярих зүйл байхгүй гэж Нортон хариулаа. Харанхуйгаас түүний шийдэмгий, гэхдээ эцэж ядарсан, аз жаргалгүй царай гарч ирэв. Буржгар үс урьдын адил чихний нь араас цухуйж, эвэр мэт харагдана. Тэр гартаа тэр "нийгэмлэг"-ийнхэнд өгсөн нэг гар чийдэнг барьжээ. Нортон өөртэй нь анх нийлсэн арваад хүний тавыг араасаа дагуулжээ.

-Бид гадагш гарлаа гэж тэр чанга хэлэв.

-Галзуурав уу, та нар? -гэж Миллер асуув. -Майкийн зөв. Бид бүхнийг эхлээд ярих хэрэгтэй. Ноён Маквей хийн шарах ширээн дээр тахиа шарж байна. Бид тайван сууцгаагаад хооллож,

тэгээд...

Нортон түүнийг замаасаа түлхэн зайлцууллаа. Миллерд энэ нь таалагдсангүй. Түүний царай улайж, дуу нь ширүүн болжээ.

-Та юу дуртайгаа хийж болно гэж тэр хэлэв. Гэхдээ та энэ хүмүүсийг алах гэж байна.

-Бид та нарт тусlamж ирүүлнэ гэж Нортон туйлын шийдэмгий байдал, эсвэл нэгмөсөн төөрөлдсөний шинж болох жигд хоолойгоор хариуллаа.

Түүний араас явсан нэг хүн Нортоныг дэмжин юм хэлж, бас нэг нь чимээгүйхэн хажуу тийш зайллан одлоо. Одоо Нортоныг дөрвөн хүн даган явж байна. Энэ ч тийм муу биш байх, бүр Христ ч дөнгөж арван хоёр хүнтэй байсан.

-Та сонсооч гэж МайкХатлен хэлэв. -Ноён Нортон... Брент, ядаж юм идчихээд яв. Халуун хоол илүүдэхгүй.

-Биднийг ятгахаа л үргэлжлүүлэх гэж байгаа биз? Би шүүхийн танхимд хангалттай суусан болохоор таны энэ дэгээнд чинь орохгүй л дээ. Та миний хүмүүсийн тэн хагасыг нь ятгаж чадлаа шүү дээ.

-Таны хүмүүс? -Хатлен бараг л ёолох нь холгүй болжээ. -Таны хүмүүс гэнэ ээ? Бурхан минь, ямар хачин яриа вэ? Тэд нар чинь зүгээр л хүмүүс. Энэ бол тоглоом биш, шүүх хурал бүр ч биш.

Гадаа ямар ч юм, муухай амьтад тэнүүчилж явна, өөр үгээр хэлэх аргагүй, тэгэхээр амь насаараа дэнчин тавих ямар хэрэг байна?

-Муухай амьтад гэнэ ээ? -гэж Нортон хүйтэн инээмсэглэв. -Хаана байна? Таны хүмүүс хоёр цаг цонхны дэргэд сууцгааж байна. Хэн, юу олж харав?

-Гэхдээ тэнд, дэлгүүрийн ард...

-Өө, үгүй, үгүй Нортон толгой сэгсэрлээ. -Бид үүний тухай ярьцгаасан. Нэг биш удаа. Бид явлаа...

-Үгүй гэж хэн нэгэн шивнэхэд энэ шивнээн гэнэт аравдугаар сарын бүрэнхийд унах навчны дуун мэт тархлаа. -Үгүй-үгүй-үгүй.

-Та нар биднийг хүчээр зогсоох юмуу?-гэж нарийхан хоолойгоор хоёр фокусын шилтэй, хөгшин авгай асуулаа. Тэр бол "Нортоны хүмүүс"-ийн нэг, хэрэв түүний үггийг хэрэглэвэл шүү дээ. Та нар биднийг явулахгүй гэж бодоцгоож байна уу?

Эсэргүүцэж байсан хүмүүсийн аяархан шивнэх чимээ намдав.

-Үгүй гэж Майк хэллээ. -Хэн нэгэн та нарыг хүчээр тогтооно гэж би бодохгүй байна.

Би Биллийн чихэнд шивнэхэд тэр намайг гайхсан, асуусан харцаар ширтэв.

-Яг одоо гүй гэж би хэллээ. -Хурдан.

Билли миний даалгаврыг биелүүлэхээр гүйв.

Нортон үсээ Бродвейн жүжигчний хөдөлгөөнөөр иллээ. Өөрийг нь хэн ч харахгүй байгаа гэж бодон хараал тавьж, хөрөөнийхөө старчериин олсноос угз татаж байхдаа тэр надад хамаагүй илүү таалагддаг байсан. Би тэгэхэд түүнд өөрт нь хэлж чадаагүй, одоо ч хийж байгаадаа тэр итгэж байсан эсэхийг хэлж чадахгүй нь. Сэтгэлийнхээ гүнд тэр юу болж дуусахыг мэдэж байсан байх. Түүний насан туршдаа итгэж, залбирч явсан тэр логик сэтгэлгээ нь эцсийн эцэст хэзээ нэгэн цагт сургуультай байсан, харин одоо зэрлэг араатан болон хувирсан бар мэт түүний эсрэг чиглэжээ.

Нортон өөр ямар нэг зүйл хүсэх мэт эргэн тойрноо бухимдаж сандарсан шинжтэй хараад цөөн дагалдагч нараа нэг кассны дэргэдүүр дагуулан өнгөрөв. Эмгэнээс гадна түүнтэй хамт хорь орчим насны тарган залуу, залуу бүсгүй, жинс өмсөж, гольфын малгай ар дагсан дээрээ тавьсан эр явна.

Нортоны харц минийхтэй тулгарч, түүний нүд жаахан томорсноо харц буруулав.

-Брент, ганц минут хүлээгээч гэж би хэллээ.

-Би юу ч яринааргүй байна. Тэр тусмаа чамтай.

-Би мэднэ, тиймээс зүгээр л чамаас нэг юм гүйх гэсэн юм. -Би эргэж хараад Билли кассны зүг гүйж явааг харлаа.

-Энэ юу вэ? -гэж Билли түүнд гялгар уут гардуулахад Нортон сэжиг авсан шинжтэй асуув.

-Хатаах даавуу өлгөдөг олс гэж би одоо дэлгүүрт байгаа бүх хүмүүс Нортон бид хоёрыг харж байгааг мэдрэн хэллээ. Нэлээд урт. Гурван зуун метр.

-Тэгээд юу гэж?

-Чи гарахаасаа өмнө нэг үзүүрийг нь бүснээсээ уячихгүй юу. Тэгээд олс дуусахаар машинаас ч юмуу, өөр юмнаас уячих.

-Бурхан минь, яах гэж?

-Та нар ямар ч байсан гурван зуун метр явсан гэдгийг чинь бид мэдэх болно гэж би хэллээ.

Түүний нүдэнд хормын хугацаанд нэг юм гялсхийлээ, гэхдээ зөвхөн хормын хугацаанд.

-Үгүй гэж тэр хэлэв.

Би мөрөө хавчлаа.

-О'Кей. Ямар ч байсан амжилт хүсье.

Гольфын малгайтай эр гэнэт дуугарав:

-Би үүнийг чинь хийе, ноёнтоон. Яагаад үгүй гэж?

Нортонд түүнд хатуухан үг хэлэх гэсэн мэт огцом эргэхэд өнөөх нь түүнийг тайвнаар харан, харц нь ер дальдирсангүй. Түүний харцанд юу ч байсангүй. Тэр шийдсэн, тэгээд огтхон ч эргэлzsэнгүй. Нортон ч бас үүнийг ойлгосон бололтой, юм хэлсэнгүй.

-Баярлалаа гэж би хэлээд тонгоргоор гялгар ууттыг зүслээ. Олсны хатуу цагаригууд уутнаас унав. Би нэг үзүүрийг нь "гольфын аварга" эрийн бүсэнд огцом татвал сулрахаар хөврөх зангидалтаар зангидаа. Гэтэл өнөөх эр дор нь тайлж, далайн зангилаагаар бөх зангидав. Танхимд нам гүм болжээ. Нортон хөлөөт сэлгэн зогсоно.

-Хутга авах уу? -гэж би асуулаа.

-Надад бий. -Тэр намайг өнөөх хүйтэн харцаараа ширтэв. -Чи хамгийн чухал нь олсоо харж байгаарай. Хэрэв орооцолдоод, тээглэчихвэл би тас огтолно.

-Бид бүгд бэлэн үү? -гэж Нортон чанга дуугаар асуулаа. Тарган залуу түлхүүлсэн мэт ухасхийв.

Нортонд хэн ч хариулсангүй, тэд хаалга руу явлаа.

-Брент гэж хэлээд би гараа сунгав. -Сайн сайхныг хүсье.

Тэр миний гарыг эргэлзэх мэт харлаа.

-Бид та нарт тусламж явуулна гээд тэр "Гарах" гэсэн бичигтэй хаалгыг түлхэв.

Би дахин өнөөх хурц эхүүн үнэрийг мэдэрлээ. "Түүний хүмүүс" Нортоны араас гарцаав. Майк Хатлен миний дэргэд хүрч ирэн зогслоо. Таван хүнтэй Нортоны баг удаан нүүн хөдлөх сүүн цагаан манан дунд зогсоцгоноо. Нортон нэг юм хэлэхэд ийм зайнаас би сонсох ёстой байсан ч манан дуу чимээг дардаг бололтой, юу ч сонсогдсонгүй. Хол ажиллаж байгаа радио шиг л юм дуулдлаа.

Дараа нь тэд холдон явцгааж эхлэв.

Хатлен хаалгыг онгорхой хэвээр барьсаар байв. Би олсыг цувуулж, болохгүй бол тас огтолно гэж хэлснийг санан, чөлөөтэй явуулахыг хичээж байлаа. Гаднаас нэг ч дуу чимээ сонсогдсонгүй. Билли миний дэргэд үг дуугүй зогсох боловч тэр сэтгэл нь хөдөлснөөс бүр чичирж байгааг би мэдэрч байлаа. Энэ таван хүн мананд далд орсон бус, ерөөсөө л гэнэт үзэгдэхгүй болчих шиг хачин сэтгэгдэл дахин төрөв. Тэдний хувцас хэдэн хором хөвөх мэт харагдаад юу ч үзэгдэхээ болилоо. Энэ манан хүнийг хэдхэн хормын дотор залгих мэт далд оруулахад л түүний ямар өтгөнийг мэдэрч болох юм.

Би олсыг цувуулсаар байв. Эхлээд бүх олсны дөрөвний нэг манан дунд алга болж, дараа нь тал нь цувлаа. Дараа нь хормын төдийд олс хөдөлгөөнгүй болж унжив. Би амьсгаа ч авч чадахаа байсан ч удалгүй дахин урагшилж эхлэв. Би олсыг хурууныхаа завсраар цувуулж байхдаа гэнэт аав намайг Бруксайдад аваачиж Грегори Пек тоглосон "Моби Дик" киног үзүүлж байсныг саналаа. Би бүр инээмсэглэсэн байх.

Олсны дөрөвний гурав дуусч, би Биллийн гутлан дээр хэвтэх үлдсэн багахан хэсгийг харж эхлэх үед миний гар дахь олс хөдөлгөөнгүй болов. Таван секунд орчим олс хөдөлгөөнгүй байснаа гэнэт бүтэн хагас метр орчим урагш ухасхийж, дараа нь зүүн тийш огцом эргэн, хаалганы ирмэгийг жингэнэн дуугартлаа чанга гүядлаа.

Дараа нь долоон метр орчим миний гараас халж түлэгдтэл угзарч, манан дундаас нарийхан дуугаар чичрэн хашгирах дуун сонсогдоо. Эмэгтэй хүн үү, эрэгтэй хүн үү гэдэг нь ч ойлгогдсонгүй.

Олсыг дахин угзарлаа. Бас дахин. Түүнийг хаалганы хоёр тал руу угзчиж, Билли сонсоод ёолсон хашгираан сонсогдов. Хатлены нүд айснаас бөөрөнхий болж, амны нь нэг талын завьж чичрэн доош унжжээ.

Хашгирах дуун гэнэт тасарч, тун удаан анир чимээгүй болов. Дараа нь эмгэн хашгираа, энэ удаа эргэлзэх зүйл байсангүй.

-Надаас үүнийг холдуулаач! -гэж эмгэн хашгираа. -Оо, бурхан минь, бурхан минь, холдуулаач наадахаа... -тэгээд дахин чимээгүй болов.

Бас дахиад л олс миний гараас угз татагдаж, түрүүчийнхээс ч илүү гар түлэн цуварлаа. Тэгээд манан дундаас би сонсоод ам хатах шиг болсон чангаар гахай мэт "хр-рр-рр" хэмээн дуугарах дуу гарлаа.

Би амьдралдаа ийм дуу сонсоогүй, гэхдээ энэ дуу африкийн ойд, эсвэл өмнөд америкийн намаг дунд авсан киноны дуунд илүү тохирохоор юм. Том амьтны дуу. Тэр дуу, намхан, зэрлэг, араатны дуу дахин бидэнд сонсогдоо. Дуу дахин сонсогдоод тасалдсан үглээ мэт болж, дараа нь нам гүм болов.

-Хаалгаа хаачих гэж Аманда Дамфрис чичирсэн хоолойгоор хэллээ. -Хаалгаа хаачих, би гүйя.

-Одоохон гэж би хэлээд олсыг татаж эхэллээ.

Олс манангасаас цувран гарч, миний хөлөн дор цагариглан унаж байв. Түүний сүүлчийн метр орчим нь туйпуун улаан өнгөтэй болжээ.

-Үхэл! -гэж хатагтай Кармоди хашгираа. -Тэнд үхэл байна! Та нар бүгд харсан биз, тийм үү?

Тасарч салбайсан олсны үзүүрт цусны бяцхан дуслууд шингэжээ.

Хатагтай Кармодитай хэн ч маргасангүй.

Майк Хатлен хаалгыг тавихад хаалга өөрөө хаагдлаа.

7. Ахны шөнө

Ноён Маквей намайг арван хоёр, арван гуравтай байхад л Брижтонд махны худалдагчаар ажиллаж эхэлсэн, гэхдээ би одоог хүртэл түүний нэр, хэдэн настайг нь ч мэдэхгүй. Тэр нэг агааржуулагчийн дор (агааржуулагч ажиллахгүй байсан ч тор нь жаахан ч болов агаар оруулж, гаргаж байлаа) хийн шарах ширээ байрлуулаад тахиа шарж, 6:30 гэхэд дэлгүүрээр нэг шарсан тахианы үнэр ханхалж эхэллээ. Бад Браун татгалзсангүй. Тэр балмагдсан байж ч магад, гэхдээ тэр мах, тахиа удахгүй муудна гэдгийг ойлгосон бололтой. Шарсан дэгдээхэй маш сайхан ханхалж байсан ч хүмүүсийн зарим нь юм идэх ямар ч хүсэлгүй болчихсон байв. Цагаан халаад өмссөн, цэвэрч, нямбай ноён Маквей дэгдээхэй шарж, цаасан тавган дээр тавилан, кафенд тавилдаг шиг эгнүүлэн тавилж байлаа.

Хатагтай Терман Билли бид хоёрт нэг нэг порц тахиа төмсний салатан хачиртай авчрав. Би цадталаа идэж, харин Билли өөрийн тавганд гар ч хүрсэнгүй.

-Залуу минь, бяртай болохын тулд идэх хэрэгтэй гэж би хэллээ.

-Би өлсөөгүй гэж Билли хэлээд тавгаа түлхэв.

-Хэрэв чи юм идэхгүй бол...

Биллийн ард сууж байсан хатагтай Терман толгой сэгсрэв.

-За яахав гэж би хэллээ. -Ядаж тоор идчих, за юу.

-Хэрэв ноён Браун загнавал яах вэ?

-Тэгвэл надад хэлээрэй.

-О'Кей.

Билли тавиуруудын дундуур аажуухан явлаа. Тэр нэг л хачин, ноомой болчихсон, түүнийг ийм байдалтай явааг нь хараад миний зүрх өвдөж байлаа. Ноён Маквей дэгдээхэй шарсаар, бараг хэн ч идэхгүй байгааг тэр анзаараагүй мэт, зүгээр л өөрийн хийж байгаад хамаг анхаарлаа хандуулжээ. Хүмүүс ийм байдалд янз бүрээр ханддаг тухай би бичиж байсан санагдана. Бодож төсөөлөхөд хэцүү ч үнэхээр тийм. Хүний оюун ухаан гэдэг балар ой л гэсэн үг.

Хатагтай Терман бид хоёр эмийн тавиуруудын дэргэд суугаад хүмүүс жижигхэн хамт олон болцгоон хэсэг бүлгээрээ хуваагдсаныг харж байв. Хатагтай Кармодигаас өөр хэнч ганцаар үл сууна. Жим, Майрон хоёр хүртэл хамт, пивоны хөргөгчийг налан хурхирна.

Зургаан шинэ жижүүр шуудайнуудын нүхэн цонхны дэргэд сууна. Тэдний нэг нь Олли. Тэр дэгдээхэйн гуя зулгааж, пивоор даруулж байна. Жижүүр бүрийн дэргэд бамбарууд шуудай түшүүлэн тавилж, хажууд нь нүурс асаах шингэнтэй сав тавьжээ. Гэхдээ одоо хэн ч энэ бүхэнд урьдынх шигээ итгэхээ больсон бололтой. Тэр аймаар муухай араатны дуу, тас хазаж,

цус болсон олсны дараа хэн ч итгэхээ болжээ. Хэрэв тэр амьтан, манангаас ирсэн тэр аймшигт араатан биднийг идэхийг хүсвэл яаж ийгээд л барина. Тэр, эсвэл тэд нар.

-Өнөө шөнө хэр аюултай байх бол? -гэж хатагтай Терман асуув.

Түүний дуу тайван сонсогдсон ч нүдэнд нь айдас шингэжээ.

-Хэтти, би мэдэхгүй.

-Билли надтай хамт байг. Би... Дэвид, би ухаангүй аиж байна. -Тэр инээд алдав. -Тийм, ингэж хэлэх ёстой байх. Гэхдээ хэрэв Билли надтай цуг байвал би зүгээр байх болно. Түүний төлөө.

Хатагтай Терманы нүд гялалзана. Би бөхийж, түүний мөрийг иллээ.

-Би Аланыг бодож, сэтгэл минь маш их зовж байна гэж Терман хэллээ. -Гэхдээ тэр үхчихсэн байх, Дэвид. Би түүнийг үхчихсэн гэдгийг мэдэрч байна.

-Хэрэггүй, Хэтти. Чи үүнийг мэдэж чадахгүй шүү дээ.

-Гэхдээ би үүнийг мэдэрч байна. Чи Стефенийн тухай юу ч мэдрэхгүй байна уу?

-Үгүй гэж би шуд зуун худал хэллээ.

Хэтти хачин дуу гаргаад гараараа амаа таглав. Түүний нүдний шилэнд гар чийдэнгийн гэрэл бүдэгхэн гялалзана.

-Билли ирж явна гэж би бувтнав.

Билли тоор идэж явна. Хэтти Терман хажуудаа шал цохин хүүг суулгаад, тоорыг идэж дууссаны нь дараа тоорын яс, утсаар хэрхэн бяцхан хүн хийхийг зааж өгнө гэж хэллээ. Билли ядарсан шинжтэй инээмсэглэхэд Хэтти ч хариуд нь инээмсэглэв.

20:00-д зургаан шинэ жижүүр шуудайнуудын нүхэн цонхны дэргэд сууцгааж, Олли над дээр ирлээ.

-Билли хaa байна?

-Тэр цаад буланд хатагтай Термантай хамт байгаа гэж би хариуллаа. -Гар аргаар тоглоом хийцгээж байна. Тэд тоорын ясаар хүүхэлдэй хийж, цаасан уутаар маск, алимаар бас хүүхэлдэй хийсэн, одоо ноён Маквей яндан цэвэрлэгч яаж хийхийг зааж байна.

Олли пивонос том балгав.

-Цонхны цаана нэг юм хөдөлж байна гэж тэр хэллээ.

Би түүнийг тас ширтэхэд тэр өөртөө итгэлтэй харцаар хариуллаа.

-Би согтуу биш байна гэж тэр хэлэв. -Би уухыг хичээсэн, гэтэл согтдоггүй. Уг нь согтохыг тун их хүсэж байна даа, Дэвид минь.

-Чи юу яриад байна? Юу тэнд хөдөлж байгаа юм бэ?

-Би бүрэн итгээгүй л байна. Уолтероос асуусан, тэр бас мэдэрч байна гэсэн. Хэдэн хором манангийн нэг хэсэг хар бараан болж байна. Нэг хэсэг, эсвэл зураас, эсвэл хөхөрчихсөн юм шиг багахан хэсэг. Дараа нь дахиад л алга болчихно. Манан өөрөө ч хөдөлж байна. Бүр Эрни Симмс ч юм мэдрээд байна, гэтэл тэр чинь сарьсан багваахай шиг сохор хүн шүү дээ.

-Тэгвэл бусад нь?

-Тэд бүгд өөр мужийнх, би тэднийг танихгүй гэж Олли хэллээ. -Би тэднээс асуугаагүй.

-Чи зүүдлээгүй гэдэгтээ итгэлтэй байна уу?

-Итгэлтэй байна гээд ганцаар сууж буй хатагтай Кармодийн зүг толгой дохив. Болсон явдал эмгэний хоол идэх хүслийг огтхон ч дараагүй бололтой, өмнө нь ясаар дүүрсэн таваг харагдана. Хоолоо тэр жимсний шүүс ч юмуу, цус ч юмуу, улаан шингэнээр даруулж байна.

Нэг зүйлийг л тэр авгай үнэн хэлсэн байна гэж Олли нэмлээ. -Бид бүгдийг үзэх болно. Харанхуй болохоор бүгдийг үзнэ.

Гэхдээ харанхуйг хүлээх хэрэг гарсангүй. Энэ бүхэн болж өнгөрөхөд Билли юу ч олж харсангүй, учир нь хатагтай Терман тэр хоёр дэлгүүрийн цаад буланд байсан юм. Олли миний дэргэд сууж байтал нэг жижүүр нарийхан дуугаар чарлаад гарaa сарвалзуулан нүхэн цонхноос зугтан гүйлээ. Цаг 20:30-д дөхөж, шүрэн цагаан өнгийн манан арван нэгдүгээр сарын бүрэнхий шиг жигд саарал өнгөтэй болжээ.

Нэг цонхны гадна талын шилэн дээр юу ч юм бууж наалдав.

-Бурхан минь гэж тэнд жижүүрлэж байсан эр дуу алдлаа. –Намайг тавиадах! Би чадахгүй нь!

Тэр нүдээ бүлтийлгэн, ийш тийш цовхчин гүйлээ. Бүрэнхийд завьжнаас нь цухуйсан шүлс гялсхийв. Дараа нь тэр эргэж, хүнсний зүйл хийсэн хөргөгчний урдуур гүйн далд оров.

Бас хэн нэгэн харанхуйд дуу алдаж, юу болоод байгааг үзэхээр хүмүүс гүйлдэв. Бусад нь цонхон дээр юу байгааг үл тоон, танхимиын цаад, холын булангийн зүг зугтан гүйлдэв.

Олли бид хоёр цонх руу юу байгааг үзэхээр ойртлоо. Олли хатагтай Дамфрисын өгсөн гар бууг хийсэн өмднийхөө халаасанд гарaa хийжээ. Бас нэг жижүүр дуу алдлаа, гэхдээ айснаас биш, ой гутан сэжиглэснээс болов бололтой. Бид кассны дэргэдүүр өнгөрөхөд жижүүр юунаас айсныг би олж харлаа. Энэ чухам юу юм гэдгийг би мэдэхгүй, гэхдээ би харж байлаа. Энэ амьтан Босхын зураг дээрх жижигхэн аймшигийн амьтныг санагдуулна. Бас энэ амьтан жаахан инээдтэй ч юм шиг, учир нь тэр найз нарыгаа айлгахын тулд хүмүүс доллар ерэн найман центээр худалдан авдаг винилээр хийсэн хачин тоглоомыг ч бас санагдуулах ажээ. Яг Нортоны хэлж байсан шиг амьтан. Богиновтор ишнүүдийн үзүүрт байрласан хоёр бүлтгэр

нүд нь хaa хамаагүй өөр өөр тийш харж байна. Шилэн дээгүүр энэ амьтан бүдүүн соруулуудаа ашиглан явах ажээ. Их биений нь төгсгөлд бэлэг эрхтэн ч юмуу, эсвэл хатгуур юмуу, нэг хурц үзүүртэй юм ёрдойно. Нуруун дээр нь ялааных шиг тунгалаг хоёр далавч харагдана. Бидний зүүн талын нүхэн цонхны дэргэд хүмүүс зогсоод гайхаж, сэжиглэн дуу алдацаана, тэнд гурван ийм хачин амьтан цонхон дээгүүр, дун мэт нойтон мөр үлдээн мөлхөж байлаа. Нүд нь, хэрэв энэ үнэхээр нүд мөн бол, хуруу шиг бүдүүн ишэн дээр ганхан хөдөлнө. Тэдний хамгийн том нь метр хорин сантиметр орчим урт ажээ. Заримдаа энэ хачин амьтад бие биесийнхээ дээгүүр зүгээр л даван мөлхөнө.

-Ямар муухай чөтгөр гээч вэ, хараач гэж Том Смолли ой гутсан шинжтэй хэлэв. Тэр бидний баруун талын нүхэн цонхны дэргэд зогсоно. Би дуугарсангүй. Хэрэв энэ амьтад нүхэн цонх бүрийн цаана мөлхөж байгаа бол тэд байшинг бүрхжээ гэсэн үг... Өт хэсэг махан дээр цуглдаг шиг. Мэдээж хэрэг энэ нь сайхан санагдсангүй, миний түрүүн идсэн тахианы мааны буцан гарах гээд байгааг би мэдэрлээ.

Хaa ч юм, уйлж байна. Хатагтай Кармоди "тамытн элч" нарын тухай хашгична. Хэн нэгэн түүнийг амаа тат гээд, дуугүй болохгүй бол нам цохино гэж сүрдүүллээ... Бүх зүйл хуучнаараа. Олли халааснаасаа хатагтай Дамфрисын гар бууг гаргахад би түүний гараас барьж авлаа.

-Чи галзуурав уу?

-Би юу хийж байгаагаа мэдэж байна гээд Олли гарсаа суллан авч, сэжиглэн ярвайсаар бууны амаар шилийг тогшлоо. Өнөөх амьтад далавчаа бараг харагдахгүй болтол хурдан дэвэв. Хэрэв би мэдэж байгаагүй бол тэднийг ерөөсөө далавчгүй гэж хэлэхээр харагдана. Дараа нь тэд хөөрлөө. Хүмүүс Оллиг дуурайн шалны модны ишээр шилийг тогшицгоож эхлэв. Өнөөх амьтад нисэж, тэгээд удалгүй эргэн бууж байлаа. Тэдний тархи ялааныхаас томгүй бололтой. Эхлээд ухаангүй аиж байсан хүмүүс тайвширч, хэрэв энэ чам дээр суувал яах бол гэх зэргээр ярилцаж эхэллээ. Ямар ч байсан энэ асуултад би туршилт хийж хариулахыг хүсэхгүй.

Цонхыг хүмүүс тогших нь цөөрч эхлэв. Олли над руу эргэж нэг юм хэлэх гэтэл амаа нээж амжаагүй байхад нь манангаас өөр нэг амьтан гарч ирэн шилэн дээгүүр мөлхөж байсан амьтныг шүүрлээ. Би хашгирсан байх. Санахгүй байна. Энэ хоёрдахь амьтан бас л нисдэг юм. Манангийн нэг хэсэг яг Оллийн хэлсэн шиг харлаж, дараа нь тас нясхийн дуугарах арьсан далавчтэй, альбинос шиг цагаан биетэй, улаавтар нүдтэй амьтан болон хувирав. Тэр ягаан хорхой шиг амьтныг шүүрэн аваад эргэн мананд шингэж алга болов. Бүх зүйл таван секундэд л болж өнгөрлөө. Ягаан хорхой шиг амьтан цахлайн хошуунд жижиг загас нумарч хөдөлдөг шиг байдгаараа тийчлэн хөдөлсөөр цагаан амьтны аманд орж алга болохыг би амжиж харсан юм.

Дахин нэг цохилт сонсогдлоо, бас дахиад нэг. Хүмүүс дахин хашгиралдаж, дэлгүүрийн хойд тал руу гүйлдэв. Дараа нь хэн нэгэн өвдсөнөөс чанга хашгирлаа.

-Ээ, бурхан минь, тэнд нэг эмгэн унаад, хүмүүст гишгүүлчихлээ гэж Олли хэлэв.

Тэр касснуудын дундуур гүйллээ. Би араас нь ухасхийснээ өөр нэг зүйл олж хараад зогтусав.

Миний баруун талд бордоотой нэг шуудай гулсан, хариугүй унах гэж байна. Том Смолли яг дор нь суугаад нүхээр гадагш, мананг ширтэнэ.

Бас нэг ягаан хорхой мэт амьтан Олли бид хоёрын зогсож байсан нүхэн цонхны цаана шилэн дээр буухад удалгүй өөр нэг цагаан махчин манангсаас шунгинан гарч ирээд шүүрэн авлаа. Унаж, гишгүүлсэн эмгэн нарийхан сөөнгөтсөн дуугаар хашигирсан хэвээр.

Шуудай. Шуудай гулссаар байна.

-Смолли гэж би хашигирлаа. -Болгоомжил! Дээрээс чинь!

Шуугиан дунд тэр намайг сонссонгүй. Шуудай гулсаж, түүний яг толгой дээр уналаа. Смолли эрүүгээрээ цонхны наад талын намхан тавиурыг цохин шалан дээр унав. Нэг цагаан махчин шилэн дэх хагархайгаар зүтгэж, шуугиан бага зэрэг намдахад түүний хяхтнан маажих мэт дуугарах нь сонсогдов. Бага зэрэг хажуу тийш хазайлгасан гурвалжин толгой дээр улаан нүд нь гялалзана. Хүнд, махир хошуугаа нэг ангайж, нэг хааж байна. Тэр динозавруудын тухай номны птеродактиль, галзуу өвчтэй хүний дэмийрсэн зүүдний аймшиг хоёрыг зэрэг санагдуулах ажээ.

Би бамбаруудын нэгийг шүүрэн авч, нүүрс асаах шингэнд дүрэхдээ хувинг татан шатдаг шингэнийг шалаар нэлийтэл асгаж орхив. Нисдэг гайхал дээд талын шуудайн дээр суугаад эргэн тойрноо харж, хурц хумстай хөлөө ээлжлэн тавилж харагдана. Энэ амьтад ч бас тэнэг бололтой, хоёр удаа тэр далавчаа дэлгэх гээд хананд цохиж, бөгтөр нуруун дээрээ тас мэт буцаан хумиж байлаа. Дараа ньтэр муухай амьтан тэнцвэрээ алдан доош унаж, Том Смоллийн яг нуруун дээр буув. Хурц хумстай хөлөө нэг хөдөлгөн Томын цамцыг урж, нурууг нь цус гартал маажиж орхив. Би түүнээс метрийн зайд л зогсож байлаа. Бамбараас нүүрс асаагч шингэн дусалж, би түүнийг алахад бэлэн байсан ч гал асаах чүдэнз байхгүйгээ гэнэт мэдлээ. Сүүлчийн чүдэнзээрээ би ноён Маквейн навчин тамхийг асаагаад дуусгаж орхиж.

Танхимд хачин юм болж байна. Хүмүүс Смоллийн нуруун дээр суух, газар дэлхий дээр хэн ч харж байгаагүй хачин муухай амьтныг харцгаажээ. Тэр хошуугаараа хурдан цохиж, Смоллийн хүзүүнээс хэсэг мах тасдан авлаа.

Би бамбараа бороохой болгон ашиглахаар зэхэж байтал түүний даавуугаар ороосон хэсэг гэнэт аслаа. Миний хажууд зогсох Дэн Миллер тэнгисийн усан цэргийн тэмдэгтэй асаагуур бариад хажууд зогсоно. Түүний царай аймшиг, уур хилэнгээс чулуу мэт болжээ.

-Наадахаа ал гэж тэр сөөнгө хоолойгоор хэлэв. -Чадах л юм бол наадахаа алж орхи.

Миний хажууд Олли гартаа буутай зогсовч Томыг онохоос айн буудаж чадсангүй. Муухай амьтан далавчаа дэлгэн дэвсэн боловч нисэх гээгүй, зүгээр л хөөрхий Смоллийн нуруун дээр улам баттай сууж аваад далавчаараа түүний биеийг харагдахгүй болтол бүтээж, тэндээс ямар нэг зүйл урагдах мэт чимээ гарлаа. Хэлэхийн аргагүй муухай чимээ. Бүх зүйл хэдхэн секундын дотор болж өнгөрөв. Дараа нь би түүнийг асч буй бамбараар хатгаад авлаа. Би цаасан шувуу хатгасан мэт хачин хөнгөн, хэврэг санагдаж, дараа нь өнөөх амьтан хяхтнан дуугарч, далавчаа дэлгээд дурсхийн аслаа. Түүний толгой салгалж, нүд нь хялайхад би

Түүнийг өвдсөнөөс ингэж байна гэж найдав. Дараа нь тэр амьтан салхинд савлах угаасан цагаан даавуу мэт дуугаран агаарт хөөрч, бас дахин хяхтнан хашгираа.

Түүний үхлийн өмнөх галт нислэгийг харан хүмүүсийн толгой эргэцгээв. Болж өнгөрсөн бүхнээс энэ дүрэлзэн шатаж буй амьтны дэлгүүрийн танхимаар ииш тийш ниссэн галт нислэг хамгийн тодор сэтгэлд хоногшин үлджээ.

Тэр энд тэнд шатаж буй хэсгүүдээ унаган ниссээр эцсийн эцэст спагеттийн сүмстэй шилнүүд өрсөн тавиур дээр унаж, "Рагу-энд-Принс", "Прима" улаан сүмснүүд энд тэндгүй цацлав. Түүнээс үns, яс хоёроос өөр бараг юу ч үлдсэнгүй. Дэлгүүрээр шатсан махны хурц муухай үнэр ой гутам ханхалж, үүнтэй зэрэгцэн хагархай цонхоор орж ирж буй манангийн эхүүн үнэр бас ханхлав. Хэдэн хором танхимд нам гүм боллоо. Биднийг энэ галт нислэгийн хар дом ховсдож орхисон мэт болов. Дараа нь хэн нэгэн хашгираа. Бүгд орилолдож, би хаана ч юм, хүүгийнхээ уйлахыг сонсов.

Хэн нэгэн миний мөрнөөс базаж авлаа. Энэ бол Бад Браун байв. Түүний нүд ухархайнаасаа унах гэж байгаа мэт бүлтийж, амаа ангайснаас хиймэл шүднүүд яrzайн харагдана.

-Тэнд бас нэг... Өөр... -гээд гараараа заав.

Шилний хагархай нүхээр ягаан хорхой шиг амьтан орж ирээд бордоотой шуудайн дээр суужээ. Түүний төө хэрийн ишэн дээрх хоёр нүд бүлтийж, шумуулынх шиг далавч нь хямд сэнс мэт жингэнэн дуугарна. Ягаан, өвчтэй мэт бүдүүн бие нь бамбалзах нь амьсгалж байгаа бололтой. Миний бамбар ассан хэвээр, би түүний зүг ухасхийсэн боловч надаас гуравдугаар ангийн багш, хатагтай Репплер түрүүллээ. Тавин тав орчим насны, туранхай, би харах бүр нарийхан хэрчсэн борц санаанд ордог энэ эмэгтэй хоёр гартаа нэг нэг сав "Рэйд" шавьжны хор бүхий шүршүүр барьсан нь ямар нэгэн инээдмийн жүжгийн галзуу дүр мэт харагдана. Дайсныхаа гавлыг хага цохиж буй ямар ч агуйн хүн бахархмаар чанга орилоод хатагтай Репплер хоёр гараа урагш сунган шүршүүрийн товчлууруудыг дарав. Ягаан амьтныг хорны зузаан давхрага нөмрөн авч тэр салгалан чичирж, эргэлдээд шуудайн дээрээс унаж, ямар ч эргэлзээгүй үхсэн Том Смоллийн биенээс ухасхийн холдож, шалан дээр унав. Түүний далавч нь хар хүчээрээ жингэнэвч эзнээ хааш нь ч авч явж чадахаасаа нэгэнт өнгөрчээ. Хэдэн секундын дараа далавчны дэвэлт суларч, дараа нь бүр зогсоод, ягаан муухай амьтан үхлээ.

Хүмүүс уйлалдах, гасалж гангинах сонсогдоно. Хүмүүст гишгүүлсэн настай хатагтай ёолсоор. Бас хаанаас ч юм, инээд сонсогдлоо. Хэн нэгэн галзуу солиотой мэт хөхөрнө. Хатагтай Репплер алсан амьтныхаа дэргэд хүндээр амьсгаадан зогсоно.

Хатлен, Миллер хоёр авдар савтай зүйлийг ачих буулгах хаалганаас дэлгүүрийн тавиуруудад зөөж хүргэдэг тэргэнцэр олж, түүгээр цонхны хагархайг бөглөлөө. Түр зуурын хамгаалалтын хувьд энэ оновчтой, зөв шийдэл болжээ.

Шөнө зүүдэндээ явдаг хүн мэт алхалсаар Аманда Дамфрис гарч ирэв. Нэг гартаа тэр цоо шинэ хуванцар хувин, нөгөө гартаа тунгалаг гялгар цаасаар ороосон шүүр барьжээ. Тэр бөхийж, хачин том, хоосон нүдээрээ урагш ширтэн үхсэн ягаан амьтныг хувинд шүүрдэн оруулав. Аманда шал шүүрдэхэд гялгар цаас тачигнан дуугарах нь сонсогдож байлаа. Дараа

нь Аманда хаалганд тулан очиж, хагас нээгээд амьтны сэгийг гадагш гарган шидэж орхилоо. Өөр нэг ягаан амьтан манангаас нисэн гарч ирээд хувин дээр сууж, тойрон мөлхөж гарлаа. Аманда чанга уйлав. Би явж очин, түүний мөрөөр тэвэрлээ.

Шөнийн нэг цаг гучин минут. Би махны лангууны цагаан паалан будагтай ханыг налан Үүргэлж суулаа. Билли миний гэдсэнд нүүрээ наан унтана. Хажууханд хэний ч юм, пиджак дэрлээд Аманда Дамфрис унтана.

Нисдэг цагаан амьтан шатаж үхсэний дараа Олли бид хоёр агуулахад очиж, Биллиг хучсан шиг ширмэл дэвсгэр зургаан ширхэгийг олж авчирсан юм. Одоо түүн дээр хүмүүс унтаж байна. Дараа нь бид хоёр жүрж, тоор бүхий хэдэн хүнд хайрцаг чирэн авчирж, дөрвүүлээ нийлж байгаад хагархай цонхны наад талд, шуудайнууд дээр тавилсан юм. Энэ шувуутай төстэй амьтад дотогш орохын тулд ихээхэн хүч зарцуулах хэрэгтэй болно, авдар бүр гучин килограмм жинтэй юм.

Гэхдээ энэ шувуутай төстэй муухай амьтад бол мананд нуугдсан ганц махчингууд биш. Нормыг чирэн авч явсан тэмтрүүлүүд бий. Бас нам дуугаар гахай мэт дуугарч, бас архирдаг амьтан ч байгаа. Үе үе ийм дуу бидэнд холоос сонсогдож байлаа, гэхдээ манан дуу чимээг дардаг болохоор энэ "холоос" гэдэг нь хэр зайлж илэрхийлж байгааг хэлэх аргагүй. Бас заримдаа архирах дуу бүр хажууд сонсогдож, байшин доргих мэт болоход зүрх мөс шиг хүйтэн усаар дүүрэх мэт санагдаж байлаа.

Билли нойрон дундаа хөдөлж, ёлох мэт дуугарлаа. Би түүний толгойг илэхэд тэр арай чанга ёолж, дараа нь аюул багатай зүүдний ертөнц рүү эргэн одов бололтой. Харин би зүүрмэглэхээ ч болж, сэргүн сууж байлаа. Харанхуй болсноос хойш би бүтэн хагас цаг л унтсан, тэгэхэд ч аймшигийн зүүд зүүдлээд ер болж өгөхгүй байсан юм. Зүүдний нэг хэсэгт би өмнөх үдшийг дахин харлаа. Билли, Стефф хоёр том цонхны өмнө зогсоод удахгүй шуурга эхлэхийг илтгэх саарал давалгаан зураастай хар ус, хурдан эргэлдэх мөнгөлөг усан хуйг ажиглаж байна. Харин би хүчтэй салхи шилийг хагалж, үхлийн шилэн жаднуудыг тасалгаагаар нэг цацаж чадна гэдгийг мэдэж, тэднийг цонхноос холдуулахыг оролдоно. Гэвч би хичнээн гүйвч тэдэнд ганц алхам ч ойртож чаддаггүй. Дараа нь усан хуйн дундаас аварга том, час улаан өнгөтэй эртний шувуу хөөрч, далавчаа дэлгэн нуурыг баруунаас зүүн зүг хүртэл бүрхэв. Нуур харанхуйлж, харин өнөөх шувуу Голландын тоннель шиг хоолойтой хошуугаа нээн Стефф, Билли хоёрын зүг шунгинан дайрч, яг үүнтэй зэрэгцэн нам зэвүүн хоолойгоор хэн нэгэн "Сум" төсөл"..."Сум"төсөл"..."Сум"төсөл"..." хэмээн давтаж гарлаа.

Зөвхөн Билли бид хоёр ч муу унтсан юм биш. Хүмүүс нойрондоо хашгирцгааж, зарим нь бүр сэргчихээд хашгирч байлаа. Хөргөгчинд байсан пиво асар хурдан дууслаа. Бадди Иглтон юу ч хэлсэнгүй, агуулахаас дахин хэдэн авдрыг авчрав. "Соминекс" гэдэг нойрны эм бас дууссан гэж Майк Хатлен надад хэллээ. Зарим хүмүүс нойрны эмийг долоо, найман шилээр нь авч байлаа.

-"Нитол" нойрны эм байгаа гэж тэр хэлэв. -Дэвид, чамд хэрэгтэй юу?

Би толгой сэгсрээд түүнд баярласнаа илэрхийлэв.

Тавдугаар кассны дэргэд манай архичид цуглажээ. Долоо, найман хүн, машин угаалгын газар ажилладаг Лу Таттингерээс бусад нь бүгд өөр мужийн хүмүүс харагдана. Лу бол шил хөнтрөх шалтгаан л гарвал татгалздаггүй хүн. Дарсны бригадын бүх гишүүд сүрхий халцгаажээ.

Бас зургаа, долоон хүн галзуурал, солиорлын байдалд оржээ. Өөрөөр хэлэх арга алга. Энэ хүмүүс элдэв пиво, дарс, эмгүйгээр гөлрөө байдалд оржээ. Хоосон, хаалганы бариул шиг гялалзсан нүдээр тэд эргэн тойрноо харцгаана. Бодит байдлын хатуу бетон байж боломгүй хачин газар хөдлөлтөд хагарч, энэ хөөрхий хүмүүс хавцал руу унажээ. Уг нь тэд аажмаар сэхээ орж болох хүмүүс. Хэрэв тийм цаг хугацаа байсан бол...

Бусад нь шийдвэр, дүгнэлт хийж, нөхцөл байдалд дасахыг оролдож байв. Зарим дүгнэлтүүд бүр хачин. Жишээ нь хатагтай Репплер энэ бүхнийг зүүд гэж байв. Ямар ч байсан тэр тэгж хэлсэн. Хэлэхдээ тун итгэлтэй хэлсэн.

Би Амандаг харлаа. Миний дотор энэ эмэгтэйд хандах эвгүй, хүчтэй сэтгэл бий болжээ. Эвгүй, гэхдээ муухай биш. Түүний нүд хачин тод ногоон өнгөтэй, би түүнийг линзээ авах байх хэмээн харж байсан ч энэ түүний нүдний төрөлхийн өнгө бололтой. Би энэ эмэгтэйг хүсч байлаа. Миний эхнэр гэртээ үлдсэн, тэр амьд байж ч магад, гэхдээ л үхсэн нь илүү үнэнд ойртох байх, ямар ч байсан би түүндээ хайртай, тэгээд түүнд Биллитэй хамт буцаж очихыг би юу юунаас илүү хүсч байлаа, гэхдээ, үүний зэрэгцээ, би Аманда Дамфрис гэдэг энэ хатагтайг бас хүсч байв. Энэ бүхний учир шалтгаан нь бид ийм хачин нөхцөл байдалд орчихсон учраас гэж би өөртөө хэлж байлаа. Үнэхээр тийм ч байж болох юм, гэхдээ элдэв тайлбар юу ч өөрчилж чадахгүй.

Би дахин зүүрмэглэж, өглөөний гурван цагийн үед гэнэт сэрэв. Аманда атиран хэвтээд хоёр гараа хөлийнхөө дунд хийжээ. Тэр бөх унтаж байх шиг. Нэг ташааных нь дээр цамц нь дээш согсойж, дун цагаан арьс ил гарчээ. Би түүнийг харж, эвгүй байдалд орж байгаагаа мэдэрч байв.

Би өөр юм бodoхыг хичээн, өчигдөр Нортоны хөргийг зурах тухай бодож байснаа саналаа. Мэдээж хэрэг, нэг их лут, жинхэнэ хөрөг биш л дээ. Зүгээр л түүнийг модон дээр өөрийн лааз пивыг бариулан суулгаад түүний хоёр чихний нь ард үс нь сэгсийсэн, ядарч, хөлөрсөн царайны ноорог зургийг харандаагаар буулган авахыгхүссэн юм. Сайхан зураг гарах байсан даа. Би жирийн сайн зураач гэдэг огт муу юм биш гэдгийг ойлгохын тулд аавынхаа дэргэд хорин жил амьдарсан хүн.

Авьяас гэж юу вэ гэдгийг та мэдэх үү? Хүлээлтийн хараал. Тэгээд түүнтэй бүр хүүхэд насандаа эвлэрэх хэрэгтэй. Хэрэв та зохиол бичдэг бол бурхан таныг Шекспирээс илүү болгохоор бүтээсэн мэт санагдана. Хэрэв та зурдаг бол... Бурхан намайг ааваас илүү зурдаг болгохоор бүтээсэн гэж надад санагддаг байсан.

Гэтэл би тийм лут зураач биш байлаа. Би лут зураач, бүр алдарт зураач болохыг хичээж байв. Би Нью-Йоркт үзэсгэлэн гаргасан, тэгээд бүтэлгүйтсэн. Шүүмжлэгчид намайг аавтай харьцуулан бут ниргэсэн, тэгээд жилийн дараа би Стеффиг, бас өөрийгөө тэжээхийн тулд мөнгөний төлөө зураг зурдаг болсон юм. Стефф жирэмсэн болчихсон, тиймээс нэг удаа би тайван сууж байгаад өөрөө өөртэйгөө сүрхий ярилцсан юм. Энэ ярианы үр дүнд сонгомол

урлаг миний хувьд зөвхөн хобби, үүнээс илүүгүй байх болно гэсэн дүгнэлтэнд би хурсэн юм.

Би "Алтан Бүсгүй" шампуний сурталчилгааны зургийг зурсан. Бүсгүй дугуйныхаа дөрөөн дээр хөлөө тавиад зогсож байгаа, далайн эргийн наран шарлагын элсэн дээр бөмбөг тоглож байгаа, өөрийн байрны тагтан дээр гартаа хундага дарс бариад зогсож байгаа зургуудыг би зурсан юм. Би бараг бүх томоохон сэтгүүлүүдийн өгүүллэгүүдийн зургийг зурдаг болсон, гэхдээ ийм болохын тулд би эхлээд эрчүүдийн хямд сэтгүүлүүдийн өгүүллэгүүдийн зургийг зурдаг байсан юм. Би киноны сурталчилгаа зурдаг байлаа. Мөнгө ч овоо олж байв. Бид ядуу амьдраагүй.

Ноднин зун би Бриджтонд явагдсан зургийн үзэсгэлэнд оролцсон. Би сүүлийн таван жилд зурсан есөн зургаа тавьж, зургааг нь худалдсан юм. Огт худалдахгүй гэж шийдсэн нэг зураг маань "Федерал Фудс" супермаркетийн зураг (хачин тохиолдол шүү), дэлгүүрийг би автозогсоолын цаад булангаас зурсан юм. Миний зурганд зогсоол дээр түрэг шоштой лаазнууд зэрэгцэн ярайснаас өөр юу ч байгаагүй. Наад талын лаазнууд улам томорсоор, хамгийн наад талын лааз үзэгчид хоёр метр хагас өндөр мэт санагдахаар зурсан юм. Зураг "Түрэг шош ба буруудсан ирээдүй" гэдэг нэرتэй. Калифорний нэг эр, тенисний бөмбөг, цохиур, өөр ямар ч юм спортын хэрэгсэл хийдэг компанийн эзэн, энэ зургийг авна гээд, зурагны жирийн модон жаазны доод буланд "Зарахгүй" гэсэн бичиг хадсаныг ч үл тоон үнэ хаяж гарсан. Тэр зургаан зуун доллараас эхлээд дөрвөн мянга хүргэсэн юм. Тэр өөрийн албан тасалгаанд зургийг хадах хүсэлтэй байгаагаа хэлж байсан. Би зөвшөөрөгүй, тэр маш их гайхсан хүн, буцахдаа ч бууж өгөөгүй, өөрийн нэрийн хуудсыг үлдээж, бодлоо өөрчилвэл холбоо бариарай гэсэн.

Мөнгө бидэнд илүүдэхээргүй байлаа. Тэр жил бид байшиндаа нэмэлт тасалгаа барьж, бас "Скаут" жип худалдаж авсан, гэхдээ л би зургаа зарж чадахгүй байлаа. Учир нь энэ зураг бол миний бүх зурагнуудын шилдэг нь, тэгээд хэн нэгэн өөрийн хатуу загнаж байгааг үл анзааран хэзээ чи үнэхээр сайн зураг зурж эхлэх юм бэ гэж асуувал энэ зургийг харж байхыг хүссэн юм.

Гэтэл би ноднин намар энэ зургаа Олли Виксд үзүүлж, тэр зургийг фото аппаратаар аваад, сурталчилгаанд хэрэглэхийг зөвшөөрөхийг надаас гүйсан юм. Энэ бол миний өөрийн буруудсан ирээдүйн төгсгөл байлаа. Миний зураг юу бүтээж чадахыг Олли шууд мэдэрч, түүнийг хийснээр намайг ч нэр хүндтэй болгосон юм. Мөнгө олох хөнгөн уран зургийн гайхамшигтай үлгэр жишээ. Үүнээс илүүгүй. Тэгээд бурханы алдар, үүнээс багагүй.

Би түүнд зөвшөөрөл өгч, дараа нь өнөөх боссын Сан-Луис-Обиспо дахь гэрээд нь утасдаж, хэрэв хүссэн хэвээр байгаа бол зургийг хоёр мянга таван зуун доллараар авч болно гэж хэлсэн. Тэр хүссэн хэвээр байсан, тэгээд би зургаа Калифорни руу шуудангаар явуулсан юм. Үүнээс хойш гомдсон хүлээлтийн дуун, "сайн" гэсэн үнэлэлт яагаад ч сэтгэлд нь нийцэхгүй байсан хурагдсан хүүхдийн дуу нам гүм болсон юм. Хэдэн удаа л манант шөнийн харанхуйд дуугарах үл үзэгдэх амьтдын архирах шиг хэдэн удаагийн дуунаас өөр зүйл дахин сонсогоогүй. Энэ хүүхдийн, шаардсан дуу хоолой чимээгүй болох нь яагаад үхэлтэй тун адилхан байдгийг та надад тайлбарлаж өгөх болов уу?

Дөрвөн цагийн үед Билли сэргж, нойрмог, гайхсан нүдээрээ эргэн тойрноо харлаа.

-Бид нар эндээ байгаад л байгаа юм уу?

-Тиймээ, хүү минь гэж би хариуллаа. -Энд л байна.

Билли сул, дорой дуугаар уйлж, энэ нь надад аймшигтай байлаа. Аманда сэрж, биднийг харав.

-Жаалхан минь гэж тэр Биллиг зөөлөн тэврэн хэллээ. -Өглөө болохоор бүх зүйл хамаагүй дээр болно.

-Үгүй гэж Билли зөрөв. -Дээр болохгүй. Дээр болохгүй. Дээр болохгүй.

-Чш-шш-шш гэж Аманда миний зүг Биллийн толгой дээгүүр харан хэлэв. -Чш-шш, чи унтах хэрэгтэй.

Билли түүнд наалдаж, жаахан тийчилж байгаад би өөрт нь харагдахаар хэвтэж авав. Нэг хэсэг тэр над руу харж байснаа дахин унтаад өглөө.

-Баярлалаа гэж би хэлэв. -Та түүнд хэрэгтэй байсан байх.

-Тэр намайг таних ч үгүй шүү дээ.

-Энэ тийм чухал биш.

-Цааш юу болно гэж та бодож байна? -гэж Аманда ногоон нүдээрээ намайг ширтэн асуулаа. - Та үнэхээр юу гэж бодож байна?

-Та nadaас энэ тухай өглөө асуу.

-Би одоо асууж байна.

Би түүнд хариулахаар зэхэж байтал харанхуйгаас аймшигийн зохиол дээр гардаг шиг Олли Викс сүүтэгнэн гарч ирлээ. Тэр гартаа чийдэнг нь эмэгтэй хүний цамцны даавуугаар боож гэрлийг зөөллөсөн гар чийдэн барьж, түүнийгээ тааз руу чиглүүлжээ. Бүдгэрсэн гэрэл хүний нүүрэн дээр хачин эвгүй сүүдэр тусгана.

-Дэвид гэж тэр шивнэлээ.

Аманда түүнийг эхлээд түгшсэн, дараа нь айсан шинжтэй харав.

-Юу болоо вэ, Олли? -гэж би асуув.

-Дэвид гэж Олли дахин шивнэлээ. -Явъя. Надтай хамт яваач.

-Би Биллиг орхимооргүй байна. Тэр дөнгөж саяхан унтсан..

-Би түүнтэй хамт байх болно гэж Аманда хэлэв. -Та нар явцгаа. -Тэгээд нэмж шивнэлээ. -

Бурхан минь, энэ хэзээ ч дуусахгүй нь бололтой...

8. Цэргүүд яасан бэ. Амандатай хамт. Дэн Миллертэй ярьсан нь

Би Оллийн араас явлаа. Тэр агуулахын танхимын зүг явж, пивоны хөргөгчний хажуугаар өнгөрөхдөө лааз пиво шүүрэн авав.

-Олли, юу болоо вэ?

-Чи өөрөө харах хэрэгтэй.

Бид хаалгаар орж, ард хаалга хаагдлаа. Энд хүйтэн байна. Норм алагдсаны дараа энд надад ер таалагдахаа байсан юм. Үүнээс гадна хaa ч юм, энэ хавьд тэмтрүүлийн тасархай хэвтэж байгаа.

Олли гар чийдэнгээсээ даавууг мулталж аваад гэрлийг дээш чиглүүлэв. Эхлээд надад хэн нэгэн таазны доогуур явсан халаалтын хоолойнд хоёр мануухай өлгөчихсөн мэт санагдлаа. Тэднийг нарийхан олсоор өлгөчихсөн юм шиг. Бүх Гэгээнтнүүдийн баярын өдрийн өмнө хүүхдүүд ингэж тоглодог шүү дээ.

Дараа нь би шалнаас долоон сөөмийн өндөрт хөлнүүд олж харлаа. Бас энд тэнд таран хэвтэх картон хайрцагнууд. Би дээш дахин харж, хоолойнд хашгирах дуун дээш өгсөж эхэллээ, учир нь би тэнд, дээр, мануухайн биш хүний нүүр олж харлаа. Хоёр толгой бие биес рүүгээ гилжийж, үхдэлүүд хачин инээдтэй нэг юм аминчлан яриад ухаангүй инээсэн мэт, бүр хөхөртлөө инээсэн мэт харагдана.

Сүүдрүүд. Тэдний ард урт сүүдрүүд харлана. Цогцоснуудын хөх хэл цухуйжээ. Хоёр хүүр хоёул цэргийн хувцастай юм. Үйл явдлын бүр эхэнд би анх олж харсан, тэгээд дараа нь бужигнаан дунд мартаж орхисон хоёр zaluuhan цэрэг мөн байна. Нөгөөх... юуны цэргүүд.

Би хашгираа. Хашгирах дуун миний хоолойгоор цагдаагийн дохиолол гаслан дуугарах мэт өгсөж байгааг би мэдэрч байлаа. Олли миний тохойноос барьж авав.

-Битгий хашгир, Дэвид, битгий хашгир. Чи бид хоёроос өөр хэн ч үүнийг мэдэхгүй. Мэдэхгүй чигээрээ үлдвэл бүр ч сайн.

Би арайхийн биеэ барилаа. Тэгээд хэлэв:

-Энэ цэргүүд...

-"Сум" төсөл" -ийн цэргүүд гэж Олли хэлэв. -Яг тийм.

Нэг хүйтэн юм миний гартаа баригдлаа. Лааз пиво...

-Наадахаа учих. Дээрдэнэ.

Би хэд балгаад л пивыг дуусгалаа. Олли ярьж эхлэв.

-Би энд ноён Маквейн шарах ширээний хий хайж ирсэн юм. Тэгээд эднийг харсан. Миний

ойлгосноор тэд эхлээд дүүжлүүрийн олсоо татаж, дараа нь цаасан хайрцагнууд дээр гарсан. Бие биесийнхээ гарыг хүлсэн бололтой юм. Ардаа. Яаж хүлсэн юм, бүү мэд. Дараа нь толгойгоо гогзоонд хийгээд татаж, чангалаад, тэгээд хэн нэг нь гурав хүртэл тоолоод л үсэргчихсэн байх. Мэдэхгүй...

-Ийм юм байж болмооргүй гэж ам хэрхэн хатаж байгааг би мэдрэн хэллээ. Гэхдээ үнэхээр тэдний гар ардаа хүлээстэй байна. Би тэдний гарнаас харцаа салгаж чадсангүй.

-Ийм юм байж болно, Дэвид. Хэрэв тэд үнэхээр их хүссэн бол болно.

-Гэхдээ яагаад?

-Чи мэдэж байгаа гэж бодож байна. Тэр нөхөр, Миллер билүү, тэд нар, гадны жуулчид, мэдэхгүй байж болно, харин эндхийн хүмүүс мэдэж байгаа шүү дээ.

-"Сум" төсөл" -үү?

-Би өдөржин кассны ард зогсдог гэж Олли хэллээ. -Тэгээд их юм сонсдог. Хаваржин би энэ новшийн "Сум төсөл"-ийн тухай сонсож байлаа. Тэгээд нэг ч сайн мэдээ байхгүй. Нуурын хар мөс...

Билл Жости миний машины цонхыг налаад над руу бүлээн архиар амьсгалж байсныг би саналаа... "Зүгээр атом биш, өөр атомууд". Харин одоо энэ дүүжлээстэй цогцоснууд. Хажуу тийш гилжийсэн толгойнууд...

Ертөнцийг харж, хүлээн авах шинэ хаалга миний дотор нээгдэж байх шиг. Гэхдээ шинэ гэж үү? Хуучин байх аа. Эргэн тойрны ерэн хувийг харахгүй байж болдог тоннелэн хараагаар өөрийгөө хамгаалж сураагүй жаахан хүүхдийн хүлээн авах хаалга. Хүүхэд харц нь хүрсэн бүхнийг харж, чихэнд нь орсон бүхнийг сонсдог. Гэхдээ хэрэв амьдрал гэдэг оюун ухааны өсөлт мөн бол тэр бас хүлээн авалтын багасалт мөн юм.

Айдас ирээдүйг өөрчилж, хүлээн авалтыг өргөтгөдөг, тиймээс ч би өлгийнөөс гарч мөлхөө насанд шилжих үед гараад явчихдаг тэр байдалд эргэн орж байгаагаас учиргүй айлаа. Яг энэ байдлыг би Оллийн нүүрэн дээрээс олж харав. Зүй зохистой бүхэн нурж эхлэхэд хүний тархины гинжин холбоосуудын ачаалал хэтэрдэг. Мэдрэлийн эд эсүүд улайсч, чичирж эхэлнэ. Хий хоосон үзэгдэл бодитой болж, ирээдүй зэрэгцээ шугамуудыг огтлолцуулдаг тэр газар үнэхээр мөнгөн усны шалбааг үүсч, үхэгсэд босч ирэн ярьж, сарнай цэцэг дуулж эхэлдэг...

-Би зарим нэг зүйлийг хэд хэдэн хүнээс зэрэг шахам сонссон гэж Олли үргэлжлүүлэн яriv. - Жастин Робардс, Ник Точай, Бен Майлсон нараас. Жижигхэн хотод нууц юм гэж байдаггүй. Юу ч юм заавал бусдын чихэнд хүрнэ. Заримдаа энэ нь яг л булаг шиг, зүгээр л газар дороос гараад ирнэ, тэгээд хаанаас анх үүссэнийг нь хэн ч хэлж чаддаггүй. Чи юу ч юм номын санд сонсоод, хэнд ч юм ярина. Эсвэл Харрисоны усан зогсоол дээр... Хаана бас, яагаад гэдгийг бурхан л мэдэх байх. Гэхдээ л би зунжин сонссон. "Сум" төсөл", "Сум" төсөл"...

-Гэхдээ энэ хоёр, бурхан минь, Олли, тэд чинь бүр хүүхдээрээ амьтад байна шүү дээ.

-Вьетнамд ийм хүүхдүүд нутгийнхны чихийг тас огтолдог байсан. Би тэнд байсан. Би харсан.

-Тэгээд... яагаад энэ хоёр амиа хорлож орхив оо?

-Мэдэхгүй. Тэд юу ч юм, мэдэж байсан байх. Эсвэл зөвхөн таамаглаж байсан биз. Гэхдээ хүмүүс эцсийн эцэст тэр хоёроос элдвийн юм асууж эхэлнэ гэдгийг энэ хоёр мэдэж байсан. Хэрэв амьд үлдвэл шүү дээ.

-Хэрэв чиний зөв бол тэр нууц нь үнэхээр аймшигтай зүйл бололтой.

-Шуурга гэж Олли зөөлөн хоолойгоор хэлэв. -Шуурганаар тэнд ямар нэг юм нь эвдэрсэн байх. Ямар нэг осол гарсан байх. Тэд тэнд юу хийдэг байсныг хэн мэдэх юм бэ? Заримын ярьж байгаагаар тэнд маш хүчтэй лазераар туршилт хийдэг гэсэн. Бас зарим нь цөмийн эрчим хүчний тухай ч ярьдаг. Тэд ямар нэг өөр хэмжигдэхүүний, зэрэгцээ ертөнцийн хамгаалалтыг цоолоод нүх гаргаж орхисон ч юм билүү.

-Наадах чинь ёстой дэмийрэл байна гэж би хэллээ.

-Тэгвэл эд нар юу вэ? -Олли цогцоснуудыг заалаа.

-Эд нар бол дэмийрэл биш. Гэхдээ одоо бидний өмнө өөр асуудал тавигдаад байна. Эднийг яах вэ?

-Олсыг нь тас огтолж буулгаад нуух хэрэгтэй гэж Олли саналаа хэллээ. -Хэнд ч хэрэггүй юмаар даруулах хэрэгтэй. Нохойн лаазтай хоол, угаалгын нунтаг ч юмуу. Хэрэв хүмүүс эднийг харвал байдал улам дордоно. Тиймээс л би чам дээр ирсэн юм. Би өөр хэнд ч итгэж чадахгүй байна.

-Германы цэргийн гэмт хэрэгтнүүд шиг гэж би бувтнав. Дайнд ялагдсанаа мэдээд широнд амиа хорлоцгоож байсан хүмүүс шиг.

-Тийм, би ч бас тэгж бодсон.

Бид чимээгүй болтол ачаалах хаалганы цаана гулсах тэмтрүүлүүдийн зөөлөн шажигнан маажих чимээ сонсогдлоо.

Бид өөрийн эрхгүй бие биесдээ ойртож; миний нуруу хүйт оргиж байгааг би мэдрэв.

-О'Кей.

-Хурдхан дуусгаад буцъя гэж Олли хэллээ. Гар чийдэнгийн гэрэлд түүний индранил бөгж бүдэгхэн гялалзана. -Би эндээс хурдан зайлмаар байна.

Би дээш харлаа. Цэргүүд миний гадагш гарсан эрийн бүсэнд уяж байсан шиг яг тийм олсыг хэрэглэжээ. Олс цэргүүдийн бандайж хавдсан хүзүүнд шигдсэнийг би хараад: "Юу тэднийг

ийм аймшигт үйлдэл хийхэд хүргэв?" -хэмээн дахин бодлоо. Хэрэв энд хоёр хүн амиа хорлож үхсэнийг дэлгүүрт байгаа хүмүүс мэдвэл байдал улам дордоно гэж Олли хэлсэн нь үнэхээр зөв байж. Надад л лав үүнээс дор гэж юу байхав хэмээн бодогдож байсан ч бүр дордсон.

Олли өөрийн тонгоргийг тасхийлгэн тэнийлгэлээ, маш сайн чанарын, хүнд тонгород. Ийм тонгоргоор цаасан хайрцаг зүсч нээхэд эвтэйхэн нь мэдээж. Бас олс тас огтлоход ч яг таарна.

-Чи юу, би юу? -гэж тэр асуулаа.

-Аль аль нь нэг нэгийг гэж би шүлсээ залгиад арай ядан дуугарав.

Тэгээд бид хоёр үүнийг хийсэн.

Намайгэргэж ирэхэд Аманда байхгүй, харин Биллитэй хатагтай Терман байж байв. Тэд хоёул унтаж байлаа. Би тавиуруудын дундуур явж байгаад намайг хэн нэгэн дуудахыг сонслоо:

-Ноён Дрэйтон. Дэвид. -Аманда менежерийн тасалгаанд хүрдэг шатан дээр зогсоно. Түүний нүд маргад эрдэнэ мэт гялалзана. -Тэнд юу болоо вэ?

-Юу ч болоогүй гэж би хариуллаа.

Тэр надад ойртон ирэхэд би сүрчигний сулхан үнэрийг мэдэрлээ. Бурхан минь, би түүнийг ямар их хүсч байна вэ.

-Намайг битгий хуураад бай гэж Аманда хэлэв.

-Үнэхээр юу ч болоогүй. Андуурал.

-За яахав. -Тэр миний гараас барьж авлаа. -Би саяхан менежерийн өрөөнд орж үзсэн. Тэнд хэн ч байхгүй, тэгээд хаалгыг нь дотроос нь түгжиж болно. -Түүний нүүр тайван харагдах боловч нүдэнд нь гал дүрэлзэж, хүзүүний нь нарийхан судас гүрэлзэн цохилжбайна.

-Би таныг...

-Чи намайг яаж харж байгааг чинь би ч бас харсан шүү гэж Аманда хэлэв. -Энэ тухай бид яриад байх хэрэггүй биз. Чиний хүүтэй Терман хамт байх болно.

-Тиймээ. -Миний толгойд би яг ингэж, хамгийн зөв арга биш ч гэсэн Олли бид хоёрын хийсэн ажлын хараалыг зөвхөн ингэж л зайлцуулахаас өөр аргагүй гэсэн бодол орж ирлээ. Хамгийн сайн арга биш, гэхдээ боломжтой ганц арга.

Бид нарийхан шатаар өгсөн тасалгаанд оров. Түүний хэлснээр өрөө хоосон байлаа. Би түгжээний чихийг эргүүллээ. Харанхуйд бүсгүйн бие муухан харагдана. Би түүнийг татан, өөртөө наан тэврэв. Аманда чичирж байлаа. Бид үнсэлдсээр шалан дээр сууж, би гарах түүний хатуу хөхөн дээр тавин, зүрх нь хурдан цохилохыг мэдрэв. Стефф хэрхэн Биллид газар унасан цахилгаан утсанд ойртож болохгүй гэж хэлж байсныг би саналаа. Сүй тавьсан үдэш тэр энгийн хүрэн даашинаа тайлахад гуян дээр нь хөхөрсөн байсныг би саналаа.

Винсент Хартгены анги руу сугандаа хавтастай зурагнуудаа хавчуулаад явж байхдаа түүнийг дугуй унаад Ороно хотын Их сургуулийн модот гудамжаар миний хажуугаар явж өнгөрөхийг анх харснаа би саналаа.

Бид шалан дээр унаж, Аманда надад хэллээ:

-Намайг хайрла, Дэвид. Намайг дулаацуул.

Дараа нь тэр намайг танихгүй хүний өөр нэрээр дуудсан, би ч дургүйцээгүй, энэ нь биднийг ижил тэгш болгох мэт санагдсан юм.

Бид доош бууж явахад үүр цайж эхэлж байв. Шуудайнуудын нүхэн цонх тас хар байсан бол одоо нугасан саарал өнгөр дургүйхэн солигдож, дараа нь шаравтар өнгөтэй болоод эцэст нь нээлттэй кинотеатрын дэлгэц мэт дун цагаан өнгөтэй болов. Майк Хатлен хаанаас олж, чирж ирсэн юм, зөөлөн сандалд суун унтаж байна. Дэн Миллер хажууд нь шалан дээр суугаад чихрийн нунтаг цацсан пончик идиэ.

-Ноён Дрэйтон, та суугаач гэж тэр намайг урилаа.

Би Амандаг харвал тэр тавиуруудын дундуур эргэж харалгүй явна. Бидний харанхуй дахь ойртолт энэ хачин өдрийн гэрэлд итгэхийн аргагүй, уран зөгнөлийн нэг хэсэг мэт санагдаж эхэллээ. Би суув.

-Пончик ид. -Тэр надад цаасан хайрцаг өгөв.

Би толгой сэгсэрлээ.

-Энэ чихрийн нунтаг чинь найдвартай үхэл гэсэн үг. Тамхинаас дор.

-Тэгвэл хоёрыг ав гээд Миллер инээд алдав.

Надад ч жаахан инээд үлдсэнийг би гайхан мэдэрлээ. Миллер намайг инээлгэсэн, үүгээрээ тэр надад таалагджээ. Би хоёр пончик авч идлээ. Дажгүй амттай юм. Дараа нь би өглөөгүүр тамхи татдаггүй ч нэг тамхи татаж орхив.

-Би хүү дээрээ очих ёстой гэж би түүнд хэллээ. -Тэр удахгүй сэргээ.

Миллер толгой дохив.

-Энэ ягаан хорхой шиг юмнууд... -гэж тэр хэлэв. -Бүгд алга болчихсон. Шувуунууд ч бас. Хамгийн сүүлчийнх нь дөрвөн цагийн үед цонх мөргөсөн гэж Хэнк Ваннерман хэлсэн. Энэ муухай амьтад харанхуйд хамаагүй идэвхтэй байдаг бололтой.

-Брент Нортон тэгж хэлэхгүй байсан гэж би дуугарав. -Норм ч бас.

Тэр дахин толгой дохиж, хэсэг дуугүй сууснаа тамхи асаагаад над руу харв.

-Бид энд удаж болохгүй, Дрэйтон гэж тэр хэллээ.

-Энд идэх юм хангалттай байна. Бас уух юм ч бий.

-Хүнсний нөөц энд ямар ч хамаагүй гэдгийг чи өөрөө ойлгож байгаа. Хэрэв өнөөх том араатнуудын нэг бидэн рүү хүчээр орж ирвэл яах вэ? Зүгээр л гадуур тойроод яваад байхын оронд орж ирэх гэвэл? Бамбараар хөөх хэрэг үү?

Мэдээж хэрэг, түүний зөв байлаа. Манан биднийг тодорхой хэмжээнд хамгаалж байж ч магад. Нууж байж магад. Гэхдээ энэ нь удаан биш байж болох юм, тэгээд ч миний сэтгэлийг өөр нэг зүйл зовоож байлаа. Бид "Федерал Фудс"-д бараг арван найман цаг сууцгаасан, тэгээд одоо намайг үхширэл ч гэмээр юм уу, нэг зүйл эзэмдэж эхэлж байгааг би мэдэрч байв.

Ичсэн амьтны нойр мэт, эсвэл эргээс хэтэрхий хол сэлээд ядрах мэт байдал биднийг хүрээлж эхэлжээ. Энд үлдэж, элдэв эрсдэлд орохгүй, Биллид санаа тавьж, ("... .бас Аманда Дамфрисыг дахин шөнө дунд цохиж" -хэмээн тархинд шивнэх шиг болов), манан арилж, бүх зүйл хуучиндаа эргэн орохыг хүлээмээр санагдаж байлаа.

Яг ийм хүслийг би өөр бусад хүмүүсийн царайнаас харж, одоо энэ дэлгүүрээс ясан ч явахгүй хүмүүс олон байна гэж бодлоо. Болж өнгөрсөн бүхний дараа хаалгаар гарах хэрэгтэй гэсэн ганц бодол л тэднийг хедөлгөөнгүй болгож орхино.

Миллер миний нүүрэн дээр бодол хэрхэн тусч байгааг харах мэт хэсэг сууснаа хэллээ:

-Энэ чөтгөрийн манан ирэхэд дэлгүүрт наян хүн байсан. Эднээс Норм, Нортон, түүнтэй хамт явсан дөрвөн хүн, бас Смоллиг хасах хэрэгтэй. Тэгэхээр одоо энд далан гурван хүн байгаа.

"Одоо гөлөгний хоолтой лаазнуудын дор хэвтэж байгаа хоёр цэргийг бас хасвал далан нэгэн хүн үлдэнэ".

-Дараа нь солиорсон хүмүүсийг хас гэж тэр хэлэв. -Тийм хүн арав, арван хоёр хүн байгаа. Арав гэж үзье. Тэгвэл жаран гурван хүн үлдэнэ. Гэхдээ... -Тэр сахарын нунтаг болсон хуруугаа өргөв. -Энэ жаран гурван хүнээс хориод нь чирч гулдарсан ч хаашаа ч явахгүй.

-Тэгээд энэ чинь юу хэлж байгаа юм бэ?

-Эндээс гарах хэрэгтэй гэдгийг л хэлээд байна. Би хагас өдөр бодлоо. Тэгээд явах хүн бүрийг дагуулна гэж шийдсэн. Тэгээд чи хүүтэйгээ хамт надтай яваасай гэж хүсч байна.

-Нортон яалаа, чи мэдэж байгаа шүү дээ.

-Нортон яг л яргын газар орж байгаа хонь шиг явсан. Надтай цуг явах хүмүүс ч ингэж явна гэсэн үг биш.

-Чи тэгээд яах юм бэ? Бидэнд ганц гар буу бий.

-Ганц байгаа нь их юм. Гэхдээ хэрэв бид замын уулзварын цаана гарч чадвал Мэйн-

Стритийн "Спортмэнс Эксчейнж" дэлгүүрт хүрнэ. Тэнд зэвсэг хангалттай байгаа.

-Энд нэг "хэрэв", бас нэг "магадгүй" -д хангалттай шалтгаан байна.

-Дрэйтон гэж Миллер хэллээ. Бид ерөөсөө тун эвгүй байдалд орчиход байгаа шүү.

Энэ үгийг тэр тун тайван хэллээ, гэхдээ түүнд харж хандах жаахан хүү байсангүй.

-Сонсооч, одоохондоо энэ яриаг орхиё, о'кей? Би өнөө шөнө олигтой унтаагүй, маш их зүйл бодож хоносон. Хуваалцах уу?

-Мэдээж.

Миллер босч, суниав.

-Цонх руу очьё.

Бид кассны дэргэдүүр, талхны тавиуруудын дундуур явж, нэг нүхэн цонхны дэргэд ирлээ.

-Өнөөх муухай юмнууд бүгд алга болчихлоо гэж тэнд жижүүрлэж байсан эр хэлэв.

Миллер түүний нурууг алгадлаа.

-Явж аяга кофе уу. Би чиний оронд байж байя.

-О'Кей. Баярлалаа.

Тэр явж одоход Миллер бид хоёр цонхны дэргэд очив.

-Юу харж байгаагаа хэлээч гэж Миллер надаас гуйлаа.

Би цонхоор харлаа. Нисдэг амьтдын нэг нь шөнө хогийн савыг дайрсан бололтой, гадаа, цонхны дор цаас, лааз, хуванцар стаканууд хөглөрнө. Цаана нь дэлгүүрт хамгийн ойр тавьсан машинууд эгнэн, мананд далд оржээ. Өөр би юу ч олж харсангүй, түүнийгээ ч хэллээ.

-Тэр цэнхэр пикап "Шевроле" минийх гээд Миллер хуруугаараа заахад би манан дунд дөнгөж цэнхэртэх машины дүрсийг олж харлаа. -Гэхдээ чи өчигдөр ирэхэд зогсоол бараг дүүрэн машинтай байсан, тийм биз?

Би өөрийн "Скаут"-ыг хараад өчигдөр үнэхээр нэг машин зогсоолоос хөдөлсний ачаар л би машинаа дэлгүүрт ойрхон тавьснаа санаж, толгой дохив.

-Харин одоо, Дрэйтон гэж Миллер үргэлжлүүлэв. Үүнд өөр зүйл нэмэх хэрэгтэй. Нортон, түүний дөрвөн хүн... Чи тэднийг юу гэж нэрлээд байлаа?

-"Дэлхий хавтгай гэдэгт итгэгсэдийн нийгэмлэг"

-Маш сайн. Яг онож нэрлэсэн байна. Тэд гараад олс бараг дуустал хол явсан, харин дараа нь

бид манан дотор сүрэг заан яваа юм шиг дуу сонссон, тийм биз?

-Тэд заантай адилгүй дуугарч байсан гэж би хэллээ. -Харин...

"Галавын үеийн намгийн амьтан шиг" –гэж хэлмээр байсан ч би дуугарсангүй. Миллер тэр эрийн нуруун дээр алгадаад кофе уулгахаар явуулсан нь түүнийг хөлбөмбөгийн багийн дасгалжуулагч мэт харагдуулсан юм. Би үгээ Оллид хэлж чадах байсан, харин Миллерд бол ҮГҮЙ.

-Ютай адил гэмээр юм, би мэдэхгүй гэж би аяархан хэллээ.

-Гэхдээ дууг нь сонсоход том амьтан гэдэг нь мэдэгдэж байсан.

-Тийм шүү. Том амьтан гэдэг ч арай багадах байх.

-Тэгвэл бид яагаад машин эвдрэхийг сонсоогүй юм бэ? Шил хагарах, төмөр хяхтнах дууг?

-Яагаад гэвэл... -Би дуугүй боллоо..

-Мэдэхгүй.

-Энд газар хөдлөх шиг болохоос өмнө тэд бүгд зогсоолоос яваад өгсөн байж явч таарахгүй гэж Миллер хэлэв. -Би энэ тухай бодсон. Миний бодлоор машинууд ерөөсөө байхгүй болохоор л бид юу ч сонсоогүй. Газрын гаваар унаад, алга болсон. Хэрэв энд модон раамнууд хугарч, тавиурууд дээрээс хамаг юм унасан бол... Хотын дохиолол ч яг тэр үед таг болсон.

Би автозогсоолын талыг дотроо төсөөлөн бодож үзлээ. Шар будгаар цэвэрхэн будсан асфальт гэнэт дуусч байгаагаар. Явсаар дун цагаан мананд бүрхэгдсэн шинэхэн хавцал, жалга, ёроолгүй нүхэнд тулж ирж байгааг төсөөлөн бодов.

-Хэрэв чиний хэлж байгаа үнэн юм бол чи пикапаа унаад хэр хол явах юм бэ? -гэж би асуулаа.

-Би пикапны тухай бодоогүй. Би чиний давхар мосттой машины тухай бодож байна.

Энэ тухай мэдээж бодох нь зөв, гэхдээ одоо биш.

-Чи юу төлөвлөөд байгаа юм?

-Хажуугийн аптек гэж нэг их гүйлгүй Миллер хэллээ. -Би энэ тухай бас бодсон. Чи юу гэмээр байна? Би түүний юу хэлэх гээд байгааг огтхон ч ойлгохгүй байна гэж хэлэхээр амаа ангайснаа хамхив. Бид дэлгүүрт дөхөж ирэх үед Брижтоны аптек ажиллаж байсан. Угаалга цэвэрлэгээний газар хаалттай, харин аптек ажиллаж байсан. Агаар оруулахын тулд тэд хаалгаа цэлийтэл нээгээд хаймар хавчуулчихсан байсан, учир нь бусад бүх газрын адил тэндхийн агааржуулагч тог байхгүй болохоор ажиллахгүй байсан. Аптекийн хаалга дэлгүүрийн хаалганаас долоон метрээс холгүй. Тэгвэл яагаад...

-Яагаад тэндээс нэг ч хүн нааш орж ирсэнгүй вэ? -гэж миний өмнөөс Миллер асуулаа. - Арван найман цаг өнгөрлөө шүү дээ. Тэд өлсөх ёстой. Тэд чинь "Дристан", ууттай ариун цэврийн цаас идээд сууж байж чадахгүй биз дээ.

-Тэнд хүнс байгаа гэж би хэлэв. -Тэд үргэлж идэх юм зардаг. Зүссэн бялуу, крекер гэх мэт. Бас чихрийн лангуу бий.

-Энд ийм их хүнс байхад тэд нар тийм юм идээд сууж байна гэдэгт би итгэхгүй байгаа юм.

-Чи тэгээд юу гэх гээд байна?

-Би хоёрдугаар зэрэглэлийн аймшигийн киноны оргодлын хоол болохоос өмнө эндээс зайлах хэрэгтэй гээд байна. Дөрөв, таван хүн хүн аптект очоод байдлыг шинжээд ирж болох байх. Тагнуулын ажиллагаа.

-Ингээд болоо юу?

-Үгүй, бас нэг юм байна.

Бас юу вэ?

-Тэр гээд Миллер дунд талын тавиуруудын зүг заалаа. -Энэ галзуу новш. Шулмас.

Тэр хатагтай Кармодиг заажбайлаа. Кармоди ганцаар биш, хоёр эмэгтэй дэргэд нь сууна. Тэдний хурц өнгийн хувцсаар нь би тэднийг зун энд ирдэг, гэр бүлийнхнээ орхиод "ганц нэг юм худалдаж авахаар хот явсан", тэгээд одоо үлдсэн нөхөр, хүүхдүүддээ санаа зовсон улс байна гэсэн дүгнэлт хийв. Тайвширч л байвал юуг ч сонсоход бэлэн хатагтай нар. Бүр хатагтай Кармодийн баргар яриагч сонсоход бэлэн.

Кармодийн өмд, костюмны хослол нь бүрэнхийд аймаар сүртэй гэрэлтэнэ. Тэр баргар, хатуу царайлан зогсоо зайнгүй ярьж, гарaa савчиж байв, Хурц өнгийн хувцастай хоёр хатагтай (гэхдээ л тэр хоёрын хувцас хатагтай Кармодийнх шиг хурц биш, бас тэр өнөөх аварга том цүнхнээсээ салаагүй, бүдүүн гараараа тэвэрсэн хэвээр харагдана) түүний үг бүрийг анхааралтай чагнаж байв.

-Энэ бол миний эндээс зайлах гээд байгаа бас нэгэн шалтгаан, Дрэйтон. Орой болоход түүний талд зургаан хүн байх болно. Хэрэв ягаан амьтан, шувууд шөнө дахин ирвэл маргааш түүний талд бүр бүлэг хүмүүс орно. Тэгвэл Кармоди хэнийг тахилга болгон өргөх тухай бодох хэрэгтэй. Намайг, эсвэл чамайг, эсвэл Хатленыг ч магад. Эсвэл чиний хүүг.

-Наадах чинь жинхэнэ дэмийрэл байна гэж би хэллээ.

Гэхдээ энэ үнэхээр дэмийрэл гэж үү? Миний нуруугаар хүйт оргисон нь түүний зөв ч байж магад гэдгийгхаруулж байв. Хатагтай Кармодийн уруул зогсоо зайнгүй хөдөлсөөр, хоёр эмэгтэй ч түүний үрчгэр уруулыг ухаангүй ширтэнэ. Дэмийрэл гэж үү? Би толин ус ууж байгаа тоостой чихмэлүүдийг саналаа. Энэ эмгэн ямар нэг хүч өөртөө агуулж байна. Тэр бүү хэл ухаалаг, тайван Стефф хүртэл түүний нэрийг айсан шинжтэй хэлдэг юм.

"Галзуу новш гэж түүнийг Миллер нэрлэсэн. -Шулмас".

-Энд байгаа хүмүүс одоо тамын найм дахь тойргийн нөлөөрхүү зүйлийг мэдэрч байна гэж Миллер хэлээд хугарч, яйжийсан цонхны раамыг заав. -Тэдний тархи одоо энэ раам шиг болсон байна. Өөрийнхөө тухайд бол би яг тэгж хэлнэ. Өнгөрсөн шөнийн талыг хүртэл би өөрийгөө галзуурчихаж, тэгээд үнэн хэрэгтээ би хaa ч юм, Данверс хавьд эмнэлэгт байгаа, тэгээд би энэ ягаан хорхой шиг амьтад, галавын шувууд, тэмтрүүлийг өөрөө бодож зохиосон, удахгүй эмч хөөрхөн бүсгүй орж ирээд надад тайвшруулах тариа хийхээр энэ бүхэн алга болно гэж бодож байлаа. -Миллериин нарийхан царай хачин төвлөрчээ. Тэр хатагтай Кармодиг, дараа нь намайг харав. -Би чамд юу болохыг хэлээд өгч чадна. Хичнээн олон хүн солиорно, тэр хэмжээгээр Кармоди бусдад сайхан харагдах болно. Тэгээд энэ бүхэн болох үед би энд байхыг хүсэхгүй байна.

Хатагтай Кармодийн уруул хөдөлсөөр. Хэл нь түүний яйжиг мурий тахир шүднүүдийн дунд бүжиглэнэ. Тэр үнэхээр шулмастай адил юм. Шовх оройтой, хар бортгон малгай өмсгөчихвөл бүх зүйл ойлгомжтой болно. Энэ торонд нь орсон, зуны хурц өд сөдтэй хоёр шувуухайд Кармоди юу ярьж байгаа бол?

"Сум" төсөл" -ийн тухай юу? Хар Хаврын тухай юу? Тамын амьтдын тухай юу? Хүнээр тахил өргөх тухай юу?

Балай юм.

Гэхдээ л...

-Чи юу гэмээр байна?

-Зарим зүйлийг би зөвшөөрч байна гэж би хариуллаа. -Бид аптект очих гээд оролдоод үзэх хэрэгтэй. Чи, би, хэрэв хүсвэл Олли, бас нэг, хоёр хүн хэрэгтэй. Дараа нь үлдсэнийг ярьж тохирцгоёё.

Бүр энэ ч надад ёроолгүй хавцлын дээгүүр нарийхан бандан дээгүүр явж байгаа мэт сэтгэгдэл төрүүллээ. Миний үхэл Биллид тус болохгүй нь мэдээж. Гэхдээ, нөгөө талаас нь авч үзвэл энд би суугаад байвал бас л юугаар ч хүүдээ тусалж чадахгүй. Аптек хүртэл долоон метр. Ойрхон байна.

-Хэзээ явах вэ? -гэж Миллер асуув.

-Надад нэг цаг өгчих.

-О'Кей.

9. Аптект очсон нь

Би хатагтай Терман, Аманда хоёрт бүхнийг ярьж, дараа нь Биллид учрыг тайлбарлав. Тэр өглөө миний хүү арай дээр байж, өглөө хоёр ширхэг пончик, таваг кааш иджээ. Дараа нь би түүнийг хөтлөн тавиуруудын дундуур урагш хойш жаахан хөөцөлдөн гүйлдэж, бүр овоо инээлгэв. Хүүхдүүд орчин тойрондоо заримдаа айдас хүрэм дасдаг. Түүний царай цонхигор, шөнө уйлсан нулимснаас нүд нь хавдаж, тэр ерөөсөө л маш аймшигтай ядарч зүдэрсэн харагдана. Одоо түүний царай хэтэрхий их сэтгэлийн хөдөлгөөнийг хэтэрхий удаан хадгалж байсан мэт бүр өтөлсөн өвгөнийх шиг болжээ. Гзхдээ тэр хөдөлгөөнтэй хэвээр, ямар ч байсан хаана байгаа, юу болж байгааг бодоогүй үедээ инээж хөгжиж байлаа.

Гүйлтийн дараа бид дахин Аманда, Хэтти Терман нартай хамт сууцгааж, цаасан стакантай кофе уугаад, би хэдэн хүний хамт аптект очих болсноо ярилаа.

-Би таныг явуулахгүй гэж Билли шууд л хэлэв. Түүний царай дахин урвайжээ.

-Их Билл минь, бүх зүйл сайхан болно. Би чамд Спайдерманы комиксууд авчирна гэж би хэллээ.

-Би таныг үлдээсэй гэж хүсч байна. Одоо тэр урвайхаасаа илүү уурлаж байлаа.

Би түүний гарыг барихад тэр дор нь суга татан авав. Би дахин түүний гарыг атгалаа.

-Билли, эрт, орой хэзээ нэгэн цагт бид эндээс явах ёстой. Чи үүнийг ойлгож байгаа шүү дээ.

-Манан арилахаар явна гэж тэр ямар ч итгэлгүй хэллээ. Тэр дуртай дургүй, удаанаар кофе балган сууна.

-Билли, бид энд бүтэн өдөр байлаа шүү дээ.

-Би ээж дээрээ очмоор байна.

-Бид тийш очих анхны алхам энэ байх.

-Хүүгээ үүнд итгүүлэх гэж оролдох нь буруу байх, Дэвид гэж хатагтай Терман хэлэв.

-Чөтгөр гэж, хүү минь ямар нэг зүйлд итгэж найдах л ёстой шүү дээ гэж би биеэ барьж чадсангүй, уурлав.

Хатагтай Терман доош харлаа.

-За, за. Чиний зөв байж ч магад.

Билли юу ч анзаарсангүй.

-Аав... тэнд аймаар амьтад байгаа, аав.

-Бид мэдэж байгаа. Гэхдээ тэд, бүгд биш, гэхдээ дийлэнх нь шөнө л анд гардаг бололтой.

-Тэд та нарыг отож байгаа гэж тэр намайг хачин том нүдээр ширтэн өгүүлэв. -Тэд нар та нарыг манан дотор отож байгаад буцаад явахаар чинь барьж иднэ. Яг үлгэрт гардаг шиг. Билли намайг ухаангүй чанга тэвэрлээ. -Аав, битгий яв.

Би түүний гарыг болгоомжтой, зөөлөн татан аваад явах ёстой гэж дахин хэллээ.

-Билли, хүү минь, аав нь эргээд ирнэ.

-За гэж тэр сөөнгө хоолойгоор хэлээд дахин над руу харсангүй. Намайг эргэж ирнэ гэдэгт тэр итгэсэнгүй, энэ нь түүний одоо ууртай биш, гунигтай, зовлонт царайн дээр бичээстэй байв.

Би өөрийгөө ийм эрсдэлтэй аялалд оролцох нь зөв үү гэж дахин бодсон ч дараа нь хатагтай Кармоди сууж байгаа дунд талын тавиуруудыг санамсаргүй харлаа. Одоо түүний сонсогчид дээр бас нэг хүн нэмэгджээ. Сахал үсээ аваагүй, цус хурсан нүдтэй эр тэнд сууна. Түүний зангиdsan хөмсөг, салгалсан гар нь ерөөсөө л "шарталт" хэмээн хашгирч байх шиг, тэгээд энэ эр бол Майрон Ляфлер байхыг би танилаа. Хүүхдийг эр хүний ажил хийлгэхээр ямар ч бодолгүй явуулж орхисон хүн.

"Галзуурсан новш. Шулмас".

Би Биллиг үнсэж, цээжиндаа чанга тэврэв. Дараа нь цонхны зүг явлаа, гэхдээ сав суулга тавилсан тавиуруудын дэргэдүүр явсангүй, би хатагтай Кармодид харагдахыг хүсээгүй юм. Намайг араас Аманда гүйцэв.

-Чи үнэхээр үүнийг хийх ёстой гэж бодож байна уу?

-Тиймээ, тэгэх ёстой гэж бодож байна.

-Уучлаарай, гэхдээ надад бол энэ чинь ердөө л эрчүүдийн онгиргон зан шиг санагдаж байна.

-Түүний хацар улайж, нүд нь улам тод ногоон харагдана. Тэр аиж, маш их аиж байлаа.

Би түүний гараас барьж, Дэн Миллертэй ярилцсанаа ярив. Машинуудын оньсого, аптекаас дэлгүүрт хэн ч ирээгүй нь Амандагийн сэтгэлийг нэг их хөдөлгөсөнгүй. Харин хатагтай Кармодийн тухайд өөр байв.

-Миллерийн зөв байж магад гэж Аманда хэллээ.

-Чи үнэхээр тэгж бодож байна уу?

-Мэдэхгүй. Гэхдээ энэ авгайд нэг тийм, хортой юм байна. Тэгээд хэрэв хүмүүсийг хангалттай удаан, хангалттай хүчтэй айлгах юм бол аврал амалсан хэний ч араас явцгаана.

-Гэхдээ хүнээр тахил өргөнө гэдэг чинь... Аманда?

-Ацтекүүд тэгдэг л байсан гэж тэр жигд дуугаар хэллээ. -Дэвид, сонс. Чи заавал эргэж

ирээрэй. Хэрэв ямар нэг юм болвол, юу ч хамаагүй, ямар нэг юм л болох юм бол шууд эргээрэй. Бүхнийг хаяад зугтаарай. Миний төлөө биш. Шөнө болсон бүхэн сайхан байсан, гэхдээ тэр шөнө болоод өнгөрсөн. Хүүгийнхээ төлөө эргэж ирээрэй.

-Ойлголоо. Би заавал эргэж ирнэ.

-Чамайг бурхан авраг... -Одоо тэр Билли шиг, ядарсан, хөгширсөн харагдаж байв. Бид бараг бүгд ингэж харагдаж байгаа гэж би бодлоо. Харин хатагтай Кармоди л лав биш. Кармоди харин ч бүр залуужаад, хүч тамир нь нэмэгдчихсэн мэт. Тэр яг өөрийн орчинд оржээ. Яг... Яг энэ бүхэн түүнд сайнаар нөлөөлж байгаа мэт.

Бид өглөөний 9:30-д бэлтгэлээ хийж дуусав. Долоон хүн явах боллоо: Олли, Дэн Миллер, Майк Хатлен, Майрон Ляфлерын хуучин анд Жим (бас л шартчихсан, гэхдээ өөрийн бурууг заавал засах шийдвэр дүүрэн), Бадди Иглтон, бид нар. Долоо дахь гишүүн нь Хильда Репплер болов. Миллер, Хатлен хоёр түүнийг хэрэггүй хэмээн итгэл муутайхан ятгасан боловч бүтсэнгүй. Би ятгалганд оролцсонгүй, надад энэ эмэгтэй магадгүй, Оллигоос бусад бүх эрчүүдээс илүү бэлтгэлтэй мэт санагдсан юм. Нэг гартаа тэр "Рэйд", "Хар далбаа" шавьжны хор бүхий шүршүүрүүдийн таглааг нь авч, шууд хэрэглэхэд бэлэн байдалд хийсэн даавуун уут барьжээ. Харин нөгөө гартаа тэр хоёрдугаар кассны тавиурууд дээрх спортын бараанаас авсан газрын тенисийн цохиур барьсан харагдана.

-Та наадахаараа яах юм бэ, хатагтай Репплер гэж би асуулаа.

-Мэдэхгүй гэж хатагтай Репплер сөөнгө хоолойгоор хариуллаа. -Гэхдээ гарт их эвтэйхэн юм.

-Тэр миний хажуугаар харж, харц нь хүйтрэв. -Жим Грондин мөн үү? Чи миний сургуульд сурч байсан байх аа?

Жим инээмсэглэх аядав.

-Тиймээ, хатагтай, би, бас миний эгч Полин.

-Өчигдөр хэтрүүлээд учихаа юу?

Жим түүнээс бүтэн толгой өндөр, хамаагүй хүнд, лав гуч гаран килограммаар хүнд байх, тэр час улаан болжээ. -Э-э-э, үгүй, үгүй.

Хатагтай Репплер огцом эргэлээ.

-Бид бэлэн гэж тэр хэлэв.

Хүн бүр ямар нэг зэвсэг барьсан ч тун хачин харагдацгааж байв. Оллид Амандагийн гар буу байгаа, Бадди Иглтон хаанаас ч юм ган төмөр лоом олж барьжээ. Би шалны модны иш барьж явав.

-О'Кей. Дэн Миллер дуугаа өндөрсгөв. -Бүгд анхаараарай!

Арван хоёр, гурван хүн хаалган дээр юу болоод байгааг үзэхээр ирж, шавааралдан зогсов.

Тэдний баруун талд хатагтай Кармоди өөрийн талын хүмүүсийн хамт зогсоно.

-Бид аптект очиж, тэнд юу болсныг харна. Тэгээд хатагтай Клапхэмд эм олж ирж чадна гэж найдаж байна.

Хүмүүст хөлөө хуга гишгүүлсэн эмгэнийг тэгж нэрлэдэг ажээ. Хөөрхий их өвдөж, шаналж байгаа бололтой.

Миллер биднийг харлаа.

-Бид аз сорихгүй гэж тэр хэллээ. -Аюул таарадвал бид хурдан эргэж ирнэ.

-Тэгээд тамын муухай амьтдыг араасаа дагуулж ирнэ! -гэж Кармоди хашгирлаа.

-Тийм шүү гэж "зуны" хатагтай нарын нэг хашгирлаа. -Та нараас болж тэд биднийг олж харах болно. Бүх юм сайхан байхад та нар тайван байж болохгүй байна уу?

-Хатагтай, та үүнийг "сайхан" гэж нэрлэж байна уу гэж би асуулаа.

Хатагтай балмагдан харцаа буулгав. Кармоди урагш алхлаа. Түүний нүд гал мэт улалзана.

-Чи тэнд үхнэ Дэвид Дрэйтон! Чи хүүгээ өнчин үлдээх гээ юу?-Тэр биднийг тойруулан харлаа. Бадди Иглтон харцаа буулгаад эмгэний муухай ховсдлоос хамгаалах мэт лоомоо өргөв.

-Та нар бүгд тэнд үхнэ. Ертөнцийн төгсгөл ирж байгааг та нар ойлгохгүй байна уу? Хүн төрөлхтний дайсан газар дэлхийгээр алхаж явна! Тамын гал дүрэлзэж, хаалгаар гарсан бүхэн тасар татуулах болно! Тэд энэ хөөрхий эмэгтэйн хэлснээр энд үлдэгсдийн хойноос ирэх болно. Хүмүүсээ, та нар үүнийг зөвшөөрөх юм уу? -Тэр одоо үлдэх улсад хандан хашгирч, хүмүүс ч ам амандаа хашгиралдаж хэлэв. -Өчигдөр үл итгэгсэд яаж дууслаа? Тэнд үхэл байна! Үхэл! Тэнд...

Ногоон шоштой лааз хоёр касс даван нисэн ирж, хатагтай Кармодийн баруун цээжийг цохилоо. Кармоди цочсоноос мэлхий мэт "гуаг" гэж дуугараад чимээгүй болов. Аманда урагш гарч ирлээ.

-Дуугаа тат гэж тэр хэлэв. -Муу элээ минь, амаа хамхи.

-Энэ эмэгтэй бол тамын элчийн зарц! -гэж Кармоди дахин хашгирч, уруул дээр нь муухай инээмсэглэл тодорлоо. -Хатагтай, та өчигдөр шөнө хэнтэй унтсан бэ? Хэнтэй хэвтсэн бэ? Кармоди ээж нь бүгдийг харж байна. Тиймээ! Кармоди ээж нь бусдын харж чадаагүйг харж чадна!

Гэвч түүний сүлжсэн тор тасарсан тул Аманда харцыг нь тайван дааж чадлаа.

-Бид явах юм уу, эсвэл ингээд өдөржин зогсоод байх юм уу? -гэж хатагтай Репплер асуув.

Тэгээд бид явлаа. Бидний бурхан авраг, бид явлаа.

Дэн Миллер хамгийн түрүүнд явна. Би хамгийн сүүлд, хатагтай Репплерийн араас явж байлаа. Би амьдралдаа хэзээ ч ингэж айж үзээгүй байх. Шалны модны иш барьсан миний гарын алга хөлөрчээ.

Хаалгаар гармагц би манангийн жирийн биш, хачин эхүүн үнэрийг мэдрэв. Миллер, Олли хоёр мананд үзэгдэхгүй болж, гуравт яваа Хатлен дөнгөж сүүмийн харагдана.

"Дөнгөж долоон метр гэж амандаа шивнэж явлаа. -Дөнгөж долоон метр".

Хатагтай Репплер миний урд удаан, гэхдээ итгэлтэй, баруун гартаа барьсан теннисний цохиураа ганхуулан алхана. Бидний зүүн талаар үнсэн блокоор барьсан улаан хана үргэлжилж байв. Харин баруун талаар автозогсоолын эхний эгнээний машинууд манан дунд суг мэт эгнэн харагдана. Дараа нь манангас бас нэг хогийн сав, дараа нь хүмүүс автомат утсаар ярихаар дарааллаа хүлээн суудаг урт сандал гарч ирлээ. "Дөнгөж долоон метр. Миллер тэнд хүрчихсэн байх. Долоон метр гэдэг чинь арваад л алхам гэсэн үг, тэгэхээр..."

-Бурхан минь! -гэж Миллер дуу алдав. -Ээ, бурхан минь! Та нар үүнийгхараач!

Миллер үнэхээр аптект хүрчээ.

Хатагтай Репплерийн урд явсан Бадди Иглтон айсан том нүдээ эргэлдүүлэн эргэж гүйх гэлээ. Репплер түүний цээжийг цохиураараа хатган зогсоов.

-Чи хаачихна вэ? -гэж хатагтай Репплер өөрийн сөөнгө, бага зэрэг хяхтнасан хоолойгоор хатуу хэлж, үүссэн паник намдлаа.

Бид Миллерийн араас аптект тулж ирэв. Би эргэн хараад "Федерал Фудс" мананд далд орон үзэгдэхээ байсныг харлаа. Улаан үнсэн блокон хана аажмаар цайвар ягаан өнгөтэй болж, супермаркетын үүднээс ганц метрийн наана үзэгдэхээ болжээ. Хэзээ ч би өөрийгөө ийм ганцаардмал, бусдаас тасархай болсныг мэдэрч байсангүй.

Аптек дотор аллага, ярга, тулалдаан болсон мэт харагдана. Миллер бид хоёр зөв таажээ. Мананд нуугдаж буй бараг бүх амьтад өөрийн олзыг үнэрээр нь мэдэрдэг юм байна. Тийм ч байх ёстой. Энэ цагаан манан дунд нүдний хэрэг бараг л байхгүй. Манан бас дуу чимээг дарж, холыг ойр, ойрыг хол дуугарах мэт болгодог тул сонсгол ч бас чухал биш. Энэ муухай амьтад манан дундуур хамгийн найдвартай мэдрэмждээ хөтлөгдөн явдаг. Тэд үнэрээр ангуучилдаг.

Дэлгүүрт үлдсэн хүмүүсийг тодорхой хэмжээнд цахилгаан байхгүй нь аварсан гэж болно, учир нь фотоэлементүүдтэй хаалга ажиллахаа болж, манан ирэхэд дэлгүүр лацадсан мэт болсон байсан. Харин аптект бүх хаалга нээлттэй байсан. Тог тасрахад агааржуулагч ажиллахаа болж, аптект байсан хүмүүс агаар оруулахын тулд үүд хаалгаа нээжээ. Гэтэл цэвэр агаартай хамт аптект өөр зүйл ч хамт орж ирсэн байна.

Үүдэнд хүрэн улаан цамцтай эр доош харан хэвтэнэ. Гэхдээ би цамцан дээрх цагаан

толбонуудыг хараад цамц анх цагаан өнгөтэй байсныг ойлголоо. Хатсан цуснаас цамц хүрэн улаан өнгөтэй болжээ. Бас энэ цогцос нэг л биш, харин чухам юу нь болохгүй байгааг эхлээд би ойлгосонгүй. Бүр Бадди Иглтон огиулж эхлэхэд ч би ойлгохгүй л байлаа. Хүмүүс ийм эргэлт буцалтгүй аймшигтай тулгараход тархи бодит байдлыг хүлээн авахаас татгалздаг бололтой. Хэрэв та дайн тулалдаанд оролцоогүй л бол.

Энэ эрийн толгой алга. Түүний хөл аптекийн үүдэнд хэвтэж байгаа болохоор толгой нь шатнаас унжиж байх ёстой. Гэтэл толгой алга байлаа.

Жим Грондинд энэ ч хангалттай болжээ. Тэр амаа гараараа даран эргэж, намайг улаан нүдээрээ хараад дэлгүүрийн зүг салгалан явлаа. Хэн ч түүнийг анхаарсангүй. Миллер дотогш явж орлоо. Түүний араас МайкХатлен оров. Хатагтай Репплер хаалганы нэг талд гартаа цохиураа барин зогслоо. Олли нөгөө талд бууныхаа амыг доош харуулан зогсоод надад хандлаа:

-Дэвид, би ч найдвар алдаж эхэлж байх шиг байна.

Бадди Иглтон мую мэдээ авсан хүн мэт утасны бүхээг налан, толгойгоо унжуулан зогсоно. Түүний өргөн мөр уйлахад нь чичирж байв.

-Биднийг ийм амархан данснаас хасах хэрэггүй гээд би аптект орлоо. Би орохыг хүсээгүй, гэхдээ би хүдээ комикс авчирна гэж амалсан.

Аптект галзуурсан эмх замбараагүй байдал ноёрхжээ. Ном, сэтгүүл хааяагүй хэвтэнэ. Миний хөлийн дэргэд "Спайдерман", "Гайхамшигт аварга хүн" комиксууд хэвтэж байгааг олж хараад би хурдан бөхийн авч, өмднийхөө арын халаасанд хийв. Эмийн шил, хайрцагнууд энд тэндгүй таржээ. Лангууны цаанаас хэн нэгний гар унжина.

Надад зүүдэлж байгаа мэт хачин санагдлаа. Эвдрэл, хэмхрэл, цус нөж -энэ бүхэн ерөөсөө л хачин. Гэтэл энэ байшинд ямар нэгэн галзуурлын баяр наадам хийсэн мэт харагдана. Хааяагүй утас, тууз унжиж байх шиг. Гэхдээ өргөн, нимгэн тууз биш, бүдүүн, нарийн төмөр утаснууд мэт зүйлс энд тэнд унжжээ. Бас тэдгээр нь яг манан мэт цагаан өнгөтэйг хараад цээжинд түгшүүрийн дохио хангинах шиг боллоо. Хэрэв энэ тор биш юм бол өөр юу вэ? Зарум "туузанд" ном, сэтгүүл зүүгдсэн, агаарт эргэлдэж харагдана.

Майк Хатлен нэг хачин, хар юмыг өшиглөв. Урт, өргөстэй ч юм шиг.

-Энэ бас юу вэ? -гэж тэр дуугарлаа.

Харин би гэнэт ойлгов. Манан ирэхэд аптект үлдсэн хүмүүсийг юу алсныг би ойлгох шиг боллоо.

-Ухраад гэж би хэллээ. Миний хоолой гэнэт хув хуурай болж, үгүүд буун дуу мэт хурдан гарч байв. -Явцгаая.

Олли над руу харлаа.

-Дэвид?..

-Энэ бол тор гэж би хэллээ. Аалзных шиг тор.

Гэнэт гадаа хашгирах сонсогдов. Эхлээд айснаас, дараа нь өвдсөнөөс хашгирах мэт болов. Энэ бол Жим. Хэрэв хувь тавиланд төлөх төлөөс гэж байдаг бол одоо Жим төлбөрөө хийж байгаа бололтой.

-Гүйе! -гэж би Майк, Дэн Миллер хоёрын зүг хашгирлаа.

Гэнэт агаарт нэг юм гялсхийн нисэв. Цагаан манан дунд юу болох нь харагдсангүй, гэхдээ ташуураар ороолгох мэт иsgэрэх дуу гарлаа. Тэгээд Бадди Иглтоны хөлийг өвдөгнөөс нь дээхнүүр ороон авахад би харсан юм. Бадди дуу алдаад утасны бүхээгнээс барьж авав. Харилцуур өлгүүрээс мултарч, унжин ганхаж эхэллээ.

-Бурхан минь! Өвдөж байна! -гэж Бадди хашгирлаа.

Олли түүнийг сугадан өргөхөд би юу болсныг харж, шатан дээр хэвтэж байсан хүн яагаад толгойгүй болсныг ойлгов. Нарийхан цагаан олс торгон утас мэт Баддийн хөлийг ороон, маханд шигдэж эхэлжээ. Сахлын хутгаар огтолсон мэт тас үсэрсэн жинсний нэг шуумаг доош унаж, цагаан олс шигдэн орсон өвдөгний дээхэн талаас цус асгарч эхэллээ. Олли түүнийг угз татав. Нэг юм тасрах шиг дуу гараад Бадди чөлөөтэй болжээ. Түүний уруул айснаас хөхөрсөн харагдана.

Майк, Дэн хоёр ухарч эхэлсэн ч дэндүү удаан явцгааж байв. Дэн торыг анзааралгүй давхин очиж, ялаа аалзны тортонд наалдах мэт болов. Тэр хар хүчээрээ тэмцсээр цамцныхаа нэг хэсгийг үлдээгээд торноос мултарлаа.

Гэнэт агаарт исгэрэх дуу зогсоо зайгүй гарч, нарийхан цагаан "олснууд" бидний тал бүрээс унаж эхлэв. Би бөхийн хоёр ч олсноос бултаж чадлаа, гэхдээ энэ нь миний авхаалжтайгийнх бус, зүгээр л аз тохиосон байх. Нэг тийм "олс" миний дэргэд унаж, би асфальт буцлах мэт шажигнан дуугарч, хөөсрөхийг харав. Бас нэг манангаас гарч ирэхэд хатагтай Репплер тун тайвнаар цохиураараа хаалаа. "Олс" цохиурт бөх наалдаж, би тасарч буй сатуркны "пинг-пинг-пинг" гэсэн нарийхан дууг сонсов. Хэн нэгэн хийлийн чавхдасыг хурдан татлах мэт дуу гарч байлаа. Хормын дараа бас нэг "олс" цохиурыг ороон авч, хатагтай Репплериин гараас суга татан, мананд орон алга болов.

-Ухраад! -гэж Олли хашгирлаа.

Бид дэлгүүрийн зүг явж эхэллээ. Олли арай ядан Баддиг мөрлөж, чирнэ. Дэн Миллер, Майк Хатлен нар хатагтай Репплериин хоёр талд гарчээ. Аалзны шулс мэт цагаан олснууд энд тэндээс үсрэн гарч ирсээр. Үнсэн блокон хананы улаан талбай дээр л "олснууд" харагдахаас биш, манан дунд огт харагдахгүй байв.

Нэг олс Майк Хатлены зүүн гарыг ороон авлаа. Бас нэг түүний хүзүүг ороож, хэд угзраад чивчрэн чангарав. Майкийн хүзүүний титэм судас тас үсэрч, цус олгойдоход нэгэнт үхсэн

Майкийг олс чирэн манан дунд далд орлоо. Түүний нэг гутал сугарч, асфальтан дээр хэвтэнэ.

Бадди гэнэт урагш унаж эхлэхэд Олли өвдөг дээрээ суучих шахав.

-Бадди ухаан алдчихлаа. Дэвид, туслаарай гэж тэр хашгираа.

Би Баддийн бүснээс зуурان өргөж, цааш бид чадан ядан явцгаав. Бүр ухаан алдчихаад байхдаа ч Бадди ган лоомоо тавьсангүй. Аалзны шүлс мэт "олс" ороож авсан хөл нь хугарсан бололтой хажуу тийш эвгүй мурийжээ.

Хатагтай Репплер эргэж харлаа.

-Болгоомжил! Ард чинь! -гэж тэр хашгирав.

Би эргэж харах хооронд бас нэг "олс" Дэн Миллерийн толгой дээр буув. Тэр олсыг гараараа тасчиж, шидэлж гарлаа.

Манангаас том нохойны хэрийн аалз гарч ирлээ. Хар өнгөтэй, шар зураастай юм. "Яг уралдааны машин шиг" -гэсэн галзуу бодол миний толгойд гялалzan өнгөрөв. Аалзны нүд улаан өнгөөр гэрэлтэнэ.

Тэр бидний зүг арван хоёр, эсвэл арван дөрвөн, олон үетэй, зүү мэт арзайсан үстэй хөлеө арвалзуулан ирж явлаа - аймшигийн кинонд "тоглуулах" гээд томруулж зургийг нь авсан жирийн аалз биш, шал өөр, бүр аалз биш ч байж магад. Түүнийг хараад Майк Хатлен аптект юу өшиглөж байснаа ойлгосон биз.

Аалз бидний зүг гэдэснийхээ дээд талын нүхээр олсон тор шидлэн ойртож байв.

"Олснууд" бидний зүг дэвүүр мzt дэлгэгдэн нисч байлаа. Манай завины саравчинд олноор байдаг, үхсэн ялаа, хорхойн дээр бодлогошрох мэт суух хар аалзтай төстэй энэ муухай, аймшигт амьтныг хараад би галзуурах дөхөж байгаагаа мэдэрч байв. Зөвхөн Биллийн тухай бодол л намайг жаахан ухаантай байлгасан байх. Би инээж байсан, эсвэл уйлж, хашгируч байсан. Яг яаж байснаа санахгүй байна.

Харин Олли туйлын тайван байлаа. Тэр буудлагын газар байгаа мэт гар бууг удаан, зөөлөн дээшлүүлэн, нэгэн жигд хэмээр бууны хүрдэн дэх бүх сумыг аалзанд зоож орхив. Ямар гээч тамиас ирснийг бүү мэд, гэхдээ л энэ муухай аалз үхэшгүй мөнх амьтан биш юм. Түүний шархнуудаас хар цус олгойдож, аалз муур мэт "мяу" хэмээн, маш нарийхан, бүр сонсохоос илүү синтезаторын басын ноот шиг мэдрэгдсэн нарийхан дуугаар муухай дуугараад мананд үсрэн орж алга болов. Хэрэв тэр асфальтан дээр наалдамтгай хар шингэн үлдээгээгүй бол саяхан би өөрийгөө зүүдэллээ гэж бодохоор аймшигтай муухай амьтан юм.

Баддийн гараасаа алдсан лоом асфальт цохин хангинаан дуугарлаа.

-Бадди үхчихлээ гэж Олли хэлэв. -Түүнийг орхи, Дэвид. Энэ муухай новш түүний гуяны титэм судсыг тасалчихаж. Чөтгөр гэж, эндээс хурдхан зайлцгаая. -Түүний дугариг махлаг нүүр дахин хөлс болж, нүд нь байдгаараа бүлтийжээ. "Олсны" нэг түүний алган дээр гэнэт

буухад тэр гараа угз татан авлаа. Арьсан дээр нь цусан улаан зураас үлдجээ.

Хатагтай Репплер бас дахин "Болгоомжил!" хэмээн хашгирч, бид түүний зүг эргэцгээв. Бас нэг аалз манангаас гүйн гарч ирээд урд хөлнүүдээрээ Дэн Миллерийг хачин муухай, галзуугаар хайрлах мэт тэврэн авлаа. Дэн нударга зангидан аалзыг цохииж гарав. Би тонгойн Баддийн лоомыг авах үед аалз шүлсэн олсоороо Миллерийг ороон, түүний супрах гэсэн оролдлогыг үхлийн аймшигт жүжиг болгон хувиргалаа.

Хатагтай Репплер шүршүүртэй шавьжны хор барьсаар аалзанд ойртоож, аалзны хэдэн хөл өөр рүү нь эргэх үед бадмараг мэт улаан нүд рүү нь хор шүршиж гарлаа. Би дахин аалз муур мэт дуугарахыгсонсов. Аалзны бүх бие чичрэн найгаж, хурц өргөс мэт үстэй хөлөөрөө асфальт маажин, Дэний өнхрөн тийчлэх биеийг чирсээр ухарч эхэллээ. Хатагтай Репплер түүний зүг савтай хороо чулуудав. Сав аалзны биеийг цохиод ойн, асфальтан дээгүүр өнхөрлөө. Аалз жижигхэн спортын машины хаалгыг машин дайвалзтал хүчтэй мөргөөд мананд шингэн алга болов.

Би арайхийн хөл дээрээ зогсох цонхигор царайлсан хатагтай Репплер дээр гүйн хүрч, тохойноос нь түшив.

-Баярлалаа, залуу минь гэж Репплер хэллээ. -Гэнэт дотор муухай оргиод явчихлаа.

-Зүгээр гэж би сөөнгөтөн хариулав.

-Би чадах байсан бол түүнийг аврахсан.

-Тиймээ, би мэдэж байна.

Олли бидэнтэй нийлж, хамтдаа дэлгүүрийн хаалга өөд олснуудаас бултан ухасхийв. Нэг "олс" хатагтай Репплериин цүнхийг ороож, тэр дор нь даавуун гадаргууг нь цоолж орхилоо. Хатагтай Репплер хоёр гараараа цүнхээ чангаасан ч хүчирсэнгүй алдаж, цүнх мананд шингэв. Бид дэлгүүрийн хаалганд тулж ирэхэд булангаас кокер-спаниелийн гөлөгнөөс томгүй аалз гүйн гарч ирлээ. Тэр "олс" шидэлсэнгүй, бага байгаа бололтой.

Олли хаалгыг нээж, хатагтай Репплерийг эхлээд оруулж байх үед би лоомоо далайн аалзыг нэвт бүллээ. Аалз галзуу мэт тийчилж, хөлөө сарвалзуулан, улаан нүд нь миний нүдийг хайж олоод санаж авах мэт удаан, цоо шильтэв.

-Дэвид! -Олли хаалгыг барьсаар.

Би ухасхийн дотогш орж, миний араас Олли орж ирлээ.

Биднийг айсан цонхигор царайнууд угтав. Бид долуул гарсан, харин дөнгөж гурвуул буцаж ирлээ. Олли хүндээр аахилан амьсгаадаж, хүнд шилэн хаалгыг налаад буугаа дахин цэнэглэж эхлэв. Түүний цагаан цамц биенд нь наалдаж, суга нь хөлснөөс харлажээ.

-Тэнд юу байна? -гэж хэн нэгэн аяархан асуулаа.

-Аалзууд гэж хатагтай Репплер баргар царайлан хариулав. -Муухай амьтад миний цүнхийг чирээд явчихлаа.

Билли хүмүүсийн дундуур гүйн миний дэргэд хоёр гараа сарвайн ирэхэд би түүнийг чанга тэврэн авлаа.

10. Хатагтай Кармодийн ховсдол. Хоёр дахь шөнө. Сүүлчийн дайсагнал..

Миний унтах ээлж ирж, энэ дөрвөн цагийн тухай би юу ч санаж чадахгүй болжээ. Аманда намайг нойрондоо юм ярьж, хоёр гурван удаа хашгирч байсан гэж хэлсэн, харин би зүүдэлснээ мэдэхгүй юм. Би бүр үдээс хойш, хачин цангачихсан сэргээ. Сүү гашилж эхэлсэн, гэхдээ бүгд гашилчихаагүй байсан тул би бүтэн литр сүү уучихлаа.

Удалгүй Аманда бидэн дээр Билли, хатагтай Терман нарыг дагуулан ирлээ. Тэднийг даган буу авчрах санал тавьж байсан өвгөн ч ирэв. Корнелл гэж би саналаа. Амбров Корнелл.

-Чи зүгээр үү, хүү минь? -гэж тэр надаас асуулаа.

-Зүгээр. -Гэхдээ миний ам бас л цангаж, бас толгой өвдөж байна. Хамгийн гол нь би аиж байлаа. Биллиг тэврээд би Корнелл, Аманда хоёрыг харлаа:

-Сонин юу байна?

-Ноён Корнелл тэр Кармоди авгайг хараад санаа нь зовж байна. Би ч бас.

-Билли, чи надтай явж жаахан зугаалахгүй юм уу? -гэж Хэтти асуув.

-Үгүй гэж Билли хариуллаа.

-Их Билл, жаахан зугаалж яваад ир гэж намайг хэлэхэд Билли дургүйхэн босч, явлаа.

-Кармоди яагаад байгаа юм бэ?

-Тэр хүмүүсийн толгойг эргүүлээд байна гэж Корнелл хэлээд над руу хөгшин хүний гутарсан харцаар харлаа. -Бид үүнийг зогсоох ёстой гэж би бодож байна. Ямар ч хамаагүй аргаар.

-Түүний талд арав гаран хүн орчихсон гэж Аманда нэмлээ. -Энэ чинь хачин зэрлэг муухай шашны байгууллага болж байна.

Би найз нарын нэг, Отисфилд хотын зохиолч, эхнэр, хоёр хүүхдээ тэжээхийн тулд тахиа үржүүлж, жилд нэг ном бичиж хэвлүүлдэг залуутай ярьснаа санав. Тэр тагнуулын тухай ном бичдэг юм. Бид аймшигийн үзэгдлүүдийн тухай зохиол жилээс жилд улам эрэлттэй болж байгаа тухай ярьсан, тэгээд дөчөөд оны үед зохиогчдод дөнгөж жаахан мөнгө төлөх чадвартай байсан "Зэрлэг түүх" сэтгүүл тавиад онд бүр дампуурсан гэж Голт ярьсан юм. Машинууд жагсаалаас гарч, технологи сүйрэлд ороход, дассан шашны систем нурахад гэж тэр хэлэв (энэ үед эхнэр нь тахианы байрнаас өндөг түүж, гадаа нь азарган тахианууд ууртай донгодож байсан) хүмүүст бас л ямар нэгэн тулгуур хэрэгтэй болдог. Тиймээс хэдэн сая бие ариутгагчтай аэрозоль хэрэглэснээс дэлхийн агаар мандлын озон давхрага цоорч, үүнээс үүссэн аймшигийн инээдмийн жүжгийн дэргэд шөнийн харанхуйд тэнэж яваа зомби хамаагүй сайхан харагддаг.

Бид хорин зургаан цаг дэлгүүрт сууж байгаа боловч юу ч хийж чадсангүй. Бидний ганц аялал тавин долоон хувийн алдагдалтайгаар дууссан, Хатагтай Кармодийн акци өсч байгаад гайхах

юм алга.

-Тэр үнэхээр арав гаран хүнтэй болсон уу? -гэж би асуулаа.

-Үнэн хэрэгтээ найман хүн гэж Корнелл хариулав. -Гэхдээ тэр зогсоо зайгүй ярьж байна. Чөтгөр ав, гайхмаар юм.

Найман хүн. Тийм ч олон биш байна. Бүр тангарагласан шүүгчдийн тоонд ч хүрэхгүй. Гэхдээ би тэдний санаа зовж байгааг ойлгож байлаа. Найман хүн гэдэг ялангуяа Дэн, Майк хоёр үхсэний дараа дэлгүүр доторх хамгийн том улс төрийн хүч болж чадна гэсэн үг. Тэгээд бидний цөөхөн хүмүүс энэ улс төрийн хамгийн том хүчний толгойлогч Кармодийн тамын аймшиг, Эзэний уур хилэнгийн тухай үг бүрийг чагнаж байгаа гэж бодохоос миний дотор бачуурч байв.

-Тэр бас дахиад л хүний цусаар тахил өргөх тухай яриад уналаа гэж Аманда хэлэв. -Бад Браун түүн дээр очоод өөрийн нь дэлгүүрт энэ муухай юмаа ярихаа болихыг шаардсан. Кармодийн талд орсон хоёр эрэгтэй, тэдний нэг нь өнөөх Майрон Ляфлер, Брауныг өөрөө амаа хамхи гэсэн, тэднийхээр бол ингэж ярих эрх бүгдэд бий, Америк бол эрх чөлөөтэй орон гэнэ. Браун амаа хамхиагүй, тэгээд... Жаахан зодолдсон гэхүү дээ.

-Брауны хамрыг цус гартал цохисон гэж Корнелл хэллээ. -Тэд үнэхээр юу ч хийхэд бэлэн байна.

-Гэхдээ арай ч хүн алахдаа тулаагүй байлгүй гэж би хэлэв.

-Тэд ямар байдалд хүрэхийг би төсөөлж чадахгүй байна гэж Корнелл зөвлөн хэллээ. -Хэрэв манан сарнихгүй бол... Гэхдээ би үүнийг харахыг хүсэхгүй. Би эндээс зайлахаар шийдсэн.

-Хэлэхэд амархан, хийхэд хэцүү гэдэг чинь энэ дээ гэхдээ л миний толгойд төлөвлөгөө орж ирлээ. Үнэр. Энэ бол шийдлийн түлхүүр. Энд, дэлгүүрт бид ямар ч байсан аюулгүй байдалд байсан. Ягаан хорхой шиг амьтдыг үнэхээр жирийн хорхой шиг, гэрэл татаж байгаа. Харин том амьтад гадагш гаражгүй л бол биднийг оролдохгүй байна. Аптект аллага болсны шалтгаан нь тэд хаалгаа нээлттэй орхисонд байгаа гэдэгт би итгэж байв. Нортоныг хүмүүстэй нь барьж орхисон амьтан, эсвэл амьтад дууг нь сонсоход байшин шиг том нь мэдрэгдэж байсан, гэхдээ тэд дэлгүүрт ойртохгүй байна. Тэгэхээр...

Би Олли Викстэй яаралтай ярихаар шийдэв. Би түүнтэй ярих ёстой.

-Би нэг бол эндээс гарна, эсвэл үхнэ гэж Корнелл хэллээ. -Би энд зунжин сууж чадахгүй.

-Дөрвөн хүн амиа хорлосон гэж гэнэт Аманда хэллээ.

-Юу? -Би юуны өмнө цэргүүдийн цогцыг олчихож гэж харамсан бодов.

-Нойрны эм гэж Корнелл дуугарлаа. -Би хэдэн хүнтэй нийлж цогцсуудыг агуулахад аваачсан.

Удахгүй тэнд жинхэнэ моорг ажиллаж эхлэх нь гэж би бодоод тэнэг юм шиг инээчих шахлаа.

-Харанхуй болж байна гэж Корнелл хэллээ. -Би явлаа.

-Та машиндаа хүрч чадахгүй, надад итгэ.

-Хамгийн эхний эгнээнд үү? Энэ чинь аптекаас ч ойрхон шүү дээ.

Би хариу хэлсэнгүй. Цаг нь болоогүй байна.

Цагийн дараа би Оллиг пивоны хөргөгчний дэргэдээс хайж олов. Тэр хэнэггүй царайлан пиво ууж байвч бас л хатагтай Кармодиг ажиж байх шиг. Эмгэн ядрах гэдгийг мартсан бололтой. Тэр үнэхээр хүний цусаар тахилга өргөх тухай ярьж, харин одоо хэн ч түүнийг амаа хамхи гэж хэлэхгүй байна. Өчигдөр эмгэнийг дуугүй байхыг шаардаж байсан хэд хэдэн хүн одоо эсвэл эмгэний талд орчихсон, эсвэл зүгээр л сонсож байна. Түүнийг сонсоогүй хүмүүс улам цөөрсөөр.

-Маргааш өглөө гэхэд тэр бүгдийг нь өөрийн талд оруулж дөнгөх байх гэж Олли дуугарлаа. -Үгүй ч байж магад, гэхдээ үнэхээр чадвал тэр хэнээр тахилга өргөхөөр шийднэ гэж чи бодож байна?

Бад Браун эмгэний дургүйг хүргэсэн. Аманда. Түүнийг цохисон эрэгтэй хүн. Тэгээд мэдээж, би.

-Олли гэж би хэллээ. -Тав, зургаан хүн эндээс явж чадна гэж би бодож байна. Хэр хол явахыг би мэдэхгүй, ямар ч байсан эндээс хөдөлж чадна.

-Яаж?

Би түүнд өөрийн төлөвлөгөөг ярьж өглөө. Би ямар ч нарийн ширийн юм бодож олоогүй. Хэрэв бид хар хурдаараа гүйн миний "Скаут"-д орж чадах юм бол тэд үнэр авч амжихгүй. Ямар ч байсан бүх цонхoo хаачихвал.

-Гэхдээ тэднийг өөр үнэр татвал яах вэ? -гэж Олли асуув. -Жишээ нь машины утаа?

-Тэгвэл бид өнгөрнө гэж би зөвшөөрлөө.

-Хөдөлгөөн гэж Олли хэлэв. -Манан дунд машин явах нь тэдний анхаарлыг татаж болно шүү дээ, Дэвид.

-Үгүй байх. Үнэр гарахгүй л бол тэд дайрахгүй.

-Гэхдээ чи бүрэн итгэлгүй байна.

-Тиймээ, бүрэн итгэлгүй байна.

-Чи хаашаа явах юм бэ?

-Эхлээд үү? Гэрээдээ. Эхнэрээ авна.

-Дэвид...

-За яахав. Шалгана. Мэдэж авна.

-Дэвид, энэ амьтад хaa ч байж магад. Чамайг дэлгүүрээс гармагц тэд дайрч болно.

-Хэрэв тэгвэл "Скаут" чинийх. Би чамаас зөвхөн Биллиг чадах хэрээрээ асарч халамжлаарай л гэж гүйх байна.

Олли пивоо ууж дуусгаад лаазыг хөргөгчинд овоолсон хоосон савнуудын зүг шидлээ. Лааз хангинан унав. Амандагийн өгсөн гар бууны бариул өмдний халааснаас нь цухуйна.

-Өмнө зүг явах уу? -гэж тэр намайг ширтэн асуув.

-Тэгэх байх гэж би хэллээ. -Өмнө зүг явж, манангаас гарагыг оролдоно. Бүх хүчээрээ оролдох болно.

-Чамд бензин хангалттай бий юу?

-Бараг бак дүүрэн байгаа.

-Гарах ямар ч арга байхгүй гэж чи бодож үзсэн үү?

Би бодож үзсэн. Хэрэв тэр "Сум" төсөл" -ийнхөн манай бүх тойргийг тэр чигээр нь оймс эргүүлэхтэй адил өөр хэмжигдэхүүнд оруулчихсан бол яах билээ?

-Бодож үзсэн гэж би хэлэв. -Гэхдээ явахгүй л бол зүгээр суугаад, хатагтай Кармоди хэнээр тахилга өргөхөөр шийдэхийг хүлээхээс өөр аргагүй.

-Чи өнөөдөр явахаар шийдсэн үү?

-Үгүй, өнөөдөр оройтсон, энэ амьтад яг шөнө идэвхтэй болдог. Би маргааш өглөө, эрт хөдөлнө.

-Хэнийг чи авч явах вэ?

-Чамайг, бас Билли, Хэтти Терман, Аманда Дамфрис. Тэр өвгөн Корнелл, хатаггай Репплер. Бас Бад Брауныг ч авч болох юм. Найман хүн болчихлоо, гэхдээ Билли хэн нэгний өвөр дээр суугаад, бид жаахан чихэлдээд явж болно.

Тэр удаан бодсонгүй.

-О'Кей гэж тэр хэлэв. -Үзээд алдъя. Чи хэн нэгэнтэй ярьсан уу?

-Үгүй, одоохондоо яриагүй.

-Юу ч ярихгүй байхыг би чамд зөвлөж байна. Өглөөний дөрвөн цаг хүртэл. Би хоёр уут хүнс

бэлдээд орхиё. Тэгээд хаалганд хамгийн ойр кассны тавиурын дор орхино. Хэрэв бидний аз тохиовол бид бусдад мэдэгдэхгүй гараад явчих байх. -Түүний харц дахин хатагтай Кармоди дээр тогтов. -Хэрэв тэр мэдвэл бидэнд саад хийх гэж оролдоно.

-Чи тэгж бодож байна уу?

Олли дахин нэг лааз пиво авлаа.

-Тиймээ, би тэгж бодож байна.

Өдрийн хоёр дахь хагас - өчигдрийн өдрийн яг л удаашруулсан кино зураг авалт мэт өнгөрөв. Харанхуй мөлхөн ирж, манан дахин бохир шар болж, найм хагас болоход гадаах ертөнц харанхуйд умбалаа.

Ягаан хорхой мэт амьтад ирж, дараа нь цонх руу дайран, тэднийг ангуучлах муухай шувууд бас ирлээ.

Юу ч юм харанхуйд хэхрэх мэт дуугарч, нэг удаа, шөнө дундаас өмнөхөн удаанаар "aa-appruu-uu" хэмээн архирах сонсогдов. Хүмүүс айсан, хүлээсэн шинжтэй бүгд цонх руу эргэн харцгаалаа. Иймэрхүү дууг намган дахь эр матар л гаргаж чадах биз.

Бүх зүйл яг Миллерийн урьдчилан хэлснээр явж байна.

Шинэ өглөө ирэх үед хатагтай Кармоди дахин зургаа, долоон хүн элсүүлж амжжээ. Тэдний дунд махны худалдагч ноён Маквей харагдана. Тэр гарцаа энгэртээ зөрүүлэн зогсоод Кармодиг анхааралтай ширтэж байв. Хатагтай Кармоди бүр даварч гүйцжээ. Түүнд нойр ч хэрэггүй бололтой. Түүний номлол гэж тэр чигээрээ Доре, Босх, Жонатан Эдвардсын аймшиг ажээ. Кармоди номлолоо үргэлжлүүлсээр, үргэлжлүүлсээр, ямар нэг зэвүүн муухай барианд дөхсөөр байх шиг. Түүний багийн гишүүд одоо энэ муухай эмгэнийг даган, "чин сэтгэлээсээ" амандаа юу ч юм, углэцгээж, урагш хойш найгаж эхэлжээ. Тэд хатагтай Кармоди хэмээх хар домын хараалчийн ховсдолд бүрэн оржээ.

Өглөөний гурван цагийн үед (номлол үргэлжилсээр, зарим хүмүүс бага ч болов нойр авахаар дэлгүүрийн цаад буланд очин хэвтэцгээсэн харагдана) Олли хүнс, ундаа хийсэн цаасан уутыг үүдэнд хамгийн ойр кассны доогуур хийж байгаа харагдав. Хагас цагийн дараа тэр дахин нэг уут юм авчран кассны доогуур шургуулав. Түүнийг надаас өөр хүн анзаарсангүй бололтой. Билли, Аманда, хатагтай Терман нар хиамны хоосорсон тавиуруудын дор бие биесдээ наалдан унтацгаана. Би тэдний хажуугаар хэвтэж, түгшүүртэйгээр зүүрмэглэж эхэллээ.

Цаг дөрөв арван тав болж байхад Олли намайг сэрээлээ. Түүний дэргэд харааны шилний цаана нүд нь гялалзах Корнелл зогсоно,

-Цаг боллоо, Дэвид -гэж Олли хэллээ.

Сэтгэл хөдөлснөөс гэдсээр хатгах шиг болсон ч би хурдан тайвшрав. Тэгээд Амандаг сэрээлээ. Нэг машинд Стефени, Аманда хоёр явах бол ямар асуудал үүсэх тухай би бодсонгүй, одоо болж байгаа бүхнийг үг дуугүй хүлээн авах л үлджээ.

Түүний сайхан маргадын ногоон өнгөтэй нүд над руу ширтлээ.

-Дэвид?

-Бид эндээс явах гэж оролдоод үзнэ. Чи бидэнтэй явах уу?

-Чи юу яриад байна аа?

Би хоёр удаа давтахгүйн тулд хатагтай Терманыг сэрээгээд байдлыг тайлбарлалаа.

-Чиний энэ үнэрийн тухай дүгнэлт чинь одоохондоо зүгээр л таамаглал биз? -гэж Аманда асуув.

-Тиймээ.

-Энэ надад огтхон ч хамаагүй гэж Хэтти хэлэв. Түүний нүүр цонхигор, унтсан ч нүдний нь доогуур хар хүрээ татжээ. -Би дахин нар хармаар байна, үүний тулд яхаас ч буцахгүй.

"Дахин нар хармаар байна". Би цочсон мэт давхийлээ. Хэтти миний өөрийн, Нормыг тэмтруул чирэн одоход намайг анх эзэмдсэн айдсын гол цэгийг яг оноод хэлчих шиг. Манан дунд нар жижигхэн мөнгөн зоос мэт, бид нарыг яг л Сугар гариг дээрээс харж байгаа мэт байсан.

Айдсыг манан дунд биднийг отож байгаа муухай амьтад төрүүлээгүй. Миний лоомын цохилт тэд бол Лавкрафтын номон дээр гардаг шиг үхэшгүй мөнх амьтад биш, өөрийн эмзэг, амин газартай, шим бодисоос бүтсэн амьтад гэдгийг баталсан. Асуудал эрч хүчийг сорж, ухаан мэдрэлийг балайруулан, айdas төрүүлэгч мананд байна. "Дахин нар хармаар байна". Хэттийн зөв. Зөвхөн үүний төлөө тамыг туулахаас ч би буцахгүй.

Би Хэттиг харан инээмсэглэхэд тэр хариулан, итгэл муутайхан инээмсэглэв.

-Тийм гэж Аманда хэллээ. -Би ч бас явна.

Би хүүгээ болгоомжтой сэрээлээ.

-Би та нартай явна гэж хатагтай Репплер шууд хэллээ.

Бид бүгд махны тавиуруудын дэргэд зогсоцгоов. Бад Браунаас бусад нь бүгд. Бад өөрийг нь хамт явахыг гүйсанд талархаад дэлгүүрээ орхиж чадахгүй гэж тайлбарлан татгалзсан юм. Тэгээд гайхам зөвлөн хоолойгоор Оллиг явж байгаад огтхон ч муу юм санахгүй гэж хэлсэн.

Цагаан паалантай хайрцагнуудаас эвгүй муухай үнэр гарч эхэлжээ. Нэг удаа бид долоо хоног аялалд яваад ирэхэд манай хөргөгч эвдэрчихсэн, дотроос нь яг ийм үнэр гарч байж билээ. Магадгүй, муудаж байгаа махны үнэр ноён Маквейг хатагтай Кармодийн багт түлхэн оруулсан биз.

-... нүглээ наманчил! Одоо бид нүглээ наманчлах тухай л бодох ёстой! Бурхан биднийг гэсгээлээ! Бид эртний Бурхадын хориглосон нууцад нэвтрэхийг оролдсоноос шийтгүүллээ! Бид газрын ам ангайхыг харсан! Бид аймшигт муухай амьтдыг харсан! Чулуу биднийг тэднээс хамгаалахгүй, хатсан мод нуувч болохгүй! Тэгээд энэ бүхэн яаж дуусах вэ? Юу тэднийг зогсоох вэ?

-Нүглээ наманчил! –гэж хөөрхий Майрон Ляфлер орилов.

-Нүглээ наманчил... нүглээ наманчил... -гэж бусад нь итгэл муутай шивнэцгээнэ.

-Та нар үнэхээр шүтэн биширч байгааг би сонсохыг хүсч байна! -гэж хатагтай Кармоди хашгирлаа. Түүний хүзүүний титэм судас олс мэт гүрийжээ. Хоолой нь сөөнгөтөж, суларсан боловч хүнийг өөртөө татах хүчээ агуулсан хэвээр, энэ хүчийг түүнд манан өгч байгаа мэт надад санагдлаа. Эрч хүч, бас хүний толгойг эргүүлэх чадварыг. Бидний нарны хүчийг булаан авсан манан. Үүнээс өмнө Кармоди зүгээр л жаахан гажигдуухан ааш зантай, хуучны эдлэлийн дэлгүүр дүүрэн хотод хуучин эдлэлийн дэлгүүртэй хөгшин байсан. Зүгээр л дэлгүүрийнхээ цаад буланд амьтдын чихмэлтэй, эртний анагаах ухааны мэдлэгтэй гэж яригддаг (шулмас, новш...) настай эмэгтэй байсан. Хүмүүс түүнийг алимын мөчрөөс ус гаргаж, мэнгэ арилгаж, бас сэвхнээс бүрэн ангижруулдаг тос худалддаг гэж ярыцгаадаг байсан, Тэр бүү хэл би Билл Жостигоос байх, Кармодид бэлгийн асуудлаар ч хандаж болох тухай сонсож байсан; хэрэв таны ор хөнжлийн ажил тааруухан байгаа бол энэ хөгшинд нууцаар хандах хэрэгтэй, тэр тусгай шингэн уулгаад асуудлыг бүрэн шийдчихнэ гэж сонссон.

-Наманчлал! -гэж бүгд зэрэг хашгирлаа.

-Тиймээ, нүглээ наманчлах хэрэгтэй, зөв! -гэж хатагтай Кармоди ухаангүй хашгирна Нүглээ наманчилвал манан арилна! Наманчлал энэ муухай амьтдыг хөөнө! Наманчлал бидний нүднээс манангийн хөшгийг авч, харах боломж олгоно! -Түүний дуу арай зөөлрөв. -Библийн сургаснаар наманчлал гэж юу вэ? Бурханы нүд, оюун ухаанд нүглийг учлах ганц арга юу вэ?

-Цус.

Энэ удаа миний хамаг бие чичирлээ, дахин жаахан сонсвол миний үс арзайн босох байсан биз. Энэ үгийг ноён Маквей хэлсэн юм. Намайг бүр аавынхаа уран гараас зуурсан жаахан хүүхэд байхад Брижтонд мах бэлтгэгч байсан ноён Маквей. Өөрийн цус болсон халаадаа өмсөөд захиалга авч, гулууз мах эвддэг байсан ноён Маквей. Хутгатай танилцаад тун удаж байгаа ноён Маквей. Бас хөрөөтэй. Бас сүхтэй. Сэтгэлийг ариусгах бодис биен дээрх шархнаас урсан гардгийг бусдаас илүү хурдан, илүү сайн ойлгох ноён Маквей.

-Цус гэж тэд шивнэлдлээ.

-Аав, би аиж байна гэж Билли миний гараас чанга атган хэллээ. Түүний царай цонхийж, хачин болжээ.

-Олли гэж би хэлэв. -Бид энэ галзуугийн байшингаас явах цаг болсон байх.

-О'Кей гэж Олли хариуллаа. -Явцгаая.

Олли, Аманда, Корнелл, хатагтай Терман, хатагтай Репплер, Билли, бид нар хамтдаа хаалганы зүг явлаа. Тавд хорин минут дутуу, манан дахин сааралтаж эхэлжээ.

Корнелл та хоёр ууттай хүнсээ ав гэж Олли надад хэлэв.

-За тэгье.

-Би түрүүлж явах болно. "Скаут" чинь дөрвөн хаалгатай биз?

-Тийм.

-Маш сайн. Би жолоочийн хаалгыг нээж ороод хойд хаалганы нэгийг нээнэ. Хатагтай Дамфрис, та Биллийг өргөөд явбал даах уу?

Аманда Биллийг тэврэн өргөлөө.

-Би их хүнд байна уу? -гэж Билли асуув.

-Үгүй хонгор минь, гайгүй байна.

-За, сайн.

-Билли та хоёр урд хаалгаар ороорой гэж Олли үргэлжлүүлэв. -Урд талын хаалгаар. Хатагтай Терман арын голд сууна. Дэвид, чи жолооны ард. Бусад нь...

-Та нар хаачихна вэ? -гэж хатагтай Кармоди асуулаа.

Тэр Олли хүнсийн уут нуусан кассны дэргэд зогсоно. Бүрэнхийд түүний канар бялзуухайн шар өнгийн костюмны хослол гэрэлтэх мэт харагдана. Тал бүр тийш галзуу мэт сэгсийсэн үс нь надад "Франкенштейний сүйт бүсгүй" киноны Эльза Ланчестерийг санагдууллаа. Түүний нүд солиотой хүнийх мэт гялалзаж, ард нь, хаалганы дэргэд арван тав орчим хүн зогсжээ. Тэгээд тэд бүгд дөнгөж сая онхолдсон машинаас гарч ирсэн мэт, эсвэл нисдэг таваг үзсэн, эсвэл тэдний нүдний өмнө мод үндсээ сугалаад явж эхэлсэн мэт харагдана.

Билли нүүрээ Амандагийн хацарт наажээ.

-Бид явлаа, хатагтай Кармоди гэж Олли гайхмаар зөөлөн хоолойгоор өгүүлэв. -Бидэнд саад болох хэрэггүй.

-Та нар явж чадахгүй. Тэнд үхэл байгаа. Та нар ойлгохгүй байна уу?

-Танд хэн ч саад хийгээгүй гэж би хэллээ. -Бидэнд ч адилхан хандахыг хүсч байна.

Кармоди тонгойж, ууттай хүнсийг гаргаж ирлээ, тэр бүр эхнээс нь бидний төлөвлөгөөг мэдэж, нууцаар харж тагнаж байсан бололтой. Тэр уутнуудыг өргөхөд нэг цаасан уут

урагдаж, шалаар лаазалсан мах өнхрөлдөв. Нөгөө уутыг Кармоди хажуу тийш чулуудаад шил хагарах сонсогдож, урагдсан уутнаас хийжүүлсэн ундаа шажигнан урслaa.

-Ийм хүмүүс л болсон бүхэнд буруутай хэмээн хатагтай Кармоди орилж гарав. -Бүхнийг чадагчийн хүслийг үл биелүүлэгч, ихэмсэг, муйхар, зөрүүд зант нүгэлтнүүд! Эднээс бид тахил өргөх хүнийг сонгох ёстой! Эдний цус бидний нүглийг наманчлана!

Хүмүүс ам амандаа дэмжин дуугарах нь түүнийг бүр гааруулав. Кармоди галзуурсан мэт болж, шүлсээ үсчүүлэн хашгирч эхэллээ:

-Бидэнд тэр хүү хэрэгтэй! Бариад ав! Бариад ав! Бидэнд хүү хэрэгтэй!

Тэр бидэн рүү ухасхийн дайрч, араас нь хоосон нүд нь ухаангүй баярлан гялалзах Майрон Ляфлер гүйж ирлээ. Тэдний араас ноён Маквей ирж явна. Түүний царай ямар ч мэдрэмж, хөдөлгөөнгүй, чулуу мэт харагдана.

Аманда арагш ухарч, Биллиг улам чангатэврээд над руу айсан нүдээр харлаа.

-Дэвид, би...

-Хоёуланг нь бариад ав! -гэж Кармоди хашгирлаа. -Хүүхнийг бас барь! Бариад ав!

Шар, баргар, аймшигт сүйрэл, үхлийн дүр мэт болсон хатагтай Кармоди өнөөх том цүнхээ барьсан хэвээр дороо цовхчин үсэрч, орилно.

-Хүүг бариад ав! Хүүхнийг бариад ав! Хоёуланг нь бариарай! Бүгдийг бариад ав! Бариад...

Гар буу тасхийлээ.

Сурагчид үймүүлж байсан ангид багш орж ирээд хаалга тасхийн хаасан мэт гэнэт нам гүм болж, бүгд зогтусав. Майрон Ляфлер, ноён Маквей нар биднээс арваад алхмын цаана зогсож, Майрон махны худалдагчийн зүг итгэлгүй харлаа. Цаадах нь түүнийг харсан ч үгүй, ерөөсөө хажууд нь Майрон байгааг тэр анзаараагүй байх. Ноён Маквейн нүүр миний сүүлийн хоёр хоногт дэндүү олон харсан хүмүүсийн нүүр царайтай адилхан болжээ: түүний оюун ухаан ачааллыг даасангүй.

Майрон аажмаар ухран, Олли Виксийг айснаас бүлтийсэн нүдээр ширтэж байснаа гэнэт эргэж, кассыг тойрон гүйж, хальтирч унаад дахин босч, дэлгүүрийн цаад буланд хүрэн харагдахаа болив.

Олли буудлагын сонгомол зогсолтоор зогсон, Амандагийн гар бууг хоёр гараараа атгажээ. Хатагтай Кармоди кассны дэргэд зогссон хэвээр, толбонд бүрхэгдсэн хоёр гараараа гэдсээ даржээ. Түүний хуруунуудын завсраар цус урсаж, шар өмдөн дээр нь дусална.

Кармодийн ам ангайж, хаагдав. Бас дахин. Тэр нэг юм хэлэх гээд, эцсийн эцэст дуугарч чадлаа.

-Та нар бүгд тэнд үхнэ гэж хэлээд Кармоди урагш зөөлөн унав. Түүний том цүнх хажууд нь унаж, дотор нь байсан зүйлс шалаар өнхрөлдлөө.

Цаасанд боосон гонзгой зүйл өнхөрсөөр миний гутлыг мөргөн зогсов. Би бөхийн түүнийг авч үзлээ. Энэ бол хэрэглэж эхэлсэн мансууруулах бодистой эм байлаа. Би түүнийг хол чулуудлаа, Кармодийн юунд ч би хүрэхийг хүссэнгүй.

Удирдагчаа алдсан бүлгийнхэн таран бутарч эхлэв. Хүмүүс шалан дээр хэвтэх цогцос, дороос нь урсаан бараан цусыг харцгаан тарлаа.

-Чи түүнийг алчихлаа! -гэж хэн нэгэн айж, уурласан дуугаар хашгирлаа. Гэвч миний хүүгээр тахил өргөх тухай ярьж байснаа хэн ч санасангүй.

Олли буудлагын зогсолтоор зогссон хэвээр, харин одоо түүний уруул чичирж байна. Би түүний мөрөн дээр гараа тавилаа.

-Явъя, Олли. Чамд баярлалаа.

-Би түүнийг алчихлаа гэж тэр сөөнгөтөн дуугарав. -Би үнэхээр түүнийг алчихлаа.

-Тиймээ. Тийм ч учраас би чамд баярлаж байна. Одоо явцгаая.

Бид дахин хаалганы зүг явцгаав. Кармодийн ач тусаар идэх юмтай уутнаас хагацсан болохоор би хүүгээ гар дээрээ авлаа. Хаалганы дэргэд бид хормын хугацаанд зогсоход Олли нам дуугаар арай ядан надад хандав:

-Дэвид, хэрэв өөр арга байсан бол би түүнийг буудахгүй байсан.

-Тиймээ.

-Чи надад итгэж байна уу?

-Тийм, итгэжбайна.

-Тэгвэл явцгаая.

Бид гадагш гарлаа...

11. Төгсгөл

Гар буугаа бэлэн барьсаар Олли урагш ухасхийв. Билли бид хоёр дэлгүүрээс гарч амжаагүй байхад тэр "Скаут" -ын дэргэд очихсон, зурагтаар кинонд гардаг хий сүг мэт харагдаж байв. Тэр жолоочийн хаалгыг нээж, дараа нь арын хаалгыг онгойлгох үед манангаас юу ч юм үсрэн гарч ирээд түүнийг дундуур нь таслан хоёр хуваалаа.

Би юу байсныг ч олигтой харж амжсангүй. Энэ нь дээр ч байж магад. Тэр амьтан далайн хавч шиг улаан, том хавчууртай, Нортон өөрийн "Дэлхий хавтгай гэдэгт итгэгсэдийн нийгэмлэг" -ийнхэнтэй супермаркетаас гарч явахад бид сонссонтой адилхнаар гахай мэт дуугарч байлаа.

Олли ганц удаа буудаж амжсан, гэвч энэ муухай амьтны хавчуур урагш тасхийн үсэрч; Олли аймшигт цусан оргилуур болон хувирсан. Гар буу унаж, асфальтанд цохиод хий буудлаа. Би зөвхөн мөчир усан үзэм шиг хэдэн арван хар нүд олж харсан, тэгээд энэ амьтан Оллигоос үлдсэнийг чирсээр мананд үсрэн ороод алга болсон. Урт, хилэнцэт хорхойнх шиг бөгжилсөн мэт бие асфальтан дээгүүр шажигнан, хурдан мөлхөж байсан.

Би маш богино хугацаанд сонголт хийлээ. Ийм богино хугацаанд шийдвэр гаргах нь хүний амьдралд заавал тохиолддог байх. Миний нэг хэсэг Биллиг биедээ наан тэврээд эргэн дэлгүүрт орохыг шаардаж байв. Нөгөө хэсэг машинд гүйн хүрч, Биллиг дотогш хийгээд араас нь ор гэж тушаалаа. Гэнэт Аманда ард хашгирч, түүний дуу улам чангараар бараг л хэт богино долгионт дуу болон хувирав. Билли миний цээжинд нүүрээ наан наалджээ.

Хэтти Терманыг аварга том аалз барьж авлаа. Тэр Хэттиг дайран унагаж, хөөрхий эмэгтэйн даашиinz дээш согсойн, туранхай өвдөг нь ил гарчээ. Аалз түүний дээр гарч, мөрнөөс нь үсэрхэг хөлөөрөө зуурч аваад олс мэт бүдүүн шүлсээрээ ороож гарав.

"Кармоди эмгэний зөв байж гэсэн бодол миний толгойд гялсхийв. -Бид бүгд энд үхнэ. Бид үнэхээр бүгд энд үхэх юм байна".

-Аманда! -гэж би хашгирлаа.

Харин байж боломгүй бүхнийг нүдээр харж, ухаан алдсан Аманда хариулсангүй. Аалз хэзээ ч юу, жирийн хүн галзуурмаар нарийн үгийн сүлжээнд дуртай байсан хүүгийн минь асрагчийн биен дээр сууж байна. Цагаан олс мэт шүлс түүний биеийг битүү ороож, хүчил нь биенд нэвтрэн орсон тэр газруудаар улаан өнгөтэй болжээ.

Корнелл биднийг шилний нь цаана таваг мэт том, дугариг харагдах нүдээрээ ширтэн удаан ухарсаар гэнэт эргэж, дэлгүүрт орох хүнд хаалгыг түлхэн үзэгдэхгүй болов.

Миний хормын төдийд эргэлzsэн байдал хатагтай Репплер Аманда руу үхасхийн хүрч, хоёр удаа алгадаад авахад гэнэт ариллаа. Би Амандад гүйн очиж, "Скаут" -ын зүг эргүүлээд:

-Урагшаа! -гэж байдаг чадлаараа хашгирлаа.

Аманда гүйлээ. Хатагтай Репплер миний хажуугаар гүйн өнгөрч, Амандаг машины арын суудалд түлхэн оруулаад өөрөө араас нь орж, хаалгаа хаав.

Би Биллиг өөрөөсөө салгаж, машинд чихлээ. Намайг машинд орж байхад манангаас "олс" хийсэн ирж, хөлийн шилбийг ороож авав. Загасны уурганы сатурк атгаж байхад гэнэт суга татсан мэт арьс хорсож байна. Mash бөх ороосон тул би хөлөө хар хүчээрээ угз татаан, "олсыг" тасалж чадав. Дараа нь би жолооны ард сууж авлаа.

-Хаалгаа хаагаач! Оо-оо, бурхан минь... -хэмээн Аманда ухаангүй хашгична.

Би хаалгаа хаамагц аалзнуудын нэг хар гүйхээрээ ирж машиныг дайвалзтал мөргөв. Би түүний час улаан, ухаангүй хүйтэн нүднээс хэдхэн сөөмийн зйтай сууж байлаа. Аалзны миний гарын бугуй шиг бүдүүн хөлүүд машины капотыг маажна. Аманда зогсоо зайлгүй, гал командын машины дохиолол мэт жингэнүүлэн хашгирч байв.

-Дуугүй болоод өгөөч, чи! -гэжхатагтай Репплер зандрав.

Аалз биднийг үнэрлэж чадахгүй, тэгэхээр олз алга боллоо гэсэн үг. Тэр эргэж, өөрийн арван хэдэн хөлөөрөө асфальт маажсаар манан дунд орж, бүдгэрэн, дараа нь далд орлоо. Түүний явсныг харж итгэмэгц би машины хаалгыг дахин нээв.

-Чи яаж байна аа? -гэж Аманда хашгирсан ч би тоосонгүй. Би юу хийж байгаагаа мэдэж байлаа, Олли ч миний оронд үлдсэн бол ингэх л байсан. Би нэг хөлөө газар тавин бөхийж, гар бууг шүүрэн авлаа. Нэг юм над руу манангаас дайрч, би ямар амьтныг нь ч харж амжсангүй хурдан эргэж, хаалгаа хаалаа.

Аманда енгэнүүлэн уйлав. Хатагтай Репплер түүнийг тэвэрч, тайвшруулж байна.

-Бид гэртээ харих уу, ааваа? -гэж Билли асуулаа.

-Бид оролдоод үзнэ дээ, Их Билл минь.

-О'Кей гэж Билли аярхан хэллээ.

Би гар бууг шалгаж үзээд урд хайрцагт хийв. Олли аптек явсны дараа бууг дахин цэнэглэсэн, үлдсэн хайрцаг сум түүний хамт алга болсон ч би сум хүрэлцээтэй гэж бодож байлаа. Олли нэг удаа хатагтай Кармодиг буудсан, дараа нь хавч шиг муухай араатныг нэг буудсан, буу газар унахдаа өөрөө буудсан. "Скаут" -д бид дөрвүүл байгаа, гэхдээ хэрэв үнэхээр гарах газаргүй болвол би өөрийнхөө амийг ямар нэг аргаар тасалж чадна гэж бодож байлаа.

Хэдэн эвгүй хором би түлхүүрээ хайлаа. Хамаг халаасаа ухаад олддоггүй. Дараа нь тайвширч аваад дахин хайв. Түлхүүр жинсний халаасанд, задгай мөнгөн дунд "нуугджээ". "Скаут" шууд л асч, хөдөлгүүрийн итгэлтэй хүржигнэхийг сонссон Аманда дахин уйлж гарлаа.

Би манангаас моторын дуу, утааны үнэрт татагдсан бас ямар чөтгөр гарч ирэх бол хэмээн болгоомжилж, араагүй хаазлан хэсэг суулаа. Миний амьдралын хамгийн урт таван минут өнгөрөхөд юу ч ирсэнгүй.

-Бид явах юм уу, ингээд суугаад байх юм уу? -гэж хатагтай Репплер асуув.

-Явна аа гэж би хэлээд машинаа зогсоолоос гаргаж, манангийн гэрэл асаалаа.

Яагаад ч юм, би машинаа супермаркетийн урдуур явуулмаар санагдаад болсонгүй. "Скаут" -ын баруун бампер газар хажуугаараа хэвтэх хогийн савыг түлхэн зайлцуулав. Дэлгүүрийн дотор талд бордоотой шуудай өрснөөс юу ч харагдахгүй, харин нүх бүрийн цаанаас биднийг хоёр, гурван цонхигор царай харж байлаа.

Дараа нь би зүүн тийш эргэж, битүү цагаан манан бидний ард хөшиг хаах мэт дэлгүүрийг хаав. Тэр хүмүүс юу болж дууссаныг би мэдэхгүй.

Маш болгоомжтой, цагт арван километр хүрэхгүй хурдтайгаар бид Канзас-роудын замаар буцан явлаа. Манангийн шар, ойр, холын гэрлээ асаагаад ч хоёр хагас, гурван метрээс цааш юу ч ул харагдана.

Миллер зөв хэлжээ. Газар хөдлөлт үнэхээр их хор хөнөөл авчирсан бололтой. Зарим газар зам дөнгөж цуурсан мэт харагдана, гэхдээ бас асфальтыг хуу татаж, гүнзгий жалга, бүр хавцал үүссэн газар ч таараздаж байв. Давхар мосттой "Скаут" замын саадыг чүү чамай даван урагшилна. Гэвч би урд энэ машин ч гарч чадахааргүй саад учирж магад хэмээн ихээхэн аиж явлаа.

Бид долоо, найман минутанд туулдаг замыг дөчин минут явж байж авлаа. Тэгээд манай байшингийн зүг эргэдэг тэмдэг харагдав. Дөрөв дөчид сээрээсэн Билли бараг л төрөлх гэр шиг нь танил машинд орж ирээд тайвширсан мэт нам унтана.

Аманда сэтгэл зовсон шинжтэй замыг ширтэнэ.

-Чи үнэхээр гэртээ харих гээд байна уу?

-Би оролдоод үзэх гээд байна.

Гэвч энэ нь бүтэшгүй зүйл байжээ. Шуурга олон арван моддыг ганхуулж, дараа нь газар хөдлөлт гүйцээн, зам дээр зайд завсаргүй шахам мод унагажээ. Хоёр багавтар модон дээгүүр би гарч чадсан, гэвч дараа нь ойн дээрэмчид биднийг отож унагасан мэт аварга том модонд тулж ирлээ. Гэр хүртэл бараг хагас километр зайд байна, Билли миний дэргэд унтсан хэвээр. Би машинаа зогсоож, алгаараа нүүрээ таглаад цааш юу хийхээ эргэцүүлэн бодлоо.

Одоо, бүх Мэн мужийг огглон гардаг хурдны замын 3 -р уулзварын дэргэдэх "Ховард Жонсонз" зочид буудлын танхимд суугаад бидэнд тохиолдсон бүхнийг буудлын тэмдэгтэй цаасан дээр бичиж байхад надад туршлагатай, гайхам эр зоригтой хатагтай Репплер бидний ямар ч найдваргүй, гарах гарцгүй байдлыг хэдхэн хурц үгээр илэрхийлэх байсан гэж бодогдном. Гэхдээ таарч тохирох дүгнэлтэнд би өөрөө хүрэх ёстойг энэ ухаалаг боловсон хатагтай бас мэдэж байгаа.

Машинаас би гарч чадсангүй. Тэднийг үлдээж зүрхэлсэнгүй. Аймшигийн кинонд л баймаар тэр муухай амьтад бүгд супермаркетын дэргэд үлдсэн гэж өөрийгөө хуурах ч хэрэг

байсангүй, машины цонхыг жаахан буулгахад л замын хажуугийн, энэ нутгийнхан Карназ гэж нэрлэдэг ойд тэдний орилолдох, бут сөөг гишгэлэн явах нь сонсогдож байв. Унжсан навчсаас зогсоо зайдийг ус дусалж, хэдэн хором манан бүр харанхуй болоод, бидний яг дээгүүр аварга том, мананд дөнгөж харагдах шувуу нисэн өнгөрлөө.

Хэрэв Стефф шуурхай хөдөлж, байшиндаа хурдан ороод хаалга цонхоо хааж, түгжсэн бол хоол унд арав, магадгүй хоёр долоо хоног хүрэлцэх ёстой гэж би өөрөө өөртөө хэлж, итгүүлж байлаа. Гэхдээ энэ ч олигтой тус болохгүй юм: би түүнийг сүүлчийн удаа харсан, хуучин дэрэвгэр бүрх малгайтай, цэцэрлэгийн бээлийтэй жижигхэн цэцэрлэгийн талбайдаа зогсож, араас нь, нуурын зүгээс манан өршөөлгүй ойртож байгаа дүр зураг миний нүдэнд харагдсаар байна.

Одоо би Биллийг бodoх ёстой. "Билли гэж би өөрөө өөртөө хэлж байна. -Билли, Их Билл, Их Билл..." Би түүний нэрийг цаасан дээр магадгүй зуун удаа бичих ёстой, Цонхоор нар гэрэлтэж, ширээнийхээ ард багш суугаад гэрийн даалгавар шалгаж, ангид дуугарч байгаа ганц дуу нь багшийн үзэг хяхтнах, бас хаанаас ч юм, бөйсбол тоглохоор хоёр баг болон талцаж байгаа хүүхдүүдийн хашгиралдах дуун сонсогдож байхад цаасан дээр "Би дахиж цаас зажилж шидлэхгүй" гэж зуун удаа бичих шийтгэл хүлээсэн сургч шиг...

Эцсийн эцэст би хийж чадах ганц зүйлийг хийв. "Скаут" -ыг болгоомжтой ухраасаар Канзас-роуд дээр гарч ирлээ. Тэгээд би тэнд уйллаа.

-Дэвид, би маш их харамсаж байна... -гэж Аманда миний мөрийг илэн хэлэв.

-Тиймээ гэж би нулимсаа тогтоохоор дэмий оролдон хариуллаа. -Би ч бас.

Бид 302 -р хурдны замаар явж, дараа нь зүүн тийш, Портлэндийн зүг эргэв. Зам энд ч хагарч, зарим газар эвдэрсэн ч ерөнхийдөө Канзас-роудыг бодвол яаж ийгээд явж болохоор ажээ. Би гүүрнүүдээс маш их аиж байлаа. Мэн муж бол олон арван голуудаар нэвт огтлогдсон нутаг, энд байсхийгээд л том, жижиг гүүрээр гарах хэрэгтэй болдог. Харин Нейплзын далан тэсч үлдсэн байж, тэндээс бид удаан боловч явсаар Портлэнд хотод орж ирлээ.

Манан өтгөн хэвээр. Нэг удаа би зам дээр унасан модод хэвтэж байна гэж бодон зогсов. Гэтэл "модод" мушгиран хөдөлж эхлэхэд би тэмтрүүлүүд гэдгийг ойлгосон юм. Бид түүнийг замаас зайлтал зогсож хүлээх хэрэгтэй болсон. Дараа нь машины хамар дээр юу юунаас ч илүү аварга том, хачин муухай сонотой төстэй, ногоон биетэй, тунгалаг далавчтай амьтан бууж ирлээ. Тэр хэсэг сууж байгаад далавчaa хурдан дэвэн, нисэн одсон.

Бид Канзас-роудаас салснаас хоёр цагийн дараа Билли сэрж, ээждээ хүрсэн үү гэж асуув. Би түүнд зам дээр мод унаснаас бид байшиндаа хүрч чадаагүйг хэллээ.

-Ээж зүгээр болов уу, ааваа?

-Аав нь мэдэхгүй байна. Гэхдээ бид эргэж ирээд бүгдийг мэднэ.

Билли уйлсангүй, дахин зүүрмэглэж эхлэв. Би түүнийг уйлсан бол дээр байхсан гэж бодлоо:

тэр дэндүү их унтааж байгаа нь миний сэтгэлийг зовоож байна.

Хэт ачааллаас миний толгой өвдөж эхэллээ. Манан дунд машин жолоодон цагт арав, хорин километр хурдтай явснаас, урд биднийг юу хулээж байгааг огт мэдэхгүй, ангал, нурсан гүүр, эсвэл Гурван толгойт мангастай ч учрахад бэлэн явснаас миний толгой өвджээ. Би бурханд залбирч явсан байх. Би бурханд Стеффиг амьд үлдээгээч, би өөр бүсгүйтэй унtsаны төлөө түүнд бүү хонзогнооч хэмээн гуйн залбirsan. Бас бурхан намайг хүүгээ аврахад минь туслаач, тэр хэтэрхий зовж шаналж байна гэж залбirsan.

Манан хүрч ирэхэд ихэнх жолооч нар замын хажуу тийш шахан зогсоцгоосон болохоор бид овоо хурдан явж, үд дунд хэрд бүр Хойд Уиндем хүрлээ. Дараа нь би Ривер-роудаар явах гэж үзсэн боловч түргэн устай жижиг голын дээгүүр тавьсан гүүр нурсныг харав. Бараг бүтэн хагас километр ухран явж байж би машинаа эргүүлж болох зйтай газар ирлээ. Эцсийн эцэст бид Портлэндийн зүг 302-р замаар явсан юм.

Хотод орж ирээд би боомтын зүгяvlaa. Зам ашигласны төлбөр авдаг эгнээ бутикуудын хагархай цонхнууд гавлын ясны нүдний онгорхой нух мэт харагдана. Нэг бутикны эргэдэг хаалганд Мэн мужийн боомтын тэмдэгтэй, цусанд будагdsan хүрэм өлгөгджээ. Супермаркетаас энд ирэх замд бид нэг ч хүнтэй тааралдсангүй.

-Дэвид, радиогоо асаагаад үз гэж хатагтай Репплер хэллээ.

Би духаа алгадлаа, яагаад би энэ тухай бодоогүй юм бэ? "Скаут" хүлээн авагчтай нь мэдээж шүү дээ.

-Өөрийгөө загнах хэрэггүй гэж хатагтай Репплер хэлэв. -Чи бүхнийг зэрэг бодож чадахгүй шүү дээ. Хэрэв тэгэх гээд байвал удалгүй галзуурч, бидэнд юугаар ч тусалж чадахаа болино.

Богино долгионоор би шуугианаас өөр юу ч барьж чадсангүй, урт долгионд эвгүй нам гүм ноёрхжээ.

-Тэд бүгд ажиллахгүй байгаа хэрэг үү? -гэж Аманда асуухад би түүний юу хэлэх гээд баигааг ойлгох шиг боллоо: бид өмнө зүг хангалттай хол явсан болохоор би Бостон хотын хүчирхэг радио станцуудын хэд хэдийг зэрэг барих ёстой байв. Гэхдээ хэрэв Бостон бас...

-Сэтгэлээр унах хэрэггүй гэж би хэллээ. -Богино долгионд шуугиад байгаа чинь saat ал. Үүнээс гадна манан радио долгионыг унтраагаад байх шиг.

-Үүгээр бүхнийг тайлбарлаж болно гэж чи бодож байна уу?

-Тийм гэж би хэлсэн ч өөрөө ч үүнд итгэж чадахгүй байлаа.

Бид далаад километрээс цувж эхэлсэн самбуруудын дэргэдүүр өмнө зүг явж байна. "1 километр" гэсэн заалт харагдвал бид Нью-Хэмпшир мужийн хил дээр ирнэ. Гол замаар явахад төвөгтэй болж ирлээ: олон жолооч бууж өгөхийг хүсээгүй тул машинууд тун олноор мөргөлдсөн байв. Хэдэн удаа би эсрэг урсгалд орж явлаа.

Нэг дөчийн үед, намайг өлсөж эхэлж байхад Билли гараас барьж авлаа.

-Энэ юу вэ? Ааваа, энэ юу вэ?

Манан дундаас бидний урд хар сүүдэр гарч ирлээ. Уул хад мэт аварга том сүүдэр биднийг чиглэн ирж явна. Би огцом тормозлож, зүүрмэглэж байсан Аманда урд шилийг мөргөх шахав.

Юу ч юм, бидний дээгүүр явж өнгөрлөө, үүнийг л би итгэлтэй хэлж чадна. Хэдийгээр манан зарим хэсгийг нь л хархаар болгосон ч үүний зэрэгцээ бидний, тархи зарим зүйлийг ерөөсөө хүлээн авч чаддаггүйгээр ч тайлбарлаж болох байх

Энэ амьтан зургаан хөлтэй байсан, үүнийг би баттай хэлж чадна, энд тэндээ хүрэн толботой саарал арьстай. Хачин юм гэхдээ энэ хурэн толбонууд надад хатагтай Кармодийн гарыг санагдууллаа. Гүнзгий үрчлээс, давхаргатай арьсанд нь ишэн дээр бүлтийх нүдтэй ягаан хорхой мэт амьтад хэдэн зуугаараа наалджээ. Энэ амьтан хэр зэрэг өндөр том биетэй байсныг мэдэхгүй, гэхдээ тэр амьтан бидний яг дээгүүр явж өнгөрсөн. Нэг саарал, үрчлээстэй хөл бидний машины хажууханд газар гишгэсэн, хожим хатагтай Репплер байдгаараа дээш өлийн харсан ч их биеийг нь олж харж чадаагүй гэсэн. Тэр зөвхөн дээд талаараа манан дунд замхран алга болсон, том хотын театрын багана мэт аварга хөл л олж харжээ.

Энэ амьтан "Скаут" -ын дээгүүр алхлан өнгөрөхөд надад тэр цэнхэр халим ч хажууд нь алгана загас шиг харагдахаар аварга том юм гэсэн бодол төрсөн. Өөрөөр хэлбэл хүний ухаан санаанд багтахааргүй аварга том амьтан. Тэр яван өнгөрсөн ч бид түүний газар доргиулан алхлахыг удаан сонсоор байлаа. Замын асфальт дээр түүний аймшигт нүхэн мөр үлдсэн, би машинаас түүний ёроолыг харж чадаагүй, харин мөр бүхэнд ачааны машин уужуухан багтахаар юм гэж бодсон.

Нэг хэсэг машинд бидний амьсгал, холдож байгаа амьтны хөлийн доргиноос өөр дуу чимээгүй болов. Дараа нь Билли асуулаа:

-Энэ динозавр байсан уу? Ааваа? Дэлгүүрт орж ирсэн шувуу шиг?

-Үгүй байх, хүү минь, Ийм хэмжээний амьтан ерөөсөө хэзээ нэгэн цагт амьдарч байсан гэж би бодохгүй байна. Ямар ч байсан дэлхий дээр.

Би дахин "Сум" төсөл" -ийг санаж, "Тэр галзуу амьтад юу хийж байсан юм бол?" -гэж бодлоо.

-Бид явах хэрэгтэй байх гэж Аманда дуугарав. -Тэр амьтан эргээд ирж магад.

Тиймээ. Эсвэл биднийг урд ч иймэрхүү учрал хүлээж байж магад. Гэхдээ би энэ тухай юм ярьсангүй. Хаашаа ч юм, явах хэрэгтэй, би машинаа урагш, аварга том мөрүүдийг замаас гартал нь тойрон заллаа.

Ийм л үйл явдал бидэнд тохиосон. Одоо арай хожим өгүүлэх ганц зүйл л үлдлээ. Та ямар нэг

тодорхой төгсгөл хүлээх хэрэггүй. Энд "тэгээд тэд манан дотроос хурц наран гэрэлтсэн тунгалаг өдөрт гарч ирэв", эсвэл "бид сэрээд хартал Үндэсний гвардийн цэргүүд ирж явлаа" гэх маягийн үгс байхгүй. Бүр аргаа барахад "энэ бүхнийг би зүүдэлжээ" гэсэн төгсгөл ч та олж харахгүй.

Миний бодлоор энэ бүхнийг аавын хөмсөг зангидан хэлдгээр "Альфред Хичкокийн дуртай төгсгөл" гэж нэрлэж болох байх. Энэ үгээр миний аав уншигч чухам яаж үйл явдлыг дуусгахаа өөрөө шийддэг, тодорхой бус төгсгөлийг хэлдэг байсан юм. Аав ийм түүхийг үргэлж үл ойшоон, "хямд үзүүлбэр" гэж нэрлэдэг байсан.

З-р уулзварын дэргэдэх "Ховард Жонсонз" буудалд бид харанхуйлж, машин барихад аюултай болсон үед хүрч ирсэн юм. Үүний өмнө бид Сако-Ривер голын гүүрээр амь насаараа дэнчин тавин байж гарсан. Тэр их эвдэрч хэмхэрсэн харагдсан, гэхдээ мананд гарч болох эсэх нь мэдэгдээгүй. Энэ удаа бид азтай байлаа.

Одоо маргаашийн тухай бодох хэрэгтэй.

Цаг шөнийн арван хоёр дөчин тав болж байна. Долдугаар сарын хорин турван. Энэ аймшигийн эхлэл болсон шуурга дөнгөж дөрвөн хоногийн өмнө болж өнгөрсөн. Билли буудлын гол танхимд миний хайж олсон гудсан дээр унтаж байна. Хажууд нь Аманда, хатагтай Репплер нар унтаж байгаа. Би ширээний ард суугаад том гар чийдэнгийн гэрэлд бичиж, харин цонхны шилэн дээгүүр өнөөх ягаан амьтад мөлхөлдөнө. Байсхийгээд шилийг алхаар цохих мэт чанга дуугарах нь цагаан биетэй, улаан нүйтэй "шуувууд" ягаан амьтдыг шүүрэн барьж байгаа хэрэг.

"Скаут" -д хангалттай, зуун тавь орчим километр явах бензин үлдсэн. Уг нь эндээс бензин авч болно. Хажууханд "Эксон" -ы шатахуун түгээх газар байгаа, хэдийгээр цахилгаан насосууд ажиллахгүй ч би хадгалагч савнаас жаахан бензин соруулж дөнгөх байх. Гэхдээ...

Гэхдээ энэ нь машинаас гарах хэрэгтэй гэсэн үг.

Хэрэв бид эндээс, эсвэл замаасаа бензин олж чадвал аяллаа үргэлжлүүлэх болно. Учир нь хаашаа явах талаар надад нэг бодол байгаа юм. Энэ бол миний та нарт хэлэх гэсэн эцсийн үг.

Тиймээ, би бүрэн итгэлтэй байгаа юм биш. Энд л хэргийн хамаг учир байна. Магадгүй миний сэтгэл санаа хүслийг бодит мэт болгон төөрөлдөж байж болох юм. Гэхдээ үнэхээр худал байсан ч бидэнд өөр явах газар байхгүй л болов уу. Урд хэдэн километр байгаа вэ? Хэдэн гүүрээр бид гарах ёстой вэ? Миний хүүг барьж идэхээр хэдэн муухай махчин амьтад биднийг хүлээж байгаа вэ?

Үүнийг би сэргүн зүүдэлсэн ч байж магад тул би бусдад юу ч ярихгүй байхаар шийдсэн. Одоохондоо.

Буудлын менежерийн ерөөнөөс би антеныг нь цонхоор гаргасан өргөн диапазонтой, зайгаар ажилладаг хүлээн авагч олсон юм. Хүлээн авагчийг асааж, зайгаар ажиллах горимд оруулаад би чихийг нь эргүүлэн, диапазоныг нь сольж, суваг хайж эхэлсэн. Хүлээн авагч шуугиж, эсвэл таг дуугүй бодохоос өөр ямар ч үр дүнд би хүрсэнгүй. Эцэст нь түүнийг унтраахаар

заагчийг богино долгионы хамгийн эцэст хүргэтэл би ганц үг сонсох шиг болсон.

Тэгээд л гүйцээ. Би бүтэн цаг хүлээсэн боловч дахиж юу ч сонсоогүй. Хэрэв ганц үг үнэхээр сонсогдсон бол тэр радиодолгионыг унтраагч манан дунд өчүүхэн зайдавсар олон нэвтэрсэн байх. Дараа нь энэ зайдав хаагдсан.

Ганц үг.

Одоо би унтах хэрэгтэй... хэрэв би өглөө болтол Олли Викс, хатагтай Кармоди, зөөгч Норм... бас өргөн хүрээтэй малгайны сүүдэрт харагдах Стеффийн царайг зүүдлэхгүй бол унтах ёстой.

Энэ буудал ресторантай, "Ховард Жонсонз" буудлуудынх шиг үдийн хоолны танхимтай, танхимд морины тах хэлбэртэй, салат, хамбургер, хачиртай талх өрсөн лангуу байдаг. Би энэ хуудсуудыг лангуун дээр үлдээнэ, хожим хэн нэгэн олж, уншиж магад.

Ганц үг.

Хэрэв би түүнийг үнэхээр сонссон бол. Үнэхээр.

Унтахаар хэвтэх хэрэгтэй. Гэхдээ би эхлээд хүүгээ үнсэж, чихэнд нь хоёр үг шивнэх болно. Муухай зүүд бүү зүүдлэг гэж.

Хоёр үг.

Нэг нь өнөөх сонссон үг: "Хартфорд"

Хоёрдахь үг нь: "Найдвар".

Төгсөв